



WORLD BANK

ARC



33100

Хатгин Осорнамжимын СҮХБААТАР

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН

SACRED SITES OF MONGOLIA

МОНГОЛЫН ТАХИЛГАТ УУЛ УСНЫ САНГИЙН СУДАР ОРШВОЙ.

Эмхэтгэн боловсруулж, эрдэм шинжилгээний
тайлбар, судалгааг үйлдсэн

ХАТГИН ОСОРНАМЖИМЫН СҮХБААТАР

РЕДАКТОР:

Доктор, профессор Л. ХҮРЭЛБААТАР

Дэд доктор Ш. СОНИНБАЯР

Х. БЯМБАЖАВ

Translation: B.ELBEGZAYA, Sh.GANBYAMBA, J.DUNN and T.LEWIS

Талархал

Энэхүү номыг хэвлүүлэхэд Дэлхийн Банк, Монголын Бурхан Шашинтны төв (МБШТ) /Гандан Тэгчилэн Хийд/, Дэлхийн Банк-Голландын засгийн газрын хамтын ажиллагааны хөтөлбөр болон Шашин ба Байгаль Хамгааллын Холбоо (ШБХХ), Дэлхийн Банк ба WWF (Дэлхийн Байгаль Хамгаалах Сан) хамтарсан Ойн нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах хөтөлбөрийн хүрээнд WWF (Дэлхийн Байгаль Хамгаалах Сан)-ийн Монгол дахь Товчоо зэрэг байгууллагууд санхүүгийн туслалцааг үзүүлсэн ба эдгээр байгууллага, түүний ажилтнуудад талархал илэрхийлье.

МБШТ /Гандан Тэгчилэн Хийд:

Их хамба Д. Чойжамц
Дэд доктор Ш. Сонинбаяр
Х. Бямбажав

Дэлхийн Банк

Тони Уитен

ШБХХ:

Б. Баатар
Чалинг Халбертсма
Женни Данн
Тара Луис
Ричард Прайм

ДБХС-ийн Монгол дахь Товчоо:

Б. Чимэд-Очир
Б. Элбэгзаяа
Р. Болор

Acknowledgments:

This publication has been made possible with the support of the Gandan Tegchilen Monastery/ Center of Mongolian Buddhists and The World Bank-Netherlands Partnership Program, through a contract with the Alliance for Religions and Conservation (ARC), and The World Bank-WWF Alliance for Forest Conservation and Sustainable Use, through a contract with WWF Mongolia and the assistance of the following individuals working with these organizations:

For Gandan Monastery:

Hamba Lama D. Chojamts
Dr. Sh. Soninbayar
Lama H. Byambajav

For ARC:

Baatar, Bazar
Jeannie Dunn, ARC UK
Tjalling Halbertsma
Tara Lewis, ARC UK
Richard Prime, ARC UK

For World Bank:

Tony Whitten

For WWF Mongolia:

Chimed- Ochir, Bazarsad
Elbegzaya, Batjargal
Bolor, Radnaabazar

ХАВТАСНЫ ЗУРАГ: Чалинг Халбертсма
ХАВТАСНЫ ДИЗАЙН: Ричард Прайм, ШБХХ-ны Англи дахь Салбар
НОМЫН ЭХ БЭЛТГЭСЭН: С. Батцэцэг

ISBN 99929-5-385-3

Улаанбаатар 2001

COVER PHOTO: Tjalling Halbertsma
COVER DESIGN: Richard Prime, ARC UK
BOOK DESIGN: S. Battsetseg

Copyright text: Mr O.Sukhbaatar
Copyright Photography: WWF Mongolia/ARC
Ulaanbaatar, 2001
ISBN- 99929-5-385-3



Date
№. . .

Ulaanbaatar -12
Phone: 976-1-322408
Fax: 976-1-310011

Foreword for the book "Sacred Sites of Mongolia"

In 1998, I joined a meeting hosted by President Wolfensohn of the World Bank who had invited a wide range of participants with different religious backgrounds to comment on issues such as sustainable development and ecology from a religious perspective.

As a Buddhist I welcomed this approach and felt that religions could make a vital contribution to these issues. I was also pleased to encounter ARC and WWF during these meetings and to find the acknowledgement of the World Bank that religions can play a vital role in these issues.

Since then, the involvement of religious communities in nature protection has, through the generous support of the World Bank and in partnership with ARC and WWF, increased significantly in Mongolia. Pupils in our schools, both religious and secular, have received ecological courses and have practically contributed to the well being of our environment. Our monasteries have also been instrumental in this and I am encouraged to hear that the model developed in Mongolia has been copied by other countries.

This book is a result of the cooperation between ARC, the World Bank, WWF, and the people of Mongolia and follows a similar book on the origin of place names in Mongolia, both written by the eminent scholar Sukhbaatar. Sacred Sites of Mongolia explores our mountains and rivers and the importance they hold for our natural environment and our identity.

Sacred Sites of Mongolia has been prepared for the occasion of the first visit of the President of the World Bank, who has expressed such great interest in the history, identity and culture of our country Mongolia. We hope many more books will welcome him on future visits.

A handwritten signature in black ink, appearing to read 'N. Enkhbayar'.

N. Enkhbayar

Prime Minister of Mongolia

FOREWORD



WORLD BANK

The changes in Mongolia since the collapse of Communism ten years ago have shown that the country's religious traditions have formed a firm basis upon which to rebuild a country with a strong historical perspective and identity. This rebuilding must encompass more than just infrastructure; the links between physical and psychological recovery should be addressed as well.

This process will involve rebuilding peoples' memories, hopes and beliefs. One way to aid in the process of rebuilding is to document Mongolia's sacred lands, an act which will in turn help to guide the ways in which land and resources are used. I note that one of the first acts of Prime Minister Enkhbayar, when he was Minister of Culture in the early 1990s, was to rebuild the towering statue in Gandan Monastery as a symbol that religious faith was again important to the Mongolian people.

Historically, religions have played a limited role in environment and development issues, but in recent years the Alliance of Religions and Conservation and the World Wide Fund for Nature (WWF) have been engaging the faiths in serious and practical dialogue, and often liaising with development institutions such as the World Bank.

The Bank seeks to engage all stakeholders in the development of its policies, programs and projects. We have been working more in recent years to bring the faiths into these discussions, and we view faith communities as essential partners in our development endeavors. They represent one of the largest networks of local communities in the world, and in many places they have a depth of understanding of poor communities that is without parallel. Exploring common goals in partnership holds great promise for the future.



JAMES D. WOLFENSOHN
PRESIDENT, THE WORLD BANK

Washington D.C.
January 2002



Миний бие 1998 онд Дэлхийн Банкны Ерөнхийлөгч ноён Волфенсоны зохион байгуулсан дэлхийн улс түмнүүдийн янз бүрийн шашин шүтлэгийн төлөөлөгчдийн тогтвортой хөгжил болон байгаль орчны чиг хандлагатай хөгжлийн хувилбар, түүний уламжлалт шашин шүтлэгтэй хэрхэн уялдаа холбоотой болох талаар хэлэлцсэн хуралдаанд оролцож байсан билээ.

Буддын шашинтай хүний хувьд би эдгээр асуудалд шашны оролцоо үүргийг нэмэгдүүлэх тухай дээрх санаачлагыг ихээхэн дэмждэг юм. Уг хуралдааны үеэр Шашин ба Байгаль Хамгааллын Холбоо /ШБХХ/ болон Дэлхийн Байгаль Хамгаалах Сангийн (WWF) үйл ажиллагаатай танилцаж, уламжлалт шашин шүтлэг, түүний нийгэмд эзлэх үүрэг, хувь нэмрийн талаарх Дэлхийн Банкны албан ёсны байр суурийг мэдэж авсан билээ.

Энэ цагаас хойш Дэлхийн Банкны өгөөмөр тусламж, ШБХХ, ДБХС зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах замаар Монголын уламжлалт шашин Монгол орны байгаль орчныг хамгаалах ажилд ихээхэн идэвхи санаачлагатай оролцож байгааг тэмдэглэн хэлэхэд таатай байна. Шашны болон иргэний сургалттай сургуулиудын сурагчид экологийн боловсрол олж авснаар байгаль орчныг хамгаалах ажилд өөрсдийн тодорхой хувь нэмрийг оруулж байна. Манай орны сүм хийдүүд байгаль хамгаалах талаар ихээхэн

идэвхитэй ажиллаж, тэдний санаачлан хийж байгаа олон үйл ажиллагааг бусад улс үндэстнүүдийн хувьд үлгэр жишээ төсөл болгон хэрэгжүүлж байгааг олж сонсоход сэтгэл нэн таатай байна.

Та бүхний анхааралд толилуулж байгаа энэхүү ном нь нэрт эрдэмтэн, хэл судлаач О. Сүхбаатар гуайн бүтээсэн Монгол орны газар орны нэрийн гарал үүслийн тухай номын үргэлжлэл бөгөөд ШБХХ, ДБХС, Дэлхийн Банк болон Монгол түмний сэтгэл шингэсэн хамтын ажиллагааны үр дүн юм. Монголын уул усны тахилгат судар оршвой хэмээх энэхүү бүтээл нь Монгол орны ариун дагшин шүтлэгтэй уул ус, тэдгээр нь хүрээлэн байгаа байгаль орчны хувьд ямар ач холбогдолтой болох, бидний үндэсний онцлог хэв шинж зэргийг дэлгэн үзүүлэх юм.

Монголын уул усны тахилгат судар оршвой хэмээх энэхүү номыг Дэлхийн Банкны ерөнхийлөгч ноён Ж. Волфенсоны Монгол орны түүх, соёл иргэншил, үндэсний тусгаар тогтнолын талаар асар их сонирхдог хувь хүний нь хувьд, түүний манай оронд хийж буй анхны айлчлалыг нь тохиолдуулан хэвлэн гаргаж байна. Түүний дараа дараагийн айлчлалтай холбогдуулан өөр олон шинэ ном хэвлэгдэн гарсаар байх болно гэдэгт гүнээ итгэж байна.

*Намбарын ЭНХБАЯР
Монгол улсын Ерөнхий Сайд*



WORLD BANK

Арван жилийн өмнө коммунист дэглэм задран унаснаар өнө эртний үүх түүхтэй Монгол орон, үндэсний тусгаар тогтнолоо уламжлалт шашин шүтлэг, зан үйлээ сэргээх замаар эргүүлэн олж авсан билээ. Улс үндэстнээ ахин төвхнүүлэх нь зөвхөн дэд бүтцийг сайжруулах, хөгжлийг түргэсгэх гэх мэт асуудлын хүрээнд яригдах зүйл биш бөгөөд энэ нь хүрээлэн буй бодит орчин болон оюун ухааны хоорондын уялдаа шүтэлцээг хэрхэн хангаж бий болгов гэдгээс мөн хамаардаг.

Энэхүү шүтэлцээг хангахын тулд хүмүүсийн оюун санаанд өмнөх үеийн түүхэн дурсамж, маргаашдаа итгэх итгэл, үнэмшлийг дахин бий болгох шаардлагатай юм. Үүний нэг тод жишээ нь ариун шүтлэгтэй газар орнуудыг ахин сэргээх замаар байгаль, түүний нөөц баялгийг ашиглаж ирсэн уламжлалт арга замуудыг дахин сэргээх явдал билээ. Монгол улсын өнөөгийн Ерөнхий Сайд Намбарын Энхбаяр Соёлын яамны сайд байхдаа энэ талаар их зүйл хийсэн бөгөөд түүний нэг


тод жишээ нь наян тохой өндөр Жанрайсаг бурхныг дахин бүтээж, шүншиглэн амилуулсан явдал юм.

Шашин шүтлэг нь байгаль орчныг хамгаалах, хөгжлийн талаар тодорхой байр суурь, үүрэг гүйцэтгэж ирсэн. Сүүлийн жилүүдэд Шашин ба Байгаль Хамгааллын Холбоо болон Дэлхийн Байгаль Хамгаалах Сан шашинтай хамтран энэ талаар нилээд бодит ажлуудыг хийж эхлээд байгаа бөгөөд энэ ажилд хөгжлийн байгууллагууд тухайлбал Дэлхийн Банк хамтран оролцож байна.

Дэлхийн Банк нь өөрийн бодлого чиглэл, хөтөлбөр төслийг тодорхойлохдоо сонирхол бүхий талуудыг аль болох өргөн хүрээтэй хамруулахыг эрмэлзэж байдаг. Энэ хүрээнд бид сүүлийн жилүүдэд уламжлалт шашин шүтлэгийн төлөөлөгчидтэй идэвхтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд бидний гол хамтран зүтгэгчид гэж үздэг.

Орон нутгийн иргэдийн нэг хэсгийг төлөөлж байдгын нь хувьд, олон улс үндэстний ядуучуудын эрх ашгийн талаар гүн гүнзгий ойлголттой байдаг учраас бид тэдэнтэй түншилж, хамтран ажилладаг билээ. Бидний хамтын ажиллагаа, түншлэл нэг зорилгод чиглэгдэж байдаг нь бидний ирээдүйд их итгэл төрүүлж байна.

Жеймс Д. ВОЛФЕНСОН
Дэлхийн Банкны Ерөнхийлөгч



ARC

**ALLIANCE OF RELIGIONS &
CONSERVATION**

launched in 1995

by HRH The Prince Philip,

Duke of Edinburgh KG KT

www.religionsandconservation.org



Gandan Tegchilen Monastery

To travel through Mongolia is to walk on sacred ground. Sacred rivers and mountains are but one part of a landscape enriched by man made ovoos, south-facing ger-tents and monasteries built in valleys of immense beauty. These special places of pilgrimage have always received special protection from the people who hold them sacred, which has been crucial for their preservation and survival.

However, a century of turmoil and unrest has meant that many of these sites have been forgotten, and that the legends and events associated with such sites have been lost. The work of the acclaimed author Sukhbaatar, who, in this publication, returns over thirty sacred sites to our memory, is therefore of tremendous importance. The Alliance of Religions and Conservation (ARC), Gandan Tegchilen Monastery and WWF Mongolia are pleased to contribute to the redis-

covery of Mongolia's sacred sites, which play such a vital role in preserving Mongolia's wild heritage.

This is the second publication in a series of books on the preservation of Mongolia's natural and cultural environment, authored by Sukhbaatar and co-funded by the World Bank and Gandan Monastery. The first publication, *Legends of the Land*, focused primarily on the origin of place names, which often derived from events and legends associated to such sites.

Sacred Sites of Mongolia takes this further and is a selection of mountains, rivers and forests which are held sacred by the people who live there, as well as the pilgrims who travel these sites. As all sacred sites in Mongolia have a historical manuscript or sutra dedicated to them we have also included these texts in the book, printed in the original Mongolian or Tibetan

script and partly translated into Mongolian. Although this series is primarily written for a Mongolian audience the publication of *Legends of the Land* received so many enquiries from people who requested a translation into English that we decided to include a brief English section in *Sacred Sites of Mongolia*.

This publication is only a small selection of sacred sites in Mongolia and many sites are yet to be rediscovered before knowledge and oral history of these places are lost. We hope this book will lead to a more comprehensive compilation of these places, which are so vital to Mongolia's identity and for the preservation of its natural and cultural environment.

*On behalf of ARC,
Gandan Tegchilen Monastery
and WWF Mongolia,*

Tjalling Halbertsma




ARCO

ALLIANCE OF RELIGIONS &
CONSERVATION

launched in 1995

by HRH The Prince Philip,
Duke of Edinburgh KG KT

www.religionsandconservation.org



Гандан Тэгчилэн хийд

Монгол орноор аялах нь бурхны ариун газраар аялахтай адил мэт санагдана. Ариун дагшин шүтлэгт газар орон төдийгүй овоо тахилга бүхий уулс толгод, өмнө зүгт үүдээ нээсэн гэр хэлбэрт сүм, хийдүүд нь байгалийн үзэсгэлэнт сайхан газарт сүндэрлэн босчээ. Эдгээр ариун газар орон нь хүн ба байгалийг ариусган нэгтгэдэг ариун бясалгалын орон хэмээн зон олны хүндэтгэл бишрэлийг хүлээн зуунаас зуунд хамгаалагдан, шүтэгдсээр иржээ. Гэвч сүүлийн хэдэн арван жилийн хөл хөдөлгөөн, бужигнааны явцад байгалиа эрхэмлэн дээдэлж ирсэн энэхүү өнө эртний уламжлал, газар усны тухай домог, тахилгын зан үйл зэрэг нь мартагдаж улмаар орхигдоход хүрсэн нь яахын аргагүй харамсал төрүүлнэ.

Иймээс нэрт эрдэмтэн, хэл судлаач О. Сүхбаатар гуайн энэхүү бүтээл нь ариун шүтлэгтэй газар, орныг бидэнд таниулснаараа мартагдан орхигдсон энэхүү зан үйлийг сэргээхэд чухал ач холбогдолтой юм. Монголын байгалийн унаган төрхийг

хадгалан авч үлдээх нэгэн үзүүрт сэтгэлд хөтлөгдсөн Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (ДБХС)-ийн Монгол дахь Товчоо, Шашин ба Байгаль Хамгааллын Холбоо (ШБХХ), Гандан Тэгчилэн хийд энэхүү ариун нандин шүтлэгийн зан уламжлал болон шүтлэг бүхий газар орныг сэргээх ажлыг хийж байгаадаа их баяртай байна.

Энэхүү судрын ном нь Монголын ариун шүтлэгт газар орны талаарх Дэлхийн Банкны санхүүгийн дэмжлэг бүхий О.Сүхбаатарын цуврал бүтээлийн хоёр дахь цуврал ном юм. Эхний цуврал ном нь Монгол орны газар орны нэрийн үүслийн талаар өгүүлдэг.

“Монгол орны ариун шүтлэгт газар орон” гэдэг энэхүү хоёр дахь цуврал бүтээл нь эхний номонд дурдсан газар орнуудаас тухайн газар орны хүн зон олон зууны турш тахин шүтэж ирсэн газруудыг сонгон авч, тэдгээрийн шүтлэгийн судрыг түвд эх болон Монгол хэлнээ хөрвүүлэн хэвлүүлж байна. Цуврал номын эхний ботийг зөвхөн монгол хэл

дээр хэвлэсэн ба энэхүү хоёр дахь цувралын хүрээнд бид хүмүүсийн хүсэлтийн дагуу ариун шүтлэгт газруудын талаар мөн Англи хэл дээр товч мэдээллийг өгөхийг зорилоо.

Энэ номонд Монгол орны ариун шүтлэгт газар нутгийн цөөн тооны голлох газруудыг хамруулсан ба эдгээр газруудын тухай олон жилийн турш хуримтлагдсан мэдлэг, түүх домог мартагдаж, улиран өнгөрөхөөс өмнө өрсөж уг газруудыг тогтоон мэдүүлэх нь зүйтэй гэж үзсэн билээ. Иймээс энэхүү номыг хэвлэн гаргаснаар улс орны түүх, үндэсний тусгаар тогтнол, байгаль болон соёлын өвөө хадгалан үлдэхийн билэг тэмдэг болсон эдгээр газруудын талаар улам дэлгэрэнгүй, бүрэн дүүрэн мэдээлэл цуглуулах эх суурь тавигдана гэж бид итгэн найдаж байна.

*Өмнөх үгийг
Чалинг Халбертсма
ДБХС, ШБХХ,
Гандан Тэгчилэн Хийдийг
төлөөлөн бичив.*

Монгол нутгийн уул усны эзэд савдгийн тухай

Монголчуудын овоо тахих зан үйл нь нутаг усаа эрхэмлэн хүндэтгэж, бишрэн тахиж ирсэн тэдний нэн эртний сэтгэлгээнийх нь илрэл болдог. Уул овоо, газар усыг тахин шүтэх зан үйлийн ул мөр монгол бичгийн болон аман яруу найрагт ч уламжлагдан ирсэн байдаг. Энэ зан үйл нь газар нутгийнх нь өвөрмөц онцлогийг тусгасан байдгаараа харилцан адилгүй байх нь ч бий.

Анх бөө мөргөлийн шашинтай холбоотой үүссэн бөгөөд овоо гэдгийг онгодын оршин буй орон гэж үздэг. Онгод нь тэнгэр, газар эзэн сахиулсантай шууд харьцаж чаддаг ид шидтэй шүтээн ажээ. Ид шидтэй шүтээний оршдог орон нь онцгой ариун дархан овоо гэдэг байна. Эртний монголын бөөгийн шашин нь газрын тахилгаас үүдэлтэй бөгөөд тэр нь Этүгэн эх болно. Этүгэн гэдэг нь газрын эзэн, газрын шүтээн зэрэг эртний утгатай үг болно. Одоогийн манай Отгонтэнгэр уулын Отгон

нь Этүгэн гэдэг үгийн хувирсан хэлбэр бөгөөд Газрын шүтээн гэсэн утгатай үг болно. Газрын сахиулсан Этүгэн нь ургамал бодисын урган үржихийг хамааран захирах ид шидтэй гэгддэг бөгөөд тэгээд ч Монголчууд мал сүргээ Этүгэнд даатган наминчилсаар ирсэний улбаа мөр нь ардын зан үйл, аман зохиолоор уламжлагдан иржээ. Энэхүү Этүгэнийг тахих үзэл нь хувьсан хөгжсөөр овоо тахилгын хэлбэр рүү шилжсэн юм. Энэ нь тус тусын оршин суугаа нутаг усыг далдын эзэнтэй болгоход хүргэжээ.

Монголчууд уул, ус хоёр өөртөө эзэн савдагтай гэж үзэж ирсэний баталгаа нь “Уул савдагтай, ус эзэнтэй” гэсэн зүйр үгээс мэдэгдэнэ. Энэ нь жинхэнэ шүтлэг болж уул усыг тахих болсонтой холбогдон “Алтай дээрээ гарч 13 сангаа тавих” гэсэн цэцэн үг гарч шүтлэгийн нэгэн зан үйл болон дэлгэрсэн гэж академич П.Хорлоо бичжээ.

Ер нь газрыг мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэлбэрээр ашиглаж байснаас түүнээ “нутаг” гэж үзэж байв. Тэрхүү нутгаа онгон бэлчээр болгож, түүнээ

тахих хэлбэрийг бий болгосон юм. Нутаг усыг бий болгодог гол мөрөн, уул нуруу, даваа гүвээ, нуур усанд нь ямар нэгэн ид шидийн хүчтэй савдаг бий гэсэн үзэл үүсчээ. Үүнийг шарын шашин өөриймшүүлэн авсан бөгөөд шашин-нийгмийн амьдралд баттай хэвшин тогтсон юм. Тэр ч байтугай өвгөд дээдсээ өндөр газар оршуулж онголж ирсэн нь өнөөх л газрын эзэн савдагтаа даатган өгч байсан хэрэг гэлтэй. Өндөр газар, өл хөтөл, аян замын уулзварт овоо босгодог нь олон онгод эзэн савдгийг хуран цуглуулах үзэл бодлынх нь илрэл юм. Иймээс хаа тааралдсан газар овоо босгодоггүй, учир зорилготой сонгосон газар босгодгоор түүнээ тахилгын орон болгодог байна. Монголчууд мод бургас огтлох, хад чулуу ховхлох, гол горхийг улаан цагаан идээгээр буртаглах, өвс ногоог үр үндсээр нь тахлан сүйтгэх, ан амьтныг хомроглон авлах, шунахай сэтгэлээр амийг нь муулахыг ихэд цээрлэн “Лус савдаг хилэгнэнэ”, “Тэнгэр догширно”, “амь нас, мал хөрөнгөнд гай цөв учирна” хэмээн нутаг усны эзэн савдгийг

аргадан баясгах шившлэг тарни шившиж, сан тавиулж, ном уншуулдаг байв. Тийнхүү тахилга тайлга хийхдээ тогтсон өдөр цагийг сонгон товлодог байна. Тусгайлан зохиосон ном судрыг үзвээс тухайн нутгийн эзэн савдгийг эхлээд урин залж, лянхуат тавцанд суулган залав хэмээн сэтгэлдээ итгэн бодож, хүслийн таван эрдэнэ болсон хүж, цэцэг, зул тэргүүтнээр тахил өргөн, түүний сайхан үнэрээр газар орны эздийг баясгадаг ажээ. Ийнхүү газарт бууж ирсэн эзэн савдаг, навдаг, шивдагийг улам баясгахын тулд тэдэнд зориулж хонь, ямаа, хөлөг морь, буур, бух тэргүүтнийг сэтэрлэх ёслол үйлдэнэ. Сэтэрлэх зан үйл нь тухайн малыг бурхан тэнгэр, газар усны эзэн савдагт өргөж, дархлан онголж байгаа хэрэг юм. Монголын газар усны эзэн савдаг нь төрөл зүйлийн хувьд олон янз буй. Хэдий тийм боловч бадрангүй догшин эзэн сахиустай уул ус нилээд нийтлэг байдаг. Тухайлбал Отгонтэнгэр уулыг Очирваань бурханы бүрэлбаа буюу сахиустай гэдэг бол Цамбагарав уулыг Эсрүн тэнгэрийн сахиустай гэдэг.

Дайчин тэнгэр буюу Далх эзэнтэй уул ч олон бий. Дарьгангын алтан овоо, Хөвсгөлийн Даян дээрхийн эзэн шүтээн нь Далх болно. Нутаг нутгийн онцлогоос болж баахан өөр өөрөөр дүрсэлсэн байдаг. Далх бүр нь эхэн үедээ Дайны тэнгэр буюу Дайчин тэнгэр байсан бол хожуу үед бурханы шашныг хамгаалагч тэрчлэн өрх гэр, хувь хүмүүсийг ивээгч, сахиулсан, аз жаргал, сайн сайхан бүхний тэнгэр, муу тотгодыг дарагч, гал голомтыг тэтгэгч тэнгэрийн үүрэгтэй болж хувирсан юм. Тэрчлэн сүлдэн тэнгэрийн сахиустай уул ч цөөнгүй байна. Тиймээс ч сүлдэн тахилгат уул гэсэн нэр томъёо үүсчээ. Энэхүү тахилгын орон болсон овоо хайрханы сангийн сударт газар лусын олон эздийг тодорхой дүрслэн өгүүлсэн байдаг. Тэрхүү эзэн савдаг нь өөр өөр байдаг нь түүнийг зохиосон хүний үзэл бодлоос хамааралтай байжээ. Тухайлбал Ойрдын газар ус болон мал хөрөнгийн эзэн нь Цагаан өвгөн байдаг ажээ. Энэ тухай Ойрод монголчуудын ойлголтоор Цагаан өвгөн сахиус савдаг нь өндөр ууланд, олон модны доторх онцлогт том удган

мод, тал хээрийн дундах өнчин ганц ишгэн толгой, цохио хаданд оршдог хэмээн бодож өндөр уул, удган мод, өнчин улиас, цохио чулууг сэтэрлэн, тэнд овоо босгон газар ус тахих үзэл дэлгэрсэн гэж зарим эрдэмтэд бичсэн нь бий. Энэ нь зөвхөн Ойрод монголд төдийгүй нийт монгол туургатны дунд байсан гэдгийг нэмж тэмдэглэх хэрэгтэй. Газар дэлхий, уул усны нэг догшин эзэн бол лус юм. Лус нь үүл үүсгэн, хур бороо оруулах сахиус бөгөөд лусын аймаг тоогүй олон бий гэдэг. "Лусыг могой буюу морьтой хүний дүрээр зурж тахих явдал үлэмж байсан. Уул тахих ёслол бол чухамдаа уулын эзэн лусыг тахих ёслол болно" гэж академич Ц.Дамдинсүрэн нэгэнтээ бичсэн билээ (Гэсэр 1968).

Бурханы шашны домгоор бол хүн толгойтой, могой хэлбэрийн биетэй, газар дэлхий, уул усны эзэн, хүмүн бусын амьтан гэдэг. Навдаг буюу орны эзэн нь орон нутгийн эзэн савдаг, сүлд болсон тэнгэр юм. Хүний оройн үсэнд ирж оршин хүний амь нас, хишиг буяныг

сахин хамгаалдаг гэдэг. Иймд хүн толгойдоо гар хүргүүлэх, морь малын толгой руу цохих нүдэхийг ихэд цээрлэн хишиг буян зайлна гэж үзэж иржээ.

Газар усны эздийг савдаг, навдаг, юлха гэхчлэнгээр нэрлэж ирсэн нь цөм төвд гаралтай үг бөгөөд эдгээр нь монгол хэлний үгсийн санд нэвтэрсэн болно. Чингээд Монголын тахилгат уул усны эзэд савдгийн төлөв байдлыг сан тахилгын судар, аман ба бичгийн зохиол, домог хууч яриа сэлтэд тулгуурлан доорхи байдлаар тодорхойлж байна.

1. Уул овоонд эзэн савдаг бий болгохдоо тухайн газар орны байр байдал, байгалийн тогтцыг ажин шинжиж ямар шинжтэй буйгаар нь бий болгох тохиол байжээ. Тухайлбал Улаанбаатарын дэргэд орших Сонгино хайрхан уулын сангийн судрыг Их Хүрээний нэгэн эрдэмт лам Төвдөөс залагдан ирсэн Лувсанпэрлэйжамцаас соёрхол эрэн зохиож өгөөч гэж хүссэн байдаг. Тэрхүү Төвдийн эрдэмт ламтан Сонгино хайрханыг шинжин үзээд: Их цэргийн ноёны дүртэй уул юм байна. Тэгэхдээ

айхавтар догшин юм байна. Хатуу үйлийг захин хүсэхэд түргэн бүтээх идтэй юм. Энэ уулын эзэн нь хөх бух унасан, араа соёо нь зөрсөн, архинд баахан дуртай хөх өвгөн байна гээд уг хайрханы сан сэржмийг зохиосон ажээ. Үүнээс үзвэл уг сангийн судрыг зохиогчид нь уул усыг шинжин, уул усны эздийг сэтгэлдээ ургуулан уран сайхнаар сэтгэн бүтээж ирсэн уламжлалтай билээ. Энэхүү уулын эзний сүрлэг догшин дүр хөрөг олны дунд ихэд тархсан нь одоо ч уламжлагдан ирсэн бөгөөд тэр нь урт үс сахалтай, сүрт хоёр соёо нь дээш ил гарсан, хөмсөг духаа зангидсан, ширүүн догшин харцтай ажээ. Сонгино хайрханд сэржим өргөх ёс бий болсон нь архинд дуртай эзэнд нь хишгийн дээж хүртээж аргадаж буй хэрэг ажээ.

2. Тухайн уулын нэр нь эзэн болсон тохиолдол олон уулын сангийн судраас ажиглагдана. Зава Дамдингийн зохиосон Дарцагтын залбирал тахилга сударт:

Хачийн дорно хязгаарын
Лин орны газарт илэрсэн

Цастын орны умар зүгийн газар Халхын хаа ч алдартай нутаг усны шивдаг Ба бүрний газар орны тэнгэр эрхин Дарцагт Наран саран мэт ив илхэн энэ орноо залрагтун гэж буй.

Дарцагт уулын эзэн нь Дарцагт нэртэй байх ба түүнийг дээд морь хөлөглөсөн их шивдаг гэсэн буй. Халзан Бүргэдтэй уулын эзэн нь Халзан Бүргэдтэй нэртэй байна. Энэ уулын сангийн сударт:

Өмнөдийн самдийн сэтгэлээр тийн хувилгасан Өнгөт торго, олон таван үзэмжит орд өргөөний төвд Баясган баясган мөшөөлгөхөөр Халзан Бүргэдтэйг Батад залснаар энэхүү ариун тахилыг зооглогтун гэж буй.

3. Зарим тахилгат уул усны эзэн нь дагинас, бүсгүй хүн байдаг. Үүнд Баянхонгорын эзэн нь цагаан заан хөлөглөсөн, ногоон торгон хувцастай, баруун гартаа рашааны бумба залсан, зүүнээ таван зүйлийн тансаг идээ

бүхий таваг барьсан хүний дүрээр илэрхийлэгдсэн байдаг. Хонгор хайрханы савдаг Баянхонгор гэгч тэр буюу. Сүүлийн үед үүнийг хөрөглөн дүрслэж Баянхонгор хотын баруун талд буюу Эрдэнэ Мандал хайрхан дээр залж байрлуулсан болно. Ховд аймгийн Мянгад, Увс аймгийн Өмнөговь сумын нутгийн заагт Өндөр Хөхий хэмээх дээрээ 13 сантай өндөр овоог мянгадууд эртнээс тахиж ирсэн бөгөөд энэ уулын эзэн нь мянгад иргэнийг үргэлж дуудаж, хувь заяаг нь түшиж байдаг ногоон торгон дээлтэй, үсээ хоёр салаа сүлжсэн, бэлгийн мэлмийтэй, цайвар царайтай, өмнөө тулга тогоо тулсан үзэсгэлэн гоо бүсгүй байдаг гэнэ. Үнэхээр тэр уулын оройд том тогоо байдаг гэнэ. Тэр тогоог хүн харахад тэгш байвал аз жаргалтай, заяа түвшин байх, хэрэв хазгай харагдваас заяа хэлтгий, үйлс бүтэл муутай байна гэж үздэг ажээ.

Тэрчлэн Дорнод аймгийн Халхгол сумын нутагт орших Буйр нуурын хойт этгээдэд Хүүхдийн овооны эзэн нь элдэв тансаг идээн тавагтай, цав цагаан дээл өмссөн, цайвар зүстэй гоо

бүсгүй байдаг гэнэ. Овооны ойролцоох нэг хадан дээр сууж өтгөс нялхасыг ивээн тэтгэж, үр өгөөжөө хүртээдэг гэж эртнээс билэгшээн ирсэн учраас түүнийг аргадан тахидаг ажээ. Бас энэ эзний тухай Н.Жуковский “Буйр нуурын эзэн нь нуурын хойт дэвсгийн хадан дээр суудаг цагаан хувцастай бүсгүй байдаг, тэр нь загасчдад тусладаг гэлцэнэ” хэмээн тэмдэглэжээ.

Ховд аймгийн Манхан сумын Гурван цэнхэрийн эзэн нь хөх дээлтэй, үсээ салаалан сүлжсэн, цайвар тунгалаг царайтай эмэгтэй, Зэргийн голын эзэн нь туг ширээ бөхтэй цагаан тэмээ унасан, ногоон дээлтэй эмэгтэй байдаг гэж домоглож иржээ.

Дорнод аймгийн Баян уул сумын Дунхан уулын эзэн савдаг нь ухаа хонгор морь унасан, улбар шар дээлтэй, ухаа өнгийн хиур дарцаг хийсгэсэн хориод насны гоо бүсгүйн дүрээр дүрслэгдэн иржээ.

Алтайн халхчуудын амаар уламжлагдсан домгоос үзвэл мөнх цасан оргилт, домогт Сутай буюу Цаст хайрхан уулын эзэн нь сэргэр хоёр эврээрээ дээд

тэнгэрийг сүлбэж, урд хоёр туурайгаараа газрын хөрсийг онгичсон, нүдээ улаанаар эргэлдүүлсэн их догшин сүрлэг цагаан бух унасан цагаан хувцастай, цайвар царайтай, догшдыг номхотгож, ядуусыг энэрсэн дөлгөөн харцтай, зүүн мутартаа эрдэнийн тавагтай, баруун мутартаа шар торгон хадаг намируулсан эмэгтэй хүн байдаг байна.

Өмнөговь аймгийн Хан богд сумын нутагт орших Ханбогд уулын эзнийг цагаан тэмээний урд бөхөнд аргалын хургатай хурганы уут өлгөсөн ногоон дээлтэй эмэгтэй байдаг гэж дүрслэн ярилцсаар иржээ. Зарим газрын эм савдагийг харилцан зөрүүтэй домоглож ирсэн байх юм. Төгрөг орчмын газар усны эзэн савдаг нь сайхан зүстэй эмэгтэй хүн бий гэж номлодог тухай докдор Ж.Цолоо тэмдэглэсэн бий. Гэтэл зарим судлаачид Төгрөгийн эзнийг царай муутай эрэгтэй маягийн хар авгай байсан гэж бичсэн нь энэ газрын эзний тухай ойлголт дүрслэл нь зөрчилтэй байсныг харуулах баримт юм.

Уул усны эм савдагийг

аргадаж тахих үзэл ард түмний дунд хүчтэй дэлгэрч байсан ба хэрэв тэдгээрт ёс бусаар харьцвал өвчин зовлон, өнчрөл хагацал учирна гэж үздэг байжээ.

Хан хөхийн нуруу хүүхэн савдагтай. Энэ хүүхэн савдаг бол Тагнын уулын эрэгтэй савдагтай улирал бүр, сар бүр уулзан учирдаг. Энэ үед уул усны нэр хэлэх, ууланд гарч элдэв үйлийг ажиглах, тэр тухайгаа хүнд хэлэх цээртэй ажээ.

Увс аймгийн Сагилын голын эхний Хан харгайн овоо нь хөх морь унасан, хөх дээлтэй эм хүн байдаг гэдэг. Улаанбаатарын ойролцоох Дээндийн Баянжаргалан овооны эзэн нь бас л эм савдаг байдаг гэнэ.

Захчин хүний тахиж ирсэн Улаанхайрхан уулын эзэн сэгсгэр үстэй охин савдаг байсан гэх ба тэр охиныг нь хагалбар имтэй гөрөөс болгон хувиргаж түүнийг нь мэдэлгүй буудсан анчин их өвдөж ядарсан мэтээр домоглодог.

Зарим нутгийн эзэн савдаг нь их төлөв эмэгтэй савдаг байх нь ажиглагдана. Эм савдаг олонтой учраас тэр газрын хүүхнүүд нь зүс царай сайтай

байдаг гэж үздэг ажээ. Тухайлбал баяд нутагт эм савдаг их олон байдаг гэнэ. Тиймээс тэдгээр савдаг нь эмэгтэйчүүдийг байнга ивээн гоо сайхны хишиг хүртээж байдаг гэж хэлэлцэж иржээ. Баяд хүүхнүүдийн ааш зан ээвэргүү, үс гээг сайхан, зүс царай өнгөтэй, нуруу өндөр, бие гоолиг, хар буюу хонин шар нүдтэй байдаг нь тэндэхийн эм савдагийн ивээл гэдэг байна.

Уул усны эзэн савдагийг ийнхүү бүсгүй хүнээр төлөөлүүлсэн нь эртний утгаараа Этүгэн эх лүгээ холбоотой, бас эхийн эрхт ёсны үлдэгдлийн илрэл гэж болно. Хожуу үеийн ойлголтоор бол шарын шашны холбоотой, онцолбол ногоон, цагаан дарь эхийн билэгдэл болно. Гэхдээ монгол ахуйд ойртуулсан нь илэрхий ажиглагдаж байна. Учир нь монгол морь, тэмээ, бух зэргийг хөлөглөсөн, монгол дээл өмссөн, хурганы ууттай зэргээр дүрсэлсэн нь бөөгийн ёсон, шарын шашны дүрслэлээс иргэний дүрслэл рүү шилжүүлсэн онцлогтой байна. Энэ бол монголчуудын ахуй байдалд идээшүүлсэн хэрэг юм.

4. Зарим уулын эзнийг номч

мэргэн хүнээр төлөөлүүлэн өгүүлсэн байдаг. Энэ тухай Чингэлтэй уулын эзнийг дурьдаж болно. Тэр нь сэнтийдээ заларсан өвгөн лам олон шавь нартаа ном айлдаж байгаагаар дүрслэгдсэн байна. Үүнийг сангийн сударт нилээд өөрчилж, дэлгэрэнгүй тайлбарласныг доор иш татъя. Их ой цэцэрлэгээр хүрээлүүлсэн гурван давхар орд харшийн дотор энэ орны эзэн Чингэлтэйн лагшин бие нь индранилийн өнгөтэй, буман нарны гэрэл авцалдсан мэт жавхлантай, гурван мэлмий төгөлдөр, зүрхэн тус газраа Бурхан багшийн зураглалыг тодруулсан, баруун мутартаа номын боть барьсан, зүүн мутартаа цагаан цэцэг барьсан, шавь хүүхдийг өвөр дээрээ тавьсан, оройдоо номын цагаан хүүдийн тоорцогтой, элбэг дэлбэг торгон навсыг асаасан, өлмийдөө ногоон саатай бойв гутал өмссөн... гэхчлэнгээр дүрслэж бичжээ.

5. Гол, мөрөн, нуур усны эзэн нь лус байх ба тэдгээрийн ихэнх нь уулын эзэн шиг тодорхой дүрслэгдээгүй байдаг. Төв аймгийн Баян төхөмийн нуурын сангийн сударт: Хур усны эзэн

Варуна. Их найман лус, Мапам далай болон төвд монголын лусын чуулган, онцолбол Баянтөхөмийн далайд оршсон Цогноймолтыг урьсан байдаг. Баядын Дэжээлэнгийн хүрээний савдаг нь салаа толгойтой могой байсан гэж үзэж иржээ. Энэ бүхнээс үзэхэд гол усны эзэд нь их төлөв Энэтхэг, Төвдийн нуур далай гол мөрний эзэн лус, ягчис байдаг.

6. Зарим овооны эзэн нь цэргийн ноён, баатар жанжнаар дүрслэгдсэн байдаг. Иймэрхүү эзэнтэй уул нь монголын хил хязгаарын уул байдаг нь гадны дайсны аюулаас авран хамгаалах билэгдлийн утгатай юм. Тухайлбал Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт байдаг Баяндулаан уулын эзэн нь Догшин цэргийн буман аймгийн цог бадарсан их цэргийн царай хөх, хар хөх морьтой, их эрдэнийн чимэгтэй, цусан улаан жад барьсан, эдийн тэвшийг зүүн мутартаа барьсан, алив дайсныг даран устгах олон дагуултай цэргийн ноён догшин тэнгэр буй гэж сударт өгүүлсэн нь байдаг.

7. Монголын олон тахилгат уул хайрханы эзэн савдаг нь

догшин бурхад байдаг нь шарын шашин дэлгэрснээс хойшхи үетэй холбогдох юм. Отгонтэнгэр уулын эзнийг Очирваань, Богд хан уулын эзнийг Дүнжингарав, Булганы Тэшиг сумын Сант хайрханы эзнийг Гомбо гэхчилэнгээр дүрслэж иржээ. Тэрчлэн Далх, Лхачинвандад, Говийн Лха эзэнтэй уул олон бий ажээ.

8. Монголын тахилгат уул усны эзэд савдагийн дагуул, бараа бологч, төрөл садан, баатар түшмэлүүд нь харилцан адилгүй байдаг. Дарьгангын Алтан овооны эзэн нь Далх тэнгэр юм. Гэтэл Алтан Овоо Хормуст тэнгэрийг төлөөлдөг бөгөөд хатан нь Ганга нуур, хоёр хүү нь Хонгор, Молцог элс, баатар түшмэл нь Баяндулаан, Лүн хайрхан, ах дүү, ураг садан, лам хуврага нь Гангын цагаан овоо, Шилийн богд, Дөш уул, Баянгол, Дагшин, Дуут нуур, Оргихын булаг, холд өргүүлсэн дүү нь Зотол хан, төрсөн дүү нь Баяндэлгэр сумын нутагт байдаг Дөхөмийн бор овоо гэдэг ажээ. Алтан овооны энгэрт байсан хийдийн бурхад нь Алтан овоог тойрсон уул усны нэртэй байсан

тухай алдарт ламтан агсан Инлай Лувсандагва гуай ярьдаг байсан билээ.

Түүнчлэн Өндөр хаан уулын эзэн Өндөр хаан нэртэй бөгөөд шадар түшмэл нь Баян уул, сөн түшигч нь Баян-Эрхэт, Хэрээ хөхөл уулыг хонх дамраа урдаа тавьсан лам нь гэдэг байна. Өндөрхааны бурхан нь Баянхутаг сумын нутагт орших Алдар уул гэдэг аж. Хэрээ хөхөл уулын энгэрт Богдын долоон цорж тасралтгүй мэндэлсэн гэдгээс энэ уулыг ихэд сүсэглэн тахидаг ажээ.

Энэ мэтээр газар ус, уул овоог өөр хоорондоо салшгүй холбоотой болгох ёс газар газарт байдаг байна. Энэ нь хэдийгээр шашны зан үйлтэй холбоотой боловч газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хадгалах гэсэн үзэл санааны илрэл юм.

9. Монголчууд уулаасаа хожуу үед нэг ууланд тогтсон нэг эзэн шүтээнтэй гэж тахиж байсан бол нэг ууланд хүний аж амьдралтай холбогдох маш арвин эзэн сахиус хамт оршиж байдаг гэж үзэх болжээ. Үүний нэг тодорхой баримт гэвэл Заваа Дамдины зохиосон Гүндсамбуу буюу Хан Хэнтийн сангийн

сударт тусгалаа олжээ. Тэнд:

Алины мутрын дүрс хөргөөс үйлдсэн нөхдийн эрхин Адууны тэнгэр, Хонины тэнгэр, Үхрийн тэнгэр, Эдийн тэнгэр
Аху сангийн эзэн, Эдийн эзэн, Хурын эзэн, Салхины эзэн
Арилагсан сансар, найман аймгийн чуулган энэ орноо ирэгтүн!

гэсэн буй.

Үүнээс үзэхэд овоо хайрханыг тахих үест олон эзэн сахиусыг урин залж тус тусаас нь эгээрэл хүслийг эрэлхийлэн, даатгал, соёрхол гуйдаг ажээ.

Энэ нь бас цааш нарийсч тухайн нэг уулыг зөвхөн “Адуу малын сахиуст уул”, “Ан гөрөөний сахиуст уул”, “Хонины сахиуст уул” гэх болсон байна. Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт орших Гичгэний овоог Хонины буян хишгийг дэлгэрүүлэгч Хонин сахиуст уул гэдэг бол бүр саяхан 1997 онд Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Хонгорхайрханыг тахихдаа “Морин сахиуст уул” хэмээн морины дүрстэй пайз босгожээ.

10. Уул усны эртний тахилга мөргөл нь нийгмийн хөгжлийн явцад бөөгийн мөргөлөөс шарын шашны агуулгаар өргөжин навдаг, савдаг эзэд нь өөрчлөгдөн “Хар шарын нийлэгжсэн” хэлбэртэй болсон юм.

Тухайлбал Богд уулын эзнийг гучин гурван саарал морь унасан, Дүнжингарав, ум аа хумын тахилгатай гэсэн байдаг. Гучин гурван саарал морь нь бөөгийн шашнаас үүдэлтэй, Дүнжингарав, ум аа хум нь шарын шашнаас гаралтай юм.

Сонгино хайрханы эзэн нь эртэн цагтаа луу байсан гэж домоглодог агаад уул нь тогтоц байдлаараа луугийн дүртэйгээс ийн хэлсэн болов уу гэлтэй. Гэтэл үүний дараагийн үеийн эзэн нь бов бор царайтай, хар хөмсөгтэй, битүү сахалтай, зовсон дүртэй өвгөн болж хувирчээ. Тэрхүү зовсон дүр нь юуг илэрхийлж байна вэ гэвэл тэр өвгөн урьд өмнө нь бөө байсан сүүлд нь шарын шашин лугаа тэрсэлдэн байж эцэст нь дагаар орсон гэж домоглодог. Гэтэл үүний дараачийн шатанд энэ дүр бүр өөрчлөгдсөн байх юм. Сонгино хайрханы нэгэн сангийн сударт

дурдсанаар бол уг уулын эзэн нь өмнө зүгийн огторгуйд их шуурган хар үүлсийн дунд хар өнгийн лагшинтай, маш хилэнт дүртэй, торгон молцогт зэр зэвсэгтэй, тод эрээн мод мутартаа барьсан, том хөх үхэр хөлөглөсөн байдлаар дүрсэлжээ. Энэ нь өмнө өгүүлсэн Лувсанпэрэнлэй-жамцын шинжин сонжин айлдсан дүрийн боловсруулсан хувилбар болно. Энэ мэтээр уул овооны эзэн савдаг нь нийгмийн хөгжил, төр шашны солигдлын үр дагавар болж өөрчлөгдсөөр иржээ. Даян дээрхийн дуудлагад:

Наян тохой биетэй
Наян найман шарга хөлөгтэй
Хан богд Даяндээрх хайрхан
минь
Дайчин улаан баатартай
Дарь эх Осоржамаа
бурхантай
Далхвандад сахиулстай
Даяндээрх гэнин чинбо
хайрхан минь... гэжээ.

Үүнээс үзэхүл бөөгийн шүтлэгт энэ газрыг шарын шашныхан өөрийн тогтолцооны дагуу эзэн савдагтай болгосон байна.

Уул усны эзэн савдгийг ийнхүү судар бичигт дүрслэн бичээд зогсоогүй бас ард түмэн амаар дамжуулан домоглож ирснээ мод чулуугаар урлах буюу цааснаа зурж тухайн газарт нь залж байжээ. Даяндээрхийн сахиулсныг монгол малгайтай, дүүрэн сумтай саадаг зүүсэн морьт баатар маягаар зуржээ. Мөн Богдхан уул, Сонгино хайрхан, Дарьгангын Алтан овоо, Баянхонгорын Хонгорхайрхан зэрэг олон уул овооны уламжлагдан ирсэн зураг хөрөг гэрчилнэ.

Энэ мэтээр тахилгат уул усны эзнийг амаар домоглож, судраар зураглан ирсэн нь цаанаа нарийн учир жанцантай байна. Шарын шашны үзлээр усны навдаг, савдаг, лусыг аргадан наминчилж, хувь заяагаа даатгаж иржээ. Үүнд нь уул усны эзэн баясч, бороо хураа буулгаж, жилийн сайн үрийг бүтээж өгдөг гэж үзнэ.

Хэрэв лус савдагийг эс аргалваас хор хөнөөл хүргэдэг гэнэ. Хад чулуу, мод бут уруу ч хамаагүй шээж болохгүй тухай аман домог хууч яриа ч элбэг бий. Нэгэн жишээ эш татъя. Сэлэнгэд

нэг өвгөн хятад тариачин байж. Хөдөө явж байгаад эхнэр хүний мээм шиг өө мөөгүй сайхан чулуун дээр шээчихжээ. Яах ч гэж энэ хөөрхөн хадан дээр шээчихэв дээ гэж жаахан гэмшсэн гэнэ. Гэтэл шөнө зүүдэнд нь нэг залуу бүсгүй орж ирээд янаглаад байж. Шөнө болгон шүү. Нэг сар өнгөрөхөд өнөөх хятад өлбийсөн цагаан өвгөн болжээ. Нэг удганаас асуусанд “Цагаан лусад бузар оруулсан байна. Тэр газраа очиж сан тавьж, тахил өргө” гэжээ. Өвгөн нөгөө цагаан хадаа эрээд эрээд олсонгүй, өлбийн ядарсаар байгаад үхсэн гэнэ. Лус савдагийн хорлол болсон гэх иймэрхүү хууч, домог элбэг байдаг нь алив нэгэн сонин учралаас үүдэлтэй бөгөөд угтаа газар усаа төдийгүй хад бутгаа ч бузарлахгүй гэсэн үзэл санааны илрэл юм.

Гэтэл зарим нутаг усны эзэн савдаг нь хүнд үзэгдвээс хор хүргэх нь байтугай хойчийн заяанд нь тус хүргэдэг ажээ. Баянхонгорын Орог нуурын эзэн нь хар ногоон зүсний усан тэлмэн жороо морьтой ногоон торгон дээлтэй, нүүрнээсээ ногоон гэрэл цацруулсан үзэсгэлэнт бүсгүй

байдаг тухай домогт өгүүлжээ. Эгэл хүнд энэ нь барагтайд харагдахгүй. Эр хүн үзвээс эхнэрийн сайныг хайрладаг, эм хүнтэй учирваас эрийн сайныг заяадаг гэж билэгшээн ирсэн буй.

Уул усны эзэн савдаг нь нүднээ үл үзэгдэх хий махбод гэх боловч монголчууд түүнд бат итгэн бүр үзсэн харсан хэмээн баримтжуулан ярих нь элбэг аж.

Хэнтийн Дадал сумын уугуул нутгийнхан нь хар морь унасан, хар нөмрөг дэрвүүлсэн, хар малгайтай, мөрөн дээрээ хар хэрээ суулгасан хар хүн байдаг гэлцдэг. Түүнийг Жамбал гэгч хүн одоогоос хориод жилийн өмнө үзжээ. Сандарсан тэрээр Түнхлэг горхины голын гарамгүй газраар давхин ортол морь нь бусгаад хаячихжээ. Жамбал сандран сэлж явтал яг урдаас нь усан дотроос үстэй хар гар гарч ирэн үсдэн авч ус уруу даржээ. Хойт дэнжийн айлууд усанд сарвалзан живж буй хүнийг уснаас гаргасанд Жамбал байж. Нутагтаа сайн усчин тэр хүн ийнхүү савдагт дайруулснаар хэлгүй болсон гэдэг.

Дадал уулын эзэн

савдагтай учирсан таарсан гэх хүн цөөнгүй боловч тэдгээр хүн их төлөв золгүй учралд хүрдэг байсан гэнэ.

Бас зарим уулын эзэн савдаг нь хүн амьтанд хор хөнөөл хүргэдэггүй ямагт хүн амьтныг ивээлдээ багтаан уул усаа ган зудгүй болгодог увдистай байдаг аж.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутаг дахь хар морь хөлөглөсөн, хар дээл өмссөн, хар сахалтай, эргэлдсэн хар хөмсөгтэй, ид хавтай хар хүний дүртэй савдаг нь тахилгат ууланд их цас орвол уулынхаа биед шингэн, цасыг нь шилгээдэг увдистай гэнэ. Тиймээс энд бараг зуд болдоггүй байна. Уг нь энэ уулын байгалийн тогтоц нь цас ордоггүй, оровч алга болдог онцлогтой бөгөөд түүнийг нь эзэн савдгийн шилгээлттэй холбон тайлбарласан нь сонирхолтой байна. Уул усны эзэн савдагийг аргадаж тахиx, ном уншлага үйлдэх нь нутаг нутагт ерөнхийдөө ойролцоо байдаг авч зарим нутагт их өвөрмөц онцлогтой байдаг нь судлууштай зүйлийн нэг болно. Булган аймгийн Гурванбулаг сумын

нутаг дахь Хөгнө хан уулын эзэн нь буруу талын хойт хөл нь өсгий цагаан, сартай хар морь унасан их догшин Түдэвванчиг хэмээгч гэнэ.

Уг уулын сангийн судрын уншлагын ая данг шилүүсний харайлт маягаар уншдаг тухай эрдэмт ламтан Ш.Сонинбаяр ярьж байна. Энэ нь уг уулын эзний унасан хүлгийн явдал нь шилүүсний харайлт лугаа адил гэж үзсэнтэй холбоотой биз. Эцэст нь нэг зүйл тэмдэглэхэд газар усны эзэн савдагийг номхотгоход тустай зан үйл үйлдэж, ном судар уншиж ирсэн нь ерөнхийдөө ойролцоо байна. Гэвч зарим нутагт эзэн савдагтай догшин ширүүн харьцаж, гэсгээл шийтгэл үзүүлэн номхотгодог явдал байжээ.

Сайн ноён хан Намнансүрэнгийн эцэг засаг ноён Төгс-Очир нэг удаа одоогийн Өвөрхангай аймгийн Хайрхандулаан, Нарийнтээл хоёр сумын заагт орших Шар тээг гэдэг газрын савдагийг номхотгосон гэдэг хууч яриа бий.

Тэр ноёны бөх Мөнхжаргал шуурганд уруудсан мал эрж яваад тэр ууланд нас барсанд ноён харуусан хилэгнэж:

“Алгын чинээ хүүг ардаа халхалж, өвөртөө нөмөрлөөд байж чадахгүй, хүний аминд хүрсэн яасан догшин савдаг вэ” гээд Шар тээгийг нэг зуун хорин удаа шаахайдуулсан гэдэг. Шар тээгийн савдгийг номхотгосноос хойш тэр газрыг Шаахайн тээг гэж нэрлэх болсон байна. Газар усны лус савдгийг аяарлан аргадах бус хүчээр номхотгох энэ ёс төдий л элбэг бус юм.

Монголын тахилгат уул усны савдаг, навдаг нь монголчуудын байгаль усаа хайрлах, хүрээлэн байгаа орчноо дархлах, энэ бүхнийг зөрчвөөс эзэн сахиус нь хилэгнэх учиртай гэсэн түүх шашдирт бичигдээгүй ардын зан үйлийн уламжлалаас эх үүсвэртэй уран дүр шүтээн болох нь тодорхой байна. Нөгөө талаар монголчууд эзэнгүй хад чулуу, мод бут, газар ус байхгүй, цөм эзэнтэй, тэдгээр эздийг нь тахиж, аргадаж байх ёстой гэсэн шашин, ардын зан үйлийн хуулийг бий болгожээ.

**Монголын зарим
тахилгат уул усны нэрийн
онцлог**

Биднийг хүрээлэн байгаа

байгаль орчин бол сав шимийн ертөнцийн үй түмэн юмс үзэгдлийн нийлбэр, хүний амьдарч оршихуйн нөхцөл, төрөлх өлгий билээ.

Монголчууд байгаль орчинтойгоо нэн эртнээс эхлэн ухаалгаар харьцаж, унаган төрхөөр нь байлгаж ирсэн нь соёл иргэншлийн нь нэг онцлог юм. Өөрөөр хэлбэл байгаль дэлхийгээ шүтэн биширч, нутаг ус, ургамал амьтан, онгон байгалиа ердийн болон онолын ухамсрын түвшинд танин мэдэж ухаалгаар харьцах харьцааны сайхан уламжлалыг бий болгосон юм. Үүний нэг тод илрэл нь хад бут, хөтөл гүвээ, нуур цөөрөм, уул хайрханаа онголон тахиж ирсэн явдал юм. Монголчуудын тахиж ирсэн газар усны тоо бидний бүртгэснээр 800 орчим байгааг баттай хэлж болно. Эдгээрийн ихэнх нь сан тахилгын судартай байснаас миний бие сүүлийн хэдэн жилд 280-аадыг нь цуглуулсан билээ. Сан тахилгын судруудыг үзэхэд монголчууд уул ус бүхнийг эзэнтэй, лус савдагтай гэж үздэг нь тодорхой мэдэгдэх бөгөөд уул усны лус савдгийн дүр төрхийг уран яруугаар дүрслэн

үзүүлсэн байдаг. Тэгэхдээ аль тааралдсан уул ус болгоныг тахьдаггүй, газар зүйн байрлал, хэлбэр тогтоц, домог яриа, түүхэн уламжлал, эртний ёс заншлын улбаа зэргийг харгалзан тодорхой уул усыг тахиж иржээ. “Уул усны тахилга” гэдэг нь идээ цонхор, айраг сүү, архи дарсаа тэнгэр хайрхандаа өргөн уншлага номыг нь уншин тогтсон зан үйлийг нь явуулах ёслолын үйл ажиллагаа юм. Тэгэхдээ нутаг нутгийн тахилга харилцан адилгүй, бас орон цагийн өвөрмөц нөхцөлөөс үүсэн бий болгосон содон тахилга, аргаар үйлддэг байжээ.

Орхонд түшээ гүн цол хайрласнаас хойш Улаан-цутгаланд жил бүр 20 лангийн ембүү өргөдөг байсан бол Тэрхийн цагаан нуурыг тахиж ёслолоор жил бүр хошууны айлууд ээлжлэн 50 лангийн мөнгөн ембүүг сарлагаа уулнаас хураадаг суран дүүгүүрээр дүүгүүрдэн өргөдөг байжээ. Энэ нь нуурынхаа усны гүн рүү, бас нуурын дундах Чандмань толгойнхоо ойр өргөх зорилгыг агуулсан байжээ.

Тахилгатай уул нь тал

нутагт бол орчиндоо өндөр, содон сүрлэг уул байдаг бол уулархаг нутагт уулын салбар уул овоо байдаг. Нэг уулыг олон сум тахидаг байхад нэг сум олон уул тахиж явдал бий гэж газар зүйч эрдэмтэн Ш.Шагдар тэмдэглээд жишээ болгож Баянхонгорын Их богд уулын ар өврөөр нутагладаг сумд өөр өөрсдийн талын салбар уулс овоог тахиад Их богд уулаа тахилаа гэдэг нь зөв болох тухай бичсэн бий.

Уул усыг тахиж гол зорилго нь газар усныхаа лус савдаг эздийг баясгаж, тэднээс нутаг хошуу, айл аймаг, гэр бүл, мал сүрэгтээ буян хишиг, аврал хайрлал гуйж буй хэрэг юм. Нөгөө нэг утгаар нь үзвэл газар усаа онголон дархлах зан үйлийн болон хүндэтгэл бишрэлийн дээд илэрхийлэл юм.

Монголын тахилгат уул усыг их тахилгатай, бага тахилгатай, байнгын шүтлэгтэй гэж хувааж болно. Тахилгын хэмжээгээр нь олон даяар тахиж, өрх гэрээр тахиж зэргийн ялгаатай. Бас нийгмийн анги давхаргын ялгаатай тахиж ирсэн байдаг. Тухайлбал, Хүрээ дөрвөн уул болох Чингэлтэй хайрханыг

номч лам нар, Баянзүрхийг худалдаачид, Сонгинохайрханыг цэргийнхэн, Богд хан уулыг засаг ноёд тахиж ирсэн байдаг.

Монголчууд тэнгэрийг эцэг, дэлхийг эх гэж шүтэж байсан нь их эртний уламжлалтай. Эртний тахилгат уул Отгон-тэнгэрийн нэрд орж яваа Отгон нь эртний Этүгэн гэдэг нэрийн хувирсан хэлбэр юм. Ер тэнгэрийн эзнийг хурмаст, хурмастын элчийг Луу, усны эзнийг Лус, уулын эзнийг Савдаг, Навдаг, Шивдаг гэхчлэнгээр нэрлэж заншжээ.

Монголын зарим тахилгат уул усны нэрийн гарал, нэр өгч байгаа ёс хувьсан өөрчлөгдөж ирсэн шалтгааныг авч үзэхийн өмнө зарим өргөмж нэрийн тухай товчхон өгүүлье.

Хан буюу Хаан зэрэг өргөмж нэрийг уул хайрханд өгсөн нь нэн олон тохиолдоно. Үүнд: Хан уул, Хөгнөхан, Хан Хэнтий, Өндөрхан ... зэрэг олон нэрийг дурдаж болно.

Богд нэрийг Ханбогд, Ихбогд, Ажбогд, Цастбогд гэхчлэн олон тооны оноосон нэрд өргөмж болгон хэрэглэж иржээ.

Иймэрхүү цол зэргэмжийн

нэрийн нилээд нь энэтхэг, төвдөөс уламжлалтай юм. Монголд хаад ноёд, хутагт хувилгаадаа Чакраварди (Хүрдэн орчуулагч), Очирваанийн хувилгаан, Манзуширийн хувилгаан, Нарбачин, Егүзэр хутагт буюу элдэв бодьсадвын нэрээр өргөмжлөх ёс ихэд дэлгэрч байжээ. 1911 онд Богдыг хаанаар өргөмжлөхдөө Олноо өргөгдсөн хаан (Махасамади) цол хүртээсэн байх жишээтэй. Энэ тухай академич Ш.Бира цохон тэмдэглэсэн юм.

Яг үүнтэй нэгэн адилаар монголчууд газар усандаа өргөмж нэр хайрлаж байсныг Очирваань (Отгонтэнгэр), Богд хан (Хан уул), Гүндсамбуу (Хэнтий хан), Зайсан толгой, Орхон түшээ гүн, Богд ханы Цэцээ гүн, Түшээ гүн зэрэг цөөн бус нэр бэлээхэн гэрчилж байна.

Газар усандаа хүртэл цол хэргэм өгдөг улс орон дэлхийд нэн ховор биз. Хайрхан тэнгэрийн нэрийг уул овоонд өгснийг Бүрэнхайрхан, Бүс хайрхан, Зорголхайрхан, Суврагахайрхан зэрэг олон нэрээс мэдэж болно. Чингэхэд бас оноосон нэрийг нь цээрлэн

зөвхөн Хайрхан гэж нэрлэх нь элбэг буй.

Зарим тахилгат уулын нэрийн ард Сарьдаг хэмээх дагалдуулсан нь Хөвсгөл, Хэнтий зүгийн уулсын нэрд олонтаа тааралдана. Орчин цагийн Монгол хэлэнд “Мөнх цастай уул, уул хөвчийн өндөр оргил” (3,472 м) гэсэн утгатай сарьдаг хэмээх нэр нь түрэг хэлний сарыг (шар, цагаан), таг (уул) гэсэн хоёр үгийн нийлэмжээс бүтсэн аж. Эхний үгийн эцсийн г гээгдэн улмаар зөөлөрсөн гийгүүлэгчийн дараа орсон т нь д болж өөрчлөгджээ.

Орчин цагийн монгол хэлнээ сариг гэсэн үг нь Сарьдаг гэсэн утгаар хэрэгдэгдсээр байгаа төдийгүй бас оноосон нэрийн үүргээр дайралддагийг Дундговийн Сариг хайрханаар жишээлж болно. Монгол аман зохиолд гардаг Сариг цагаан ингэний сариг нь энэ үг мөн гэж бодож байна.

Тахилгатай уул даваа бүхэн овоотой байдгаас Өлийн овоо, Сангийн далайн овоо, Биндэр овоо, Алтан овоо гэх мэтээр овоо нэрийг дагуулж нэрлэсэн нь элбэг байна. Овоо

гэдэг нь угтаа уул хайрханы орой болон ус булаг тэргүүтний эхэнд мод, чулуу, шороо овоолж босгосны нэр боловч бас уул, толгой гэсэн утгаар хэрэглэгдэх нь бий.

Бөө мөргөлийн шашин хүчтэй хөгжиж байсан үед уул хайрханыг Хан, ус голыг Хатан гэж нэрлэж байсан бол шарын шашин дэлгэрснээс хойш Богд, Хайрхан нэрийг уулын нэрд дагуулах ёс дэлгэрчээ. Тэрчлэн Ноён уул, Онон хатан, Ээж хайрхан, Ээж мод, Хүү уул, Их ах, Бага ах, Дунд ах, Буурал ах, Ноён хангай, Хатан хангай гэхчилэн-гээр ноён, хатан, эцэг, эх, хүү зэрэг нэрээр нэрлэсэн хад мод уул, ус цөөнгүй буй. Эртний шүтлэгт Ханд хад (Төв, Сэргэлэн) нь газрын зурагт энэ нэрээр орсон ба Дагина хад гэсэн утгатай төвд үг болно. Гэтэл нутгийнхан Ханд хад гэж хэзээ ч хэлдэггүй, “Ээж хад” буюу “Авгай” хад гэдэг болсноор уугуул нэр нь мартагдах болсон байна.

Нүүдэлчин удамтай монголчууд бид онгон дархан уул усны нэрээ байнга хэрэглэж, үеэс үе дамжуулан ирсэн

бөгөөтөл тэдгээрийн нэрийн үүх түүх, утга гарал, хувьсан өөрчлөгдөж ирсэн зүй тогтлыг төдий л анхаарч судлаагүй байна. Энэ бүхнийг тодруулах нь эрт эдүгээгийн монгол хэлний нэрлэх чанар, хэлний соёлын уламжлал, залгамжлалын онцлог болон утгазүй судлалд чухал ач холбогдолтой юм.

Суурин иргэншилтэй бусад улс оронтой харьцуулахад монголчуудын нүүдлийн соёл иргэншил нь газар усны нэрийг өөрчлөх үндсэн шалтгаан болж байсны зэрэгцээ дагалдах бусад шалтгаанаас нөлөөлсөн байна. Монголын газар усны хуучин нэрс мартагдах буюу сунжрах шалтгаан нь тэнд болсон түүхэн явдал, тэндэхийн оршин суугчид нь зайлан одох, нүүн ирэх явдалтай нягт холбоотой байсныг эрдэмтэн Х.Пэрлээ агсан хэдэн жишээгээр тодорхойлсон буй.

Үүнд: Монгол оронд феодализм хүчтэй дэлгэрч, нутгийн эзэн ноён буюу хувилгаан лам нараас газар усны нэрийг сольж байсан нь үлэмж. Эртний Дэлүүн болдог, Балжун арал хоёрын ойр оршдог Шурагтай буюу Шурагзай хан уулыг Угтамын хийдийн

хувилгаан лам миний төрсөн нутаг гэж Баянхаан уул болгожээ. Хоёрт. Онон голын солгой этгээдэд байдаг Хонзоосон талыг тэнд хожим нүүж ирсэн хамнигад Их тал гэж нэрлэжээ. Гуравт, монголчууд эрт цагаас газар усны нэрийг цээрлэж байснаар жинхэнэ нэрийг мартсан байдаг. Хэнтий уулын баруун зэргэмжээд орших Их газрын давааг цээрлэж, одоо Богд (Чингис Богд)-ын даваа гэж нэрлэдэг болоод байна” гэж онцлон тэмдэглэсэн байна.

Энэ мэтийн тодорхой шалтгааны улмаас газар усны нэр өөрчлөгдсөн нь маргашгүй үнэн болно. Ялангуяа тахилгат газар усны сангийн судар олноор зохиогдох болсонтой холбогдоод хуучин нэр нилээд хэмжээгээр өөрчлөгдсөн болно. Иймд бид сангийн судрын эх хэрэглэгдэхүүн болгосноо дурдсу.

Тухайн судрыг зохиолгосон хүний хүсэлт, эсвэл зохиогчийн үзэл бодол, газар шинжээчийн өгсөн нэрээр уугуул нэрийг солин бичсэн нь хүндэтгэл, цээрлэл, шүтлэг бишрэл, билэг дэмбэрлийн зэрэг олон шалтгаанаас үүдсэн байна.

Иймээс зарим газар усны нэр, түүхэн уламжлалт нэр гэсэн хэд хэдэн нэртэй болсон буй. Бас нутаг хошууны ноёд язгууртнууд өөрийн харъяаны нутгийн зах заагийн гол овоо, уул усанд нэр өгч байсан тохиолдол ч байжээ.

Отгонтэнгэрийн дараа орох мөнх цаст нэгэн сөнөсөн галт уулыг хуучин цагт Очирхайрхан гэж нэрлэж байсныг хожуу үед сангийн судар зохиох үест Халзан бүргэдтэй гэсэн нь энэ нэрээр алдаршжээ. Тэрчлэн Хорхойт толгой нэртэй нэгэн уулыг Заяын гэгээн муухай нэр гээд Эрдэнэ уул (Архангай, Эрдэнэмандал) гэж нэрлэсэн байна.

Дундговийн Цагаандэлгэр сумын нутаг нь Боржигины нутаг бөгөөд VIII Богд өөрийн нутаг гэж зарласан удаатай гэнэ. Хошуу ноён Гомбосүрэн (цээр нэр нь Омбонүрэн) Ухаа овоо хэмээх газрыг зааж нэр хайрлаач гэж Богдоос хүсчээ. Боржигины энэ уул хонины буян хишигтэй, хонь үржих өлзийтэй сайн газар юм байна гэж шинжээд хонины идэх дуртай ургамлаар Гичгэнэ уул гэсэн нэр хайрласнаар одоо болтол энэ нэрээр нэрлэгдсээр

байгаа ажээ.

Тахилгат уулын нэрийг цээрлэн нэрлэж ирсэн нэг онцлог нь төвд нэр өгөх буюу монгол нэрийг төвдөөр орчуулж байсан явдал юм. Энэ нь нутгийнхны дунд төдийлөн дэлгэрээгүй, гагцхүү лам нарын хүрээгээр хязгаарлагдмал байжээ. Ийм нэрс нь зөвхөн тухай тухайн уулын сангийн судраар дамжин ирсэн буй. Тухайлбал, Их угтаал (Дундговь) уулыг Он бо чин по ри (Их хөх уул), Суварга хайрхан (Архангай)–ыг Чэ ри гар ри (Их цагаан уул), Хэнтий ханыг Гүндсамбуу (Хотолд сайн), Есөн зүйл (Өвөрхангай) уулыг Ролган хайрхан (Бүрэнцэнгэл), Зотолханыг (Сүхбаатар) Сэвжидбалбар (Сүр жавхлант цогбадрах), Тооно (Хэнтий) уулыг Дашбалбар гэхчлэнгээр нэрлэсэн бол Тогос (Төв, Эрдэнэ) уулыг Мажаа гэж орчуулсан байна. Оцол уулын нэр нь дээхэн үедээ Ац уул нэртэй байсан бөгөөд үнэхээр ац хэлбэрийн хоёр уул байдаг билээ. Ац уул нэр нь хэлэхүйн урсгалд хувьсан өөрчлөгдөж Оцол болсон байхад сангийн сударт төвд хэлний үг болгон билэгшээж *od gsal* (од сал-

”Тэгээн гэрэлт) болгосон байна. Түүнчлэн Сансар уулын нэр нь сангийн сударт *seng ser* (Шар арслан) буюу Сэнсэр гэж тэмдэглэгдсэн байх ба судрыг зохиогч уг уулыг хэвтэж буй арслангийн хэлбэртэй гэж шинжснээс ийн нэрлэсэн ажээ.

Монголын газар усны нэрийг Монгол, Түрэг хоёр хэлний үгээс бүтсэн, гэхдээ монгол үг нь голлодог гэж эрдэмтэд үзсээр иржээ. Нэр зүйч эрдэмтэн В.А.Жучкевич: “Түрэг гаралтай цөөвтөр нэрийг эс тооцвол монголын газар усны нэр ганц хэлний үгээс бүрэлдсэн” гэж бичсэн байна. Монгол газар усны нэрийн бүрэлдэхүүнд монгол нэр зонхилдог нь үнэн боловч төвд, самгарди гаралтай нэр түрэг хэлнийхээс дутахааргүй олон буйг бидний гарт байгаа хэрэглэгдэхүүн гэрчилнэ. Зөвхөн тахилгат уул усны нэр гэхэд л Зотол, Матад, Дашбалбар, Ловон, Гэлэн, Самбалхүндэв, Цамбагарав, Дашдэрчин, Сэвжидгацал, Ажбогд, Бумбат, Агархайрхан уул, Ринченжүгнээ, Гандан, Ганга нуур гэхчлэнгээр билэг дэмбэрлийн үүднээс өгсөн олон нэрийг дурдаж болно.

Уулаас монгол нэртэй байсныг ийнхүү төвд нэртэй болгон өөрчилсөн нь санамсаргүй тохиолдлын зүйл биш болох нь дээрх баримтуудаас тодорхой байна. Ийм маягаар өгсөн зарим нэр бүрмөсөн мартагдаж, утга гарал нь мэдэгдэхээ больсон байдаг. Энэ тухай нэгэн мэдээг академич Ц.Дамдинсүрэн тэмдэглэхдээ “Дэлгэрхангай уулын хуучин нэр бол Инэл хаан буюу Инээл хаан гэж Дорж мэйрэн ярьсан юм” гээд энэ нэрийн учрыг олох гэж ихэд сонирхсон боловч тайлж чадаагүйгээ бичсэн нь бий.

Өнөөдөр бидний гарт олдоод байгаа зарим газар усны сангийн судрыг үзэхэд чухам хаанахын ямар газар болох нь мэдэгдэхгүй байна. Жишээлбэл, Баянхонгороос олдсон Ми тонг ри (*mi gtong ri*) уулын сангийн сударт буй энэ нэрийг орчуулбал “Хүмүний нигурын уул” гэсэн утгатай ч энэ уул хаа байгаа, одоо ямар нэртэй зэрэг нь огт мэдэгдэхгүй байна.

XVI зууны үеэс Монголд шарын шашин дэлгэрснээс шашны зан үйлийн дагуу нутаг усаа эрхэмлэх болж, зарим газарт

шашны онцлог зан үйл явуулж байснаас тэр зан үйлээр нь тухайн газрыг нэрлэх явдал байсан байна. Төв аймгийн Батсүмбэрийн нутаг Хүйн долоон худгийн дэргэдэх бяцхан толгойд анх VIII Богдын үеэс Долоон хошуу даншиг наадам хийж мандал өргөх ёслол хийдэг болсноос хойш Мандал овоо гэх болсон байна. Үүнтэй адил нэг жишээг дурдвал Улаанбаатарын Тасганы овоо нь угтаа Заан хошуу нэртэй байсан бөгөөд хэвтэж буй зааны дэвссэн хушуутай адилтган өгсөн нэр болно. Заан догшин хэмээн номхотгох үүднээс хошууны үзүүр бэл нь Гэсэр сүмийг байгуулж, лам нар овоог нь тахиж тасга хэмээх шашны зан үйл явуулдаг болсноос хойш Тасга буюу Тасганы овоо гэх болжээ.

Энэхүү Тасга буюу Тасган нэрийг зарим судлаачид “Энэ нэр бол түрэг угсааны аймгууд VII зууны үед Хүн чулуутын хөндийд нутаглах болсонтой холбоотой. Эртний түрэг хэлний Таскыл буюу Нүцгэн толгой гэсэн утгатай энэ нэр хожим монгол хэлэнд дуудлага сунжран Таскын-Тасган-Дасган болсон түүхтэй”

гэж бичжээ. Энэ бол илэрхий ташаарсан хэрэг гэдгийг эрхбиш цохон тэмдэглэлтэй. Түүхэн үйл явдал бүхэн нь тухайн газартайгаа холбоотой байж газрын нэрд тусгалаа үлдээсэн байдгийг үгүйсгэхгүй. Гэхдээ газарзүйн түүхэн нэрс нь түүхэн үйл явдлуудын үе бүрд үүсч эдгээрийн олонхи нь цаг хугацааны урсгалд олон шалтгаанаас болж шинэчлэгдэх, өөрчлөгдөх, хувирах зэргээр хэд дахин солигдсон байхад зарим цөөхөн газар зүйн нэрс нь хэвээрээ байдаг онцлогтой ажээ.

Гэхдээ түүхэн үйл явдалтай холбоотой юу, үгүй юу гэдгийг судлахад олон баримт хэрэгтэй болдог. Энэ асуудалтай холбогдуулан Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт байдаг Бүрэгхангай хэмээх уулын нэрийн талаар эрдэмтэн судлаачдын дэвшүүлсэн саналыг авч үзье.

Манай нэрт солонгос судлагч, доктор Б.Сумъяабаатар “Хятан гүрнийг үндэслэгчийн сурвалж бичигт Абаоцзы хэмээсэн байдаг бөгөөд энэхүү Абаоцзыг оршуулсан газрыг “Му-е-шань” гэдэг бөгөөд “шань” гэдэг нь уул, уул нуруу

гэсэн утгатай. “м” ба “б” авиа олон хэлнээ харилцан сэлгэдэг, тохирдог авианууд тул “Му-е” нь “Бүрэг” (хангай) байж болох юм” гэж Киданы (X-XII) үетэй холбож тэмдэглэжээ. Мөн эртний Хэрэйд аймгийн тэргүүний цол болох Түрэг гарлын *bujuquq*, *bujuq* (захирагч) гэсэн үг хувирч Буюруг-Буруг-Бүрэг (хангай) болсон гэсэн санал ч бас байдаг.

Монголчууд нутаг усандаа хүндэтгэл үзүүлж цол зэргэмжийн нэр хайрлаж ирсэн баримт буйг өмнө нэгэнтээ өгүүлсэн билээ. Тэгэхдээ Бүрэг гэдэг нэр нь Буюругаас ч юм уу эсвэл Му-е-шань-аас ч юм уу үүссэн эсэхийг нарийн нягтлах хэрэгтэй юм.

Миний бие энэ нэрийн талаар өөр нэг саналыг дэвшүүлж байна. Бүрэгхангай сумын нутагт Ихдулаан, Баянхангай, Бичигтийн гурван гозгор, Загцаг уул, Шувуут уул зэрэг хэд хэдэн тахилгат уул байдгаас хамгийн эртний бөгөөд гол тахилгат уул нь Бүрэг (хангай) уул юм. Оройд нь үүл манан хөшиглөн бүрэг бараг харагддагаас бүдэг бүрэг гэсэн утгаар нэрлэсэн байж болох талтай. Гэвч Бүрэгхангай уулын төвд хэлээр байгаа сангийн

сударт энэ уулыг Брүг хангай (*brug hang kas*) гэж тэмдэглэсэн нь нэн шинэ баримт болж байна. Энэ Брүг гэсэн үг нь Луу гэсэн утгатай төвд үг болно. Монголчууд уул усаа шинжихдээ дөрвөн хүчтэн болоод өөр бусад ан амьтантай адилтган тайлбарлаж ирсэн нь газар усны магтаал, газар шинжихүйн сударт тодорхой туссан байдаг. Мөн тухайн нутагт ямар ан амьтан оршдоогоор нь тэр амьтны нь нэрээр уг газрыг нэрлэдэг байжээ. Уул хангайг Барс, Ирвэс, Чоно, Булга, Буга, Согоо, Зоргол, Хандгай, Үнэг зэрэг амьтны төвд монгол нэрээр нэрлэсэн тохиол олон бий.

Сэврээ (Өмнөговь) уулын нэр нь төвд хэлний *gzig ri* буюу “Ирвэст уул” гэсэн утгатай. Завхан голыг хөвөөлөн, алсаас сүндэрлэх Сар хайрхан хэмээх тахилгат хар уулын нэр бол зэлүүд хээрт оготно, хулгана отон суугаа Сар шувуутай адил хэлбэртэйгээс үүдэлтэй болно.

Өмнө өгүүлсэн Сансар уулын нэрийг Сэнсэр болгосон нь үүн лүүгээ адил жишгийн нэрлэлт юм. Тэгвэл Бүрэг уулын оройд үүл манан хөшиглөн байдгаас луу байдаг гэсэн төсөөллөөр ч юм уу

эсвэл луугийн хэлбэртэй атрилдан сунаж тогтсон байц байдлаар нь ч юм уу, дөрвөн хүчтэний нэгээр билэгдэл болгон нэрлэсний аль нь ч байж болох юм. Монголчуудын газар шинжихүйн ёсоор бол атираатай үргэлжилсэн уул нурууг луугийн шинжтэй гэдэг.

Нутгийнхны дунд энэ уулыг луутай холбосон домог ч бий. Эрт цагт тэнгэрээс нэг луу бууж ирж, ард олонд аймшигтай гай гамшиг тарьжээ. Үлэмж хүчтэй нэгэн баатар эр тэр луутай ноцолдож, цусыг нь урсган, ясыг нь цувруулан сөнөөгөөд урагш нь шидчихсэн гэнэ. Шидэгдсэн луу хад чулуун уул болон тогтсон нь Бүрэг уул болсон, цус урсгасан газрыг нь Цуст, яс цувруулсан газрыг нь Яст гэх болсон гэнэ. Энэ хоёр газар нь Бүрэгхангай уулаас холгүй оршдог ажээ.

Өөр нэг сонин зүйл гэвэл энэ зууны эхээр бүтээсэн Гүн Дашдэмбэрэлийн нутгийн зураг бүхий газрын нэрийг төвд үсгээр үгчилж тэмдэглэсний дотор бидний ярьж буй Бүрэг уулыг Вгуг (луу) гэсэн төвд үсгээр бичжээ.

“Гэсэрийн тууж”-д Брүг

луу гэсэн нэр гардаг нь сүм хийдийн дээвэрт урласан нэг зүйл гөрөөсийг хэлсэн байдаг.

Нэгэн үеийн хошууны нэрийг тухайн нутгийн хамгийн алдартай уул усаар нэрлэдэг уламжлал ёсоор Бүрэг уулын нэртэй Сазинбүрэг уулын хошуу гэж байсан нь түүхийн баримтад үлджээ.

Дүгнэвэл Бүрэгхангай уул нь “Луут хангай уул” гэсэн нэр байж болох юм. Дашрамд тэмдэглэхэд Монголын нууц товчоонд гардаг Эриг Бүрэг буюу Бүрэг Эрэг нь бүрэг бараг гэсэн утгатай байж болзошгүй. Хэрлэнгийн эхэн урсгалын баруун биед орших Эриг Бүрэг хэмээх хорь шахам метр өндөр эгц цавчим эрэг нь үнэхээр бүрэнхий эрэг болно. Өмнө өгүүлснээс бид нэг асуудлыг онцгойлон сөхөж тавих ёстой гэж бодож байна. Энэ нь газар усны нэрийн утга гарлыг зөв ухаарч тайлбарлахад үгийн гарлын ухааныг анхаарч үзэх явдал юм.

Эртний тахилгат Увс нуурын нэрийн гарлын талаар гэхэд эрдэмтэд янз бүрийн санал дэвшүүлсэн байдаг. Э.М.Мурзаев энэ нуурын нэр тодорхойгүй,

нутгийн оршин суугчид ч уг нэрийг ухаардаггүй гэж тэмдэглээд Потанин “дөрвөдүүд Их нуур гэдэг, халхчууд Субсан нуур, хотонгууд Зоргол, тагна-урианхайчууд Упса холь буюу Усва-холь гэдэг” хэмээн бичсэнийг дурдсан байна.

Түүнчлэн Б.Я.Владимирцов 1910 онд Ховд дөрвөдөөр явсан тайландаа Увса нуур гэсэн, Г.Е.Грумм Грижайло (1914) дөрвөдүүд Усуа гэж тод дуудлаг гэснийг иш үндэс болгон Э.М.Мурзаев нутгийнхнаас миний бие мөн л Усуа, Усва, Усба гэсэн хэлбэрүүдийн хоёр дахь үеийн у буюу ва (ба)-г уртаар хэлж байхыг сонссон гээд нуурын өмнөд эргээр суудаг түрэг гаралтай бага ястан хотонгууд мөн л тэгж хэлдэг. Халхчууд Усба нэрийн гийгүүлэгчийн байрыг сольж Увс гэж дуудах болсон. Ус гэдэгт ба буюу ва формат залгасан гэж батлахыг оролджээ.

Эдгээр санал эргэлзээтэй байна. Бидний үзэж байгаагаар Увс нэр нь нутгийн аялгууны нөлөөгөөр юм уу цээрлэл эерүүллийн улмаас Усба буюу Усва болсон бололтой. Харин халхчуудын дунд анхны хэлбэр

болох Увс гэсэн дуудлагаар дэлгэрсэн гэлтэй. Ба буюу ва формат залгаж үүсгэсэн гол усны нэр Алтай-Сибирийн нутаг дэвсгэрт бараг дайралддаггүй. Увс (ubsu) гэдэг нэрийг түрэг хэлний ub(гашуун) + su (ус)= Гашуун уст нуур гэж үзвэл зохино. Учир нь Увс нуур нь давстай учраас ингэж үзэх бүрэн үндэс бий.

Алтайчуудын нутагт Сарысу (Шар ус), Шорсу (Давст ус), Аксу (Цагаан ус) зэрэг түрэг гаралтай гол нуурын нэр элбэг тохиолддог нь бүтцийн хувьд Убсу-тай яв цав нийлж байна. Энэ нь загасны толгойг сүүлнийх нь оронд залгаж болдоггүйтэй адил дэс дарааллыг нь огтхон ч өөрчилж болохгүй нарийн зүй тогтолтой бүтэц болох нь илэрхий байна.

Газар усны нэрийг магадлаж учрыг нь олоход түүний этимон буюу анхдагч хэлбэрийг олж тогтоон бүтцээр нь задлахад үр дүнд хүрнэ гэдэг нь дээрх баримтаас тодорхой байна. Ер нь үгийн гарал судлал нь үгийн түүх хийгээд гарал буюу түүний утгат хэсэг болох морфемуудыг авч үздэг учраас

энэ зарчмаар газар усны нэрийг судлах ёстой юм. Үүнээс гадна аливаа домог хууч ярианд үнэний хувь байдаг тул зарим газар усны нэрийг тэдгээрээс тодруулж болох үндэс бийг дурдах нь зүйтэй гэж бодож байна.

Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутагт орших нэгэн тахилгат уулыг Эзэрлэг гэдэг. Дээр үед Нармандах гэдэг нэртэй байсан энэ уулыг ХХ зууны эхэн үед Алтайн урианхайн долоон хошуу нийлж тахьдаг байжээ. Нэг удаагийн тахилгын үед эмээлтэй морь алга болж хэд хоногийн дараа уулын оройд хөлдөж үхсэнийг нь эзэн нь олжээ. Морины эзэн тэр уулыг морь булааж авсан эзэрхэг буюу эзэнлэг уул байна гэснээс үүдэн Нармандах уулыг Эзэрлэг уул гэх болсон гэдэг. Энэ мэтийн олон арван жишээг дурдаж болно.

Тахилгат болон бусад газар усны нэрийг солин нэрлэж ирсэн нь олон шалтгаантай байвч бас сүүлийн үед дур зоргоор өөрчлөх хандлага бий болсныг зөвтгөх аргагүй. Дорноговь аймгийн Хатанбулаг сумын газрын нэрсийг нягтлан байцаахад Хянга уулыг Ханги

уул, Номтын хярыг Номтын толгод, Шохойтын булгийг Цохиотын булаг, Баяртын овоог Цагаан толгой гэхчлэнгээр өөрчилсний дээр өндрийн хэмжээ цэг заах зорилгоор өндөрлөг газар босгосон мод, төмөр шонгоор нь Модот өндөр, Төмөрт овоо гэхчлэн нэрлэх явдал олшрох төлөвтэй болов. Тэрчлэн үйлдвэрлэлийн явцуу эрх ашгийн хүрээнд зохицуулж шинжлэх ухааны ач холбогдлыг үл хэрэгсэн нүүдэлчний соёл иргэншлийн зан үйл, тогтсон заншлаас салгасан нэр өгсөн нь түүхэн үйл явдлуудтай огтхон ч хамаагүй байна. Ийнхүү солих нь үнэн хэрэгтээ ард түмний зан заншил, хэл ярианы соёлын тогтсон дэг журмыг зөрчиж байгаа хэрэг гэлтэй.

Угсаатан ястны хэл түүх, соёл, шашин шүтлэг, хэв заншил, нүүдэл суурьшил, байгалийн баялаг, амьтан ургамлын байршил тархац, үе үеийн танин мэдэхүйн чухал мэдээллийг хадгалагч монголын газар усны нэр нь өөрийн гэсэн нарийн тогтолцоотой, тус бүр нь утга учиртайг өмнө дурдсан баримтууд гэрчилж байна.

Иймд газар усны нэрийн гарал үүсэл, хувьсал өөрчлөлт, нэрийн агуулга, үүсвэр бүрэлдхүүн, шинээр буй болсон нэрсийг нарийвчлан судлах цаг болжээ. Газар усны нэрийн гарлыг нийгэм түүхийн үйл явдлаар хөөн тодруулахдаа нарийн нягт хандаж, хэл, түүх, газар зүй, угсаатан зүй зэрэг олон ухааны баримтад дулдуйдах шаардлагатай нь харагдаж байна. Учир нь газар усны нэр гэдэг бол зөвхөн газрын гадаргуугийн байдалд дүйцүүлэн өгсөн нэр төдий бус олон үеийн хэл түүх, шашин соёлын олон давхаргыг гэрчилсэн баримт болно.

Үлгэрлэн хэлбэл, газрын гүний давхаргыг хөндлөн зүсэхэд олон үе давхраас гардагтай адил бөгөөд түүнийг нь мэрэгжлийн хүн цаг үеэр нь тогтоодог билээ. Газар усанд төвд нэр өгөх, нэрийг орчуулах, уугуул монгол нэрийг төвдийн төстэй дуудлагат нэрээр буюу өөрөөр солин нэрлэх, өргөмж нэр өгч ирсэн сонин тогтолцоо нь эрт үед ховор байсан агаад шарын шашин монголд дэлгэрсэнтэй холбогдон XVI

зуунаас ХХ зууны эхэн үе хүртлэх хугацаанд бий болсон байна. Энэ бол монголчуудын нийгмийн сэтгэлгээнд буддын болоод шарын шашин хүчтэй нөлөөлсний нэг баримт болж байна.

Энэ мэтийн нэрийг судлахад газар шинжихүйн судар, тухайн газар усны судар, домог хууч зэрэг нь нэг чухал эх сурвалж болох ба үүнд үгийн гарлын ухааны үүднээс хандах шаардлагатай юм.

Уялга үг

Монголчуудын уул ус шүтэх уламжлал нь дээд ертөнц тэнгэр, доод ертөнц лус хоёрыг эгцээр нь хүний буюу дунд ертөнцөд холбож үзэх үзэл санааг илэрхийлдэг билээ. Өвгөд дээдсийнхээ авшиглаж, шүншиглэж ирсэн уул усандаа амь нас, мал сүргээ даатган тахин шүтэж ирснээс юу санасан есөн хүсэл минь биеллээ олов хэмээн омогшин баясдаг ажээ. Тэрхүү тахин шүтэж ирсэн уул ус нь өөр өөрийн эзэнтэй, лус савдагтай гэж үзээд сан тахилын судар ном бүтээлгэж уншуулдаг нь газар

газар ойролцоо байна. Учир нь монголчууд эцэг эхээс төрсөн гэх боловч гарал язгуураа таван махбодь буюу газар шороо тэргүүтнээс үүсэн бүрэлдсэн гэж үздэг. Иймээс байгаль дэлхийгээ хайрлахын тулд лус савдаг хэмээх ойлголтыг бий болгожээ.

Нүүдэлчин удамтай монголчуудын хувьд ган зуд зэрэг байгалийн хатуу ширүүн үзэгдлийг хариулахын тулд нутаглан суугаа газар усаа юуны өмнө аргадан сан сэржим уншин, сайн идээ шүүс өргөн, санаа бодлоо илэрхийлдэг ёс нь эртнээс уламжлалтай ажээ. Иймээс:

Хан Хормост
Хөх Тэнгэр минь
Зунаа наашаа
Өнөө наашаа
Өвлөө цаашаа
Хураа наашаа
Хуйгаа цаашаа
Нойтоо базааж

Ногоогоо элбэгжүүлээсэй гэж хөх тэнгэр, хөрс дэлхий, уул усныхаа эздээс соёрхол эрдэг нь үгийн ид шидээр аргадаж байсны нэг илрэл болно.

Байгалийн эр үүтгэл нь тэнгэр, эм үүтгэл нь газар дэлхий гэж үздэг байснаас тэнгэрийг

эцэг, дэлхийг эх гэдэг байна. Тэнгэр нь алив зүйлд амь оруулдаг, газар нь хэлбэр дүрс оруулдаг гэсэн үзэл бий болжээ. Монголчууд тэнгэрийн эзнийг Хурмаст, Хурмастын элчийг Луу, Усны эзнийг Лус, Уулын эзнийг Савдаг гэж тахиж иржээ. Энэ бол газар тэнгэрт далдын хүчин буюу эзэн бий гэдэгт итгээд зогсоогүй, байгаль гэдэг нь сав шим ертөнцийн хязгааргүй олон юмс үзэгдлийн нийлбэр болсон өлгий гэж үзэж байсны гэрч юм. Үүнээс ургуулан бодвол монголчууд газар усаа хайрлан хамгаалах ухаалаг харьцааны сайхан уламжлалыг бий болгожээ. Энэхүү уламжлал нь шашин-соёлынх нь нэг томоохон өв болсон юм. Монголчууд хүн байгаль хоёр хүйн холбоотой гэдэг нь байгалийн хүчин, хүний хувь заяа хоёр цаанаа далд холбоотой гэж үзсэн хэрэг болно.

Хүний өөрийнх нь санаа бодол газар дэлхийдээ нөлөөлдгөөс газар дэлхий нь эргээд хүнд нөлөөлдөг гэсэн ойлголт эртнээс бий болсон авч энэ холбоог судлаагүй юм. Монголчууд газар усаа болон тэдгээрийн эздийг тахин

шүтэхийн тулд олон зуун сан тахилын судрыг зохиож, зохиолгож иржээ. Миний бие сүүлийн гурван жилд монголын тахилгат уул усны нэрийг гаргаж, хоёр зуу орчим сан тахилын судар цуглуулсны дээжээс энэ номд орууллаа. Газар зүйч, эрдэмтэн, профессор Ш.Шагдар багш “Монгол газар зүйн нэрийн товч толь бичиг” хэмээх бүтээлдээ аль аймгийн аль сумын нутагт ямар ямар тахилгат уул ус байдгийг жагсаан хавсаргасан нь чухал зүйл болсон юм. Ш.Шагдар багш “Монголын тахилгат уул ус” гэсэн өгүүлэл бичиж нийтлүүлсэн билээ. Тэдгээрт монголын тахилгат уул усыг Их тахилгатай уул, нутгийн тахилгатай уул, байнгын шүтлэгтэй газрууд гэж гурав хуваасан байдаг. Монголын тахилгатай уул ус гэдгийг уул, овоо, рашаан ус, гол мөрөн, нуур цөөрөм, булаг шанд, удган мод, онгон хад чулуу гэх мэтчилэнгээр нарийсган задлаж болно. Эдгээр нь нутаг нутагт том жижгээрээ харилцан адилгүй. Хангайн уулын ноён оргил Отгонтэнгэр, Дорнод Монголын Дарьгангын Алтан-Овоо хоёрыг хооронд нь харьцуулах аргагүй

бөгөөд тухай тухайн нутгийнхандаа шүтэхээс өөр аргагүй том уулс юм.

Монголчууд тахилгат уулаа хүндэтгэн хан, хайрхан, тахилгат, тахилт, богд гэхчлэнгээр нэрлэж ирснийг миний бие “Газар усны өргөмж нэр” гэсэн өгүүлэлдээ тодорхой өгүүлсэн болно. Эл номд орсон сан тахилын судрууд нь харилцан адилгүй хураангуй, дэлгэрэнгүй хэлбэртэй буй. Дэлгэрэнгүй гэдэг нь илт онол, заллага, хангал, наманчлал, ариусгал, залбирал, өргөл, өлзий өгүүлэх, даатгал соёрхол, сэржим, магтаал, сэтэрлэх зэрэг олон хэсгээс бүрдсэнийг хэлж байгаа юм. Судрыг зохиогчдын ихэнх нь Монголын эрдэмт лам нар байгаа ба бас цаст төвдөөс залагдан ирсэн эрдэмт хувилгаад ч зохиосон буй.

Уул усны ихэнх сударт уул усныхаа эзэн сахиусыг урин дуудаж, буянт мал сүргээ тэнгэрийн од шиг олон болгож, будаа тариагаа газрын үндэс шиг арвижуулахыг эгээрч, гай барцад, гарзын үүдийг үл хүсэмжлэн, хижиг өвчин, ад дон, муу хулгай дээрэм, ган зуд, хяруу мөндөр,

салхи шуурга болон хямран тэмцэх хол ойрын хорлол, хэл ам, хэрүүл уруул тэргүүтэн үл зохилдох зүгийн бүхнийг амирлуулан зохиож, хотол олны нас буян батжиж, цог учрал, амны хишиг дэлгэрч, санасан хэргийг ая зөнд нь бүтээхийг олон зүйлээр хувь бүрдүүлэн өгүүлсэн байдаг. Уул усны тахилга гэдэг нь монголчуудын дунд маш өргөн дэлгэрсэн байгаль хамгааллын нэг хэлбэр гэдгийг цохон дурдалтай. Уул усны сан тахилын судрууд нь зөвхөн шашны зан үйлийг явуулахад унших ном төдийгөөр хязгаарлагдахгүй монголын төвд хэлт уран зохиолд авч үзвээс зохилтой нэгэн төрөл зүйл болж өгнө. Учир нь уул усны сан сэржим, магтаал соёрхол сэлт нь манай аман зохиолын дотор гардаг уламжлалт магтаалын өгүүлэмжтэй тун төстэй байдаг билээ. Уул усны сангийн судар, тухайн уулын зураг сэлтийг эрэн сурвалжилж цуглуулах, судрыг орчуулах зэрэгт ШУА-ын Хэл зохиолын хүрээлэнгийн Төвд судлалын салбарын эрхлэгч, доктор, профессор Т.Хүрэлбаатар, Шашны дээд сургуулийн захирал, Ш.Сонинбаяр, МУИС-ын багш,

төвдөч, эрдэмтэн Д.Бүрнээ, нэрт сэтгүүлч, орчуулагч Г.Аким нарын зэрэг олон сайн нөхөд туслалцаа үзүүлсэнд гүнээ талархаж байгаагаа илэрхийлсүгэй.

Энэ номыг хэвлүүлэх сайхан санаачлага гаргаж бүх талаар дэмжлэг үзүүлсэн Дэлхийн банк болон Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь товчооны эрхэм нөхөд – Б.Чимэд-Очир, Б.Баатар, Б.Элбэгзаяа, Р.Болор нар, Гандантэгчинлэн хийдийн хамба лам Чойжамц, ламтан Х.Бямбажав, төвд судрыг хуулан бичсэн Шашны дээд сургуулийн оюутан Н.Даваасүрэн, Дуладрагчаа, Д.Ёндонжамц, Сугардорж, Б.Сэнгээ нарт мөн нэгэн адил баярласан сэтгэлийн хадгаа өргөн барья.

Олны сэтгэлийн дэмжлэгээр бүтсэн энэ ном олон түмэнд буян түгээх болтугай.

SACRED MOUNTAINS IN MONGOLIA

*By O. Sukhbaatar with M. Palmer,
Secretary General of ARC*

One of the major reasons for working with the traditional religion of Mongolia is that buried deep within it are legends, stories, even names which tell us a great deal about a proper relationship with nature. Flowing from pre-Buddhist cultures, enhanced and often codified by Buddhism and now fused with environmental awareness, the ancient names of sacred mountains, lakes and rivers indicate a profound respect for nature which is one of the hallmarks of Mongolian culture. As the country rebuilds itself following the Communist era, it is appropriate to look back and to see what insights our forebears had when they saw this land as inherently sacred.

For many outside Mongolia it might seem strange to look to the names and legends of the past to build a new future. But Mongolia has a delicate ecology which has been respected – indeed venerated – throughout history because people instilled in names and legends wisdom concerning the

correct and appropriate use of such places. In an era of rapid change such as that which confronts Mongolia at the start of the 21st century, we need to know how to walk gently upon this fragile land and the past tells us how. This book opens the door to such careful, respectful walking. It explores the relationship between people and landscape, between the land and the people and as such provides a unique map of the sacred ecology of Mongolia which lies, literally as well as metaphorically, just below the surface.

One of the distinctive traits of Mongolian civilization is its profound relationship with nature and its preservation of wilderness. Mongolians have developed outstanding traditions of a relationship with nature by deifying nature and the earth, and by worshipping and glorifying their homeland, flora, fauna and wildlife, mountains, hills and lakes. There are some 800 venerated mountains and sites in Mongolia according to our estimation. Over 280 of them have their own holy Buddhist texts – known as sutras. The sutras reveal how Mongolians deify nature, with their belief in the existence of chief local

deities who are described so beautifully through the poetry and symbolism in the literature for every mountain and place.

The nomadic Mongolians have a long tradition of honouring the land through the reading of religious books, making offerings and praying in order to seek to avoid natural disasters such as draught and heavy snowfall. The following is an example of a prayer asking for blessings and benediction from the deity of the blue sky, the Earth, mountains and waters:

Dear Blue Eternal Heaven
Let summer come to us
Let well being come to us
Let winter go away
Let rain come to us
Let wind go away
Let it be wet, and
Let us have more grassland.

In traditional Mongolian belief, the ruling deities, Heaven and Earth, were male and female, respectively. It was believed that heaven makes things come alive and the land shapes and sustains things. Mongolians have created traditions such as this embodying a profound relationship

with nature, indeed explicitly for the protection of nature, which is part of the heritages of Mongolian religion and culture. Mongolians believe that the fate of humanity is inextricably interwoven with the fate of nature itself.

Despite the profound belief that the world affects humanity and vice versa, this relationship, so fundamental to the spiritual and physical ecology of Mongolia, has never been studied thoroughly. Mongolians have created hundreds of ritual sutras in order to express their veneration of the land, the mountains and their deities. Over two hundred have been collected by this project in just three years and Professor Sh. Shagdar has produced a study of many of these in his "A Brief Dictionary of Mongolian Geographical Names". He also published an article "Venerated mountains and waters in Mongolia" in which he classified them into 3 categories: mountains with major ritual worship; local worship and regular worship. Under venerated mountains we also classify subgroups of mountains, hills, ovoos, spring, rivers, lakes, udgan (worshipped) trees, virgin rocks and others. Their

sizes differ from place to place. This is a major area for study, revealing as it does the deep relationship between religion and ecology, culture and people which runs as a river through the history of Mongolia. We offer it here because we believe it holds one of the keys to a true understanding of how Mongolia can develop without losing its identity. This book is a new expression of the sutras which taught so powerfully and for so many centuries that the fate of humanity is interwoven with the fate of nature itself.

It should be emphasized that the veneration of mountains is one of the most popular methods of traditional nature conservation among Mongolians. Mountain-sutras are not only religious books for ritual ceremonies, but they are also an invaluable repository of wisdom derived from Mongolian culture and written in Tibetan – the religious language of Mongolia.

This is shown by the fact that Mongolians respected and honored their mountains, awarding them titles such as khan, khairkhan, or bogd. A traditional 'nature' sutra consists of

many sections including theory, offering, purifying, praying, bestowal, eulogy, praising, naming of spirits, and marking of the site with ritual and statues.

The majority of mountain-sutras honor the chief deities of the mountains and waters; wish for the increase of sacred animals, such as the snow leopard, so that there will be as many as there are stars in the sky; pray for a good harvest; ask for a long life, prosperity, well being and happiness; and seek to prevent disaster and troubles such as draught, heavy snow, hail, wind storm, diseases, robbery and sin.

All examples cited here prove that the names of sites and mountains which preserve ethnic culture, history, language, religion, traditions and nomadic life style, relate also to natural resources, and location and spread of wildlife. They were created in order to preserve and protect, and this is reflected in their very structure.

Therefore, it is time to undertake comprehensive studies into the origins, background, evolution, meanings, and structure of the names of sites and mountains. It is important

to be precise and critical when we study the background of the names in relation to social and historic events, exploring them through theories arising from a number of sciences such as linguistics, history, geography, ethnography and others. These names are not only names related to the geographic formation but preserve the heritage of language, history, culture, ecology and religion of many generations. For just as the mountains reveal to us the layers of time in their sediment beds, so do the traditional names, rituals and sutras of these selfsame places. We are about to begin to delve into history, religion, culture, ecology and wisdom which these long ignored names and sutras reveal to us.

For millennia, Mongolians entrusted their lives and the well being of their livestock to the mountains worshipped by the ancestors and lived contentedly with the belief that this would work. They believed that the venerated mountains and rivers had their own spirit or deities and with the coming of Buddhism and the emergence of written texts, they created sutras for each of them. An interesting aspect of this is the giving of a Tibetan name to the land and mountains, often

reflecting the older Mongolian name but sometimes complementing it. This began around the 17th century when Buddhism first became a popular religion within Mongolia. This is an interesting example of the growing influence of Buddhism in Mongolia.

The origins of the religious ceremonies of the Mongolians are found within Shamanism and are an expression of the ancient tradition of respect and honour shown to both nature and homeland. The traditions of venerating mountains have arisen from both oral and written Mongolian sources, but the oldest of these are the shamanic oral traditions.

These traditions and ceremonies originated with shamanism, where the role of ancestors is pivotal. The focus of shamanic ritual is the ovoos (a pile of stones) each of which is considered the home of an ancestral spirit. The ancestral spirit can communicate directly with the deities of heaven and earth. The Shamanism of ancient Mongolia arose from deification of the land and veneration of local deities associated with particular physical features. From ancient times Mongolians deified the sky identifying

it with a father and the Earth with a mother. Foundational to this was the Mother of the Earth, known as Etugen, which means a possessor of the land. Onon, a part of the primeval venerated mountain Otgontenger is a revised version of the ancient name of Etugen. The name Otgon in Mt. Otgon is a modified version of Etugen. Etugen, the deity of the land, is said to have magical abilities related to the fertility and fecundity of plants, and Mongolians also dedicate their animals to her as well. This is still very much the case even today.

Mongolians believe that each mountain, stream, river and lake has its own deity. This is illustrated by the proverb "a mountain has a deity and water has a spirit".

The land was used as a pasture for livestock and considered to be a 'homeland' and generated a variety of forms of worship. Rivers, mountains, hills, and lakes, which make up the homeland each have a deity. This belief was adopted by Buddhism and later became an inseparable part of the society and religion. Even ancestors were buried at a high altitude to entrust them to the deity. Creating ovoos on

the top of hills and at the juncture of roads is intended to serve as many deities as possible. Thus the location of ovoos is not accidental, they are power points of influence within the landscape, and this is as true physically as it is true spiritually. Along side this shamanism instilled respect for nature through traditions forbidding the cutting of young trees, moving rocks and stones, dropping blood and dairy products into water, destroying roots of grasses and hunting certain animals. This is encapsulated in the saying 'the deity will get furious' and 'lives and properties may be in trouble'. The deities were placated by burning incense and reading religious sutras. In order to please deities and spirits, a ceremony of marking as holy, sheep, goats, horses, camels and bulls takes place.

Deities of Mongolian lands and water are of several types. For example, mountains with a ferocious deity are very common. Mt. Otgontenger is said to have a ferocious deity, while Mt. Tsambagarav is said to have a fierce heavenly deity associated with Esvun. The differences in the physical appearance of the site often determines

the kind of deity they are thought possess. In the ritual sutras of ovoos a number of deities of lands and waters were clearly described.

Different descriptions of deities are connected with local points of view. For instance, the spirit of Oird's mountain is known as White Old Man. Oird Mongolians think that the White old man lives in a high and much worshipped tree, which is big and very special. It is situated on an isolated hillock in the middle of the steppes. Thus they worship high mountains, a sole tree, or rocky hills by creating an ovoos there.

Goblins are one of the most feared and respected of the ferocious deities of the land and waters. The goblin is able to collect clouds and bring rain, and is found everywhere. Academician Ts. Damdinsuren once wrote: "The goblin was often illustrated as a man on a horseback or on a snake. Venerating mountains is a ceremony worshipping the goblin, a deity of a mountain". (Gezer 1968) According to a Buddhist legend a goblin is a deity of the land and water, a manlike creature with man's head and a snake's body. Navdag goblin is a local deity.

It is believed to enter a person via the hair to protect people, even acting as a blessing. Therefore, people dislike being touched on their head and fear to beat the heads of animals saying that this will drive the blessing away.

Only particular mountains and hills are considered for veneration, depending on landscape, formation, historic and traditional value and ecological/spiritual significance, and the familiarity of the local population with legends and tales. The veneration of mountains is a ceremony/ritual, where religious scriptures or sutras are used for special chanting, and offerings are made to Heaven of food, mare's milk, and vodka. But the scope and sequence of the ritual differs from place to place due to the specific traditions of local areas. For instance, since Orkhon River was awarded an honorary title of Tushee Gun, the Ulaantsutgalan waterfall has been offered a silver ingot of 20 lan of silver (a lan equals to 37.3 gm) annually, whilst local families in turn offered an ingot of 50 lan using a sling to hurl the ingot into the waters of the Terhiin White Lake during appropriate ceremonies. The purpose of the ritual is in order to cast the offering deep into the lake's heart

as well as trying get it as close as possible to the sacred Chamdmani hillock in the middle of the lake.

A deified or venerated mountain of the steppe is usually the highest, most spectacular and picturesque one in contrast to its surrounding environment, whereas in mountainous areas they are usually the highest peaks of the mountain range. One particular mountain can be deified by many soums (the smallest administrative unit in Mongolia) and one soum can worship as many mountains as they wish and can afford, notes Sh. Shagdar, a prominent geographer, by citing an example of the Mount Ikh Bogd in Bayanhongor aimag, whose mountain ranges are worshipped by the locals living in adjacent areas.

The main purpose of deifying mountains is to please the possessor and deity of the land and ask for blessings and benedictions for the well-being of the province, families, and livestock. Through such veneration, the balance between humanity and nature has been maintained for centuries.

It is this wisdom which we are

uncovering through this project.

The sacred mountains of Mongolia are divided into three distinct groups in terms of ritual: a) mountains with greatest extent of veneration; b) those with comparatively lesser extent of worship and c) routinely worshipped mountains. They also differ according to the extent of public involvement in the rituals: For instance, the four folding mountains around Khuree, the capital city, were worshipped by different classes; the Mount Chingeltei by scholarly lamas (monks), Bayanzurkh by merchants, Songino-khairhan by the military and Bogd Khan by the governors.

Before we describe the stories behind some of the names for some mountains and the reasons for changing traditions of naming process for these mountains, we need to briefly look at some classic types of titles.

The Khan or Khaan is a very popular title given to mountains. We can list plenty of them including for example Khan Uul, Khan Khentii, Undurkhan and many others.

The Bogd is used for many mountains such as Khanbogd, Ikh Bogd, Ajbogd

and Tsast Bogd. Such titles originated from India and Tibet.

In Mongolia, traditions of awarding titles such as of Chakpavardi, Ochirvaani, Khubilgan (reincarnation), Manzshurin Khubilgan, Narbachin, Yeg uzur khutagt to its kings, lords and nobles were common. When the Bogd Khan ascended to the throne in 1911, he was given a title of the King (Mahasamadi), publicly proclaimed. The reverence shown for his person was an echo of the reverence shown to the 'person' of the mountains.

Royal and noble titles were also given to mountains and places. The titles of Ochirvaani (Mt. Otgontenger), Bogdkhan (Mt. Khan Uul), Gundsambuu (Hentiikhan), Zaisan hillock, Orkhon Tushee gun, Tsetsee gun of Bogd khan, and Tushee gun are clear examples of this tradition.

There are, possibly, only a few countries which give titles to the land and mountains. The Khairkhan, an euphemistic reference for the sky, is used also for mountains and hills- Burenkhairkhan, Buskhairkhan, Zorgolkhairkhan, Suvargakhairkhan and many others. It is quite often the case that proper names of the

mountains are not said, but they are referred by the title of Khairkhan.

Some sacred mountain names are followed by the word Saridag, a custom frequently found in Khovsgol and Khentii mountain ranges. Saridag, meaning a snow capped peak or a summit (3,472m) in modern Mongolian language, is a compound noun consisting of 2 Turkish words of Saryg (yellow and white) and tag (mountain). The last consonant (g) of the first word is omitted and the first consonant (t) of the last word is replaced by 'd' following the soft consonant.

Every deified mountain has an ovoo (a pile of stones constructed by humans). The ovoo itself has a special name, usually that of the mountain itself, such as Ulyn Ovoo, Sangyn Dalain Ovoo, Binder Ovoo, Altan Ovoo etc. Although the "ovoo" is strictly the pile/heap of stones built on the top of the mountain, hill, and at the beginning of the rivers and springs, it is often seen as being in effect identical with the mountain.

Whilst in the period when shamanism was dominant, mountains were

referred to as Khan (king) and water as Khatan (queen), the Bogd and Khairkhan titles became more traditional following the acceptance of Buddhism in Mongolia. A number of mountains still keep traditional titles such as lord (noyon), queen (khatan), father (etseg), mother (ekh and eej) and son (khuu). There are many, including Noyon Uul (Mt. Lord), Eej Khairkhan (Mother Sky Mountain), Eej Mod (Mother tree), Khuu Uul (Son Mountain), Baga Akh (Young Brother), Dund Akh (Middle Brother), Buural Akh (Eldest Brother), Noyon Khangai (Lord Khangai) and Khatan Khangai (Queen Khangai). The traditionally venerated rock Khand Khad (Sergelen soum, Tuv aimag), a Tibetan word meaning the Goddess rock, is recognized by that name on the official maps of Mongolia but locals call it Eej Khad or Avgai Khad (old lady rock). They never use its original name which has become an archaism.

The Mongolian nomadic culture itself has been a basic reason for frequent changes of mountain and site names, unlike more settled civilizations.

H. Perenley, a prominent scholar,

identified several reasons of archaism and conversion of old mountain names into alternative names. They are closely connected with historic events at the site and movements of local residents. For instance, during the feudal period in Mongolia, it became very popular to name the mountains and places after famous lords and nobles. The Shuragtai or Shurugai khan mountain located near to ancient Deluun Boldog and Baljin aral was renamed mount Bayankhan, as the birthplace of the Ugtam monastery. It is also the case that from time immemorial the names of mountains and lands were taboo-words amongst the Mongolians and resulted in deliberate avoidance of using the original names.

Due to such reasons, renaming of mountains and sites have occurred regularly throughout Mongolian history. As a result of an emergence of numerous sutras for venerating mountains and water, many of the original names have been revived. Changes in mountain and land names have been made at the request of a sutra sponsor or author. Consequently, some places and mountains have both versions of names: original and

traditionally-accepted ones. Indeed, lords and nobles of the particular regions had a right to name main oboos and mountains in their areas. The second largest snow-capped mountain after Otgontenger is Ochirkhairkhan, the dead volcano, which is well known by its renewed name of Khalzan Burgedei. Saint Zaya renamed Khorkhoit Tolgoi, which means the Insect Hillock, as Mt. Erdene (Erdenemandal soum, Arkhangai aimag) in order to make the name a bit more attractive.

Naming places in the Tibetan language or translating Mongolian names into Tibetan was the other specific way of creating sacred mountain names. For instance, Mt. Ikh Ugtaal in Dundgobi aimag was named On Bo Chin Po Ri (Great blue mountain), Suvarga Khairkhan in Arkhangai as Che Ri Gar Ri (Great white mountain), Khentii khan as Gundsambuu (Good Hotol), Yesun Zuil in Uvurkhangai as Rolgan Khairkhan (Full of Joy), Zotolkhan in Sukhbaatar as Sevjidbalbar (Glorious Togbadrah) and Toono in Khentii as Dashbalbar and Togos in Erdene soum, Tuv aimag was translated as Maja (Rma Bua). Mt. Otsol whose shape resembles a

pitchfork used to be named Ats (pitchfork). Evolution of language converted Ats into Otsol which was later transferred into the Tibetan od gsal (saint shining). Mt. Sansar, seen by the author of the sutra dedicated to the mountain as resembling a crouching lion was renamed as to seng ser (yellow lion) in the sutra.

Scholars have found that the names of Mongolian sites and mountains are mostly dominated by Mongolian words plus some Tureg (Turkish) words. Although Mongolian words dominate in the names of Mongolian mountains and lands, resource materials we found confirm that there are many names that also originate from Tibetan and Samgardi. A number of names of the venerated mountains such as Zotol, Matad, Dashbalbar, Dovon, Gelen, Samballhundev, Tsambagarav, Dashderchin, Sevchidgatsal, Ajbogd, Bumbat, Agarkhairkhan Uul, Rinchinjignee, Gandan and Ganga Nuur are borrowed words.

According to some sutras the actual location of some mountains is not clear. The mountain sutra found in Bayankhongor talks about Mi Gtong

Ri, translated as Human mountain. Yet it is very uncertain where it is and by what name it is known nowadays.

Starting with the spread of Yellow Buddhism (Gelugpa or Vajrayana Buddhism) in Mongolia from the 16th century, lands and mountains were honored and named according to religious customs associated with that tradition. When the wide range Danshig naadam festival covering 7 provinces with an offering to the God began to be observed, initially in 8th Bogd's time on a small hillock of Khui Doloo Khutag in the territory of Batsumber soum, Tuv aimag, the hillock was renamed as the Mandal Ovoo (offering ovoo). A similar example can be seen in that Tasgany Ovoo in Ulaanbaatar, used to be called Zaan Khoshuu (Elephant Trunk) identifying it with the trunk of an elephant. In order to please and pacify the elephant, considered one of the 'angry animals', a monastery dedicated to the deity Geser built at the end of its trunk. Ever since lamas have hosted a religious ritual there called Tasga, from which has arisen the new name of the hill – Tasgany Ovoo. But some researchers see 'tasga' or 'tasgan' as Turkish 'Taskil'

(Open hillock), which turned into 'tasgan-dasgan' in Mongolian language. But we feel this is a little too far fetched. It cannot be denied that traceable historic events wrought their effect on the names of those places.

Өдөр, шөнийн цаг бүгдэд амгалангаар цэнгэхийн өлзий хутаг орштугай.

хэмээн өгүүлэгдэхүй.

Ер дээдсийн зохиосон дэлхийн эздийн тайлганы судар нэн олон адис ихтэй. Эртнээс өлзий болсоор ирсэн. Гэвч цөм төвдийн хэл бөгөөд газрын эзэд заримууд нь үл ухахуйг болзошгүй. Мөн энгийн монголчууд мэдэх мэдэхгүй монголчилвоос уг төвдийн өгүүлэх байдлыг дагалдуулж учраар монгол хэлэнд яв хийтэл нийлэлцэхгүй бөгөөд уг санааг үнэн сайтар бүрнээр мэдэхүйеэ бэрхлэг шигийг санаваас монголын дэлхийн эздэд монгол идээ бэлдэж, монголын үгээр зориулж, учир зоригоо дуудаж өгүүлвээс харин монголын орондоо өлзий билигтэй болов уу гэхийн гадна энгийн монголчууд учрыг мэдэж сүслэлдэх санаа олмуй хэмээх санаа сэдэж Богд нарын зохиосон судруудын байр санаа авч ийн эвсүүлэв.

Ман га лам

Өлзий хутаг оршиж даяар амгалан жаргалан болтугай.

ЛУСЫН САНГИЙН СУДАР

Нэн хичээнгүй бичсэн энэхүү судар Ц.Дамдинсүрэнгийн гэр музейд МН-993 гэсэн дугаартай хадгалагдаж байгаа болно. Энэ судрыг төвд хэлнээс орчуулсан бололтой. Бас өөр нэг түвд судрыг хавсаргав.

Again, this sutra is not dedicated to a particular sacred site, but to the different guardian deities of all sacred places in Mongolia. In particular it is recited for the wellbeing of the land, lakes, rivers and the sky.

Намо гүрү. Гэгээн сансар найман аймгууд дэлхийн эзэд бүгдээр хийгээд ялангуяа хийд сүм, гэр байшин, орон тэргүүтнээ ойр орчин нутаглан суусан хамаг дэлхий хийгээд хуучин шинэ буусан нутаг ус болон /2a/ тойром нуур ба уул хад ба чулуун овоо, ой мод, өвс цэцэг, тал хийгээд их зам, нарийн зам, харгүй тэргүүтэн-дор оршсон тэнгэр, лус-чу мөн дэлхийн эзэд, хүмүүн бус, учирсан тотгор зэтгэр нугуд бодинарын язгууртан бүгдэд цагаан тос гурил, элдэв үр жимс ба сайн үнэрт хив торгон, модон жимс хийгээд түлсэн утааны үүлс огторгуйн орон дэлхий дүүрэн бус /3a/ бас сэтгэлээр хувилгасан тахилын чуулганыг таалан үүсгэхүйн тул залбирал өргөмүй, тахимуй. Та бүгдээр энэрэн үнэрлэн амсан соёрхоод ба бүрэн би хийгээд хамаг миний нөхөр сэлт-дор хор хүргэхүй юун боловч ... бүү үйлдэж зохиогоод энэ нутагт манаа халуун хүйтэн зуд ба хатуу догшин хур мөндөр, дуу цахилгаан ба гал түймэр, үер усан, их шуурга цас, /4a/ их хий, улаан хар хуй салхин, өвчин зэтгэр, үхэл гарлага, чоно хулгай, элч довтолохуйг зайлуулан үйлд. Эд идээн, сааль шим дор хор болох алин-дор-чу үл болоод энэ өдрөө /4б/ хур ус цагтаан буугаад өвс тариан элбэг гараад эд идээн мал дэлгэрээд эрдэнийн үр арвидаж амгалан баясгалангийн цогийг эдлээд ном лугаа зохилдон санааныг сайтар эдэлснээр /5a/ ялгуусан шажин зүг цаг үгүй дэлгэрэх болтугай. Блама гурван эрдэнийн хүчин чадал шүтэн барилдагчийн үнэний хүчнээр сайн буян зуны дэлхий мэт арвидахын өлзий хутаг орших болтугай. Ум сүбара дистана базар яай сухаа.

ཧཱུྃ། །སྲོ་བའངས་ཙམ་གྱི་བབ་ལྷན་གསུམ་པོ། །
 ཧཱུྃ། །སྲོ་བའངས་མཚོ་བཟང་སྒུ་མཚོ་བཟང་རོང་པམ། བསངས་རྒྱལ་བཟུངས།
 བདག་དང་འབྲེ་གུ་ཤི་མ་མཚོ་ག་ག་སུ་མཁུ་ལ། ཡུག་འཚལ་སྤུ་བས་མཚོ་བྱང་རྩལ་
 བེ་མཁུ་བཟུང་ངོ། རང་ཉིད་ལྷན་གསུམ་སྤུ་ལས་འདྲ་འབྲེའི་པམ། རྩམ་རྩམ་མཁུ་
 བསངས་ལྷུངས་ཤི་ཙམ་སྤུ་སྤུ་མཚོ་སུ་བུ་ལྷན། ཨོྃ་ཙམ་རྩྏ་རྩྏ། རིམ་ལེགས་གསུམ་མཚོ་ངོ།

སྤུ་མཚོ་ག་ག་སུ་མཁུ་ལ་སྤུ་བས་སུ་མཚོ། སྤུ་སྤུ་ལ་སྤུ་ལ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་
 ལྷན་དུ། བསངས་ལྷུངས་ལ་མཚོ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་
 བསངས་ལྷུངས་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་
 སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་
 ལྷན་ལ་མཚོ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་

བསྤུས་དཔོན་པོ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་
 ལྷན་ལ་མཚོ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་སྤུ་ལ་
 ལྷན་ལ། །

МОНГОЛ ОРНЫ САН

Энэхүү хураангуй сан ариусгалын судар нь төвд хэлээр элбэг байдаг бөгөөд зарим нь нэргүй байх ба зарим нь “Монгол орны сан” нэртэй байна. Зарим хүний үзэхээр бол үүнийг Бүрэгхангайн сан гэх ч бий. Учир нь Бүрэгхангай уулаар эхэлснээс тэгсэн хэрэг биз.

Энэхүү ганц хуудас судар Түмэндэмбэрэлийн судрын хавчуулга болж явдаг болно. Ямар боловч энэ сударт монгол орны дөрвөн зүг, найман зовхисын алдарт уул, усны нэр гарч байгаа тул нэгбүрчлэн тайлбарлах шаардлагагүй юм.

SUTRA ON MONGOLIAN LAND

Information on the sutra:

This sutra is an excerpt taken from the Tumendemberel Sutra, written in Tibetan. In Mongolia the sutra is known by various names, such as ‘Buregkhangai Sutra’, due to the vivid description of Buregkhangai mountain at the very beginning of the sutra, or ‘Sutra on Mongolian Land’.

The sutra praises the sacred places of Mongolia through ebullient description of her beauty.

Аяа,

Аугаа хүчит Бүрэгхангай хийгээд
Алдарт Бүрэн, Орхон, Сэлэнгэ
Асарлах уул, урсах усан бүхнээ

оршсон

Ачит төвийн шивдаг бүгдийг
ариусгая.

Онон, Алтай хавийн их уул ус
Олноо алдартай Увс, Их арал
тэргүүтэн

Ихэнх уул усан бүхнээ оршсон
Ич этгээдийн хамаг шивдагийг
ариусгая.

Хэнтийн улаан сүрэг мал болон
Хэрлэн, Туул, Хөлөн тэргүүтэн
Догшин уул, усан бүхнээ оршсон
Дорно зүгийн шивдаг бүхнийг
ариусгая.

Аяа,

Умар зүгийн Монгол орны Их
сүлдэн тэнгэр

Уул Хангай ханы дөрвөн их тэнгэр
Эх хөвгүүн, гадаад, дотоод, түшмэл

Элчис, үйлчний нөхдийг ариусгая.
Бус бас дөрвөн зүг, найман
зовхисын

Ус гол, уул хайрханд оршсон
Улс орны тэнгэр, шивдаг хамгийг
ариусгая.

Ялангуяа ба бүрний нөхөд сэлтэс
Ямарваа шүтээн, мөр, үйл хамаг
гурванаа

Алинд нь ч оршсон энэ зүгийнхээ
Алдарт орны тэнгэр, хамаг
шивдагийг ариусгая.

Хангай ханы аймагт харьяалагдсан
Хань болсон Идэр, Тэрх хоёр
Хас өлзийт Цагаан нуур,

Чулуутын

Хамаг шивдаг, орны тэнгэрийг
ариусгая.

ХАЛХ ОРНЫ ШИВДАГУУДАД САН ТАХИЛ ҮЙЛДЭХҮЙ ЁСОН

Халх орны эзэн шивдагт тахил балин өргөж, сан ариусгал талбигсан судар цөөнгүй байгаагийн нэг нь энэ болно. Халхчуудын нутаглаж ирсэн газар өргөн уудам бөгөөд энэ сангийн сударт газар усных нь нэрийг дурдсангүй тул хаанаас хаа хүртэлх газар нутгийг хамарч байсныг тогтоох боломжгүй байна.

Гэхдээ Халх нэртэй газрууд олон байдгийн заримаас дурдвал: Халхгол, Халхын таван өндөр /Дорнод/, Халх толгойн говь, Халх морин хушуу /Сүхбаатар/, Халх худаг, Халхын баруун өмнөд овоо /Өмнөговь/, Халхын цагаан хайрхан /Ховд/, Халхын гурван оргил /Дорноговь/, Халхын дундад өндөрлөг, Халхын манхан /Дорнод/, Халхын өндөр нурууд /Дорнод/... гэх мэт. Эдгээр нь Монголын баруун хязгаараас зүүн хязгаар, умраас өмнө зүгийн хязгаар хүртэлх нутагт байгаа нь тэнд халхчууд оршин сууж ирсний баримт болж байгаа юм.

SACRED SITES OF THE KHALKH PEOPLE




Information on the sutra:

There are several handwritten and printed versions of this sutra-manuscript all focusing on the Khalkh territories.

The Khalkh are an ethnic people originally living in Central Mongolia and many sacred sites in Mongolia refer to the Khalkh people.

These sacred rivers, mountains and steppes include; the Khalkh river, Khalkh Five Heights (Dornod province), Khalkh Hill Gobi, Khalkh Morin Khoshuu (Sukhbaatar province), Khalkh Well, the South-Western Ovoo of Khalkh (Omnogobi province), Khalkh White Show-Capped Peak (Khovd province), Khalkh Three Peaks (Dornogobi province), Khalkh Mid-Point, Khalkh Sand Dune (Dornod province), Khalkh Mountain Ranges (Dornod province).

The location of these sacred sites lend witness to the fact that the Khalkh people moved from Central Mongolia and eventually settled all over the country.



Аяа,
 Язгуур гурван мянган орны шивдагууд үл хоцрон
 Ялангуяа Халх нутгийн газар, усны тэнгэр бүгд
 Ягштал урьдын тангараг бошгыг чухагаар таалаад
 Ялгуусан энэ зүгийн газар орноо амгаланаар залрагтун
 Цуврилгүй рашаанаар адистидласан балингийн чуулган
 Цул сайн үнэрт элдэв сангийн утаан үүл, нэн ялангуяа
 Цуут ажинай, махи, сарлаг, хүслийг ивэлгэгч үнээдийн
 Цутгах сүүний урсгалаар шивдагийн нөхдийг тахъяа
 Асар уужим газрыг баригч орон бүхний эрдэнэс
 Аяндаа цогцлон дүүрсэн гадаад, дотоод эрдэнэс
 Амттайхан идээ хүнсийг орон жигдэлснээр
 Айлдагч тэнгэрс Та бүхэн хотлоор баясах болтугай
 Энэ орон зүгийн хүн амьтан хоцролгүй
 Эд баялаг нь арвидан чанадсын бэрх хөнөөлгүй
 Эрх цог хийгээд эдээр баяжин, насан уртсаад
 Энх жаргалангийн далайг арвижуулан нөхцүүлж хайрла
 Үлэмж ялгуусны хөвгүүн бүхний их амгалангийн хүчээр
 Үнэхээр та бүхэн эндэхийн тэрсүүд бодинарын чуулганыг
 Үзтэл насад амуутгаад ном-дор төгсөөр жаргаан
 Үнэн чухаг дээд гурваас үл хагацуулах болтугай.

ОЙРАД ОРНЫ ТЭНГЭРИЙН САНГИЙН ТУХАЙ

Орос цааснаа хар бэхээр бичсэн таван хуудас энэхүү төвд судрыг хэн хэзээ зохиосон нь тодорхойгүй.

Ямар боловч энэ сударт гарч байгаа газар усны нэрс нь Ойрадын түүхэнд олонтоо дайралддаг түүхэн нэрс байна. Тэдгээр нэрийг төвдөөр тэмдэглэснийг үзэхүл Булган, Цагаан гол зэрэг нэрийн га, го зэргийг gha, gho гэж галигласан нь монголчуудын төвд үгийг галиглаж ирснээс ондоо байгаа нь сонирхол татаж байна.

Доктор Ж.Цолоо “Газар дэлхий усны бүгдийн сан” нэртэй нэгэн судрыг тод үсгээс кириллээр буулган “Дал” сонинд хэвлүүлсэн ба уг сударт гарч буй газрын нэрийн ихэнх нь бидний гарт буй төвд сударт тааралдаж байгаа болно.

Алтай - Ойрадуудын нутаглаж ирсэн асар уудам талбай эзэлсэн уулархаг район.

Эрчис: Алтайгаас эх авч Казакстаны нутаг, Баруун Сибирийн тэгш талаар урсах гол. Орос газрын зурагт Иртыш гэж тэмдэглэсэн буй. “Чингис богдын өчиг” сударт гардаг Өлгэ газар буюу одоогийн Өлгий хүй гэдэг уулаас эх авсан гол. “МНТ”-д Эрдиш мөрөн гэж гардаг.

Ховог сайр: Хятадын Шинжианд оршино. Торгуудууд нутаглаж ирсэн учир Ховог сайрын торгууд гэж онцлон нэрлэж байжээ. Хоо бугын сайр гэсэн утгатай нэр.

Эмэл-Шинжианы Тарвагатай уулаас эх авч Алаг тугалын нуурт цутгадаг гол, Чингис хааны үед энэ нутаг Өгөөдэй хааны эзэмшилд байжээ. Хожуу үед Торгуудын ноён Хо өрлөг энд нутаглаж байсан ажээ. Одоо монголоор ярьдаг арван суман өөлдүүд энд бий. Ойрадын сангийн судруудад энэ газрын нэрийг Эмэл, Эмил, Эмис гэхчлэнгээр бичсэн байдаг.

Эмэл Зайрын уул нь эмээлийн хоёр бүүрэг хэлбэртэй учраас Эмэл нь эмээл гэсэн үг болно.

Зайр: - нь уулын нэр бас Зай (Урал) голын нэр болно. Энэ нь Тарвагатай уулнаас эх авдаг. Зайр гэдэг нь түрэг хэлний Жайнка гэдэг

үгийн хувилбар гэж доктор Ж.Цолоо үзсэн. Бидний бодлоор бол Сайр гэсэн үгийн хувирсан хэлбэр бололтой.

Бор тал: Хятад улсын Шинжианы Тарвагатай аймгийн нутаг. Бор талын монгол аймаг ч гэнэ. Зая бандидын намтарт гардаг газар. Энэ тухай доктор Ж.Цолоо “1648 оны өвөл Зүй хэмээх газар Авлайн дээр Зая бандида Тод үсэг зохиогоод 1649 онд Бор талын сүмийн ойролцоо Хар бутанд ирж өвөлжжээ. Сэнгэ хун тайжийн хүү Галдан Бошготын ач хүү Цэвээнравдан Бор талаар суурин болгож бүх зүүн гарыг нэгтгэж Уйгар Харашарын хойт ба бүх хотны газрыг эрхэндээ оруулаад Зүүн гарын жинхэнэ хаан болжээ” гэж тэмдэглэжээ.

Хүнхэс: Тэнгэр уулын дунд биед орших Илийн голын нэгэн цутгалан. Тод үсгийн номд Хүнхэс, Күнгүс, Хүнгэй, Күнгэй гэж янз бүрээр бичсэн байдаг. Төвдөөр Хүнгүс гэж тэмдэглэсэн. Зарим эрдэмтэд Хүнгээн Алтай гэдгийн Хүнгээнтэй холбосон байдаг ба бидний үзсэнээр Хүнх гэдэг язгуурт “с” гэдэг олны дагавар залган үүсгэсэн нэр бололтой.

Хаш: голын нэр.

Тэхэс - Тэхэс гол нь Хашийн голтой нийлээд Илийн гол болдог. Одоо Хятад улсын нутагт буй. Баянголын монголчууд нутагладаг.

Илийн газар: Илийн голын сав газар буюу Илийн хөндий. Шинжианы нутаг. Зүүн гарын улсад байсан хамгийн нэртэй сүм болох Гулз, Хайнаг хэмээн хоёр том сүм Илийн голын хөвөөнд байв. Галдан бошгот үүсгэн байгуулсан гэдэг. Гулз гэдэг нь Угалз гэдэг үг болно.

Тэхэс: голын нэр. Хашийн голтой нийлээд Тэхэс гол нь Илийн гол болно. Одоо Тэхэс сияан гэнэ. Зүүн гарын хуучин нутаг, одоо Хятад улсын нутаг. Тэкис, Тэгис гэхчлэнгээр бичнэ. Нэрийн гарал нь Тэх (янгирын) гэдгийн олон тооны хэлбэр болно.

Жүлтэс: Жултус: Тэнгэр уулын дунд хэсэг, Эрээн хавиргын өмнө бие Күнкүс, Тэхэс хоёр голын зүүн биеийн олон уулаар хүрээлэгдсэн өндөрлөг хөндийд бий. Одоо хятад улсын Шинжианы Баянголын монголчуудын буй Хэчин сияанд байдаг. Их жултус, Бага жултусийн хоёр бэлчир нь Хайдагийн гол болно. Жултусыг одоо Баянбулаг гэнэ. Жүлтэс нь түрэг гаралтай үг бөгөөд казакаар Жүлдыз

буюу “Од” гэсэн утгатай.

Түсхүл нуур: Дөрвөн Ойрадын үед Төмөрт уул гэж байсан. Одоо казак, киргиз хэлээр Иссык күл нуур гэнэ. Тэнгэр уулын баруун биеийн уулархаг газарт бий. Урьд зүүн гарын нутагт байсан. Одоо киргизийн нутаг болно. Түсхүл гэдэг нэр нь эртний түрэг хэлний tuz (давс) + kul(нуур) гэсэн Давст нуур гэсэн утгатай болно..

Шар бэл- Бор талын баруун бие дэх Хан Харчигай уулын баруун үзүүрт байдаг. Урьд Зүүнгарын нутаг байсан. Одоо Казакстаны Алимтайн харьяа газар болно. Энэ нутагт Зүүн гарын түүхэнд онц холбогдолтой хэд хэдэн түүхэн үйл явдал болж өнгөрчээ. Энэ тухай доктор Ж.Цолоо: Энэ нутагт 1676 оны өвөл Жүлтусын Күнгүс голд уруудаж ирсэн Цэцэн хаан, Галданбошгодот баригдсан, 1756 онд Амарсанаа Шар бэлд Чин улсын цэрэгтэй хамгийн эцсийн удаа байлдсан тухай мэдээлсэн буй.

Хар тал: Бор талын Хан харцгай уулын баруун биеэс эх авч Балхаш нуур: цутгадаг гол. Хөх усан, бичгийн голын сав газрыг Хар тал гэдэг. Зүүн гарын нутагт байжээ. 1660 онд Зая Бандида Хар талд хоёр дахь удаагаа ирж өвөлжсөн ажээ.

Хөх усан- Ийм нэртэй газар эл нутагт гурав байжээ. Энд гарч буй Хөх усан нь Жултусын баруун хэсгээс эх авч Тэкэс голд цутгадаг гол бололтой. Бас Алтайд ийм нэртэй газар бий.

SACRED SITES OF THE OIRAD



Information on the sutra:


The sutra was written by an unknown author and describes sacred sites within the territories once occupied by the Oirads ethnic minority group.

The manuscript mentions numerous rivers such as the Bulgan and Tsagaan

rivers, and areas around the Altai mountain range.

Some of the sacred places mentioned in this text such as Khovog Sair, Emel, Zair and the Bor-tal areas and the Erchis and Irtysh-rivers are now situated in China and Russia, indicating the wide area in which the Oirads traditionally lived.





**ОЙРАД ОРНЫ ТЭНГЭРИЙН
САН ОРШВОЙ**

Намо гүрү бхая: Энэ Ойрад орны тэнгэрийг ариусган үйлдэхийг хүсвээс сангийн зай сэлтийг сайтар бэлтгээд тангараг бат алив тэнгэрийг дотроо бясалгал омог төгс болгоод:

Ум аа хум хэмээн гурвантаа уншин адистидлаад бурхны сэтгэлийн угаас саарсан гэрлээр энэ орны дотор багтан буй тэнгэр, лус, тэнгэр бус, бодинар тэргүүтэн хамгийг урин дуудмуй.

Гама ла еэ сдам

Зэ

Тахилын эд эс болох цэцэг, хүжис хийгээд

Тансаг үнэртэн, зул, идээ ундаа сэлтэс

Таалалт бүжиг, хөгжим, хүслийн таван эрдмээр

Тахил тавиг өргөмүй, таалан соёрхох ажаамуу.

Тогосын хоолойн өнгө мэт сэтгэлд зохистой

Тон үзэсгэлэнт дээд хүчит морь, ямаа, хонь

Сүр жавхлант тэмээ, сарлаг, үхэр тэргүүтнээр

Сүжирхэн баясгахаар орны тэнгэр нартаа өргөө.

Өргөлийг таалан соёрхож, хагацашгүй

Өмөг садан болж хайрлагтун.

Сайн хив торго, зэр зэвсэг, банжид дувааз

Сайн эм, есөн хүслийн эрдэнэсийн хөмрөг

Сан сэржим, элдэв зүйл идээ ундаа сэлтээр
Сац их орны тэнгэрсээ баясгахын тулд өргөө.

Таалан энэрч, өмөг түшиг хийгээд
Тасаршгүй садан амраг болж хайрла.

Зээ,

Улаан цагаан зандан, агар болон

Улалж, гавар, гүргэм тэргүүтэн

Улмаар задь, бойгор, даль

Ургамал башуг, сүлү, агь

Утлага сангийн мянга мянган эд эс

Ундаа идээ элдэв болоод самар

Ургамал модны олон зүйл үр жимсийг

Хайлсан алт мэт гал бадраан асааж

Хан огторгуйг утаан үүлээр нь бүрхүүлж

Ойрад орны тэнгэр, шивдаг

Огоот хамаг бүхнийг ариусгамуу.

Алтай, Эрчис, Ховог сайрын газрын

Аливаа уул нуруу, далай цөөрөм, урсгал мөрөн

Ариун найлзуур, ой шугуй, зам харгуйд оршсон

Адбиш тэнгэр, лус, тэнгэр бус, бодинарыг ариусгая.

Эмэл, Зайр, Бор талын газар дахь

Энэ уул нуруу, далай цөөрөм, урсгал мөрөн

Эгнээ ой шугуй, найлзуур, зам харгуйд оршсон

Эрхин тэнгэр, лус, тэнгэр бус, бодинарыг ариусгая.

Хаш, Хүнхэс, Илийн үндсэн нутаг дахь

Хамаг уул нуруу, далай цөөрөм, урсгал мөрөн

Харгуй зам, ой шугуй, найлзуур модноо оршсон

Хан тэнгэр, лус, тэнгэр бус, бодинарыг ариусгая.

Тэхэс, Жүлтэсийн орчин нутаг дахь

Тэр л уул нуруу, далай цөөрөм, урсгал мөрөн

Тэр л найлзуур мод, ой шугуй, зам харгуйд оршсон

Тэнгэр лус, тэнгэр бус, бодинарыг ариусгая.

Түсхүл нуур хийгээд Шар бэлийн газар дахь

Түмэн уул нуруу, далай цөөрөм, урсгал мөрөн
Ой шугуй, найлзуур мод, зам харгуйд оршсон
Олон тэнгэр, лус, тэнгэр бус, бодинарыг ариусгая.
Хар тал хийгээд Хөх усны нутаг дахь
Хавийн уул нуруу, далай цөөрөм, урсгал мөрөн
Харгуй зам, найлзуур мод, ой шугуйд оршсон
Хамаг тэнгэр, лус, тэнгэр бус, бодинарыг ариусгая.
Богд алаг уулын бүх орчин нутаг дахь
Болдог даваа, далай цөөрөм, урсгал мөрөн
Босоо зам харгуй, найлзуур мод, ой шугуйд оршсон
Бодинар тэнгэр, лус, тэнгэр бусыг ариусгая.
Ойрад орны бүх орчин нутаг дахь
Олон уул нуруу, далай цөөрөм, урсгал мөрөн
Ой шугуй, найлзуур мод, зам харгуйд оршсон
Онгон тэнгэр, лус, тэнгэр бус, бодинарыг ариусгая.
Булган, Чингэл, Цагаан голын нутаг дахь
Буман уул нуруу, далай, цөөрөм, урсгал мөрөн
Ой шугуй, найлзуур мод, зам харгуйд оршсон
Олон тэнгэр, лус, тэнгэр бус, бодинарыг ариусгая.
Нэн ялангуяа энэхүү орны бүх газар нутгийн
Нэлэнхүй уул даваа, далай, цөөрөм, урсгал мөрөн
Ой шугуй найлзуур мод, зам харгуйд оршсон
Онгон тэнгэр, лус, тэнгэр бус, бодинарыг ариусгая.
Зээ,
Ариун бус идээ ундаа, хувцас хунар хийгээд
Аху бие, сэтгэл, зарлиг лугаа харшлах бүхнийг ариусгая.
Тангараг дамцаг доройтон өш хонзон элбэгшиж
Тавгүй хирт сэтгэлийн гай гамшиг дэгдэн
Таагүй улай ярга, бэлэвсрэлийн гамшиг болсныг ариусгая.
Бусармаг явдал, хэрүүл тэмцлээр бузардсан болгоныг
Буй тэнгэр, хүмүүнд тохиолдох түйтгэр бүхнийг
Бултад хоцроолгүй тахиснаар ариун болтугай.
Есөн хүслийн тансаг эд эдлэлийг таалан соёрхож

Ер үйл, үйлдвэр алив хамаг сэлтийг ч
Омог атгаггүйгээр явуулахад зохилдох нөхцөл
Осолгүй сэтгэлчлэн бүтэхийг ивээн хайрла.
Ойрад зүгийн орны хуврагын аймаг өргөжөөд
Онол бүтээлийн зохилдох нөхцөл сэтгэлчлэн бүтэж
Шашин номын өглөгийн эзний заяа зохистой арвижин
Цог учралыг үл бууруулан мөнхөд дэлгэрүүлэн зохиотугай.
Ариун эдлэл, нөхрийн чуулган, эрүүл оршихуй ёсон
Аз заяа, санасан хүссэн ёсоор үргэлжилж
Аливаа эд баялгийн үр дээд амгалан
Аяндаа илтэд дэлгэрэхийн эрхин үйлсийг хайрла
Сац бас ертөнц амгалан болоод
Сайн тариа, үр жимс дэлгэрч, сүрэг арвижин
Сайн амгалан хамаг бүхэн үүсэн гараад
Санасан хүссэн бүхэн үүдэн гарах болтугай.

ЗҮҮН ГАР ДӨРВӨД ОРНЫ ШИВДАГТ САН ТАХИЛЫН ТУХАЙ

Энэхүү судрын төгсгөлийн үгээс үзэхүл “бодьтой буяны садан Даа лам Самданпунцаг-бээр өөрийн орны тэнгэр, шивдагуудад сан тахил хэрэгтэй гэж дурдсаны урмаст ... Янжингаавийлодой найруулав” гэжээ. Үүнээ хамгийн сонирхолтой нь найруулсан хүн нь болно. Янжингаавийлодой нь XIX зууны үеийн төвдийн зохиолч бөгөөд энэ хүний тухай нэрт эрдэмтэн, доктор Д.Ёндон “Монголын уран зохиолын тойм” (УБ. 1977. II боть) хэмээх номд дурдсан байдаг. Түүний алдар нь Ажа Ёнзон нэрээр алдаршсан бөгөөд “Ажа Ёнзон нь уран зохиолч төдийгүй утга зохиолын онолч хүн байсан байна” гэж доктор Д.Ёндон онцлон тэмдэглэсэн буй. Янжингаавийлодой нь “Цагаан лянхуан баглаан тайлбар-нарны гэрэл”, “Үлгэрийн ном эрдэнэ цогцолсны дохионы тайлал”, “Хөх товхимолын үгийн тайлбар” гэх мэтийн олон сайхан бүтээл туурвисан билээ.

Энэ сударт гарч буй газар усны нэр нь нийтэд алдартай юм.

Хархираа: Түргэн уулын өмнө хэсэгт орших тахилгат уул бөгөөд зүүн урагш 100 км орчим сунаж үргэлжилсэн байдаг. Увс нуурын ай савын дархан цаазат газар багтах энэ уулын хамгийн өндөр цэг нь Цагаан шувуут (4037 м) болно.

Түргэн: Дээр өгүүлсэн Хархираа уулаас баруун хойш 70-аад км үргэлжилдэг. Хамгийн өндөр цэг нь газар зүйч, нэрт эрдэмтэн Ш.Шагдар гуайн тодорхойлсноор 3965м Цагаан дэглий ажээ. Нэг оргил нь Дэнхэрвээ нэртэй, энэ нь эртний тахилгатай.

Хөндлөн гол: Монгол Алтайн нуруунаас буюу түүний салбар Түргэн уулаас эх авч Увс нуурт цутгадаг гол.

Увс нуур: Энэ нуурыг Монголд мэдэхгүй хүн байхгүй. Аймгийн нэр болсон энэ нуур нь их нууруудын хотгорт нилээд цөлөрхөг газарт оршдог, манай улсын хамгийн том нуур бөгөөд нуурын талбайн урт 84 км, өргөн нь 79 км болно. Увс гэсэн нэр нь “гашуун уст” гэсэн утгатай түрэг гаралтай үг юм.

Торхилог гол: Тагнын нурууны өврөөс эх авч Давст, Шүдэн уулын дундуур урсаж, Увс нуурт цутгадаг.

Хяргас нуур: Ханхөхий уулын өмнө этгээдэд 1028 м өндөрт орших давст, тогтмол нуур. Хамгийн урт газар нь 75 км, өргөн нь 31 км, гүн нь 80 м болно. Уг нуурын орших газрыг Хяргасын хотгор гэдэг. Энэ нуурын өмнө талд Хяргас нуурын уул гэгдэх Гилмэнт уул бий.

Ёл уул: Хархираа уулын зүүн өмнө этгээдэд Шивэр голын нэг эх болох Гooжуурын гол эх авдаг уул.

Ачит нуур: Монгол Алтайн хамгийн том нуур, урт нь 24 км, өргөн нь 18 км, гүн нь 5 м. Энэ нуураас нилээд гол урсаж Ховд голд нийлдэг.

Намир гол: Хархираа уулаас эх авч Хар-Ус нуурт цутгадаг.

Яргайт: Хан Хөхийн нурууны ич этгээдэд Хяргас сумын төвөөс баруун ургааш орших 2302 м өндөр уул.

Улиастай гол: Түргэн уулаас эх авч баруун урагшаа Ачит нуурт цутгадаг.

Ховд гол: Алтай таван богдын зүүн талаас эхлэх Цагаан голоос эх авдаг. Сагсай, Согоо, Цагаан гол томхон цутгал нь болдог. Ховд гол Хар-Ус нуурт цутгадаг. Энэ голын тухай олон сайхан дуу шүлэг буй.

Шивэр гол: Түргэн уулын энгэрээс эх авч урагш урсан Ховд голын зүүн гарт нийлнэ.

Шаазгайт нуур: Хархираа уулаас урагш Ховд сумын нутагт орших уртаараа 5 км, өргөнөөрөө 2 км Давст нуур.

Завхан: Хангайн баруун хажуугаас эх авч 808 км урт урсаж Айраг нуурт цутгана.

Эцэст нь тэмдэглэхэд энэ сайхан судрыг одоогийн Увс аймгийн Улаангом сумын Дэчинравжаалин хийдийн умзад лам К.Бөхчулуун өөрийн гараар хуулж өгсөн болно.

ЗҮҮН ГАР ДӨРВӨД ОРНЫ ШИВАТТ
САН ТАХИЛ ӨРГӨХҮЙ

Аяа,
Млгуусан номын төвийн арилгасан ордоос
Мзгуур үндэсний лам, ядам, тэнгэрс



Хурмаггүй дээд гурав, зарлигийн элчис тэргүүтэн
Хутагт ариун тахилчын энэ оронд зардан соёрх
Зүдгүүргүй буювнт сайхан тэмдэг, хишгийн сүр жавхлан
Зүүн гар дөрвөд хэмээн алдаршсан газрын

Зүйлийн Өлзийт уул, хонхор төхөм, тал зэрэг
Зүг сайн энэ оронд нуур ус, гол мөрөн элбэгшээд
Алдарт далайн эд тэргүүтэнд оршин тогтоод

Аугаа хүчнийг барих хүний буюн хишин
Орны тэнгэр, шивдаг бодинарын чуулган
Олон эгч нөхөд сэлтүүд

Онц багсаагчид сан тахилын орон энд залрагдун.
Есөн хүслийн тахилын үүдэн битүү бүрхсэний төвд
Ер сэтгэл булаам тавцан ширээгээ лэвнхувьт заглаад
Зөөлөн эелдгээр үгтээсэн лэвсгэр тэргүүтэнд
Зөн багсаар мөшөө өнгө сүлдээр батад оршигдун.

Аяа,
Алтан хаймал мэлтэлсэн адил галын дунд
Амт шимтэй элдэв эм, хивэрлэг торго тэргүүтнийг
Авар шатаасан утаан үүдэн отоггүйг дүүрсгээд
Авуурьд бодьтой бэлтгэсэн, сэтгэлээр хувилгасан тахилын элдээр
Мзгуур үндэсний багш хамгийн ариусгая.
Мдам, дээд гурав, зарлигийн эздийг ариусгая.
Млангуяа энэхүү орны зүгийн
Млгуусан ерднийн банжид болсон Улангом
Ухэлгүй мөнхийн рашаан болсон Хархираа
Узэмжит цаст биндэрьяа болсон Түргэнээ ариусгая.



Үнэхээр сэтгэлчлэнгийн эрдэнэ болсон Хөх нуур
Үзвээс өнгө тунамал гэгээн гэрэлт Хөндлөн
Амьтан зоны эгээрлийг хангагч Увс нуур
Аливаа үр тариаг бүрдүүлэгч Юлтыг ариусгая.
Асарлах Хандгайт хийгээд Торхилог гол
Арц бойшигт Хяргас нуур
Амирлуулагч Ёл, Баян айраг тэргүүтэн
Ачит, Хайланбуугаа асар сайнаар ариусгая.
Ариун Намир, Тогтохын нуруу
Аяа бас Жаргалант, Яргайт
Алдуурашгүй Улиастай, Ховдын гол
Амьд Шивэр, Шаазгайтаа ариусгая.
Ачтай тустай Олон нуур ба Завхан
Алтай, Хан Хөхий тэргүүтэн
Асар догшин уул, хэвцэг бэрх лусад оршсон
Агуу хүчит тэнгэр лусын нөхөдийг ариусгая.
Нуур, далай цөөрөм бүрд, ой цэцэрлэг зүлэг модон
Нутаг орны зам харгуй, хавцал ганга, хонгил хөндийд
Тус тус эгүүрд оршин тогтсон
Тухайн бодинарын нөхөд сэлт хамгийг ариусгая.
Ариулсанаар үл ариуссан аливааг, бас бус
Ариун тангараг эвдэрсэнийг үл хоцроон ариусга.
Алагчлалгүй бас бус сэтгэлээр хувилгасны
Аливаа хэрэгтэй бүх л эд таваарыг хоцроолгүй өргөө.
Бид бүхний үйл явдал нь эс мэргэний тул
Бие, хэл, сэтгэл гурванаа харшилсны
Билэггүй гэм алдал алин буйг өгүүлэн наманчилмуу.
Билбүүргүй хүлцэн таалж сахин аварч өршөө.
Энэ л зүгийн орноо хур усан цагтаа бууж
Элбэг дэлбэг тариа ногоо, өвс ургамал ашид дэлгэрээд
Энэрэлгүй үл зохилдох доройтлын нэр ус нь ч арилж
Эрхэмсэг өлзийт буяны бэлгийг бүтээх болтугай.
Хуврагийн аймгууд сэтгэл санаагаар зохицоод

Хуурмаггүй гурван суртахууны номлол бүтээл арвидан дэлгэрч
Хутаг өглөгийн эзний хүчин барилдлага, язгуур үндэс арвижин
Хурднаа учрал төгс цог-дор цэгнэх болтугай.
Үр, мөр, шүтээн гурав оршлоо ч
Үл алгасан өдөр шөнийн харуул манаа болтугай.
Үүнд аливаа санасан бүх хэргийг хоцроолгүй
Үйлс өөсөөн бүтээхийн өлзийг оршоох болтугай
... Ом аа: Базра му: Зочид нөхөд сэлт энэ орноо залрах болтугай...

АЛТАЙ ХАН

Эл сангийн судар Хэл зохиолын хүрээлэнгийн харьяа академич Ц.Дамдинсүрэн агсны гэр музейн хөмрөгт ТН-154 гэсэн дугаартай хадгалагдаж байгаа болно. Орос цааснаа хар бэхээр маш гаргацтай бичсэн 7 хуудас энэ судрын хуудасны дугаарыг төвд үсгээр самгарди хэлээр тэмдэглэжээ.

Зохиогч нь Ишлуvsсандамбийгомбо гэдэг хүн бөгөөд уг судрыг Ойрад нутгийн Дөрвөн аймаг буюу Дөрвөдийн нутаг Алтайд зориулжээ.

Энэ сударт Алтай нутгийн хэд хэдэн газар усны нэр гарч байгаа нь гол төлөв тахилга шүтлэгт газрууд болно.

Борхайрхан – Увс аймгийн Хяргас сумын нутагт орших /д.т.д 2511 м өндөр/ илжгэн халхын дөрвөн сум. /Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан, Завхан сартуул/-ын тахилгат уул болно.

Баянхайрхан – Увс аймгийн Малчин сумын нутаг дахь /д.т.д 2270 м өндөр/ тахилгат уул.

Хангилцаг – Хангилцагийн даваанаас эх авч Хан-Хөхийг сэтлэн баруун хойш Увсын хотгороор Увс нуур луу чиглэн урсдаг гол. Бөөрөгийн элсний баруун өмнөд хэсэгт ороод ширгэнэ. /х.ө. 50, з.у. 93 21-д оршино/

Нарийн гол: - Баяннуур, Бориг дэл элсний булгаас эх авна. Дал гаруй км урсаж Увс нуурт цутгана. Адагтаа их ширэнгэ буттай, хойшоо Тэсийн голын ширэнгэтэй нийлнэ. /х.ө. 50 22, з.у. 93 20-д оршино/

Эдгээрээс гадна Эрдэнэхайрхан /тахилгат/ уул, Улаан гол, Ус буух, Суман гол зэрэг энэ нутгийн гол усны нэр гарч байна.

ALTAI SACRED MOUNTAINS

Information on the sutra:

This sutra-manuscript was written by Ishluvsandambiigombo in dedication to Altai region, the land of the Oirad. The sutra is written in Sanskrit language using Tibetan characters.

The sutra describes the sacred mountains and rivers in the Altai region, such as Mount Borkhairkhan (2,511 m.), Mount Bayankhairkhan (2,270 m.) and the Khangiltsag and Nariin Rivers.

The Altai mountains are Mongolia's largest and highest mountain range, measuring 200 to 300 kilometers in width, and 500 kilometers in length with an average altitude of 2,260 meters and with summits up to 4,000 m. The mountain range connects with the extensive Gobi-Altai mountain ranges.

Handwritten text in a rectangular frame, likely a page from a manuscript. The text is written in a cursive script and is partially obscured by dark ink smudges.

Handwritten text in a rectangular frame, likely a page from a manuscript. The text is written in a cursive script and is partially obscured by dark ink smudges.

Handwritten text in a rectangular frame, likely a page from a manuscript. The text is written in a cursive script and is partially obscured by dark ink smudges.

Handwritten text in a rectangular frame, likely a page from a manuscript. The text is written in a cursive script and is partially obscured by dark ink smudges.

Handwritten text in a rectangular frame, likely a page from a manuscript. The text is written in a cursive script and is partially obscured by dark ink smudges.

Handwritten text in a rectangular frame, likely a page from a manuscript. The text is written in a cursive script and is partially obscured by dark ink smudges.

АЛТАЙ ХЭМЭЭН АЛДАРШСАН ОРНЫ ШИВДАГУУДАД САН ТАХИЛ ӨРГӨХ ЁС ХЭМЭЭГДЭХ ОРШВОЙ

Намо гүрү базра бхайрава ябхяа. Эндэх их Монголын орны газраас Ойрад дөрвөн аймгийн доторх Дөрвөд хэмээн алдаршсан нэгэн хэсэг аймгийн нутаг газар Алтай Хангай хэмээх газрын шивдагуудад сан залбирал үйлдэхийг хүсэхүл дэлгэрэнгүйхнээр үйлдвээс усан тахил хоёр, чухаг хэрэгтэй эдлэл, цэнгэлийн төгрөг цагаан балинг жимс, бурам, гурван цагаан идээ, гурван амттанаар чимэглэсү. Хонины цагаан махыг баруун гартаа барьж, бас бус цай, архи, айраг, сүү, тараг, цэгээ тэргүүтэн ба самар, жимс тэргүүтэн нутгийн ёсны гэгээн сайн саран, мэсийн билэгдэл, торгон хувцас зэргийг зурж, хадаг банждыг хийлгэж, морь, үхэр, тэмээ, ямаа, хонь тэргүүтэн хөлөөр явагчдын өвөрмөцтөнийг бодитойгоор болон дүрс хөргийг инагш чинагш багтаан алинаа учруул.

Арц, агь, балуу зэргийг ариусгаад элдэв хүжийг галаар сагнаад их утааг эгүүтгэх ба өөрийн ядамыг алимад үйлдэн эн тэргүүнээ өөрийгөө баясган тус тусын тахил балинг шүгнэчлэн хийгээд Намхайзодын (Огторгуйн сангийн О.С) зуун тарни болон зургаан тарниар адистидлан үнэнхүү хүчээр өгүүл. Түүнээс гадна хэнгэрэг хөгжим тэргүүтнийг хоршуул.

Жээ,
Уужим замбуутивийн ягчсын зүгийн газарт
Угаас чухаг амарлингуй Монголын орон хэмээх
Цог учрал, эд эдлэл дэлгэрсэн ялгуусан их орон
Цогт Алтай хэмээн алдаршсан орныг баригч нь
Тэнгэрийн онгон догшин уул Эрдэнэхайрхан
Тэгүүнчлэн Борхайрхан хэмээх хийгээд
Баянхайрхан болон Улаан гол
Басхүү Ус буух, Хангилцаг
Нарийн, Суман зэрэг уул усанд оршсон

Навдаг савдаг, их хүчит рид хувилгаантан
Энэ орны сав шимийн учралыг тэтгэн үйлдсэн
Эрхт тэнгэр, лус, ягчсын язгуур болсон бүгдийг
Өдгөө тахилын зочноор урин дуудан үйлдвээс
Өөр өөрийнх нь язгуурт багтсан нөхөд сэлтүүд нь
Өвөрмөц зэмсэг чимэг хийгээд, унаа хөлгийн хамтаар
Өнид өөдлөн заларч хайрлагтун, эн тэргүүнээ.
Ямар мэт барилдлагын тахилын зай, жансиг тэргүүтнийг
Ягштал бодитой бэлтгэн сэтгэлээр хувилгасан
Ямарваа чухаг хэрэгтэй эд эдлэл цогцолсон хот мандал энд
Янагш өөдлөгтүн, баясгалангийн дүр байдалтайгаар
Эгүүрд тахиснаар түүнээс янагш батад залар.
Эрхэмлэж юу даатган захьсан үйлсийг бүтээхийн тул
Эндэлгүй бэлдсэн тахил балингаар баясган цэнгүүлж
Эгээрч санасан хэргийг хоцроолгүй сэтгэлчлэн бүтээ.
Өмнөдийн эрдэнийн сайхан ордон, торгон хувцдын
Өнгө үзэмжит уужим өргөөний тавцант сууринд элдэв чуулган
Өөдлөн залраад тахилын цогцлол, эндэхийн эд эдлэл
Өв тэгш орон зүгийн буяны билэгийг боловсруулан батад
залрагтун

Сангийн тахил нь:

Жээ,
Элдэв эрдэнэсийн язгуураас бүтэн бүрэлдсэн
Энгүй уужим үзэсгэлэнт саваар дүүрэн ундааны үргэлжлэл
Эээр бэлгэдсэн цайны шим, найман гишүүн төгөлдөр ус
Энгүй цагаан сүү, тараг цэгээ, үр жимсний дарс
Асар цагаан сүү тараг, цэгээ, үр жимсний дарс
Аагт нэрмэлийн архи, арз, харз, тэргүүтэн
Арилагсан ундаа сэржмийн зүйлийн тоо нь сэтгэснээс
нөхцөлд
Амтат цагаан үр элдэв төрлийн идээг найруулсны
Ариун зуун амтат бүхэн, тэнгэр бурхны зоог

Цагаан тос, цөр хөөрүүлсэн сүү бонго зэрэг
Цагаан зайг сэтгэлд зохистой төгс болгоод
Ямаа, хонь, үхэр, гөрөөс тэргүүтний
Ямарваа махыг чанан шатааж болгоон найруулах ба
Эмийн багсарга хольсон идээ сэлт элдэв шимтийг
Энгүй нарийн хив торгон хувцас, элдэв сайн бөс даавуун
Эв зөөлөн суудал, намилзан туналзсан баринтаг, малгай
хувцас

Эрдэнэт чимгийн зүйл, хуяг дуулга, зэр зэвсгийн зүйл
Галт сумны аргасын хүрд, илд, сум, жад
Гажууд дайсныг дарагч элдэв мэсийг зэхэн тавиад өргөмүү
Тэнэмэл араатны арьс, агт морь, луус уналга
Тэмээ, ямаа, хонь, үхэр тэргүүтэн хөлөөр явагч
Тэвээрэг сайт сүргийн чуулган газар дэлхий алинаа
Тэрчлэн тутрага буудай, буурцаг, хоног, амуу, гүнжид
тэргүүтэн

Аливаа зүйлийн үр тариаг амсар бялхтал дүүргэсэн хүү сан
Алт мөнгө, шүр сувд, лавай номин хийгээд
Олон зүйл эрдэнэсээр дүүргэсэн сан хөмрөг тэргүүтэн
Онцолбоос тэнгэр хүмүний чухаг хэрэгтэй эд агуурс бүхнийг
Огоот тарнийн өнидийг баригчийн чадлаар машид арвитгаад
Огторгуй тэнгэрийн нөхөд лугаа сэлтэд өргөснийг таалагтун
Энэ орноо оршсон төрөлхтөн бүхнийг хоцроолгүйгээр
Эс мэдсэний эрхээр гурван үүдний гэм авсныг шинжилсний
Эрхин дээд бурхны таалалд харшлах гэм алдсын чуулганыг
Эс хоцроон наманчилж ариутгасныг өршөөн соёрх
Онгон модыг огтлох, догшин газрыг малтах хийгээд
Олон гөрөөсний амь бүрэлгэх, тангарагийн үг алдах, сүр
хиншүү тавих

Дээрхийн бурхны таалалд харшилсныг үтэр түргэн чин
зүрхнээсээ залбиран

Дээдийн эндэл болсон гэрийн бараан үүлсийн чуулганыг

Зориуд гэмшихүй сэтгэлээр боомтлон, хуй салхиар үлдэн
хөөж

Зоригдол үгүй сацралаас хагацсны агаарт наманчлан
үйлдсэнээр

Зохилдлогогүй доройтлын орноос ялгуух болтугай

Магтаал нь:

Жээ,

Үлэшгүй буяны үйлнээ машид боловсорсон

Үлэмж буянт зуны усан сангаас эгүүдэгсэн

Үнэхээр ширүүн хүчин чадлын цогийг эрхшээн учруулсан

Үзвээс догшин шивдагийн нөхөд сэлтийг магтмуу

Асар цагаан сэтгэлийн орны сав шимийн

Адьбиш буяны билэг тэмдгийг арвитган, хойхор харгисын
өмгийн

Алимад дайсны аймгийг хотлоор нь даран зохиогч орны
тэнгэрийн чуулган

Аль буй нөхөд сэлтсийг би-бээр магтсан болой

Тоолшгүй тэнгэр мангас, найман аймгийн өмгийн төвд

Тотгоргүй цагаан зүгийг тэтгэсэн банждыг эгцлэн босгож

Асар сайн дөрвөн үйлсийн цогт хүчнийг аху ихээр

Аяа эндэх сансарт оршсон дээд-нүгүдийг магтая

Урьд насны төрөл олон дээдийн нигуурыг толилоод

Учралын дээд номын рашааны сайн шимийг машид

хүртсэнээр

Урвашгүй өнид бутны мөрт оршсон хамаг төрөлхтөнүүдийн

Урмаст тус амгалангийн цогийг тэтгэн зохиохуйг тань магтая

Даатган соёрхох нь:

Тэр мэтээр энэ орны догшин тэнгэр нөхөд сэлтийг

Тэрчлэн учралын тахилын чуулганыг сайтар тахиад магтаад

Энэхүү орныг чухагаар авран сахиж зохист болгоод

Эрхшил айлтгаж зүрхнээсээ эгээрэл хүслийн үрийг

Дэлгэр уужим ялгуусан орон бүхэн ба энэ орон зүгт
Дээрэнхүй догшин савдгуудын сайтар тэтгэсний чадлаар
Үл хүсэхүй нитгэл цөвийн доройтол бүхэн арилаад
Үнэн шашныг болгоохын сайн чуулган бүхнийг арвитга.
Зөөлөн цогт эгшиг, бодтой бүхнийг айлдагч Зонховын
Зөвхөн хиргүй шашин номын ёсыг барьсан хуврагууд
Зөнгөөрөө насад олз хүндлэлээр баяжин, номлол бүтээлийн
Зөв сайн зохиол зуны хур усан адил балинд зочлон болгоо
Чухаг дээд эрдэнэт тахил болон албат иргэдийг амтуулсан
Чухам буяны цогоор явдлын газрыг тэтгээчингүүдийн
Нас цаг, язгуур, үндэсний хүчний барилдлага арвидан
өргөжөөд

Маш цагаан буянд орох мөрийн явдлыг зохио.
Урьдын хураасан сайн муу завсрын үр нь
Явдлын дээд доод завсрын төрөлхтөн амьтан бүхнийг
Насад арван буяны биед лагшинд оруулан
Амар жаргалын барилдлагаар хэзээд эс ядангитахыг зохио
Энэ орон зүг бүхнээ зун цагийн ган гачиг хийгээд
Элдэв хяруу мөндрийн үндэс, аалз арваалж тэргүүтний
Үр жимс өвс ургамал зэрэгт гоц хөнөөл хүргэх
Үл хүсэхүй харшлах нөхцөл бүхнийг амирлуулагтун
Өвөл хаврын пасны язгуур, улаанхуй тэсгэм хүйтэн
Өч төчнөөн хүн малын амь биеийг дайсагнаж болохыг
Өдгөө үлдээлгүй амирлуулаад, цаг бүхний хур усыг төвшитгөн
Өвсний шим, тариа төмсний хувь бүхэн дэлгэрээд
Мал сүрэг арвижин, эрдэнийн хувцас, хортой торго
Манлай зүгийн арилжаа наймааны үйлийн үүд аяндаа үүдээд
Тэнгэр, хүмүүн хатад ихсийн асрахуй тэтгэхүй
Тэр бүхий сайн чуулган хоцролгүй арвижин дэлгэрч өнид
оршихыг зохио

Эвдрэл хямрал, халдвар хижиг өвчин, зуд турхан, хэл ам
Илэрхий цуу шуугиан, цэрэг дайны аюул, хааны ял цааз,
Сав шимийн бүхэнд тэрсэлдэхийн онцын хор хөнөөлийн

Саар нэр нь ч эс алдаршин амгалангаар амирлуулахыг зохио
Тэр мэт залбирснаар даатгасан үйлс бүхэн
Тэнсэлгүй бүтэж, бас бас өөрийн орноо ажраад
Тэгдрэлгүй тахьж урин залахуйн цагт залраад
Тэнгэрлэг энэ орны зочноор ирж тангарагийг хатуу сахин
Эрдэмт багш, дээд гурав сахигч эхийн үнэн хүчний
Эрхин дээд бурхны нөхөд сэлт энэ орны цогт хийдэд
Эрхшил өргөн суу залиг тэгшид магтваас
Эрх чадлын сүр жавхланг таалахуйд арвидах болтугай.
Сансар нирвааны орны буяны билэг тэмдэг, цог учрал бүхэн
Сац эдүгээ энд оршсон хишгийг чухалчлан урин дуудваас
Зуны цагийн зөөлөн хур мэт сайн буяны
Шид бүтээлийн барилдлагаар өлзийт их хурыг буулга
хэмээсэн шар малгайтны шашны ринбүүчий эеэрийн нууц эмд
зүрхнээсээ сүслэн биширч тахихуйн шашны их өглөгийн эзэн Ойрад
дөрвөн аймгийн дээдэс, дөрвөдийн ноёд, албат харцсын орон нутаг
Алтай хэмээн алдаршсан орны дэлхийн эздэд сан тахил оргох ёсыг
дэлгэрүүлэх нь чухаг хэмээн үрийн үүдийн олон хуврагын язгуурт
Алтай дөрвөө хошууны равжамба Шэйравням хийгээд Жамбасамбуу
хоёул-бээр Гүсүнтүгийн мандал шүтээн сэлтийг дурдсаны мэтэст энэ
орны дэлхийн эзний дүр байдал зэрэг ямар байгаагаас бусдыг гоомой
бичиж чадавч харшлахгүй ёсны сан тахилыг өчүүхэн дэлгэрүүлсэн
төдий үүгээр ч Басо хувилгааны нэр баригч ялгуусны төлөөх үүрэгт
даамал дацаваа, Ишлуvsанданбийгомбо бичсэний сайн буян
арвижитугай.

АРВАН БУЯНЫ БЭЛГЭ ТӨГС ИХ ТЭНГЭР ХАНГАЙ ХАН

Энэхүү Хангай ханы сангийн судрыг Өндөр гэгээний дотны шавь ламын гэгээн Лувсанданзанжанцан (1639-1704) төвд хэлээр зохиожээ. Ламын гэгээний бүтээлийн жагсаалтыг байцаан үзвэл түүний нэгдүгээр ботид “Хангай ханы шивдаг” гэсэн зохиол тэмдэглэгджээ. Улсын төв номын сан, Гандантэгчинлин хийдийн номын санд хадгалагдаж байгаа дөрвөн боть сүм бумынх нь нэгдүгээр ботийг шүүж үзсэн авч харамсалтай нь дээр дурдсан сангийн судар болон бас бус хэсэг бусаг судар үрэгдсэн байв. Харин ШУА-ийн хэл зохиолын хүрээлэнгийн төвд хөмрөгт Хангай ханы нэг сангийн судар хадгалагдаж байсныг үзвээс эцсийн хуудас нь дутуу байв. Гэтэл Хангай ханы дөрвөн судар хувийн цуглуулгад байсныг тулгавал нэг нь тус судрын хуулга болох нь тогтоогдсон тул нэгийг нөгөөгөөр нөхөн энд орууллаа. Төгсгөлийн үгийг үзвэл цорж Лувсаннамжил бээр дурдсанд бурханы тойн Лувсанданзанжанцан найруулсаны бичээч нь Гэлэнравдан гэжээ.

Энэ сангийн судрын нэг сонирхолтой тал нь Хангай нутгийн ан амьтан, араатан жигүүртэн, мал сүрэг, савдаг шивдагт хангал өргөсөн явдал болно. Ялангуяа зүрх цагаан хар нохой, их савагт догшин халтар сарлаг, хар хонин сүрэг зэргийг онцлон дурдсан нь жинхэнэ монгол ахуйдаа зохицуулсан ажээ.

Хангайн хан, Хангайн нуруу нь Монголын төв хэсгээр Цэцэн хайрханаас эхлэн зүүн тийш Дэлгэрхаан уул хүртэл 700 орчим км үргэлжилсэн урт нуруу юм. Хангай гэдгийн хан нь хаан, хан гэсэн үг бус ханхар гэсэн утгатай үг болно. Архангай, Өвөрхангай, Зүүнхангай, Баруун хангай гээд зүг чиг байрлалаар нь ялгаж ирсэн нь ханагар уудмын гэрч буй заа.

KHANGAI SACRED MOUNTAIN

Information on the sutra:

This manuscript on the sacred Khangai mountains was written by a Lama Luvsandanzanjantsan in Tibetan language.

The sutra pays a tribute to the sacred places and wildlife found in the region. The sutra is unusual in that its praise focuses on wildlife and domesticated animals, drawing out their individuality by describing their idiosyncracies. Animals described in the text are yaks, dogs, and sheep.

The Khangai mountain range stretches for over 700 km. from Tsetsen Khaikhan Mountain to Delgerkhaan Mountain in Arkhangai and Ovorkhangai provinces.

1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 | 31 | 32 | 33 | 34 | 35 | 36 | 37 | 38 | 39 | 40 | 41 | 42 | 43 | 44 | 45 | 46 | 47 | 48 | 49 | 50 | 51 | 52 | 53 | 54 | 55 | 56 | 57 | 58 | 59 | 60 | 61 | 62 | 63 | 64 | 65 | 66 | 67 | 68 | 69 | 70 | 71 | 72 | 73 | 74 | 75 | 76 | 77 | 78 | 79 | 80 | 81 | 82 | 83 | 84 | 85 | 86 | 87 | 88 | 89 | 90 | 91 | 92 | 93 | 94 | 95 | 96 | 97 | 98 | 99 | 100 |

1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 | 31 | 32 | 33 | 34 | 35 | 36 | 37 | 38 | 39 | 40 | 41 | 42 | 43 | 44 | 45 | 46 | 47 | 48 | 49 | 50 | 51 | 52 | 53 | 54 | 55 | 56 | 57 | 58 | 59 | 60 | 61 | 62 | 63 | 64 | 65 | 66 | 67 | 68 | 69 | 70 | 71 | 72 | 73 | 74 | 75 | 76 | 77 | 78 | 79 | 80 | 81 | 82 | 83 | 84 | 85 | 86 | 87 | 88 | 89 | 90 | 91 | 92 | 93 | 94 | 95 | 96 | 97 | 98 | 99 | 100 |

1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 | 31 | 32 | 33 | 34 | 35 | 36 | 37 | 38 | 39 | 40 | 41 | 42 | 43 | 44 | 45 | 46 | 47 | 48 | 49 | 50 | 51 | 52 | 53 | 54 | 55 | 56 | 57 | 58 | 59 | 60 | 61 | 62 | 63 | 64 | 65 | 66 | 67 | 68 | 69 | 70 | 71 | 72 | 73 | 74 | 75 | 76 | 77 | 78 | 79 | 80 | 81 | 82 | 83 | 84 | 85 | 86 | 87 | 88 | 89 | 90 | 91 | 92 | 93 | 94 | 95 | 96 | 97 | 98 | 99 | 100 |

1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 | 31 | 32 | 33 | 34 | 35 | 36 | 37 | 38 | 39 | 40 | 41 | 42 | 43 | 44 | 45 | 46 | 47 | 48 | 49 | 50 | 51 | 52 | 53 | 54 | 55 | 56 | 57 | 58 | 59 | 60 | 61 | 62 | 63 | 64 | 65 | 66 | 67 | 68 | 69 | 70 | 71 | 72 | 73 | 74 | 75 | 76 | 77 | 78 | 79 | 80 | 81 | 82 | 83 | 84 | 85 | 86 | 87 | 88 | 89 | 90 | 91 | 92 | 93 | 94 | 95 | 96 | 97 | 98 | 99 | 100 |

1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 | 31 | 32 | 33 | 34 | 35 | 36 | 37 | 38 | 39 | 40 | 41 | 42 | 43 | 44 | 45 | 46 | 47 | 48 | 49 | 50 | 51 | 52 | 53 | 54 | 55 | 56 | 57 | 58 | 59 | 60 | 61 | 62 | 63 | 64 | 65 | 66 | 67 | 68 | 69 | 70 | 71 | 72 | 73 | 74 | 75 | 76 | 77 | 78 | 79 | 80 | 81 | 82 | 83 | 84 | 85 | 86 | 87 | 88 | 89 | 90 | 91 | 92 | 93 | 94 | 95 | 96 | 97 | 98 | 99 | 100 |

АРВАН БУЯНЫ БЭЛГЭ ТӨГС ИХ ТЭНГЭР ХАНГАЙ ХАНД САН ТАХИЛ ӨРГӨХҮЙ ЁС

Свасти, жээ,

Гурван орны хамаг бүхнийг эрхэндээ хураасан хортон бүхнийг таслан янагш хураан огоот урвуулснаар Их тэнгэр Их Хангайн лагшингийн өнгө нь цаст уулнаа наран ургасан мэт цайраад амирлан мөшөөхүйд баяссан мэлмийгээр болгоосон нэгэн нигур, хоёр мутартай баруунаа таван үзүүрт алтан очир барьсан, зүүнээ эдийн тавагийг бэлхүүснээ тулан барьсан их эрдэнийн найман чимгээр чимэн тэнгэрийн эдийн баринтаг хувцсыг намилзуулан хөдөрсөн гарди, хажир элчийг дагуулсан түүний баруунаа элдэв лянхуа чимээд нарны тавцнаа дэлгэрсэн Их тэнгэр, Алтан Хангай хааны лагшингийн өнгө нь болохоор баруун мутартаа шижир алт мэт их эрдэнэ бадруулан барьж, зүүнээ мөнгөн тавгийг эрдэнээр дүүргэн бэлхүүсний дээхнэ барьсан Их эрдэнийн найман чимгээр чимээд торгон шамтавыг алтан бүсээр бүсэлж дээд хөлөг морь, чимэг зэмсэгээр чимсний дээр хаан цэнгэлийн аясаар заларч хэдэн чөтгөр олон ягчсаар хүрээлүүлэн, мангас, элээ элчийг дагуулж, зүүнээ орших эрхтний их тэнгэр Хангай ханы лагшингийн өнгө бадмаараг адил улаанаар эргэлдэн, мөшилзөн хээмсэрлэсэн байдалтай, чин үнэн мэлмийгээр болгоосон ширэн хуяг, дуулга хөдөрч баруун мутартаа очир хийгээд төмөр гох барин, зүүнээ дайсны тотгорыг хүлэх цалам барьсан аянган гилбэлгээн мэт улаан морин дээр машид үзэсгэлэнгийн ёсоор оршин шонхор бүргэд элчийг дагуулж, бас түүний өмнө лянхуат тавцанд шулмасын догшин хар мөрийг зэр зэмсгээр чимэн их тэнгэр догшин Хангайн лагшингийн өнгө хав хар болоод, хар урин хилингээр мэлмий хөдөлгөн хөмсөг ба сахалын үс нь үзэсгэлэнтэйеэ дээш сөрвийсөн, доод уруул нь унжсан, үхээрийн орны чимгээр чимсэн. дөрвөн мутрын баруун хоёртоо сүх, төмүгээ, зүүн хоёртоо нум сум, цалам саадаг барьсан дөрвөн завсартаа их хатан охин тэнгэр дөрөв бас бус тэдгээрийн эргэн тойронд газар

дэлхийн эзэн дөрвөн хатан, бас чу тэнгэр, мангас, найман аймгийн цэргийн чуулган, цаглашгүй тэргүүлсэн хамаг нөхөд тэргүүндээ цагаан Ум, хоолой нь улаан Аа, зүрхэндээ хөх Хум завсардсан болой.

Агуужим эд баригчийг тэтгэгч тэнгэрийн эрхт дээд Асар их тэнгэр Хангайн хатан, хөвгүүн, түшмэл Анд олон нөхдийн чуулган сэлт энэ л орноо Ашид түрвэлгүй нигүүлсэхүйн эрхээр залран соёрх. Арван буяны билэг төгөлдөр их Хангай уулнаа Адбиш орсон тэнгэр, лус, орон, дэлхийн эзэн Аху газрын эзэн, хүмүн бус, ад тотгор, өр төлөөсөн Аливаа бодинарын чуулганууд ас асын орноо залрагтун. Тааламжит эдлэл, хүсэл эрдэм, төрийн долоон эрдэнэ Тансаг олон идээ, үр жимсний зүйл, цай, ундаа, дарс Ташаагүй хэрэгтэй эд агуурс, жансигийн чуулганыг өргөө. Аясгалан зохист их эрдмийн гэрэл бадарсан уужим саванд Ариутгагч рашааны тахил, эрдмийн далай мэт уйлганаад Алтан лянхув, удвал, гүмдаа тэргүүтэн Асар тэнгэрийн эд, цэцгэс огторгуйн морь дүүрсэн үүгээр Агуу их тэнгэр Хангай хантны сэтгэлийг хангамуй. Хөх биндэръяагийн усан баригчийн дусал мэт Хөвчин хүжийн үнэр анхилаг тэнгэрийн мөрт түгэн Хөнөөлгүй гурван орны харанхуйг арилган амирлуулагчийн Хөгжсөн зулын эрхисийг жигдлэн өрсөн үүгээр Хөхөмдөг их тэнгэр Хангай хантны сэтгэлийн хангамуй Индранилийн сүрлэг уул хөрвөөн шилгээх мэт Их савагт догшин халтар сарлаг урамдах дуун дуурсхан Эрхтний нум адил үзэсгэлэнт тэнгэрийн эд мэт Эрвэн хоёр чихээ хөдөлгөсөн хар хонин сүргээр Эрхэт их тэнгэр Хангай хантны сэтгэлийг хангамуй Хоёр жигүүрээ дэвсэн, олон дүрээр хувирсан Хосгүй дээд хүчит тэргүүнээ хөдөлгөсөн шувуудын чуулган Хотол гурван газрыг хөдөлгөгч аймшгаар архиран хуцагч

Ховхиногч баавгай мэт гүйгч зүрх цагаан хар нохой үүгээр
Холч их тэнгэр Хангай ханы сэтгэлийн хангая.
Сааталгүй чанадын орны үйлийн ялгуугч зэр зэвсэг
Сац бас хурц ир төгөлдөр үл шантрах мэсийн чуулган хийгээд
Сансарын үзүүрт тултал босгосон үзэсгэлэнт банжид
Салхинаа дэрвэсэн оронгыг огторгуйн мөрд дүүргэн байж
Сахиулсан их тэнгэр Хангай ханы сэтгэлийн хангая.
Нэндэн бадарсан галд шатсан үнэр шимт утаан үүлэн
Нэлэнхүй огторгуйн мөрт түгсэн ариусгалын тахил үүгээр
Нэтрүү их тэнгэр Хангай ханы нөхөд сэлтийг сагнай.
Нэл хань хамсааг үйлдсэн тэнгэр, лус, шавдгийг сагнай.
Хүмүн бус, ад тотгор, савдаг, өр төлөөсийг сагнай.
Хүчит бодинарын чуулган бүхнийг үлдээлгүй сагнай.
Хүлэл, мэнгэ, жил, сар, хоног, цагийн тэнгэрсийг сагнай.
Хүсэлт нуур, цөөрөм, булаг шанд бүгдийг сагнай.
Хар уснаа оршсон догшин лус, савдгийг сагнай.
Ханаад цуврилгүй амгалангаар баясах болтугай.
Хамаг бидний багш шавь, хүмүүний эд нөхөд сэлтийн
Харьшгүй нас цог буяны их хүчин цог учрал дэлгэрч
Харгүй сэтгэлдээ юу санасан үйл бүхэн
Хавтайяа номчлон бүтэх үйлсийн хань хамсааг зохио.
Ус хур цагтаа бууж, жилийн өн машид сайжран
Улс амьтны хүчир өвчин, малын гарлага болоод
Улиан чонын хорлол, хулгай дээрэм, хэрүүл тэмцэл хөнөөлгүй
Угийн энэ орноо амар амгалан хотол чуулганыг аривтган зохио.
Бид бүхний орон нутаг, аян замд хаа ч байлаа
Биш буруугаар хөнөөхүй хүмүн ба хүмүн бусын
Билэггүй санасан муу учралын гүжир тотгодыг амирлуулан
Билбүүргүй аль санасан хэргийг бүтээж хайрла.
Байгаа шашин нийт ба номын их хүрээ энд
Баараггүй чухлаар оршин, хутагт чуулганыг хураахуй аймаг сэлтийг
Бас бус огтхон ч алгасралгүй сахин аварч
Балагт ягчис, дайсан тотгорыг үлдээлгүй гэсгээн хайрла.

Хураангуйлбаас орон цаг бүхнийг хүчир хөнөөлөөс
Хуу ангижруулаад элдэв хүслийн эд эдлэл өөсөөн бүтэх болтугай.
Хувь зуураа сэтгэл зохилдон номчлонгийн явдлын
Хутагт сайн буяны хотол гурван чуулганы үйлсийг зохио.
Төр шашин өнөд оршоод түүнийг баригч
Төрөлхтөн дээдийн нас, бие илэрхийеэ батдан
Төв гурван сургаал төгссөн хуваргууд өргөжин дэлгэрч
Төөрөгт номлол бүтээлийн шашны үйлсийг аривтган зохио
хэмээх арван буяны билэг төгс Их Хангайн сан тахил өргөхүй ёс
хэмээх үүнийг цорж Лувсаннамжил бээр энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн
дурдсаны урмаст бурханы тойн Лувсанданзанжалцан бээр
найруулсны бичээч нь гэлэн Лувсанравдан болой.

БОГД ХАН УУЛ

Хэл зохиолын хүрээлэнгийн номын санд хадгалагдаж байгаа 155 гэсэн дансны дугаартай Богд хан уулын сан, сэржим хэмээх эл судрыг Гэлэн Дашравдан Үнэнбилигт -бээр дурдсанд Шагжийн гэгцэл Вагиндра артасиддхи шаасна сядху Зарнагула сагар-бээр найруулан бичсэнийг төгсгөлд нь тэмдэглэжээ. Халхын дөрвөн их тахилгат уулын нэг болох Богд хан уул Хэнтийн нурууны баруун урд төгсгөл бөгөөд дундаж өндрийг газар зүйн сурах бичигт 2000 м гэж тэмдэглээд хамгийн өндөр цэг нь Цэцээ гүн 2257 м гэж дурдсан буй. Богд хан уул дархан цаазтай уул болно. Улаанбаатар хотын өмнө этгээдэд з.у. 107, х.ө. 47° 48'-д оршино.

XII зууны үеэс Хэрэндийн ван хан Тоорил Туулын хар шугуйд нутаглаж байснаар өмнө этгээдийн нь уулыг Хан уул гэх болжээ. Ван хан уг ууланд ан ав хийх, гал түлэхийг цаазлан хориглож байжээ. Манж чин гүрний үед 1778 онд халхын ноёдын санаачилгаар уг уулын дархан цаазыг албан ёсоор баталгаажуулжээ. Энэ уулын 21 аманд цагдаа суулган жилд нэг удаа тахиж байхаар болсон буй. Хан уулын ар хөндийд Богд өргөмжит хаад нутаглах болсны улмаас Богд хан уул гэж нэрлэх болж, 1952 онд Чойбалсан уул өдгөө Богд хан уулаараа нэрших болов.

Монголын эртний алдарт дархан газар Богд хан уулыг тайж тахих ёслол нэн ёсорхог болдог байв. Богд хан уулын Цэцээ гүнд тусгай сүмд Баатар бэйл, Шижир баатрын нум сум, эмээл хазаар байсан гэдэг. Зүүн хойт хяр дээр нь Бүүвэй баатрын харуул харж байсан домогт чулуун цохио буй. Богд уул Түшээ гүн цолтой байсан ба тахилгын үед овоонд нь мөнгө, мөнгөн ембүү өргөдөг байсан гэдэг. Богд хан уулын сүрэг гэж хоёр мянга шахам агт байсан ба энэ уулыг тахихад цэргийн яам, Гадаад яамны сайд нар очиж тахилгын байшинг онгойлгон Баатар бэйл, Бүүвэй баатрын эмээл хазаарыг гарган сэтэртэй моринд тохон, сэтрийг ариулж, уулын овоонд өргөл өргөн эмээл хазаарыг эргүүлж сүмд хийгээд Дүнжингаравын дэнжид ирж наадамладаг байжээ.

Мөн тэнд Дүнжингаравын сүм гэж байсан агаад түүнд Богд уулын эзэн оршдог гэж үзэж байжээ. Богд хан уулыг Шашныг тэтгэгч их Богд хан хайрхан уул гэж нэрлэж байсан тул Богд хаант Монгол улсын тайх тахиглах ёслолын хуулинд "... Богд хан хайрхан уул, Хан Хэнтий уулын тэнгэрийг жил бүр зун, намар хоёр цаг-дор хуучин удаагаар тайлагтун. Тайлах удаа бүр хэрэгсэх үхэр, хонь, дарс, боорцог, идээний зэрэг зүйлийг Халхын дөрвөн аймаг урьдаас зарлан бэлд.

Дотоод яамнаас тайх өдрийг тогтоон айлдсаны хойно зарлигаар тайх бичгийн үг зохион шар цаасны эвхмэл айлтгаж, дээрхээс уулын тэнгэрт өргөх сум, хүж, торгыг сангийн яаманд тушааж бэлдүүл. Шашныг тэтгэгч их Богд хан хайрхан уулын тэнгэрийг тайлахуйд таван яамны тэргүүн сайдаас нэгэн хүнийг жишээлэн гаргагтун. Шашныг тэтгэгч их Богд хан хайрхан уулын тэнгэрийг тайх тэргүүн сайд мөрдөхүй-дор:

Зарлигаар тайх бичгийг хичээнгүйлэн үүрч засах ба өмнө удирдах түшмэдэд мөнхүү уулын цагдаа цэргийг захирах занги дарга нэжгээдийг гарга, хоёр хажууд жагсан явах нум, сум, саадаг, сэлэм зүүсэн дагалт хүн найм, харьяат сайдыг дагалдан ёслон мөргөх бэйс, гүнгийн зэрэг ихээхэн түшмэл хоёр хүнийг цөм Түшээт хан, Сэцэн хан хоёр аймгаас томилон гаргагтун.

... Уулын тэнгэрийг тайхад Нийслэл хүрээнээс цорж лам нарыг гарахад хэрэглэх бөс гэр, ачилга тэмээ, хүнс, уналга зэргийг дөрвөн аймгаас бэлтгэн өг. Уналгын морийг мөнхүү уулын сүргээс нийлүүлэн хэрэглүүлэхээс гадна гагцхүү тахил бэлэг, зул хүжийн зүйлийг урьд ёсоор ламын сангаас гаргуулагтун.

Уулсын тэнгэрийг тайх цорж лам нар тайлгын ном уншиж төгсөх лүгээ тэнгэрийн шүтээний өмнө хүжийн ширээ жагсааж тайх сайд хичээнгүйлэн зарлигаар тайх бичгийг ширээнд өргөн, талбайд дагалдах түшмэдийг авч тэнгэрийг угтах ёсоор гурвантаа сөгдөн, есөнтөө мөргөөд, босч буянт дарс гурван цом өргөмүй. Зарлигийн бичиг, хүж, торгыг хүжийн саванд шатаан тахигласны хойно

тэнгэрийг үдэх ёсоор дахин гурвантаа сөгдөж, есөнтөө мөргөн ёслогтун” гэсэн байдаг.

Холбогдох ном:

1. Өвгөн Дэндэвийн дурдатгал. УБ, 1961 он
2. Өвгөн Жамбалын яриа. УБ, 1959 он
3. Х.Нямбуу. Олноо өргөгдсөн Богд хаант монгол улсын төрийн ёс, ёслол. УБ. 1993
4. Ш.Шагдар. Монголын газар зүйн нэрийн товч толь бичиг. УБ. 1978 он.

THE BOGD KHAN SACRED MOUNTAIN

Information on the sutra:

The original manuscript of the sutra for Bogd Khan Mountain is being kept in the archive of The Language and Literature Institute, Ulaanbaatar. The manuscript was written by Bikkhu Lama Dashravdan Unenbilegt.

The Bogd Khan mountain gained official protection status in 1778, making it the world’s first ever officially protected site.

However, the tradition of protecting mountain ranges dates back to the 12th Century, when the King of the Hereid tribe, King Tooril, who lived in the Tuul River valley, decreed that it was forbidden to hunt or start fires at these sacred sites. King Tooril even assigned a guardian to protect the twenty-one valleys in the region.

Each year before the Nadaam festival, state officials paid homage to the mountain.

ПОЛХА /БОГД/ ДҮНЖОНГАРАВЫН ЗАЛБИРАЛ ТАХИЛ ОРШВОЙ

Намо гүрү Бүдха бодхисатва бхяа: Эндэх огторгуйн түшмэл, газрын эсрүн Чингисийн язгуурыг сахигч Полха Дүнжингарав /Өмнийг тэтгэгч цагаан лавай О.С./ орны тэнгэр, шивдаг сэлтсийг тахил, балин, ариусгалаар баясган үйлдэх ёсыг товчлон хурааж зохиосу. Тахил балин ариусгалын зай, жансиг тэргүүтэн зургаан үсэгт тарни, зургаан мутраар чухаг хэрэгтэй болгон үйлдээд огторгуй дүүргэн адистидла.

Их амгалан өөсөөн бүтэхүй номын бие Гүндсамбуу
Илт төгс жаргалангийн бие, сэтгэлээр хувилгасан бие Шагжтүв
Идэт тарнисыг баригч Бадамжунайн ялгуусан эрхт Зонхов
Ийм гурван язгуурт тэнгэрийн чуулганууд -бээр хутгийг соёрх.
Өвөрчлөнгийн их амгалан орд өргөөнөөс
Өндөр огторгуй газрын эрх баялаг их Чингисийн
Өөр язгуур үндсийг тэтгэсэн дээд тэнгэр Дүнжингарав
Орны тэнгэр, шивдаг нөхөд сэлт ажран соёрх.
Өмнөдийн огторгуйд рид хувилгааны хүчин чадлыг барьсан
Өөсөөн сэлгүүрэх цагаан үүлэн мэт ажнай хөлөглөсөн
Цаст уул мэт цагаан сүлдэн тэнгэрийн их хаантан
Баруун мутартаа дайсны амийг таслагч урт жад
Зүүн мутартаа хорлогчийг хүлэх цалам барьж
Улбалзан намилзсан торго, чимгээр үзэсгэлэнжээд
Хань хамсаа болсон тэнгэр, лус, шивдгууд
Хамаг нөхдийн хамт баясгахуйн ёсоор залрах болтугай.
Үнэнхүү уужим саван дахь ариутгагч хоёр усан тахилын
уйлганд
Үзэсгэлэнт сайхан цэцэг, элдэв навч гишүүнийг дэлгэрүүлэн
Үнэр шимт хүжсийн утааг үүлэн мэт бүрхүүлээд
Үсэд гэрэлтэгч зул бадарснаар зүг бүхнийг гийгүүлэн
Хүж, усны үнэрийн анхилгаар бие сэтгэлийг хангаад
Хүмүүн дээдийн биеийг дэгжээгч идээ зоогийг уул мэт

цогцлоон

Үнэхээр яруу аялгуу элдэв цэнгэлийг дуурсгаад
Үнэр өнгө, анхилгын хотол чуулган зуун амтаныг
Үлэмж цуврилгүй амгаланг өгөгч рашаанаар адистидласны
Үнэн гурван цагаан, гурван амтат үр жимс, элдэв самар
тэргүүтэн

Идээ зоогийн балинг уул овоо мэт цогцлуулан
Сарны сүрчилгийн уйлгатай ижилдсэн тараг сүү
Сайн гүргэмийн өнгө төгөлдөр билгийн цайг дээжлэе.
Элдэв үр жимсийн шимийн охь сүлд тэргүүтэн
Идэт ундааны рашаан далай мэт хүрээлээд
Арц зандан, агарваа тэргүүтний болон
Аятай сайхан үнэр төгс элдэв мод, эм тан
Олон зүйлийн үр жимс, элдэв торго, сайн бүхнийг
Олж шатаасан сангийн утаагаар завсрын үзэгдлийг дүүргэсү.
Асар дулаан баринтаг хувцад, шасар малгай, хөмөн гутал
Агуу үзэсгэлэнт чимэг, сайн тавцант суудал
Бат бэх хуяг дуулга, хатан болд мэсийн зүйл
Бадралт төрийн долоон эрдэнэ, өлзийт найман тахил
Барьж унах дээд морь, ачлагын атан тэмээ
Байнга үргэлж сүүн урсгалыг барин мөшөөхүй
Бас бус шалтгааныг арвитгасан сүргийн манлай үхэр
Үнэт ноос, ноолуурыг үүтгэн баригч хонь, ямаа
Үзээрийн дайсан хулгай, араатны хөнөөл аврагч нохой
Үргэлж газраар гүйгч гөрөөс араатан болон
Үүлт огторгуйгаар бядагч шувууд болоод бялзуухай тэргүүтнээ
Үнэхээр хэрэгтэй бүхий л хав заслыг дутаалгүй өргөө.
Гурван мянганыг хормын зуурт эргэх хүчин чадалт
Гуталгүй цагаан ажнайн хазаар ногт, үзэсгэлэнт чимгийн дээр
Лагшингийн өнгө нь цайвар цагаан баясгалангаар мөшөөсөн
Лавтайяа улбалзан намилзсан элдэв торгон баринтаг хувцастай
Таарсан дайсны тотгодын амин үндсийг таслах хурц илдтэй
Тангараг доройтсон бүхнийг хоцроолгүй хүлэгч цалам барьсан

Даамай урьдаас язгуур үндсийг сайтар тэтгэн зохиосон
Далха-Сүлдэн тэнгэрийн хаан, нөхөд сэлтийг магтая.
Алимад шалтгааны барилдлагат ба бүрний нөхөд сэлтийн
Аху нас цаг, хүчний учралын амны хишгийн язгуур үндэс
Адуу мал, эд баялаг, хонь, ямаа, тэмээ, нөхөд, зардсан
Алт, мөнгө, хив торго, чухаг хэрэгтэй эд эдлэлийг арвитга.
Цаг бусын үлэмжийн их хур цас, хяруу мөндөр, ган халуун
Цалгай хямрал, хэрүүл тэмцэл, хүн малын өвчин
Хүмүүн ба хүмүүн бусын санасан муу шалтгаан цөвүүн учрал
Хүчир хөнөөлийн хорлолын үндэс бүхнийг хариулан буцаа.
Ус хур цагтаа бууж, өвс ургамал, үр жимс дэлгэрээд
Ухаант хүн зоны амар баясгалангийн гэгээ машид арвижаад
Урьдын ихэс дээдсийн сайн явдал өргөжөөд
Улмаар асар цагаан буяны хичээлийн үйлсийг зохио.
Сансар огторгуйд сайн гариг одыг сайтар учруулж,
Сац бас газрын өлзийт хишиг буяныг сайтар арвижуулж
Сайн буяны хотол чуулганы цогт цэнгэлийн
Сайн амгалангийн өлзийт буяны билэгийн хурыг буулга.

хэмээх үүнийг урт наст тэнгэрийн заяагаар уужим их газрыг эрхшээн
хураасан тэнгэрийн зарлигийн газрын ариун Чингисийн язгуураас
гаралтай Үзэмчин сэцэн чин ван Цэдэндондов, эх, хөвгүүд -бээр энэ
мэтийн нэгэнийг үйлдсү хэмээн дурдсанд зальхай дэмий явдалт
Агваанлуvsанчойндон-бээр шашин амьтны огоотын цогт итгэлийн
дээд сайжралыг дэлгэрүүлж шавран Гунгаадэлэг-бээр зохиосон
Чингисийн язгуурыг сахигчийн солхыг шүтэн үйлдэхэд зөөлөн эгшигт
дээдийн нийслэл Бээжингийн Бод чойлха - гийн харш хэмээн
алдаршсанд найруулсны бичээч нь хоёр хэлний өгүүлэхийн эрхэт гэцэл
Данзан болой. Сайн буян арвижтугай.

ОТГОНТЭНГЭР

Отгон тэнгэр уул нь 750 гаруй км үргэлжилсэн Хангайн нурууны мөнх цаст ноён оргил болно. Улиастай хотоос зүүн тийш 70 гаруй км зайд, з.у. 97°33', х.ө. 47°36' орших, 4031 м өндөр уул юм. Судлаачдын үзэж байгаагаар Отгонтэнгэр уул нь монголчуудын эртний өвөг дээдсийн тахилгын газар байжээ. Иймээс Отгон гэдэг нэр нь түрэг монгол хэлний дундын гэгдэх Отхан буюу Галын хан /голомт сахигч хүү/ гэсэн үг биш, Этүгэн гэдэг жинхэнэ монгол үгийн хувирсан хэлбэр болно. Халхын дөрвөн тахилгат уулын нэг болох Отгонтэнгэрийг анх 1828 онд Дархан цаазтай болгож Богд Очирваань гэж нэрийдэх болжээ. Иймд Отгонтэнгэрийг Очирваанийн сахиустай уул гэдэг ажээ. Очирваань нь монголчуудын дунд арван хангал гэж алдаршсан догшин сахиусны нэг бөгөөд үгчилбэл “Мутартаа очирт” гэсэн нэр болно. 1911 онд Монгол орон манжаас ангижирсны хойно олноо өргөгдсөн Богд хаант Монгол улсын хууль зарлигаар Отгонтэнгэрийг жил бүр тайхаар тогтоож, ийнхүү тайх нь 1930-аад оны үеэс бүрмөсөн зогссон байна. Харин 1995 онд Монгол улсын Ерөнхийлөгч эдүгээ цагийн байдалд нийцүүлэн тайх талаар олон түмний санаачлагыг дэмжсэн зарлиг гаргаснаар дахин тайж тахихыг нь сэргээжээ. Энэхүү онгон дагшин уулын сүр хүчийг илтгэсэн олон алдарт зүйл бий бөгөөд тухайлбал нэг суганаас нь урссан Богдын гол, Отгонтэнгэрийн арц, Отгонтэнгэрийн рашаан зэрэг нь монгол даяарт нэр зартай. Энэ уулын тухай нэгэн домог ч буй.

Эрт урьд цагт Туул голын өмнөдөд Богд хан хэмээх үзэсгэлэн төгс сүмбэр оргилт уул байжээ. Гэтэл баруун зүгийн их Говьд ган гачиг болоод амьтан, хүн ангаж цанган, өлсөж ундаасан туйлджээ. Нэгэн хүчит эр Богд хан ууланд хүрч ирээд урт аргамжаар уг уулыг оосорлон үүртэл цээжин бие нь тасарч бөгсөн бие нь үлджээ. Мөнөөх эр нэгэнтээ эргэн харж “Дуртай цээж нь наашаа, дургүй бөгс тэндээ” гэж хэлээд явчихжээ. Авчирсан уулын

цээжээ нутаг газартаа тавьсанд тэр нь бүхнийг ундаалж тэтгэснээр Эдүгэн эх болсон гэнэ гэсэн домог буй.

Сударт гарч байгаа Бадархундага нь Отгонтэнгэр уулын өвөр элгэнээ орших бадар аяганы хэлбэртэй үзэсгэлэнт нуурын нэр. Энэ нуурыг мөнгөн эмээл хазаартай цагаан морь буюу есөн эрдэнээр чимсэн алтан мөнгөн мандаагаар тахиж байсан гэдэг. Хожуу үед тавин лангийн мөнгөн ембүү, алт, мөнгө, шүр, сувд зэрэг зүйлээр тахидаг байсан мэдээ буй.

Цэцэрлэг – нь Хангайн нурууны зүүн хойд зүгт Булган аймгийн нутагт х.ө. 47°30', з.у. 103°45' орших 1962 м өндөр уул юм.

Баянзүрх – Завхан аймгийн Нөмрөг сумын нутагт х.ө. 47°30', 103°45' орших д.т.д 2080м өндөрт орших уулын алдарт рашаан

Хөх нуур – Отгон тэнгэр уулаас баруун зүгт 11 км зайтай орших Богдын голын савд з.у. 97°20', х.ө. 47°36' соливцолд буй 2456 м өндөрт орших нуур

Хар нуур - Улаагчны хар нуурч гэдэг Хангайн уулын баруун хэсэгт з.у. 96°08', х.у. 48°19'-д 1980 м өндөрт орших урт нь 20 гаруй км, өргөн нь 6 км нуур

Цагаан нуур – Даян уулын нэг талд нь Отгонтэнгэрээс холгүй баруунаа орших жижгэвтэр нуур болно.

Мянган сүмбэр уул – нь Хангайн нуурууны салбар, Завханы нутагт орших мянганы уулс болно.




Энэхүү нийтлүүлж буй төвд гар бичмэл судрын хуулгыг Шашны дээд сургуулийн багш, төвдөч Ш.Сонинбаяр өгсөн болно.


OTGONTENGER SACRED MOUNTAIN

Information on the sutra:

Otgontenger Mountain is the highest snow-capped peak of the Khangai mountain range. It is located 70 km from Uliastai town in Zavkhan Province. The mountain is one of the four nationally worshipped mountains in Mongolia and was declared as protected in the year 1928.

The mountain is one of the oldest sacred sites in Mongolia. The mountain features in numerous legends; once upon a time, the people of Zavkhan Province suffered from a famine and drought, depriving the community of much of their livestock. The people began searching for a way to end the tragedy that had befallen them. It was known by some that the great Bogd Khan Mountain, which stands at the banks of the Tuul River, was indeed a sacred mountain, and in bringing the mountain, with its plentiful supply of water, to their homeland, the people could be freed from their misfortune. Thus, they sent a strong man from their land to fetch the Bogd Khan Mountain and bring it home to them. Alas, when the man came up to the Bogd Khan Mountain and swung his lasso around it, the mountain broke in half. Nevertheless, the man was content and took with him the upper part of the mountain delivering it to his land, where it miraculously saved his people from famine and drought.





**ИХ ТЭНГЭР ОТГОНТЭНГЭР ТЭРГҮҮТЭНД
САН ТАХИЛ ӨРГӨХ ЁС ЕСӨН ХҮСЛИЙН
САЙН АМГАЛАНГИЙН ХУР БУУЛГАГЧ**

Очирваань бурхнаа мөргөмүү. Эндэхийн цогт нуурын эзэн
Очирваанийн орныг сахигч Их тэнгэр Отгонтэнгэр нөхөд сэлтэд сан
тахил өргөхийг хүсвээс эл:

Аяа, Васуу

Асар тийн удирдагч мянганы аугаа хүчтийг үл хоцроох

Асар олон зүйл номхотгогдохууныг номхотгох хилэнт биет

Асар ялгуусан хүчний эрх баялагт нууцын эзэн

Асар тодорхой номлол бүтээлээ арвитгахын тулд энд
ажрагтун

Умар зүгийн эд баригч агуу их хот мандлын төвд

Уг газрыг баригч олон нөхдөөр огоот хүрээлүүлсэн мэт

Арван буяны бэлгэ төгс болор сүмбэр уулнаас

Ариун орныг сахигч Отгонтэнгэр ажрагтун, энэ орноо

Аливаа эд идээ төгс эдлэлийн есөн хүслийн хур буусан мэт

Аху эл газар дээрх буй бүхнийг эрхшээхийн ид хүчтэн

Бага Богд хэмээн алдаршсан цаст уулнаа оршсон

Бадрангуй өлзий хутгийн цогт аймгийн нөхөд залрагтун

Басхүү их тэнгэр таны бэрх хатуу их хүчин

Баялаг Мянган сүмбэр уул, Цэцэрлэг

Баянзүрх, Хөх энгэр тэргүүтэн уулсын

Байгаа мянган шивдаг нь залрагтун

Бадар хундага, Баянбулаг болон

Бахдалт Цагаан, Хөх, Хар нуур

Баялаг Буянт болон Ширээ чулуут

Бас бус ус далайн лусууд

Байршиж энэ орноо ажрагтун

Цагаан тохой, Тасын суудал хийгээд

Ботго балгатай лугаа Чандмань

Урт юмбүү, Цагаан булан тэргүүтэн

Уужим тал зүгийн савдаг энэ орноо ажрагтун

Тэрчлэн газар ус, найлзуур модон, хад чулуу

Тэтгэгч цөөрөм бүрд, нуур далай

Тэргүүр зам, хад асга, зүлэг ногоо, уул тал, даваа гүвээ

Тэдгээрт суугаа орон нутгийн шивдаг ажрагтун.

Өөрийн өмнөдөд самадийн хөрөнгөөр байгуулсан

Өчнөөн үзэсгэлэнт ордон мэт тэгш баяслын төвд

Өлзийт эрдэнийн тавцант ширээнээ ас асдаа заларсны дээр

Өгөөмөр баясгалангийн эгшигээр өнөдийн ёсоор залрагтун

Өөрийн сэтгэлийн самадийн хөрөнгөөр бүтсэн, бодитой

бэлдсэн

Өөдлөх сэтгэлээр хувилгасан тахилын зай

Өөр тангарагийн эд тансаг, элдэв эд сангийн чуулганыг

Орон газар, завсрын үзэгдэл, огоот аливаа бүгдэд өргөмүү

Үнэнхүү билэг билгийн гал бадарсны төв дунд

Үнэрт сангийн элдэв эд зайг шатаан хөгжөөснөөр

Үлэмж их утаан үүл нь огторгуйд түгсэн үүгээр

Үе завсар, дээд доодын зочид баясан ханах болтугай

Язгуур үндэсний лам, ядам тэнгэрсийн чуулган

Ялгагч баатар, дагинас, чойжин, сахиулсан эхийн чуулган

Ялангуяа аугаа хүчит эрх баялагт Очирьг баригч

Ялгуулсан зарлигийн үйлч, эдийн эзэн нөхөд сэлтийг

ариусгая
Ба бүрний болоод үйлсийн хүсэгдэхүүнийг машид гийгүүлж
Бас урьд төрлийн үес энэ насны барилдлагыг үгтээсэн
Бадралт их тэнгэр Отгонтэнгэрийн ачлалыг санан
Байгаа тэнгэр, лус, шивдаг бодинарын нөхөд сэлтийг сагна
Товчилбоос минийхийлэн ачилсны орон нутаг
Товлон суугаа газар, хад чулуу, орд харш
Толгод тал, гол ус тэргүүтнээ оршсон
Тоот амьтны язгуур болсон хамгийг сагна
Адбиш цуврилгүй билэг билгийн амгаланг үүсгэх чадалт
Ахуй их дээдийн энэхүү сан тахилыг өргөснөөр
Ачлалт егзэрийн эзэн, эрдэм тахил нөхөд сэлтийг
Алгасалгүй өдөржин шөнөжин авран сахигтун
Хүчирхэг Монголын орон хийгээд онцолбоос энэ газарт
Хүн, малын өвчин хүчирхийлэл, хямрал тэмцэл
Хуйхуй хулгай, дээрэм тонуул, хуцах улих араатны хор
хөнөөл
Хуудуутай муу харш нөхцлийг хуу цөмийг урвуулан хариул
Арван газрын мөсний цаг
Агуу хүйтэн, хур цас хийгээд
Газар нутгийн шимийг булаах
Халуун гэрлийн энэлгэ
Ган зуд, хяруу мөндөр
Хамаг язгуур бүгдийг
Хүний жилийн махбодын сайн үрд
Хүслээр зохируулж дэлгэрүүлэн зохио
Амьтан, хүмүүний амийг булаах
Тангарагийн буг, өвчний эзэн
Адуу малын амийг хулуух
Гарлагын буг, нэгэн нүдэт шулам
Амт шимтгэй идээг долоох
Гарзын есөн ах, дүү тэргүүтэн
Аливаа бүрэлгэн үйлдэгчийг

Амьтны орноос зайлуулан зохио.
Хур усан цагтаа бууж,
Үр тариа, мод ургамал ургаад
Хүний язгуур үндэс дэгжин
Дөрвөн хөлт мал тэргүүтний
Үржин арвидахын ам дэлгэрээд
Идээ ундаа, сүү тараг бүхэн
Идэр зуны далай мэт арвижихын
Эрхин үйлсийг эгнэгт зохиогтун.
Хураангуйлбаас тус амгалан гарахуй орны
Хутаг өлзийт ялгуусны шашин
Санасан хүссэнээр өргөжин дэлгэрч
Самадийн өлмий батдан номын явдал арвидаг.
Эндэх нутгийн эзэн бидний
Эрдэм тахил, хуврагийн аймгуудын
Эвсэлдэн зохилдохуй нөхцөл, санасан хэргийг
Эгнэгт бүтээх хань хамсааг зохиогтун
хэмээн энэхүү Их тэнгэр Отгонтэнгэр тэргүүтэнд сан тахил өргөх ёс,
есөн хүслийн сайн буяны хур буулгагч хэмээх үүнийг доод төрлөхт
хувилгаан нэр баригч ханчин /их хамба/ Агваанпринлайжамц- бээр
найруулсан болой.

**ГҮНДСАМБУУ ХЭМЭЭН АЛДАРШСАН ГАЗРЫГ БАРИГЧ
(УУЛ)-ИЙН ЭРХТ ТЭНГЭР, ЛУС, ШИВДАГУУДАД
АРИУСГАЛ ТАХИЛ ӨРГӨХ ЁС ХОТОЛД САЙН
БАЯСГАЛАНГИЙН ХУРИМ ХЭМЭЭГДЭХ ОРШВОЙ**

Энэ судрыг Зава Дамдин зохиожээ. Төгсгөлийн үгээс үзвэл Дашдондовын хүсэлтийн дагуу ХҮ жарны шороо морин жилийн зуны эхэн сарын 21-нд буюу 1928 онд зохиожээ. Энэхүү судар нь Зава Дамдины эргүүлэн НА-ботийн дотор буй.

Гүндсамбуу гэдэг нь “Хотолд сайн” гэсэн утгатай төвд нэр бөгөөд Хан Хэнтийн нэгэн оргилын нэр болно. Одоо чухам ямар нэртэй оргил болох нь тодорхойгүй байгаа юм.




BURKHAN KHALDUN SACRED MOUNTAIN

Information on the sutra:

The sutra was written in 1928 by Zava Damdin, a well known scholar of the 19th Century.

The manuscript pays tribute to Burkhan Khaldun Mountain, one of Mongolia's four nationally worshipped sacred sites, revered since ancient times.

The place is considered sacred for being a burial site of Mongolia's great khans and other noted historical figures.



1. 此山名曰蘇魯山，其山頂有石人，其石人頭頂有日月，其石人手足有雲，其石人腹中有火，其石人背中有水，其石人腹中有風，其石人背中有雷，其石人腹中有雨，其石人背中有霧，其石人腹中有霜，其石人背中有雪，其石人腹中有冰，其石人背中有雪，其石人腹中有冰。

2. 此山名曰蘇魯山，其山頂有石人，其石人頭頂有日月，其石人手足有雲，其石人腹中有火，其石人背中有水，其石人腹中有風，其石人背中有雷，其石人腹中有雨，其石人背中有霧，其石人腹中有霜，其石人背中有雪，其石人腹中有冰。

3. 此山名曰蘇魯山，其山頂有石人，其石人頭頂有日月，其石人手足有雲，其石人腹中有火，其石人背中有水，其石人腹中有風，其石人背中有雷，其石人腹中有雨，其石人背中有霧，其石人腹中有霜，其石人背中有雪，其石人腹中有冰。

4. 此山名曰蘇魯山，其山頂有石人，其石人頭頂有日月，其石人手足有雲，其石人腹中有火，其石人背中有水，其石人腹中有風，其石人背中有雷，其石人腹中有雨，其石人背中有霧，其石人腹中有霜，其石人背中有雪，其石人腹中有冰。

5. 此山名曰蘇魯山，其山頂有石人，其石人頭頂有日月，其石人手足有雲，其石人腹中有火，其石人背中有水，其石人腹中有風，其石人背中有雷，其石人腹中有雨，其石人背中有霧，其石人腹中有霜，其石人背中有雪，其石人腹中有冰。

**ГҮНДСАМБУУ ХЭМЭЭН АЛДАРШСАН ГАЗРЫГ БАРИГЧ
(УУЛ)-ИЙН ЭРХТ ТЭНГЭР, ЛУС, ШИВДАГУУДАД
АРИУСГАЛ ТАХИЛ ӨРГӨХ ЁС ХОТОЛД САЙН
БАЯСГАЛАНГИЙН ХУРИМ ХЭМЭЭГДЭХ ОРШВОЙ**

Намо гүрү базра пааниеэ

Ялгуусан бүхний хүчин чадалт Очирт орны

Ялгуугч түшмэл, цэргийн ноён, Сүлдэн тэнгэр тэргүүтэн

Юун боловч хуурмаг зохионгуйн үйлсээр

Умар зүгийн шашин, амьтныг өнөд тэтгэ

Эндэх хүчний нөхдийг хувилгасан Чингис хааны мэндэлсэн орон Хэнтий ханы уул нуруунд багтсан Гүндсамбуу хэмээн алдаршсан газрыг баригчийн эрхтэд оршсон тэнгэр, лус, шивдагуудад ариусгал тахил өргөхийг хүсвээс тахил, балин, дээд эд зай, жансигийг ёсоор барилдуулах хийгээд нэн ялангуяа үнэр анхилаг, амт шимийн ариусгалын зайн утаан үүлийг цогц мэт бясгаруулан үйлдээд, аврал явуулах сэтгэлийг үүсгэн, эн тэргүүнээ цаглашгүй дөрөвт тавиад өөрийн чанарын Чагдор тэргүүтэн Ядам алинд ч болсон омгийг оршуулснаар ариусгалын зайг Амрита-гаар ариусган, свабхава-гаар адистидла:

Хоосон чанарын агаараас Ум аа хум-ын гэрэлд шимтэгнээс үүдэн ариусгал тахил хүсэл эрдмийн цогц огторгуйн машинд хэтэрсэн сацралын зодуудын эрхт оронд баясган жаргуулахын чадал лугаа төгөлдөр болтугай. Ом сарва бид пүүра пүүра сура суар авартаяа авартаяа

Хо: базра спхарна хам суухаа хэмээн Намхайзодын чагжа (Огторгуйн сангийн мутар) сэлтийг гурвантаа унш. Дуршлаар зургаан тарни ба зургаан мутраар ч адистидлахдаа Миний санасан... хэмээх тэргүүтнээ үнэн хүчээр өгүүл. Түүнээс:

Хум,

Ялгуусан бүхний айлдал энэрэлийн чадлын уужим төвөөс

Умар зүгийн монгол орныг номхотгохын тул огоот заларсан

Ядам, тэнгэр, багш, сахиулсны чуулган бүгд

Цаглашгүй нигүүлсэхүйн эрхээр энэ орноо ирэгтүн.

Буяны арван билэг төгс Хэнтий ханы оргил

Ян сарьдаг арван гурван хан уул тэргүүтнээ оршсон

Баатар дагинас, тангарагтны чуулган бүхэн

Баяслын бүжиглэлээр өөдлөн энэ орны залрагтун.

Нэн ялангуяа бат өндөр сүр жавхлант эрдэнийн уул

Нэвтэрхийеэ билэгдлээр Гүндсамбуу хэмээн нэрийдсэн

Тэнгэрийн буяны садан үлэмжийн ид хүчтний

Тэнгэрлэг эцэг, эх, хөвгүүн чуулган сэлтэс энэ орноо ирэгтүн.

Амины мутрын дүрс хөргөөс үйлдсэн нөхдийн эрхин

Адууны тэнгэр, Хонины тэнгэр, Үхрийн тэнгэр, Эдийн тэнгэр

Аху сангийн эзэн, Эдийн эзэн, Хурын эзэн, Салхины эзэн

Арилагсан сансар, найман аймгийн чуулганууд энэ орноо

ирэгтүн

Онцолбоос энэ орны уул даваа, мөрөн гол, цас мөс, хад чулуу

Ойл усан, рашаан эм тэргүүтнийг эрхшээн хураасан

Орны тэнгэр, лус, шивдагийн хань нөхдийг

Ойгүй ариусгал тахилын зочноор дуудсанаар энд ирэгтүн.

Хоёр усан тахил, чухаг эдлэл, хөгжим цэнгэл, хүслийн таван

эрдэм

Хоормог тараг сүү, цай, дарс тэргүүтэн идээ сэлт

Хосгүй үнэт эрдэнэс, алт мөнгө, торгон хувцас, эм тан, үр жимс

Холбогдох өөрийн сахиус, хуяг дуулга, дайсныг дарагч мэсийн

язгуур

Дайр буга, зээр гөрөөс тэргүүтэн гөрөөдийн чуулган

Дайчин барс, ирвэс, хавлан гурваар тэргүүлсэн араатны

чуулган

Дархан сүрэг-морь, үхэр, хонь, тэмээ тэргүүтний чуулган

Далай өлзийт сэтгэлд зохист асар олон эд баялаг

Гайхам жансигийн зохилдсон элдэв дээдийн эд зайгаар

Газар хийгээд завсрын үзэгдлийн орныг дүүргэн өргөө

Жагсаан өрсөн улаан, цагаан зандан, тэнгэрийн арц, агар

Жагар гүгэл, хээрийн суйх, цагаан агь, балуу зэрэг

Үнэр шимт элдэв эм хүнсийг сайтар шатаасан
Үүлэн утааг хүсэлт эрдмийн далайгаар адистидлаад
Авралын орон, хуурмаггүй багш, ядам, тэнгэр
Амгалан ажирагсан хөвгүүн сэлт дагинас сахиулсан
Агуу хүчит орны тэнгэр, шивдаг, найман аймаг
Авралт дээд, доод зочдын язгуур бүхнийг тахин сагна.я.
Хамгаас онцгой Хэнтий хан зэрэг бэрх хэцүү өндөрлөг
Хаан уул тэргүүтэн асар олон хан уулын
Хавтгай дээд оронд оршсон баатар дагинас болон
Харилтгүй сахигч эх, тангарагтныг тахин, зохист бүхнийг
сагна.я.

Чилгэр цагаан зүгийн тэнгэрийн язгуурыг сахин тэтгэж
Чивэлт хар зүгийн шуламсын язгуурыг мөхөөх ид хүчит
Чингис хааны мэндэлсэн орон их тэнгэр Гүндсамбуу
Чин сүжигт эх хөвгүүн, зарлигийн элчийн чуулганыг сагна.я
Эд баялгийн хишиг буян, идээ ундааг машид арвижуулсан
Ээлт Адууны тэнгэр, Хонины тэнгэр, Баялагийн тэнгэр, Эдийн
тэнгэр
Элдэв цас хур, хуй салхи, чийг дулааныг эрхшээн үйлдсэн
Эрхт тэнгэр чөтгөрийн цэргийн чуулганы ирд хувилгаантныг
сагна.я

Уужим орон газрын энэ зүгт чухаг хамаатай
Уул овоо, асга хад, намаг ширэг, зүлэг ногоо, ой мод
Ургих бургих рашааны шим, хадны хонгил, тэнгэр шүтээн
Ургаа үхэр чулуу, өнчин мод тэргүүтэн
Урсгал төгс гол горхи, нүдэн булаг
Ундармал цөөрөм бүрд, нуур усан булаг тэргүүтэн
Уул ус бүхэнд оршоод эрхшээн хураасан
Хурмаст тэнгэр, лус ягчис, далайн эм тэргүүтэн
Хүмүүн бус их хүчит хэтийдсэн омогт богдос нөхдийг
Хүслийн таван эрдэм төгс ариусгалаар сагна.я.
Товчилбоос энэ газар орны энэ зүгт оршоод
Тойлох ба бүрнийг дааж, хамсаа болон зохиох

Толбоггүй цагаан зүгийг тэтгэсэн, тэнгэр лус, шивдагууд
Тойрсон дагуул нөхөд, өмөг түшээг нь үлдээлгүй сагна.я.
Тэр мэтээр баясган үйлдэх хүсэл эрдмийн тахил
Тэсэргүү нисванисын дэвийг арилгагч ариун тахилыг
хэтийдүүлснээр

Эс мэдсэний эрхээр үйлдсэн гэм алдаст явдлуудыг
Их энэрлээр хүлцэн зохиож, хайрлан соёрх.
Чадагчийн нийт шашин, нэн ялангуяа Зонховын
Чанд судар, тарнийн сайн ёс арван зүгт дэлгэрч
Шашныг баригч дээд төрөлхтний өлмий батдаад
Шар хуврагийн аймаг болон номлол бүтээлийг арвитган зохио.
Ертөнц нийтэд болоод нэн ялангуяа энэ зүгийн орноо
Ерөөлгүй өвчин хижиг, хямрал самуурал, зуд турхан, хулгай
дээрэм зэрэг

Есөн жорын үл зохилдох онц хүчир хөнөөл эс гараад
Ер сав шимийн цог учралыг зуны далай мэт арвитгаж хайрла.
Олон бид бүхний эрдэм тахил нөхөд сэлтүүд
Огтхон ч хүмүүн ба хүмүүн бусын хорлолоор үл гартаад
Ойлон санасан хэрэг бүхэн сэтгэлчлэн бүтэж
Онцолж дээр үгүй бодийг бүтээхийн хамсааг зохиогтун.
Өвчин хуучингүй буян төгсөөр амин насан батдаж
Өнөд үл барагдах есөн хүслийн учрал, эдийн хишиг ариудан
Өчүүхэн ч бууршгүй буян хишиг тэргүүтэн
Өрнөх тус амгалангийн сайн чуулган дэлгэрэхийн өлзийг соёрх.
Онцын Хэрүга цогт Жавзандамбын итгэл
Оор хувилгаан зэргээр өөдөлснөөр зарлигийн түшмэл мэт
Орны их тэнгэр-бээр бид бүхнийг өдөр шөнийн цагт
Огт үл алгасран сахин аврахын өлзий хутаг орштугай.

ИХ ХҮРЭЭНИЙ ДӨРВӨН УУЛ

Улаанбаатар хотын дөрвөн талд орших тахилга шүтлэгт дөрвөн уул-Богд уул (хамгийн өндөр цэг нь 2265 м), Сонгинохайрхан (оргил нь 1663 м), Чингэлтэй (1831 м), Баянзүрх (1846 м) нь тус тусдаа сан тахилгын судартай ч дөрвүүлийг нэгтгэн тахихаар зохиосон энэ хураангуй судар ихэд тархсан юм. Зөвхөн 4 уул төдийгүй Хан уулын ард орших Зэндмэнэ уул, Хатан Туулыг ч энэ судраар тахиж болно.

Дөрвөн уулын энэхүү хураангуй судар ихэд дэлгэрсэн байдаг. Дөрвөн уул нь Монголын түүхэнд эртнээс алдартай бөгөөд олон сайхан домог хууч уламжлагдан иржээ. Тухайлж нэгийг өгүүлбээс Чингис хаан есөн өрлөг, 13 баатрынхаа хамт Алтан тэвшийн хөндийд буюу Хүн чулууны хонхорт нэг удаа саатан морилжээ. Тэр үедээ дөрвөн зүгт нь сүндэрлэх дөрвөн уулыг сонжин шинжин ажаад тус бүрт нь нэр хайрласан гэнэ. Тэр үед дөрвөн уул тухайлсан нэргүй байсан гэнэ. Чингис хаан дөрвөн уулыг нар зөв эргэж Хан уул, Сонгино хайрхан, Баянзүрх, Цэнгэлтэй хэмээн нэрлэсэн нь цөм учиртай байжээ. Үүнээс өмнө энэ дөрвөн уулыг Хан гарди (Хан уул), Арслан (Сонгинохайрхан), Луу (Цэнгэлтэй хайрхан), Бар (Баянзүрх уул) гэж савдагаар нь нэрлэж байсан гэнэ. Чингис хаан Арслан савдагтай хайрханд явж байтал арслан архирах шиг дуун гарч, хад асга нурж, их эзний өлмийд том сонгино өнхөрч ирээд тогтсонд уг уулыг Сонгинохайрхан гэж нэрлэсэн домогтой. Энэчлэн бусад уулыг нэрлэсэн домгуудтай.

Тайлбар а: “Чингэлтэйн сан тахил” хэмээх эл модон барын судар нь богино авч товч тодорхой юм. Чингэлтэй уул нь Улаанбаатар хотын умар биед оршдог. Хүрээний тахилга шүтлэгт 4 уулын нэг бөгөөд Хэнтий ханы олон салбар уулын нэг юм. Энэ уулыг ном эрдмийн цагаан өвгөн сахиустай гэж ном бичгийн хүмүүс дээдлэн тахиж шүтэж иржээ. Чингэлтэй ууланд Их Бурхант, Бага Бурхант хэмээх хоёр уул буй. Чингэлтэй салбар уулын ам бүрээс олон гол, горхи, рашаан булаг

урсдаг. Тэдгээрээс Хайлаастын гол, Яргайтын гол, Чингэлтэй, Сэлбийн голд зориулсан олон сайхан дуу шүлэг зохиогджээ. Чингэлтэй нэр нь Цэнгэлтэй гэсэн нэрийн хувирсан хэлбэр болно.

Тайлбар б: Эн сударт Сонгино хайрхан уулыг Зонжаа гэж төвдөөр орчуулсаны дээр бас Өндөр хайрхан гэж өргөмж нэрээр нэрлэсэн байна. Энэ уул Улаанбаатар хотын баруун этгээдэд Туул голын хойт биед орших, дундаж өндөр нь 1600 м болно. Сонгинохайрхан уулыг бүрэн зэвсэгээ агссан их баатар эр, цэргийн жанжин зэрэг олон шинжтэй гэж ард түмэн домоглон ярьсаар иржээ. Энэ нь арсгар барсгар асга хад ихтэй тул ийн хэлсэн биз.

Судрын төгсгөлийн үгээс үзвэл Рүдан хийдийн ханчин Агваанпринлайжамц зохиосон ажээ. Рүдан буюу Раден хийд нь 11-р зууны эхээр төвдөд Брондонба хувилгааны байгуулсан хийд болно. Тэгэхлээр Агваанпринлайжамц нь энэ хийдээс Их хүрээнээ залагдан ирсэн бололтой. Их хүрээний нэгэн эрдэмт лам Агваанпринлайжамцаас Сонгинохайрханы сан сэржим зохион хайрлахыг хүсчээ. Тэгэхэд нь Агваанпринлайжамц тэр өндөр хар уул их догшин уул юм байна. Энэ уулын эзэн нь хөх үхэр хөлөглөсөн, араа соёо нь зөрсөн, архи нанчид зооглох дуртай, айхавтар хөх өвгөн байна. Бас зарим үед их цэргийн ноёны байдалтай болдог ид шидтэй өвгөн байна гэж айлдаад дээрх сангийн судрыг зохиосон гэдэг.



Сонгино хайрхан уул нь Монголын эрт эдүүгээгийн түүх соёлын дурсгалаар баялаг уулын нэг болно.

THE FOUR HUREE SACRED MOUNTAINS

Information on the sutra:

The text describes the four sacred mountains surrounding Ulaanbaatar, Mongolia's capital city once called Urga. The mountains are Bogd Khan Mountain named after the traditional ruler of Mongolia (South), Songino Khaikhan Mountain (West), Bayanzurkh Mountain (East) and Chingeltei Mountain (North).

Each of the four sacred mountains has an individual sutra. However, a fifth sutra is dedicated to the four mountains as a group.



...
 ...
 ...
 ...
 ...
 ...
 ...
 ...
 ...

...
 ...
 ...
 ...
 ...
 ...
 ...
 ...

...
 ...
 ...
 ...
 ...
 ...
 ...
 ...

...
 ...
 ...
 ...
 ...
 ...
 ...
 ...

...
 ...
 ...
 ...
 ...
 ...
 ...
 ...

...
 ...
 ...
 ...
 ...
 ...
 ...
 ...

Handwritten text in a rectangular box, oriented vertically. The script is dense and appears to be a form of Cyrillic or a related Slavic alphabet. The text is arranged in several columns, with some lines starting with decorative initials.

Handwritten text in a rectangular box, oriented vertically. Similar to the first block, it contains dense script in columns, with some larger initials at the beginning of sections.

Handwritten text in a rectangular box, oriented vertically. The text continues in the same style, with multiple columns of dense script and decorative elements.

Handwritten text in a rectangular box, oriented vertically. This block contains several columns of dense script, with some lines starting with large, ornate initials.

Handwritten text in a rectangular box, oriented vertically. The text is arranged in columns, with some lines beginning with decorative initials.

Handwritten text in a rectangular box, oriented vertically. The script is dense and fills most of the box, with some larger initials at the start of lines.

**ИХ ХҮРЭНИЙ ОРНЫ ТЭГЭР
ДӨРВӨН УУЛЫН САН**

Хум,

Тэтэж ба бүрнийт сахин аварсан

Тэнгэр сахиулсан хамтнийт ариусгая

Тэнгэр арын уул Чингэлтэй болоод

Тэргүүний өмнө зүгийн хан уул

Тэндсхийн хормойд орших Зэндэмч уул

Тээр зүүн зүгийн Баянзүрх хайрхан

Тэндээс өмнө зүгийн Сонгинод оршсон

Тэнгэр шивдаг, Их ялтүүтсад-нугд

Өөр өөрийн болоод тус тусын хатад ба

Өмөт хөвгүүн, түшмэл цэргийн ноён цөм

Өтөөмөр сант сахин алив нэгэн артаар

Өлзийт нөхөр, зарилгийн харц иргэдийн хамтаар

Өнидийн хувилгаан, хувилгасан сэлтийт ариусгатай.

Тусын их гол Туулд оршсон

Лусын хаан, Васука тэнгэрийн нөхөдийт ариусгая.



Бус бас ойр орчны ус гол, уул газарт оршсон

Лус савдаг тэргүүтнийт ариусгая

Омол дээрэрнхүй дэвжид-найман аймаг

Осолдон хоцролгүй ариусах болтугай

Хэмээсэн үүнийг аллагч Лувсан нэрт-бээр найруулав.



ИХ ХҮРЭЭНИЙ ЭРХТ ЗҮГИЙН УУЛ БАЯНЗҮРХ ХЭМЭЭН АЛДАРШСАН ОРНЫ ТЭНГЭР САН ТАХИЛ ӨРГӨХ ЁСОН АМГАЛАН ЖАРГАЛАНГИЙН ХУР БУУЛГАГЧ ХЭМЭЭХ

Хум

Өвөрчлөнгийн тийн ариун номын агуу уудам төвөөс
Өөсөөн асар олноор гэтэлгэх тус амгалангийн хур буулгах
Өнөө бидний Багш, Ядам, Чухаг дээд гурав, зарлигийн хамсаа сэлт
Өөдлөж эдүгээ энэ орноо ариусгалын зочноор зочлогтун.
Онцолбоос умар зүгийн халхын эд баригчийн төвд
Олноос сүртэй үзэсгэлэн төгс Баянзүрх хэмээн
Онгон нэрээр алдаршсан уулнаа дээд орны тэнгэр
Орны эзэн, дэлхийн эзэн нөхөд сэлт энэ орноо залрагтун.
Өмнөдийн үзэсгэлэнт дүр байдалт орны төвд
Өнгө улаан, цагаан үзэсгэлэнт эрдэнийн уналга баригч
Өв тэгш хивэрлэг торго, эрдэнийн чимгээр чимсэн бар хөлөглөсөөр
Өөрийгөө баясгасан дүр байдлаар батад залрагтун.
Самди тарни хийгээд ариун мутраар адистидласан
Сайн тахил, балин тангарагийн зай элдэв жансиг зэргийг
Сац бас маш хэтэрхий газар хийгээд завсрыг гэгээн гэрлээр
дүүргэснээр
Сайтар хоцроолгүй нөхцөлдүүлэн бүхнийг баясган жаргуулахын
тулд өргөө.

Өгөөмөр эрдэнийн санд долоон морьт хэмээгдэх нарны
Өгснийг идэгч хэмээх галд билгийн гал бадарсны төвд
Угаас сайхан үнэрт сангийн элдэв зайг шатааснаар
Утаан үүлэн үхэлгүйн мөр бүхнээ түгсэн үүгээр
Багш, Ядам, Чухаг дээд гурав, зарлигийн хамсааг ариусгая.
Бас ертөнцийн амарлангуй зочдуудыг хоцроолгүй ариусгая.
Онцгойлбоос сайн жавхалант Баянзүрх хайрханы
Онгон навдаг, шивдаг, эзэд нөхөд сэлтийг ариусгая.
Улмаар та бүхэн дээдийн сан тахилгыг таалсан бөгөөтөл бидэн
Улаан, цагааны хиншүү хярвас тавих, амласанаа эвдсэн аваас

Урхаггүй тэнгэр шүтээнд андаймаа буруу юм хийсэн ахиул
Ууч таалалтай харшилсан бүхнийг хүлцэн зохиож хайрла.
Гутаггүй ба бүрний багш, шавь өглөгийн эзэд, нөхөд сэлт-бээр
Гурван үүднээс тийн үйлийг юутай ч атугай үйлдэвч
Гутаах атаа хилэн болон найдангуйн дээдийг зохиохуй-дор чу
Гудиггүй санасан хэрэг бүхнийг бүтээхийг нөхцөлдүүлэн хайрла.
Бус бас хэл ам, хэрүүл тэмцэл, эвдрэл самуурал болон
Бусцар хяруу, мөндөр, ган зуд, догшин хуй салхин үймэх
Буруу дайсан, хулгай дээрмийн хир хэмжээ ихсэх, гуйранч мухардах
Бусад үл зохилдох барцадыг үлдээлгүй арилган зохио.
Ус хур цагтаа бууж өвс мод, навч цэцэг дэлгэрээд
Ухаант хүмүүний язгуур үндэс эд баялаг арвидахын ам дэлгэрч
Улс амьтны амгалан жаргалан нь зуны далай мэт тэгшрэн
Угаас зуун баясгалангаар мөшөөлгөх эрхин үйлсийг зохио.
Хамгаас онцолбол Их хүрээний энэ зүгийн газар оршоод
Хамтаар хуран чуулсан хамаг төрөлхтөний
Харшлах нөхцөл арилаад зохилдох нөхцлүүдийг бүтээхийг
Хань хамсаа болсон Далх-та бээр ивээтүгэй.
Багш, Ядам, Чухаг дээд гурвын адистид хийгээд
Басхүү тангарагтан далайн орны догшин тэнгэрийн хүчээр
Ба бүрний нөхөд сэлтийн барилдлагын шүтээн гарснаар
Баясангуй сэтгэлийн ерөөл ямарчлан бүтэхийн өлзий хутаг оршиг.

ХАН УУЛЫН ЗАЛБИРАЛ ТАХИЛГА

Ом свасти
Урд зүгийн огторгуйд мянган навч сайтар дэлгэрсний дээр
Угаас нарны лянхуат тавцан дээр
Ухаант багш, Ядам, Аврагч гурвыг үл хоцроон
Уулаасаа онцгой Хан уулын шивдагууд
Баясангуй нигуураар тус тусын тавцан дээр
Батад оршоод зохилдох зай эдгээрийг таалагтун.
Бадрангуй сан зохиолт эрднээр чимсэн агуу саванд

Балрашгүй чухаг эдлэл, хүслийн таван эрдэм шашин төрийн долоон
эрдэнэ хийж

Үхэлгүй рашаан алтан ундааг далай адил уйлгалуулаад
Үнэнхүү зуун амт төгссөнийг балт уул мэт цогцлуулан
Үвтэгш тэнгэр хийгээд хүмүүний сангийн зай үлэшгүй нүгүдийг
Үзвээс алтан хайлмал бадарсны адил бэлгийн галаар шатаасны
Утаан үүлсээр огторгуй газрын зүг бүхнийг дүүргээд
Ухаант багш, Ядам, Номын сахиулсан хотол олон
Урдах хан уулын шивдаг нөхөд сэлтийн
Улмаар цувиралгүй амгалан жаргалангийн тулд би бээр өргөө.
Баясаад сайтар дөрөв, егзэр ба бүрний
Байгаа орон нутаг өлзийтэй, хүмүүний нас урт, эд дэлгэрч
Бас хээрийн замд хуйхуй дайсан, хулгай дээрэм, усны аюул
Барилдлагагүй гадна дотны аюул бүхний үйлээс авраад
Сац бас сонсох бясалгах, номлох бүтээх, сурах сургахын
Сайн чуулганы шашны үйл бүтээл дэлгэрэх ба
Жилийн өнө үргэлжид сайжирч, хур ус цагтаа бууж
Жир хүмүний эд баялаг, буян хишиг, хийморь сүлд дэвжин
Номын барилдлага, амгалан жаргаланг дэлгэрүүлэх сайн бэлгийг
соёрх.
Номт хуврагийн аймгуудын таалал, зохилдох номлолыг бүтээж
арвитга.
Хаан түшмэл, харлиг иргэн арван буяны хууль цаазад оршоод
Хаа ч зохилдохгүй бүхнийг амирлуулан зохилдох нөхцөл хур усан
мэт буугтун.
Харин өлзий хутгийн далай насад дэлгэрэх болтугай.
Хан уулын залбирал, тахилга үүгээр орштугай.

СОНГИНОТ БУЮУ ӨНДӨРХАЙРХАНЫ ШИВДАГУУДАД САН ТАХИЛ ӨРГӨХ ЁС ЕСӨН ХҮСЛИЙН ХУР БУУЛГАГЧ ХЭМЭЭХ ОРШВОЙ

Намо гүрү таа ра наа тха еэ. Эндэх хүрээний баруунаа орших
Сонгино /Зон жаа/ уул буюу Өндөр хайрхан хэмээн алдаршсан ууланд
оршсон шивдагуудад ариутгал тахил өргөхийг хүсвээс агар, хүж
тэргүүтэн сайхан анхилагт элдэв ариун эд зайг галд шатаагаад:

Ум хэмээн

Ариутгалын зай, тахил балин гадаад дотоод нууцын

Аль буй тэргүүтнээр гол болгон адислаад:

Хум,

Агуу уужим газрын эд баригч хамгийг эрхэндээ хураасан

Асар жавхлант, үзэсгэлэнт Өндөрхайрханаар алдаршсан

Энэхүү уулнаа оршсон орны их тэнгэр

Эрхт нөхөд сэлт өөдлөн өөдлөн эл орноо ирэн соёрх.

Өмнөдийн огторгуй дахь шуурган хий адил

Өрвөлзөх догшин хар үүлсийн дунд

Өөрийн лагшин нь харанхуйн өнгө адил

Өгүүлэшгүй маш хилэнгийн дүртэй

Торгон молцогтой зэр зэвсэг

Тод эрээн мод мутартаа барьсан

Том хөх үхрийн дээрээс

Тонж баясгалангаар залрагчийг урьмуу.

Үнэмлэхүйн агаарт өвөрчлөн зорьшгүй ч

Янагуухуйн гадаад дотоод тахилгын үүлэн

Үлэмж дээд эд зай, жансиг үл бүрэлдсэн үүнийг

Дайны тэнгэр, хэвцэг нөхдийг баясгах үүднээс өргөө.

Гайхам бхрүмийн эрдэнээр зуунтаа чимэн хээлсэн

Гагцхүү илтэд үзэсгэлэнт савын доторх билгийн

Галын цогцод сайхан анхилга үнэдийг шатааснаар

Гарсан утаан үүл нь огторгуйд түгсэн үүгээр

Багш дэгэд гурав, номыг тэтгээчин сахиулсан

Бас онцолбоос Өндөрхайрхан хэмээгдэхийн
Навдаг шивдаг, охин тэнгэр, найман аймаг тэргүүтэн
Насад хоцролгүй ариусан баясаж ханах болтугай.
Таалснаар орны эзэн ба бүрний багш шавийн эрдэм тахилаар
Таагүй улаан, цагаан эдээр тулга тогоо бузар болох
Чулуу ховхлох, газар сэндлэх тэргүүтнийг юун боловч
Чухаг хүлцэн тэвчиж, залбирч хөвгүүнчлэн тэтгэн зохио.
Энэ л орон газрын хүн, малд тусах
Элдэв өвчин хижиг, хяруу мөндөр, ган зудаас
Этгээд муу гай гамшиг
Эрчит догшин аянга цахилгаан буухаас
Энэрэлгүй араатан амьтны хор хөнөөлөөс
Эрх биш тэжээхүй бүхнийг амирлуулан
Жилийн сайн үр шимийг
Жигд арвижуулан дэлгэрүүлж хайрла.
Эрдэнэ сүрэг, адгуус амьтан арвидахын ам дэлгэрч
Эсэг цагаа, тараг айраг зуны далайтай тэнцэн
Хамаг төрөлхтөний энх эсэн, орь залууг дэлгэрүүлэх
Харгүй сайн буяны хотол гурван чуулганы үйлсийг зохио
Хамгаас ангид Жавзандамбын энэ хүрээнд
Халамжит бурхны шашны зул машид мандаад
Хотол олны доройтлын харанхуйг сайтар арилгаад
Хосгүй тус амгалангийн гэгээг түгээн хайрла.
Аанай бас энэ зүгийн орноо хуран чуулсан
Алив хүмүүн хаа нэгтээ одож, хаа нэгтээ суух болсон ч
Орон нутаг, зам харгуй, хээр тал бүхэнд ялгалгүй
Онц цагаан үйл бүтээхийг нөхцөлдүүлэн зохио
Эмхтгэвээс хэвцэг догшин орны тэнгэр та бүхэн
Энэ газрын хүн төрөлхтөнийг алгасалгүй сахин аварч
Элдэв дайсны тотгодыг дарж, өнид зүрхний нарыг гийгүүлж
Эээр заяагч тэнгэрийн сахиусыг үл алгасран сахиж
Энгүй хэвцэг Гүл тэнгэрийн их хүчний хувилгаанаар

Эл гурван сансрын хамаг буян хишгийг энд хураагаад
Сав шимийн хамаг дуртмал өнгө, сүр жавхлан
Сайн хутгийн далайгаар газар бүхнээ түгэх болтугай
хэмээсэн Их хүрээний өрнийн сайн жавхлант уул Сонгинот буюу
Өндөрхайрханы шивдагуудад ариутгал тахил өргөх ёс есөн
хүслэнгийн хур буулгагч хэмээх үүнийг ариун явдалт дээдийн даяанч
Лувсаннамжилын дурдсанд Радэн хийд Доржчангийн хувилгааны нэр
баригч ханчин Агваанпрэнлайжамц найруулсны бичээч нь Дамдин
болой. Сайн буянд орох болтугай.

СОНГИНО ХАЙРХАНЫ СЭРЖИМ

Намо гүрү еэ. Эндэх Их хүрээний өрнө зүгийн уул
Өндөрхайрханд оршсон орны тэнгэрт сэржим өргөхийг хүсвээс
догшин архи, ариун алт тэргүүтэн нарийн гурил тавиад
адистидлагтун.

Хри:

Гурван ерттөнцийн галын бурхан цогт цагийн хар дайсан
Гурван сансрын сүрээр дарагч цогт их догшин гүрү
Гуйвашгүй зарлигийн найман тэнгэрийн чуулганд сэржим
өргөснөөр

Гутаггүй их амгалан дээдийн адистидыг бодитой бүтээн соёрх.
Хамгаас онцгой Халх нутгийн газар орон бүхнийг ч
Харъяалан эрхшээгч хүчин төгс Өндөрхайрхан
Хавтай идээр аянга буулгагч эх, хүү, түшмэл сэлт
Ханатал энэ сэржмийг таалж, дайсны тотгорыг эрэн тасал.
Албин шуламс бас бус ад ягчис хийгээд
Ажрах тэнгэр, лус найман аймаг газар дэлхийн эзэн, хатадад
Архи цусан сэржим өргөснөөр хортны зүрхний цусыг юүл.
Өдгөө тэр мэт сэржим ундаа үүнийг өргөснөөр
Өшөөтөн дайснууд тоосон товрог болон дарагдаад
Өчүүхэн ба бүрний нас цог, есөн хүслийн сайн чуулган бүхнийг

Өнид хоцроолгүй үтэр түргэнээр арвитган зохио
хэмээсэн үүнийг даяанч Лувсаннамжил бээр дурдсан хүслээр Радэн
хийдийн хувилгааны нэр баригч ханчин Агваанпрэнлайжамц
найруулбай. Буян болтугай.

ЧИНГЭЛТЭЙН САН ТАХИЛ ТУС БҮХЭН ОРШИВ

Ом сва сти,

Өмнө зүгийн огторгуйд элдэв өнгийн эрдэнэсээр
Өөрөө бялхтал дүүрсэн зарлигийн сүүн далайгаас үүдсэн
Хүслийг хангагч ороонгон модны найлзуур сэлгүүрэхийн дээр
Хүчит арслант тавцанд лянхув, нар, сараар чимэглэсний
Элдэв дэвсгэр дээр аврагч гурвын зарлиг лугаа
Эрхин чухаг Чингэлтэйн шивдагийг амирлуулан
Амирлангуй хилэнт элдэв дүр байдалт нөхөд сэлт
Аргачлан тус тусын суурин дээр машид баясаад
Ашид мөшилзөхүй нүүрээр сүсэглэн батад оршин соёрх
Эрхэм та нарыг баясгах дээд эд зайг өргөснөөр
Эгэл миний зарлигийн болон зарлигийн бус сайн бүхэн нь
Эндэхийн тахилын үүлэн цогц болон газар орныг дүүргээд
Эндэлгүй дээд зай, жансигийн сэржмийг дэлгэрүүлэх зэргийг
Ил бодитой бэлтгэн, сэтгэлээр хувилгаж та бүхэндээ өргөө.
Сац бас ялангуяа гурван оронд эгүүдэгсэн
Сайн сангийн зай хаа буй бүхнийг
Сааршгүй билгийн галаар шатаасны утаан үүлс
Сааталгүй бүх л орчныг дүүргэснийг Тандаа өргөө.
Ийн баясгаснаар сайтар дөрөв, ба бүрний багш шавийн
Эд баялаг, нас буян, сав шимийн юм доройтсны шалтгаан
арилж
Илрэх зүүдний болоод хонзонгийн бузар, их будангуйн
хийгээд уруудахын бузар
Илтэд ариун бус дэв бүхэн эдүгээ цэвэршин ариусах болоод
Эрхин цаглашгүй дөрөв хутагжин, нөхөд харлиг иргэд эд

эдлэлээр дэлгэрч
Элчилгүй аянд тохиох аюул, хулгай дээрэм зэргийн
Онц ноцтой хөнөөл бүхнээс авран соёрхож
Ончтой ном, цог учрал бүхэн сайтар дэлгэрээд
Огтоос үл зохилдох болгон амирлиж, зохилдох шалтгаан эсэн
Өөрийн санасан хэрэг шамдлагагүйгээр өөсөөн бүтэхийн
өлзий оршиг

хэмээсэн Чингэлтэйн сан тахил тус бүхэн энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн
Чадагчийн шашны огоот төгссөн агуу эзэн, умар зүгийн их хөлгөний
зан үйлт Халх Жавзандамбын ринбүүчийн зарлигаар дурдсанаар /эс/
зохиосончлон зөөлөн цогт эрлэгийн шидийн егзөрваа Шагжийн гэлэн
Лувсанбалдандамбийнямчоглайнамжилбалсанбо-бээр алба бүтээх
төдийд үйлдсэн болой.

ДАРЬАНГЫН АЛТАН ОВОО ХИЙГЭЭД ТҮҮНИЙ САНГИЙН СУДРЫН ТУХАЙ

Байгаль усаа хайрлах хүний энэрэл, хүн амьтныг тэтгэх байгалийн өгөөж, бие биеэ шүтэж оршихуйн шүтэлцээний учир зүйн зангилааг түүх соёл, шашин шүтлэгийн ёсондоо хадгалж ирсэн олон газар монгол нутагт буйн нэг нь Дарьгангын Алтан овоо юм.

Дорнод монголын нүүдэлчдийн соёл иргэншлийн хүрээнд авч үзэхэд тахилгын хувьд томоохонд нь багтдаг Алтан овоог нутгийнхан эртнээс аяарлан, аргадан тахиж, дэргэд нь нэрээр нь хэлдэггүй, дээр нь эмэгтэй хүн гардаггүй, хад чулууг нь хамаа бусаар ховхолдоггүй, хар буруугаар ус булгийг нь бузарладаггүй. Энэ бүхнийг зөрчвөөс эзэн савдаг нь хилэгнэнэ гэсэн элдэв түүх шашдирт бичигдээгүй ийм хуулийг бий болгон мөрдөж иржээ.

Дарьгангад сүрэг байгуулагдсаны дараахан Манжийн хааны зарлигаар Захын Хар өндөр нэртэй нэгэн уулыг Дарь овоо буюу Алтан овоо гэж өргөмжлөн нэрлэж, жил бүр хоёр удаа хаврын эхэн сар ба зун тахихаар болгожээ. Бас хааны зарлигаар Орлой мэргэн хутагтыг Дарьгангачуудын шүтээн лам болгосон байна.

Алтан овоо нь Дарьганга сумын төвийн дэргэд Молцог элсний умарт захад (з.у. 11°30'50", х.ө. 45° 21') оршино. Эртний сөнөсөн энэ галт уул 1349 м өндөр ажээ. 1923 оны нэг удаагийн тахилгыг үзсэн А.Эрэнчингийн дурдатгалыг түүхч Л.Жамсран тэмдэглэснийг үзвэл таван гар сүрэгчний Да бүр идээ цонхор, бай шанг урьд адил авч очсон. Дарьгангын сүм хийдийн лам бүр овоон дээр очиж хурал хурсны дараа Орлой мэргэн хутагтаа залсан. Ноёд овооны урдуур, мэргэд хутагт нар овооны баруун талд майханд олон шавь нартайгаа ном уншина. Энэ ёслол 2-3 цаг үргэлжилж ардууд овооны зүүн урд буй ноён хатны хөрөгт хадаг тавьж мөргөнө. Үдээс хойш овооны баруун урд талд наадам эхэлж, их насны морь уралдуулж, бөх барилдуулдаг байсан. Тахилгын төгсгөлд Алтан овооны бэлд байдаг гурван замын дээд талын замаар нь лам нар, дундахаар нь харцуул дээд замаар нь эмэгтэйчүүд явж гороолдог байсан ажээ.

Дарь уулын чанх орой дээр алтан ганжирт Батцагаан овоо байжээ. 1927 онд В.А.Казакевич Дарьгангаар явсан тухай “Поездка в Даригангу” номыг 1930 онд Ленинградад хэвлүүлсэн бөгөөд түүндээ “Батцагаан шиг нэн ховор сонин дурсгалыг хаана ч олж үзээгүй” гэж гайхан бичсэн байдаг. Эх нутгаа бишрэн хайрлах билэг дэмбэрлийн шүтээн болсон. Батцагаан суварга шиг ийм сүрлэг байгууламж монголын бусад нутгийн уул хайрханы оройд үнэхээр байхгүй байжээ.

Энэ нутгийн ахмад сэхээтний нэг С.Лувсанноров гуай “Дарьгангачууд зовлон зүдгүүрээс хагацах эрэл хийж зөвхөн тэнгэр бурханд мөргөх зорилгоор энэ овоог бүтээсэн гэвэл мөхөс болно... өгөөж буяных нь ундрага болсон төрсөн нутгаа хайрлах зөн олныхоо хиргүй сэтгэлийн баталгааг илэрхийлж энэхүү овоог босгоод бүх сайн үйл бат бэх, ариун цагаан байг гэсэн утгаар Батцагаан нэр өгч өмнөх үеийнхээ шилдэг өв уламжлалаар хойч үеэ хүмүүжүүлэх ухаалаг аргыг аль эрт бодож олжээ гэвэл зохино” гэжээ.

Гэвч түүхэн цаг үеийн байдлаас болж Алтан овооны тахилга хэдэн арван жилээр тасалдсан билээ. Даригангын Алтан овооны их тахилгыг 1990-ээд оноос хойш хоёр дахь удаагаа үйлдсэн бөгөөд долоон түм орчим хүн оролцсон ийм том тахилга монголын бусад нутагт бараг болоогүй болов уу.

Алтан Дарь овоо нь өөрийг нь шүтдэг нутгийн хүнээ хаана ч явахад тус авралаа хүргэдэг тухай цөөнгүй домогтой.

Дарьгангаас Баруун зууд шавилан сууж байсан нэг лам хурлын жаяг зөрчиж гэсгүйд бэрээдүүлэх болжээ. Бэрээдүүлсэн хүн амьд үлдэх нь ховор байж. Гэсгүйг бэрээгээ далаймагц дуганы үүдээр саарал морь унасан, жад барьсан хүн орж ирээд гэсгүйн суганд жадаа тулгахыг Далай лам хараад бэрээдүүлэхийг зогсоож

- Танай нутгийн шүтээн юу вэ гэж асуусанд тэр лам Дарь Алтан овоо гэдэг цагаан саарал морьтой, жадтай, хоёр хүний дүрстэй эзэн сахиус байдаг гэжээ. Түүнээс хойш Дарьгангын ламыг бэрээдэхээ больсон гэдэг домгийг нутгийн өтгөсүүд ярьдаг. Алтан овооны эзний хөргийг урьд цагт нутгийн айл бүхэн тахиж байсан ба уг эзний дүр зургийг сангийн судрын эхэнд нэн тодорхой дүрслэн өгүүлсэн буй. Тэнд өгүүлэхдээ Алтан

овооны эзэн сахиулсан нь эрдэнийн цагаан хөлөгтэй, эрдэнийн навс баринтагтай, баруун мутартай шашны дайсныг үндсээр таслагч болор шилэн илдтэй, зүүн мутаргаа эрдэнэ агуулагч тэвш залан барьж, хүссэн бүхнийг хайрлах, гурван цагийг эзэмдэх гурван мэлмийтэй, тэргүүндээ торгон титэмтэй, баатар дагинас, лам түшмэл, бараа бологч нараар хүрээлүүлсэн баатар эрийн дүртэй гэсэн буй.

Талын дунд онцгойрон харагдах энэ алдарт уулыг тал талаас нь харахад олон дүртэй харагдана. Наран жаргах үеэст зүүн урдаас нь харахад баруун хойшоо мөлхөж яваа яст мэлхий шиг харагддаг бол баруун хойноос нь Өргөөгийн ширээ дээрээс сайтар ажвал дэлээ хийсгэн давхиж хангал азрагны дүр тодрону. Баруун урдаас нь харахад хэвтэж буй арслангийн хэлбэртэй.

Энэхүү алдарт уулын төвд хэлээр байгаа сан тахилгын судар хэд хэдэн хувилбартай авч энд орчуулж толилуулан бүхий сан нь хамгийн сайн нь төдийгүй иж бүрэн байгаагаараа бусад уул хайрханы судраас өвөрмөц ялгаатай юм. Уг сударт уул усныхаа эзэн сахиусыг урин дуудаж, буянт мал сүргээ тэнгэрийн од шиг олон болгож, будаа тариагаа газрын үндэс шиг арвижуулахыг эгээрч, гай барцад газрын үүдийг үл хүсэмжлэн, хижиг өвчин, ад дон, муу хулгай дээрэм, ган зуд, хяруу мөндөр, салхи шуурга болон хямран тэмцэх хол ойрын хорлол, хэл ам, хэрүүл уруул тэргүүтэн үл зохилдох бүхнийг амирлуулан зохиож хотол олны нас буян батдаж цог учрал, амны хишиг дэлгэрч санасан хэргийг ая зөнд бүтээж өгөхийг заллага магтаал хангал, залбирал, ариусгал, даатгал, соёрхол, өргөл, өлзий, өгүүлэхүй хэлбэрээр хувь бүрэлдүүлэн яруу тодорхой дүрсэлжээ.

Ер нь Алтан овооны хийморь сүлдэнд энэ нутгийн хүн ард, мал сүрэг, ан гөрөөс, ус ургамал, өглөг хишиг, зовлон жаргал, нүгэл буян, сайн муу бүх үйл багтан хором бүрт авралд нь байдаг гэж нутгийнхан үздэг нь сангийн сударт туссан ажээ. Хангалын хэсэгт:

Идтэй салхины хүчийг баригч
Үлэмжид хувилгаан дээд морь
Их савагт хар сарлагаар
Гурван мянган ертөнцийг дүүргэж

Дөрвөн эвэртэй. хошуу үзэсгэлэнтэй
Дөлгөөн хар хонь хийгээд
Мянган өднийхөө хүчин чадлаар
Мятрашгүй дэвсэн хар шувуу үүгээр
Тэнгэр бурхны буяны садны
Тэргүүн дээд тааллыг хангая гэхчилэнгээр өгүүлсэн бол

тахил өргөхүйн хэсэгт:

Айраг тараг, сүү цагаа
Архи, цай зэрэг эрдэнэт тахилыг
Авуурьд сайтар байрлуулж
Анхилуун үнэрт цэцгээр чимсэн
Арц агь тансаг үнэртний
Анхилга утлагаар огторгуйг дүүргээд
Ариулсан галын гэгээн гэрлээр
Алимад харанхуйг үлдэн хөөж
Эмийн найрлага төгөлдөр үнэдийг
Орон бүхнээ түгээн тархааж
Элдэв зуун амт төгс
Тэнгэр хүмүүний идээ болон
Эгшиглэн сонсголонт яруу эгшиг
Энэ хөгжим тахилыг өргөн барья гэсэн байх жишээтэй

Тэгвэл ариусгалын хэсэгт нь лам, бурхан бодисадва, братига шарвааг, Цогт охин тэнгэр, Номун хаан Чойжин тэргүүтнийг ариусгаад эцэст нь:

Энэ замбуутивийн газрын эзэн
Ерөнхий ба ялгамжаат чанарт
Эрхин хүчний сүр бадарсан
Дарь сүмбэр уулаа ариусгая
Бас Харангуд Хонгорын эзнээ ариусгая
Баян Молцог элс, Дуутаа ариусгая
Баянгол тэргүүтэн цагаан зүгийг тэтгэгч
Бадрангуй дэлхийн эздээ ариусгая
Бас бус энэ газраа оршигч
Байдал догшин лус авдгаа ариусгая гэж энэ зүгийн газар ус болон

тэдний эздийг ариусгаж байна. Алтан овооны сэржим нь:

Хамаа чуулган хүслийн таван эрдэнэтийн
Хавархалт алтан ундааны тахил үүнийг
Хавацашгүй лам, ядам чухаг гурав
Хандаа, Чойжин хамаг бүгдэд хийгээд
Хамгаас алдартай Манай Дариганга нутгийн

Хан тэнгэр лус найман аймагт өргөө гээд тахилыг өргөснөөр ган зуд, хяруу мөндөр, өвчин хижиг, хэл ам зэрэг үл зохилдох бүхнийг амуутгаж цагийн хур цагтаа бууж мод ургамал дэлгэрээд санасан бүхнийг бүтээхийг соёрхжээ.

Энэ нутгийн авъяаслаг хүү зохиолч, яруу найрагч Гомбожавын Мэнд-Ооёо “Алтан овоо” хэмээх сайхан романдаа: “Хүнийг таньж мэдье гэвэл аав, ээж, ахан дүүс, хамаатан садан, найз нөхдийг нь таних хэрэгтэй юм гэнэ лээ. Алтан овоог бүрэн танья гэвэл, ахан дүү амраг садан шадар олон уул усыг нь таньж мэдэх хэрэгтэй билээ” (80-р тал) гэж бичсэн буй. Тэрхүү таньж мэдвээс зохилтой орчин тойрны олон уул усыг уг сударт дурдсан байдаг. Ганга нуур нь Хонгор, Молцог хоёр хүүтэй, хойно урдаа Баяндулаан, Лүн хайрхан зэрэг баатар түшмэлтэй, Гангын Цагаан овоо, Шилийн Богд, Дөш уул, Баянгол, Дагшин, Дуут нуур, Оргихын булаг гээд хавь орчны хараа барааны бүхий л газар ус нь Алтан овоотой ах дүү, ураг садан, лам хуврагийн барилдлагатай гэж нутгийнхан ярилцдаг. Мөн Егүзэр хутагтын нутагт орших Зотолхаан нь холд өргүүлсэн дүү нь гэж үздэг бол Дөхөмийн бор... төрсөн дүү нь гэдэг ажээ.

Энд дурдсан хийгээд сангийн сударт дайралдаж байгаа газар ус нь домог түүхтэй нэрийх нь гарлыг тайлбарлах нэг сэжим болж өгдөг. Үүнтэй холбогдуулан “Дарьганга” нэрийн гарлын тухай товчхон өгүүлсүгэй. Дарьганга гэсэн нэр нь нутгийн нэр, тэнд оршин суугч ястны нэр болсон ажээ.

Дарь овоо, Ганга нуур гэсэн энэ хоёр нэрийн тухай нутгийн ард түмний дунд дэлгэрсэн домог яриа ч цөөнгүй бий.

Эрт цагт жагар оронд эрдэм ном сураад эргэж нутагтаа ирсэн нэгэн хүн Ганга мөрний рашааныг залж авчраад их элсний хормойд булснаас хожим нь тэндээс булаг усан бургилж нуур тогтсоныг Ганга

нуур гэх болсон тухай нэгэн домог бий.

Бас эрт цагт нэгэн баян айлд Ганга нэртэй зарц хүү байсан тухай домог бий. Тэр зарц хүү тэр баяны хүн мөргөдөг бухыг мөргөхөөр ирэхэд нь хүзүүг нь мулт алгадаж алаад, өргөөд авч ирсэнд гэрийн эзэн уурлаж гэрээсээ хөөжээ. Тэр хүү овооны наадамд барилдаад Дарь гэдэг хоньчин хүүтэй үзүүр түрүүнд үлдэж хүч тэнцсэнээс нэгнийх нь нэрийг овоонд, нөгөөгийнх нь нэрийг нууранд өгснөөс сүүлд нь Дарьганга гэсэн нэр үүссэн гэнэ. Түүнчлэн эрхэм сурвалжит язгуурын Дарь гэдэг хүү, Ганга гэдэг охинтой хүж барилдсанаас уул овоогоо Дарь, ус нуураа Ганга гэж нэрийдсэнээс Дарьганга гэдэг нэр үүссэн. Дараа нь Дарь Алтан овооны зүүн урд бэлд тэдний дурсгалд зориулан ноён хатан хоёр чулуун хөрөг босгосон гэдэг ам дамжсан домгийг түүхч Л.Жамсран тэмдэглэжээ.

Эдгээр домгоос үзэхэд Дарь, Ганга гэсэн хоёр нэрийг уул усандаа хэрхэн өгснийг өгүүлж байгаа авч чухам ямар гаралтай болох нь мэдэгдэхгүй байна.

Монгол хэлэнд буу зэвсгийн цэнэг хийх тэсрэх бодисыг нэрлэдэг перс (дааруу) гаралтай дарь (хүхэр) гэсэн нэг үг байдгийн дээр самгарди хэлнээс орж ирсэн “гэтэлгэгч” гэсэн утга бүхий Дарь (эх) сам. Таараа гэсэн бас нэг нэр байдаг.

Чингэтэл Дарьганга хэмээх нэрийн бүрэлдэхүүнд байгаа Дарь овооны нэрийг зарим судлаачид галт уулын оргилолт, дарь хүхэр мэт хүчтэй дэлбэрэлтээс үүсч тогтсон хүрмэн чулуутай сөнөсөн галт уул учраас ийн нэрлэжээ гэж үзсэн нь олны дунд их дэлгэрчээ. Дарьгангад төдийгүй монгол нутагт олон тооны сөнөсөн галт уул бий боловч тэдгээрт Дарь нэртэй уул дайралдахгүй байгаагаас үзвэл энэ овооны нэрийг дарь (хүхэр)-тай холбох нь үнэмшил муутай мэт.

Түүнчлэн өмнө өгүүлсэн “гэтэлгэгч” гэсэн үгээс үүсэлтэй байж магадгүй гэсэн таамаглалыг зарим хүн дэвшүүлжээ. Ингээж үзэх ч учир холбогдол байж магадгүй. Нутгийнхны заншлаар энэ овооны оройд эмэгтэй хүн гардаггүй нь Дарь эх лүгээ адилтган хүндэтгэсэн хэрэг байж болзошгүй.

Дарьганга нэрийн гарлын талаар В.А.Казакевич, Э.М.Мурзаев, Ж.Цэвээн, Бавуудорж, Л.Жамсран нар өөр өөрийн саналаа дэвшүүлсэн буй.

Миний бие “Дарьганга нэрийн гарлын тухай” гэсэн өгүүлэл бичиж..... 1940-өөд оны үеэст нэрт газар зүйч, эрдэмтэн Э.М. Мурзаев Дорнод монголоор жуулчилсан бөгөөд “Монголын уудам нутгаар” хэмээх номдоо: “Дарьганга гэдэг үг бол эртний үг бөгөөд Ганга гэдэг жижиг нуур ба тахилгатай байсан Дарь овоо гэдэг галт уулын нэрсээс үүсчээ. Энэ газар зүйн нэрсүүд онц сонирхолтой юм.

Ганга гэдэг монгол үг бол голын хөвөөний жалга, голын гульдирлыг томъёолдог. Дарь гэдэг бол монгол хэлээр тэсэрч дэлбэрдэг зүйлийг өгүүлнэ. Дарьгангын галт уулсын нэрийг тэсэрч дэлбэрдэг Ганга гол гэсэн үг гэж тайлбарлаж болох болов уу. Үнэндээ лавын урсгал бол чухамхуу тийм халуун бөгөөд хий ундруулсан голын байдалтай байдаг билээ. Иймд Дарьгангын галт уулс эртний хүмүүсийн үед оргилж байсны гэрч нь манай үе хүртэл дамжаар ирсэн газар зүйн нэрс юм” (36-р тал) гэж тэмдэглэжээ.

Энэ бол сонирхолтой санал авч Дарь овоо гэдэг нэр хожуу үүссэн бөгөөд дээр үеийн нэр нь Захын хар өндөр нэртэй байсныг өмнө нэгэнт дурдсан билээ. Зах зайдуу нутагт байсан энэ галт уулыг Хар өндөр гэдэг байсан нь жинхэнэ хүрмэн чулууных нь өнгөөр нэрлэсэн их эртний үеийнх нь холбогдолтой нэр юм байна.

Ширээт гүүшийн орчуулсан “Үлгэрийн далайн” хоёрдугаар бүлэгт “Тэнгэрийн хөвгүүн Гангадарь нэргийн зүйл” гэсэн үлгэрт гарч байгаа хүүгийн нэртэй холбон үзэх бүрэн үндэс байна.

Тэр үлгэрт:

Эрт цагт үр хүүхэдүй нэг баян Ганга мөрний хязгаарт орших Маньбадраа гэдэг шүтээнээс үр гуйсанд Хурмастын зарлигаар нэр тэнгэрийн хөвгүүн тэр баяны хатны хэвлийд орж маш үзэсгэлэнтэй хүү болон төрснийг өгүүлдэг. Нэгэн шинжээч тэр хүүг үзээд хүүгийн төрсөн шалтгааныг эцгээс нь асуусанд эцэг нь: “Ганга мөрний хязгаар дахь нэгэн тэнгэрээс гуйсан бөлгөө” гэсэнд шинжээч, тэр хүүд Гангадарь гэсэн нэр өгчээ. Тэр хүү өндөр хаднаас харайн унавч бэртдэггүй, мөрөн голд харайн унавч живдэггүй, хор идэвч үхдэггүй ер бусын чадалтай ажээ. Эцэг эх нь өв хөрөнгөө залгамжлуулах гэсэн авч хүү түүнээс нь тэрсэлж эцэст нь Бурхан багшид шавь орж тойн болоод их ном эрдэмд гэгээрч, дайныг

дарсан бодь хутгийг олсон тухай гардаг. Дээрх үлгэрт гарч байгаа Гангадарь гэсэн нэрийн Ганга нь Ганга мөрний нэр болох нь тодорхой агаад харин дар нь самгарди хэлний дхара гэсэн үгээс гаралтай, үгчлэн орчуулбал “баригч” гэсэн үг.

Зарим хүний бичсэнээр Дуу Дарамбазарын гэгээн гэдэг төвд хүн зохиосон гэдэг боловч үнэн хэрэгтээ “Эрдэнэ мэргэн хутагтын хувилгаан Лувсанжигмэддорж хийгээд равжамба Лувсанбалжор хоёулын дурдагснаар шагжийн гэлэн Лувсанбалдан Дамбийням-бээр найруулан бичив” гэсэн төгсгөлийн үгтэй “Алтан овооны сан тахилгын судар”, “Са зин Даа ри дан чү во Ганга...” гэж эхлэх бөгөөд үүнийг “Газрыг баригчийн баригч (Даа ри)хийгээд Ганга мөрөн...” гэж үгчлэн буулгаж болно. Уламжлалт орчуулгын үүднээс Са зин (Газрыг баригч)-ийг уул гэж орчуулж ирснийг харгалзвал энэ нь Дарь уул болох ажээ. Иймд дарь нь “бүхнийг баригч, өөртөө баригч” гэсэн утгатай. “Чү во Ганга” буюу Ганга мөрөн гэдэг нь Дарь овооноос урагш элсэн манханд орших тунгалаг уст нуурын нэр юм. Овооны сударт энэ нуурыг мөрөн гэсэн учиртай бөгөөд “мөрөн хэмээх нь далай болой” гэж “Гаслангаас нөгчигсэн судар” (доньянг дай)-д номлосон” гэж Номтын Ринчин “Төвд монгол толь”-доо тэмдэглэсэн байдаг. Чингэвэл Ганга мөрөн гэсэн нь даруй Ганга далай гэсэн утгатай болох нь тодорч, нутгийн ард зон нь энэ үзэсгэлэнт нуураа далайтай зүйрлэж байсан, бас уг судрыг зохиогч нь бурхан шашны үлгэр цадигт гардаг нэрийг билэг дэмбэрлийн үүднээс авч хэрэглэсэн зэргийг гэрчилж байна.

Ингэхлээр Дарьганга гэсэн нь “Гангыг баригч” гэсэн утга бүхий Гангадарь нэрийг тонгоруулан үүсгэсэн нэр байна. Ийнхүү тонгоруулсан нь монгол уламжлалтай бас холбоотой. Энэ овооны сударт Ганга нуурыг Дарь овооны эхнэр (хатан) гэсэн байх тул уулын нэрийг өмнө нь оруулснаар Дарьганга гэж нийлүүлэн хэлэх болжээ.

Монголын олон алдарт уул ус нь цөм л магтаалтай. Алтан овооны магтаал нь өдгөө амаар уламжлагдан ирсэн болно. Алтан овооны тухай монголын яруу найрагчид шүлэг зохиол бичиж, зураач урчууд уран бийрээ билүүдэн хөрөглөж, хөгжмийн зохиолчид ая дуугаа өргөсөөр иржээ.

Дарьганга сумын харьяат өвгөн лам Балдангийн Жунайгаас С.Лувсанноров гуайн бичиж авсан “Овооны магтаал” (“Сүхбаатарын зам”, 1994, № 26), түүхч Л.Жамсрангийн “Дарь Алтан овооны магтаал” (Дарьгангын сүрэг хошуу, УБ, 1994) академич Д.Цэрэнсодномын 1966 онд Дарьгангаас сурвалжилж ирсэн “Дарь овооны магтаал”, Д.Маамын “Газар шороо” романд буй магтаал болон Равжаа хутагтын зохиосон гэх “Алтан Дарь овооны магтаал” (Г.Ловор “ИЛ товчоо” 1992, №02) зэрэг нь энд толилуулж буй магтаалаас бага зэрэг ялгаатай байна. Миний бие 1994 онд Дарьгангаар явахдаа нутгийн хэд хэдэн хүнээс энэхүү магтаалыг тэмдэглэж авснаа нэгтгэн толилуулж байна.

АЛТАН ОВООНЫ МАГТААЛ

Богд л Дарь овоо минь
Богд эзнээс мэдээтэй
Зуугаас буусан сунтагтай
Зургаанаас буусан цалинтай
Банчин Богдоос лүндэнтэй
Бадамлянхуа цэцэг шиг
Бахтай сайхан нутаг даа
Богд л Дарь овоо минь
Босоо дөрвөн түшмэлтэй
Баруун урд зүгт нь
Баяндулаан хангайтай
Баруун хойт зүгт нь
Лүд шулмыг дарсан
Лүн хангайн уултай
Зүүн хойт зүгт нь
Зүс эрээн барын шинжтэй
Нарийн дөрвөн өнцөгтэй
Нарт хангайн уултай
Зуун урд зүгт нь

Зүйлийн аюулыг дарсан
Зүмбэр цагаан уултай
Дарь, Чойжин овоо минь
Хосгүй Дагшин, Дуут булагтай
Холбоо, Ганга нууртай
Ганганасан олон шувуутай
Гайхамшигт сайхан орон доо
Алтан Дарь овоо минь
Авралт шажин дэлгэрүүлсэн
Арван гурван хийдтэй
Сан сэржим өргөсөн
Санваар сахьсан хуврагуудтай
Шавгийг нь уншиж шаагьсан
Шажны олон шавь нартай
Эргэж мөргөх суврагатай
Эрэгзэндагвын орон доо
Алтан Дарь овоо минь
Таван гарын амбастай
Гурван малын сүрэгтэй
Тансаг сайхан нутаг даа
Дарь Чойжин овоо минь
Түүхт Дарь Гангын өлгий Таны
Түмэн өлзий орших болтугай.

Ихэнх газар усны магтаалд тухайн магтаж байгаа газрыг дөрвөн талаас нь шинжин харж магтдаг нэг онцлогтой байдаг бол Алтан овооны магтаалд зөвхөн түүний баруун урд, баруун хойт, зүүн хойт, зүүн урд талд нь орших дөрвөн хайрхан уулыг дурдаад Алтан овоог Рэгзэндагвын бүрэлбаатай гэснээрээ ялгаатай байна. Энэ нь Алтан овооны сан тахилгын судар, түүнийг тахиж ирсэн зан үйлтэй учир холбогдолтой зохиогдсоныг харуулж байна. Энэ магтаалын эхэнд Манжийн эзнээс зөвшөөрөгдсөн, Баруун зуугаас сургаал авдаг, Сангийн яамнаас цалин хүртдэг, Төвдийн Бачин эрдэнээс зарлигтайг онцлон өгүүлж байна. Мөн

тэрчлэн таван гарын амбастай, гурван малын сүрэгтэй гэж гарч байгаа нь Дарьгангад сүрэгчин бий болсныг хэлж байгаа хэрэг юм. Энэ нь баруун, зүүн гарын адуучны сүрэг, баруун, зүүн гарын тэмээчний сүрэг, хоньчны сүрэг болно. Мөн “Авралт шажин дэлгэрүүлсэн арван гурван хийдтэй” гэсэн Овоон сүм, Молцог, Рашаант, Сөдөт, Гүн худаг, Талын модон, Хатавч, Халзан, Их булаг, Бөөр, Өгөөмөр, Будар, Ширээт зэргийг хэлж байна. Эдгээрийн дотроос хамгийн том нь Алтан овооны хийд гол төв нь болж байжээ. Энэ хийдийн бурхад нь Дарь овоог тойрсон уул усны нэртэй байсан тухай энэ нутгийн алдарт ламтан агсан Инлай Лувсандагва гуай ярьдаг байсан билээ.

Алтан овооны Батцагаан суварганы өмнө талд лам хуврагууд сууж тахилга, уншлага үйлдэх үест нутгийн сайн хуурч нар Алтан овооны магтаалыг аялгуулан хуурдаж хурсан олныг цэнгээн баясгадаг байжээ. “Богд л Дарь овоо минь, Дарь Чойжин овоо минь” гэсэн давталтаар Алтан овоондоо хандан өгүүлсэн байдлаар зохиогдсон энэ магтаал Дарьганга марзайд ч тусгалаа олжээ. Тэнд:

Ум марзай мамий суухаа
Алтан Дарь овоо минь өршөө
Зууртаа сайн яваарай
Зуугийн Чойжин өршөө
Дандаа сайн яваарай
Далай лам нь өршөө
Аяндаа мэнд яваарай
Алтан Дарь овоо минь өршөө
Ум марзай мамий суухаа гэж байдаг.

Дарьганга нутгийнхан өглөө бүр цай сүүний дээжээ өргөхдөө “Алтан овоо минь өршөө” гэж сүслэн залбирдаг нь хэвшсэн заншил болно. Ийнхүү Алтан овоо өтгөс нялхасын амны уншлага болсон нь Жанрайсигийн зүрхэн тарнитай утга дүйх юм.

Энэ уулын сан, сэржим хийгээд магтаалыг бас эгэл жирийн ард олны сэтгэлдээ залсан Алтан овоо, Дарьганга нутгаа эрхэмлэн хайрлаж, шүтэн биширч ирсэн сэрэхүй, мэдрэхүйн нь онгод хийморийг бадраасан яруу дуулал гэлтэй.

Алтан овооны магтаал сан сэржимд энэ уулын орчин тойрны шинж төлөв, өвөрмөц онцлог, өвс билгээр, ан амьтан, савдаг навдаг гоо үзэмж зэргийн тухай жирийн нэг тоочсонгүй тал бүрээс нь нарийн ажиглаж судалж, уран сэтгэлгээний аргаар яруу сайхан дүрсэлсэн тул хүмүүсийн байгаль орчноо танин мэдэхэд чухал ач холбогдолтой туурвил гэдгийг эцэст тэмдэглэе.

ALTAN-OVOO OF DARIGANGA

Information on the sutra:

The front cover of the manuscript is adorned with a vivid painting of the deity that is believed to be the guardian deity of this ovoo, a man-made sacred mountain or rocks and stones.

The Altan Ovoo is found on the northern edge of the Moltsog sand dunes in Dariganga soum, Sukhbaatar Province and is located near a dormant volcano. The ovoo has a golden-topped stupa, explaining why the Altan Ovoo is sometimes known as the Golden Mound.

Women were traditionally not allowed to climb the sacred mountain on which hunting was prohibited. Large crowds of up to 70 000 people were involved in the annual gatherings and celebrations around the ovoo.

The tradition was revived in the 1990's after the celebration was prohibited from the 1920's.

| | 1. 2. 3. 4. 5. 6. 7. 8. 9. 10. 11. 12. 13. 14. 15. 16. 17. 18. 19. 20. 21. 22. 23. 24. 25. 26. 27. 28. 29. 30. 31. 32. 33. 34. 35. 36. 37. 38. 39. 40. 41. 42. 43. 44. 45. 46. 47. 48. 49. 50. 51. 52. 53. 54. 55. 56. 57. 58. 59. 60. 61. 62. 63. 64. 65. 66. 67. 68. 69. 70. 71. 72. 73. 74. 75. 76. 77. 78. 79. 80. 81. 82. 83. 84. 85. 86. 87. 88. 89. 90. 91. 92. 93. 94. 95. 96. 97. 98. 99. 100.

| | 1. 2. 3. 4. 5. 6. 7. 8. 9. 10. 11. 12. 13. 14. 15. 16. 17. 18. 19. 20. 21. 22. 23. 24. 25. 26. 27. 28. 29. 30. 31. 32. 33. 34. 35. 36. 37. 38. 39. 40. 41. 42. 43. 44. 45. 46. 47. 48. 49. 50. 51. 52. 53. 54. 55. 56. 57. 58. 59. 60. 61. 62. 63. 64. 65. 66. 67. 68. 69. 70. 71. 72. 73. 74. 75. 76. 77. 78. 79. 80. 81. 82. 83. 84. 85. 86. 87. 88. 89. 90. 91. 92. 93. 94. 95. 96. 97. 98. 99. 100.

| | 1. 2. 3. 4. 5. 6. 7. 8. 9. 10. 11. 12. 13. 14. 15. 16. 17. 18. 19. 20. 21. 22. 23. 24. 25. 26. 27. 28. 29. 30. 31. 32. 33. 34. 35. 36. 37. 38. 39. 40. 41. 42. 43. 44. 45. 46. 47. 48. 49. 50. 51. 52. 53. 54. 55. 56. 57. 58. 59. 60. 61. 62. 63. 64. 65. 66. 67. 68. 69. 70. 71. 72. 73. 74. 75. 76. 77. 78. 79. 80. 81. 82. 83. 84. 85. 86. 87. 88. 89. 90. 91. 92. 93. 94. 95. 96. 97. 98. 99. 100.

| | 1. 2. 3. 4. 5. 6. 7. 8. 9. 10. 11. 12. 13. 14. 15. 16. 17. 18. 19. 20. 21. 22. 23. 24. 25. 26. 27. 28. 29. 30. 31. 32. 33. 34. 35. 36. 37. 38. 39. 40. 41. 42. 43. 44. 45. 46. 47. 48. 49. 50. 51. 52. 53. 54. 55. 56. 57. 58. 59. 60. 61. 62. 63. 64. 65. 66. 67. 68. 69. 70. 71. 72. 73. 74. 75. 76. 77. 78. 79. 80. 81. 82. 83. 84. 85. 86. 87. 88. 89. 90. 91. 92. 93. 94. 95. 96. 97. 98. 99. 100.

| | 1. 2. 3. 4. 5. 6. 7. 8. 9. 10. 11. 12. 13. 14. 15. 16. 17. 18. 19. 20. 21. 22. 23. 24. 25. 26. 27. 28. 29. 30. 31. 32. 33. 34. 35. 36. 37. 38. 39. 40. 41. 42. 43. 44. 45. 46. 47. 48. 49. 50. 51. 52. 53. 54. 55. 56. 57. 58. 59. 60. 61. 62. 63. 64. 65. 66. 67. 68. 69. 70. 71. 72. 73. 74. 75. 76. 77. 78. 79. 80. 81. 82. 83. 84. 85. 86. 87. 88. 89. 90. 91. 92. 93. 94. 95. 96. 97. 98. 99. 100.

| | 1. 2. 3. 4. 5. 6. 7. 8. 9. 10. 11. 12. 13. 14. 15. 16. 17. 18. 19. 20. 21. 22. 23. 24. 25. 26. 27. 28. 29. 30. 31. 32. 33. 34. 35. 36. 37. 38. 39. 40. 41. 42. 43. 44. 45. 46. 47. 48. 49. 50. 51. 52. 53. 54. 55. 56. 57. 58. 59. 60. 61. 62. 63. 64. 65. 66. 67. 68. 69. 70. 71. 72. 73. 74. 75. 76. 77. 78. 79. 80. 81. 82. 83. 84. 85. 86. 87. 88. 89. 90. 91. 92. 93. 94. 95. 96. 97. 98. 99. 100.

| | ... |

| | ... |

| | ... |

| | ... |

| | ... |

| | ... |





Энэхүү газрыг баригч Дарь уул хийгээд Ланга мөрөн хэмээн алдаршсан орны эзэн, буюны садан, нөхөр сэлтэд тахил багин, өргөхийг хүссэн бодогчид-бээр энэ сон дор чухал хэрэгтэй явдал, тахил багин, тангарагийн эд мэлмийгээр болоогч тэргүүтнийг үзэхүй шийн гарын авлагачлан бэлтгэж адистигдлаад зургаан ус сэт гарниин зургаан мутраар адистигдлан өрөн жигдлэгтүүн.

Бодит суурь нь: Үүлсийн тарниар ариугтасан स्वाбхава (араншин)-гаар хоосоо чанарын агаараас урьд зүгт лөхөм сэтгэлд зохистой эм тат хийгээд ой шүтүйт цагаар чимэглэж рүүгээд төрөөс хийгээд элдэв жигдүүртэн пенгэн наагаж бүжиглэхүй-вээр барилдүүлэн сөөн үзүүрт төв агарт тушаалдүүлж, сүр жавхлан, аймшигт дүр урвах дугаа сэлтсийн их газар баригчийн бхрүмээс үүдсэн их эрдэнээс бүтсэн үлгшгүй их харш, сүм хаагч бшүш эрдэнийн дот дугаа сэлтийн дотор сөөн хүсгийн эд алгуур санасанчлан хязгааргүй дүүрээд алгуураар

Намо гурь Баэра бхайра ваа ва.

(Дарьгангын Алтан Овооны тахилгын сувар)

ТАХИЛГА ОРШВОЙ
НАМАНЧЛАЛ, ХУВЬ БҮРДСНИЙ ЗАЛБИРАЛ
НӨХӨР СЭЛТИЙН ИЛТ ОНОЛ, ЗАЛЛАГА, ХАНГАЛ,
ГАЗАР БАРИГЧ ДАРЬАНГА ОРНЫ ЭЗЭН, БУЯНЫ САДАН



явахын ялдамд бөмбөгөр цагаан болор уул адил дээд морь, цагаан үүлэн жигүүртийг тэнгэрийн их эрдэнийн эмээл хазаар тэргүүтэн чимгээр бүтээж дээр нь цагаан болор урт илдний хурц ир нь машид бадраад түүнээс нь гэрэл сацран дайсан тотгод, хортон хамгийг тас хяргаад сэтгэлд санасан үйлс хэрэг бүгдийг эрхшээн хурааж, урт илднээ шингээн огоот болсноос дээд тэнгэр, гурван сансарын эзэн Махаадевагийн лагшингийн өнгө Кайлаасын ууланд нарны буман гэрэл эвцэлдэх мэтээр үзэсгэлэнт гэрлийг машид бадруулсан нэгэн нигуур, хоёр мутартай, баруунаа цагаан болор урт илдийг огторгуйн төвд барьж шашны дайсныг үндсээр нь тасалж, зүүн мутартаа эрдэнийн тэвш таалан барьж шашныг баригч хөвгүүн мэт тэтгээд, есөн зүйлийн хур буулгагч тэргүүндээ Кашига хийгээд торгон, титэм чимгэн, биедээ бурханы хувцас навс хөдөрч, ханцуйтан ямагт залбирч үзэсгэлэнд нь омогшин, хилэн маш бадарсан гурван мэлмийгээр ажаархан шуламсын омгийг хэмхчин таслаад хоёр өлмийдөө ялгуусан цэнгэлдэхийн байдлаар оршоосон авай. Түүний зүүн этгээдэд нь Мамаас гарсан хатан эрдэнийн титэмтэй агаад биеийн өнгө цагаан саруул, нэгэн нигуур, хоёр мутартай, эрдэнийн тэвшийг ихэд дүүргэн барьсан энэ хоёрын эргэн тойронд хөвгүүн, түшмэл, цэрэг цуух, ноёныг татаж, дөрвөн аймаг цэргийн ноён тэргүүтэн, баригч эхийн эх орныг огоот дүүргэн, амирлангуй догшин байдалт дүрээр үл мэдэх барагадсан мэргэн нөхдийн чуулганаар хүрээлүүлж, гол нөхөд бүгдийн оройд нь цагаан Ум, хоолойг нь улаан Аа, сэтгэл зүрхийг нь хөх өнгийн Хум-аар билэгдэж, өөрийн чанарын нигүүлсэхүй хөх ХУМ-аас гэрэл сацруулж, гох хэлбэртэй Будлан уул, Үржинхандын тив. үхээрийн харанхуйн дуун дуурсгагч тэнгэрт оршигч гучин гурван тэнгэр тэргүүтэн хаа оршигч Очирын ордон тус тусаас Дарийн тэнгэрийн их гэлэн, нөхөд сэлт агшин зуурт энэ орноо ажирагтун.

Үнэнхүү гурван цагийн ялгуулсан бүхний айлдал энэрлийн дүрс нь

Үлэмж хязгааргүй амьтны тусыг зохиосны тул

Үзвээс машид дэлгэр мөшилзөхүй нүүртийн дүрт эзэн сэлт

Үзэсгэлэнт Будлан уулнаас өөдлөн залрагтун.

Итгэлт гурван орны баатар дагинасыг хоцроолгүй
Эрхэндээ урвуулж их амгалангийн самади дияаныг сайтар
төгссөн

Илт онол, байдлын ирд хувилгаан зөн билгээр ханасны учир
Ижилгүй оройн чимэг дагинасын тивээс заларч соёрх.
Ирт мэсээр мэлмийг эмнэх хөлийг хурдасгах тэргүүтнийг
Их бүтээлийн найман хувилгааны нөхөр, зай, тарни тэргүүтэн
Хүчин төгс хүч чадлын гайхамшгийг үзүүлдэг учир
Харанхуй дуун дуурсгагч орноос залран соёрх.

Буруу хар зүгийн, тэнгэр бусын орныг машид доройтуулсан
Бурхан багшийн шашны зүрхэн зөөлөн цогт Зонховын
Бүтээл номлол шашныг сахигч эрхин чанарын тулд
Бүхий л гучин гурван тэнгэрийн орноос өөд болон соёрх.
Эрхт, догшин, амарлингуй, дэлгэрэнгүй үйлсийг үзүүлэхийн тулд
Элдэв магадгүй аливааг ч ямарчлан буулгаснаар
Эгнэгт тоолошгүй хувилгааны зохионгуйг бэлгэдсэний тулд
Эдүгээ хаа ч байсан Очирт орноос залран соёрх.

Ум махаа дээва убасига сабари ваара базра самаяа за, за, за,
хум бан хо хоёр- дор үгүй бол.

Ялгуусны шашны сахигч бүхнээс эрхин
Ялгуух егзөр, сүлдэн тэнгэрийн огоот багш
Тэнгэрийн буяны садан, нөхөд сэлтийг
Тэнсэлгүй гурван үүднээс бишрэлээр магъя.

Ум махаа дээва убасига сабари ваара аргхам-аас шабдаа-гийн завсар хүртэл тахь. Дээрх тарнид гурван үр зүүгээд дотоод тахилгыг ч өргө. Өөрийн зүрхний Хум-аас гэрэл сацарч гурван Очирын тэнгэрийн чуулган өмнийн огторгуйд залран соёрх зэргийг мэдэхийн зоригдол лугаа сэлт мутрын тэмдэг (игчаа)-ийг гурвантаа унш.

Аяа!
Очирыг эрхшээлдээ барин агч
Орчлонгийн эрх баялагт тэргүүтэн
Оор язгуур үндэсний ламын
Олны чуулган таалан соёрх!
Олон бүхний дэв түйтгэр
Олж эс мэдсэний харгайгаар болсноор
Онц гурван нууцын тангарагтаа
Огоорч доройтуулсанаа хүлцэн наманчилъя.
Ялангуяа их буяны садан
Янаг нөхөд сэлт тэргүүтэн
Хүсэлт номыг тэтгэн сахигч-бээр
Хүү мэт тэтгэсэнчлэн-дор
Бүтээлийн хангал, наманчлал зэргийг
Бүр ёсчлон эс үйлдээгүйн учирт
Тангарагаас гэтэлсэн гэм бүгдийг эс баримтлан
Тааллын хоосон чанарын агаарт наманчилъя

Хэмээн наманчлал үйлдээд түүнээс хангалгын эд, тахил
балинг адистидлан ерөнхийд нь өгөө гүйцэтгэсүү.

Аяа!
Өөсөөн бүтэхүй туурвилаас хагацсан
Өгүүлэшгүй их амгалангийн харш
Өөгүй асар ариухан агаарт нь
Өөдлөж усан баригч тулцалдан бурханы
Гадаад дотоод хоёр нууцын
Гайхамшигт эд зай, их хураар
Сайн буяны их нөхөр сэлтийг
Сайтар, оройдоо тахин үйлдье.
Найман гишүүнт бурханы тахил эрдэм
Лянхув, гүмдаа зэрэг үзэсгэлэнт цэцгэс
Үнэр сайн, машид бадарсан утлагын хүжис

Гурван савын мунхгийг арилгах зулаар
Тэнгэрийн их буяны садны
Тэргүүн дээд тааллыг хангая
Тэргүүлэшгүй хатан, хүү, түшмэл, цэргийн
Тэргүүн дээд тааллыг хангая.
Алжаал ядралыг сэргээх болоод
Алив шид бүтээлийг үлдээлгүй хайрлая.
Гаврын дусалт ахилуун сүрчиг
Үнэр сайтай усан хийгээд
Гайхамшигт бурхан болон хүмүүний
Идээ зоогийн сүрлэг цогцлол
Тансаг болсон, хамт төрсөн
Энх амгалангийн цогийг өгөгч
Тааламж яруу жавхланг үүсгэх
Энэ хөгжмийн дуун эгшиг сэлтээр
Тэргүүн дээд тааллыг хангая
Идтэй салхины хүчийг баригч
Үлэмжид хувилгаан дээд морин
Их савагт хар сарлагаар
Гурван мянган ертөнцийг дүүргэж
Дөрвөн эвэртэй, хошуу үзэсгэлэнтэй
Дөлгөөн хар хонь хийгээд
Мянган өднийхөө хүчин чадлаар
Мятрашгүй дэвсэн хар шувуу үүгээр
Тэнгэр бурханы буяны садны
Тэргүүн дээд тааллыг хангая.
Омог хүчит, үзэмжит хар үсэн биетэй
Орсон луугийн дуурсах мэт аймшигт хүрхрэгч
Догшин зааны сүрээр дайсны амийг булаах
Доодсыг авардагаараа үл уйдагч тэмээгээр
Тэнгэр бурханы буяны садны
Тэргүүн дээд тааллыг хангая.
Амаа ангайж, шүдээ ярзайлгасан

Аймшигт нохой тэргүүтэн араатан
Аху их долоон эрдэнэ хийгээд
Өлзийт найман тахил, шинжлэхүйн зай
Дөл наран, саран, сүмбэр уул
Дөрвөн тив, өчүүхэн тив тэргүүтэн
Бодитой бэлтгэсэн, сэтгэлээр хувилгасны
Бойлох тахилын үүл үүрээр
Тэнгэр бурхны буяны садны
Тэргүүн дээд тааллыг хангая.
Энгүй цагаан усан баригч
Тэнгэр огторгуйд цойлсон адил
Эрдэнийн чимэгт хөлөг хийгээд
Цагаан лавайт зэндмэнэ эрдэнэ
Эгнэшгүй их улаан балингийн
Торгон манжлага чимгийг хөдөлгөсөн
Эрхэт дотоод, гадаад нууцын
Шүтээн болсон ханьцашгүй үүнээр
Тэнгэр бурхны буяны садны
Тэргүүн дээд тааллыг хангая.
Тэргүүлэшгүй хатан, хүү, түшмэл, цэргийн
Тэргүүн дээд тааллыг хангая.
Тэрхүү нөхөдийн чуулган, тангарагтны далайн
Тэргүүн дээд тааллыг хангая.
Алжаал ядралыг сэргээгч болоод
Алив шид бүтээлийг үлдээлгүй хайрлая.

Хри:

Угаасаа арилсан номын лагшин
Уужим огторгуйн энтэй болсоноор
Элдэв янзын байдал төлөв нь
Эрхтэний нум адил саруул
Олон язгуур бүхнээ түгэн арилсан
Очир баригч ихэс дээдийг

Лавтай ачлал төгс язгуур үндэсний
Лам багшийн чуулган хүрээлснээр
Ядам бурхан тэнгэрийн чуулган
Солонгын өнгө мэт дуртмал болоод
Даамай бодит сэтгэлт хутагт
Сонсоод сонсогч, өөрөө ялагч
Дагинас, номын сахиулсаны чуулган
Үүлэн мэт хуран цогцолсноор
Лус найман аймаг орны
Тэнгэр газрын эзэд сэлт
Тангараг ариухнаар залрах амуй.
Энэрлийн эрхээр ариуссан тахилыг
Энэ орноо залан оршуулъя.
Ялгамжаат орчлон хорвоогоос
Гэтэлсэн сайн буяны
Явдлыг бахимлан тогтооч
Хотол чуулгант уул
Эрхин сүр хүч нь бадарсан
Дарь сүмбэр уул хийгээд
Ээлийн өлзий хишиг тогтсон
Далай ерөөлийн Ганга нуур
Эрхэм түшмэл, харцасын орон
Баяндулаан уул болон
Хонгор, Харангуд, Дуут нуур
Хотол манхан Молцог элс
Баянгол тэргүүтэнд орших
Эзэн тэнгэр, лус савдаг сэлт
Энэхүү ариусгалт тахилын орноо
Эгнэгт залраад адис хүртээ.
Бас бус энэ зүгийн
Ус далай, уул талд оршигч
Лус савдаг, бурхан тэнгэр
Хүмүүн бус гаргалгаатангууд

Цагаан, хар хольцолдсон хийгээд
Улаан явдалт найман аймаг
Зочлон ирэхүйд зохистой энд
Зочирхож хоцролгүй хуран чуулагтун.

Хри:
Авралын орон бүгдийг хураасан
Багш, лам, ядам, бурхан
Асрал, энэрэлт бурхан бодисадва
Братига сахиулсан хийгээд
Тэнгэрлэг Дарь уул тэргүүтэн
Тэнгэр лус зочлохүй аймаг-дор
Бодитой бэлтгэсэн хийгээд бас
Бодол сэтгэлээр хувиргасан тахил өргөх инү:
Айраг, тараг, сүү цагаа
Архи, цай, зэрэг эрдэнэт тахилгыг
Авуурьд сайтар байрлуулж
Ахилуун үнэрт цэцгээр чимсэн
Арц, агь тансаг үнэртний
Анхилга утлагаар огторгуйг дүүргээд
Ариулсан галын гэгээн гэрлээр
Алмид харанхуйг арилган хөөж,
Эмийн найрлага төгөлдөр үнэдийг
Орон бүхнээ түгээн тархааж
Элдэв зуун амт төгс
Тэнгэр, хүмүүний идээн болон
Эгшиглэн сонсголонт яруу эгшиг
Энэ хөгжим, тахилыг өргөн баръя.
Бас бус хүслийн таван эрдэнэ
Байгаа их долоон эрдэнэ
Өлзийт найман тахилын дээдээр
Өгүүлэшгүй сайтар чимсэн
Үзэсгэлэнт морь, үхэр, тэмээ

Үзэхүй зохист хонь, ямаа эдгээрийг
Бүгд зочны чуулгануудыг
Бүрнээ баясгахын үүднээс өргөө.
Ийнхүү баясган таалснаар
Эрдэм, тахил, нөхөд сэлтийн
Есөн хүслийн сайн чуулганыг
Ер аривтган зохиож хайрла.

Хри:
Аливаа хүсэл эрдмийн зүрхэн бүгдийг
Ашид хураасан ариутгал, тахил үүгээр
Язгуур оор, үндэсний лам
Ядам бурхдын чуулганыг ариусгая.
Бурхан хийгээд бодисадва
Братига, шарвага нарыг ариусгая.
Буцалтгүй түргэн зохиогч итгэл
Тангарагт номун хааныг ариусгая.
Бууралтгүй цогт охин тэнгэр
Сайтар олонтаа сонсогчийн хөвгүүнийг ариусгая.

Хураагуйлбаас:
Огторгуйгаар зорчигч эх болон
Номыг тэтгээчин нарыг ариусгая.
Огоот, ариутгал, тахил
Ахуй ихийн дээдээр таалуулсанд
Дээдсийн хийгээд нийтийн
Шид бүтээлийг хоцроолгүй хайрлая.

Хри:
Энэ замбуутивийн газрын эзэн
Ерөнхий ба ялгамжаат чанарт
Эрхин хүчний сүр бадарсан
Дарь сүмбэр уулаа ариусгая.

Өлзий хишгийг тогтоон барьсан
Далай хүслэнгийн Ганга нуураа
Өндрийн дээдэд шадар оршигч
Баяндулаан уулаан ариусгая.
Бас Харан гуд, Хонгорын эзнээ ариусгая.
Ийн ариусгасан болой.
Ийн соёрхсон болой.
Ийн тахисан болой.
Мань мэт нь үйл ажил
Явдал суудалд эс мэргэний тул
Хорлох аливаа юм гарсанд гэмшин
Хортой гэм алдсаа наманчилснаар
Асралт эх нь хүүгээ энхрийлдэгчлэн
Адбиш нигүүлсэнгүйн сэтгэлээр хүлцэн таалаад
Аянд нь орхилгүй насанд сахих ивээлийг зохиоё.
Ийн шүтсэн болой.
Ийн тахисан болой.
Эс алгасан чухлаар таалагтун.
Хижиг өвчин, ад дон
Хулгай дээрэм, тотгор хийгээд
Хяруу мөндөр, ган зуд
Хуй салхи шуурга тэргүүтэн
Хямрал тэмцэл, ойрын хорлолыг
Хуу цөмийг амирлуулан зохио.
Нас, буян, цог учрал
Нэр алдар зэрэг дэлгэрээд
Насад гурван савын сайн чуулган
Вашам багшид залбирч мөргөө
Орших суух сэтгэлийг барьсан
Хүмүүн ба хүмүүн бус бүхэн
Онц илт явдлын хатуу шинжийн
Билэг тэмдгийг түргэнээ үзүүл
Ялангуяа этүгэн эхийн

Энэ орноо эрхэнд урвуулсан
Их догшин сүргийн манлай
Махи үхэр сайтар оршиж
Хотол чуулган буяны билгийг
Хадгалсан газрын энэ зүгт
Дэлхийн эзэн, тэнгэр лус
Дээд сахиулсны чуулгануудад
Эргэлтгүй сэтгэлээр залбирсан болой.
Эргэлтгүй сэтгэлээр тахисан болой.
Эргэлтгүй сэтгэлээр ариусгасан болой.
Эс алгасан чухлаар таалагтун.
Эгүүнээр хүн, малын ойрын хөнөөлийн
Элдэв өвчин, хижиг, гарз, алдлага
Эрсдэл сүйрэл бүхнийг амирлуулаад
Хотол чуулганы цог учрал
Хоромхноо зуны саран мэт дэлгэрснээр
Хосгүй сайн чуулган бүхэн
Ховор сэтгэлчлэнгийн зэндмэнэ мэт болоод
Есөн хүслийн тус бүхэн
Өөсөөн аяндаа бүтэн бүрдээд
Ер замбуулан даяар түгсэн
Өлзий хишгийн буяныг хайрла.
Шашин хийгээд шашныг баригч
Амьтны найман аймаг хотлоорыг
Шахцах их усны сан далайн
Адбиш цог тэнсэхүй-дор зохио.

Хураангуйлбаас
Өнөөдрөөс авахуулаад бурхан бодийг
Эгээрч эс олсныг хүртэл
Өдгөө гадаад дотоодын харшлах шалтгаан
Энэ бүхнийг арилгаад
Шашин дээдийн номыг сайтар бүтээхийн

Зохилдох шалтгаан болгоныг
Шамдлагагүйгээр өөсөөн бүтэхийг соёрх.

Доор дурдсан мэт балинг өргөөд энэ завсарт сэржим өргөн сануулан
үйлдэх нь:

Аяа,
Хамаг чуулган хүслийн таван эрдэнэтийн
Хавархалт алтан ундааны тахил үүнийг
Хагацашгүй лам, ядам чухаг гурав
Хандаа, чойжин хамаг бүгдэд хийгээд
Хамгаас алдартай манай Дарьганга нутгийн
Хан тэнгэр лус найман аймагт өргөө.
Алтан ундааны тахил үүнийг өргөснөөр
Ахуй энэ орны хүн, хүмүүн бус бүгд
Аюулгагч ган зуд, хяруу мөндөр
Аливаа ад хижиг, ам хэлд өртөх
Үл зохилдох зүгийн бүхнийг
Үй нийтэд нь амуусгаснаар
Урин цагийн хур цагтаа бууж
Ургамал, мод тэргүүтэн дэлгэрч
Ариун буян, нас, цог учрал
Амны хишиг арвижаад
Аль санасан хэрэг зорил
Аяндаа өөрөө бүтэхийг соёрх.
Анд нөхөр, багш сэлтээс аваад
Аанай бүтээх болтугай.

Аяа,
Энэрэнгүй агаад асар хилэнт байдлаар
Этгээд дайсан тотгодоос гэтэлгэх хүчин чадалтан
Их буяны өмөг бүхний эрхин биеийг өөдрөг болгоод
Эрхт шашны дайсан бүхнээс өөдөө гэтэлгэгтүн.

Тэндээс урин үйлдэх нь: Их буяны садан нигүүлсэхүйн нарны хот
мандлын дээр урт жад Хум үсгээр бэлгийн хязгаар тарнийн эрхисээр
хүрээлүүлэгчээс гэрэл сацарсанаар хамаг дайсан, тотгор, хортоньг
дуусган тасалж гурван ертөнцийн хүмүүн, эд идээн тэргүүтэн бүгдийг
эрхэндээн хурааж, хамаг хүссэнийг хур мэтчлэн буулгахыг сэтгэж Ум
махаа дэва убасига сарва сиддхи за: хэмээн алтдаа олон уриад энэ
үест буян хишиг хураахыг зорин үйлдээд тэр мэт өөрийн хүчээр хишиг
даллах тэргүүтэн сайтар үйлдэхээс бус хэрэгцээ үгүйг энд эс бичвэй.
Тэндээс гол мэт адислаад их буяны садан нөхөд сэлтсийн хэлний
гэрлийн соролтоор хамаг балингийн шимийг татан соёрх.

Ум махаа дэва убасига сабари вара идам балимта ха ха, хаа хи,
хаа хи хэмээн гурван тэргүүтнийг өргөж гадаад дотоод тахил өргөөд
Хум: их буяны нөхөд сэлтэст хэмээхээс Маа ра яа пад хэмээхийн
завсрын балин сацал үйлдээд, шивдагт, дором уншаад магтаал үйлдэх
нь:

Аяа,
Үлэмж хэтэрхий ялгуугчийн
Үзэл баримтлалгүй энэрэгчид
Үнэнхүү ертөнцийн эрх баялаг
Үйл билэгдлийг өгөн соёрхогч
Эрхт, догшин, амирлангуй дэлгэрэнгүй
Энэ дөрвөн үйлс өөрийн дүрээр
Эрхээр эрхшээгч их буяны садныг
Эндэлгүйгээр эгүүрд магтмуу.
Мутар баруунаа цагаан жад далайж
Туу дайсны амин голыг таслагч
Мутар зүүнээ эрдэнэ атгаснаар
Муугүй хүслийг хангагч сан бологч
Гурван мянган ертөнцийг хэрэхийн тулд
Онгон цагаан морь хөлөглөгч
Сэрэн дэлгэрэн бурхан төгссөн
Сэтгэшгүй сахиулсан таныг магтмуу.

Дээд төгс бүтээлчийг даган төрж
Дэмий мунхгийг арилгах догшин үйлсээр
Шашны дайсныг сөнөөхийг хэзээ ч үл алгасагч
Шашны амин их баатар таныг тагтмуу.
Эрхин гурван цагийн ялгуугчийг хоцролгүй төрүүлэгч эх
Элдэв хувилгааны сайрхан өгүүлэх хязгаарлалгүйгээр
Махадевад цуврилгүй амагланг зохиогч
Манлай хатан эрдэнийн титэмт таныг магтмуу.
Заримууд номын олон хувилгаанаар
Заналт дайсан тотгорыг номхотго.
Заримууд дээд төгс хөвгүүн мэт
Залбиран энэрч тэтгэн зохио.
Огоот зарим тотгор саад хийгээд
Оршилгүй буйд газрыг үгүйсгэн зохиогч
Олон зүйл нөхөд чуулганыг
Оломгүй далай мэт магтан үйлдмүй.

Тэндээс эрхшээлийг үзүүлэх нь:
Аливаа сайн чуулган бүхэн
Аяндаа гарахуй орон ачит богд
Ариун буяны садан танаас
Анги бусад нь эс байснаар
Язгуур үндэсний ламын чанартанд
Ямарваа эрхшээл үзүүлэн үйлдмүй.
Ялгуух адистидын рашаан хангах
Ялгуум баяслыг үзүүлэн соёрх.
Ийнхүү дурдсан төдийгөөр
Их амгалангийн билгэ билгийн
Хоосон чанараар баясган
Хотлыг цэнгэлдүүлэн соёрх.
Авах гээх, тэвчих авах
Адил зэргэмжийг тодруулан үзүүлээд
Аливаа үгүйсгэлийн мөрийг илтэд болгон

Ашид нөхцөлдүүлэн зохиохын тулд
Хуурмаггүй чухаг дээд гуравт
Хувришгүй эрхшээл үзүүлэн үйлд
Сансар орчлонгийн хамаг аюумшгаас
Салгаж авран зохиож хайрла.
Гадаад, дотоод нууц тотгор хийгээд
Хамаг муу гай барцадыг
Гайхамшигт олон мэргэн аргаар
Халсалгүй ариутган зохиохын тулд
Номыг тэтгэн сахигч эхийн
Нотод чанарыг эрхшээн үзүүлж үйлд.
Дөрвөн үйлсийг хөвгүүн мэт энэрч
Дөлгөөн та нь сэтгэлдээ дурдахын төдийгөөр ч
Харшлах хамаг нөхцөлийг амирлуулан
Харин зохилдохуй нөхцөл бүгдийг бүтээхийн тулд
Өнид итгэл, аврал сахиулсанд
Өршөөлт эрхшээл үзүүлэн үйлд
Бодь мөрт хагацал үгүй болгож
Болгоож сахин аварч зохио.

Богд ламаас болтугай. Тэндээс игчаа үлэмж, аман хангалыг
соёрхогч хүлцэнгүй залбирал, зорих ерөөлөөр эцэст
чимүүлсний даруйд бат оршуулан залан соёрхох үест
бүрдүүлэн үйлдээд өлзий өгүүлэх нь:

Аяа,
Адистидын рашаан хувьт номхотголын үндэс
Аль буй хумхыг огоот дүүргэн зохиогоод
Онол бясалгалын сайн үргэлжлэлийг дэлгэрүүлэх
Олон цорж, цорж ламын өлзий хутаг орш.
Алимад нэгэн сэтгэлийн төдий дурдснаар ч
Аяндаа зул мэт гийгүүлэн бүхнийг зохиогоод
Ялгуугч дээд лугаа зохилдох шидийг соёрхогч

Ядам, бурхан чуулгануудыг өлзий хутаг орш.
Боловсруулан гэтэлгэхүйн сайн мөрийг
Бодитой үзүүлэх бурхан
Сансар нирвааны аюумшигт үйлсээс
Сайтар гэтэлгэн аврал өргөөд
Авирд үлэмж сайн буяны
Ачит дээд хэмжээлшгүй
Хуурмаггүй чухаг дээд гурвын
Хутаг өлзий орших болтугай.
Урин дайсан, хорлол тотгор тэргүүтэн
Улмаар барцад, адыг үнсэн товрог болгогч
Хүчин төгс дүрвэлгүй өвөрмөц чанарт
Дээд тэнгэр их гэлэнгийн өлзий хутаг орш.
Дэврүү хилэнтийн байдлаас болох хоосныг үйлдэх
Дээд хорт номхотгогдхуун бодь бүтээлийн аргаар
Хичээлгүй өөрөө бүтэхийн чанартан
Хэвцэг нөхдийн чуулган далайн өлзий хутаг орш.

Бад хийгээд залба-гаас шог хэмээн өгүүлж өлзий өгүүлснээр эцсийн чимэг болгон үйлдэх болой хэмээх Дарьгангын орны (навдагийн) эзний ил онол, заллага, хангал, наманчлал, дурдал, сорилго, балин, сацал, магтаал, эрхшээл, соёрхол, өлзий өгүүлэхүй сэлтсийг хувь бүрэлдүүлэх энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн Эрдэнэ мэргэн хутагтын хувилгаан бие Лувсанжигмиддорж хоёул дурдагдсанд Шагжийн гэлэн Лувсанбалдандамбийнямчоглайнамжилбалсанбо-бээр найруулбай.

**АРЦ БОГД УУЛНАА АРИУСГАЛ, ТАХИЛ ӨРГӨХҮЙ
ЁСОН ХҮССЭН ХЭРЭГ ӨӨРӨӨН БҮТЭХҮЙ
ХЭМЭЭГДЭХ ОРШВОЙ**




Арц Богд уул нь Говь-Алтайн нурууны захын том уулын нэг бөгөөд түүний оргил нь 2447 м өндөр Ихбаян уул гэж газарзүйч эрдэмтэн Ш.Шагдар багш тодорхойлжээ. Арц Богдын зүүн үзүүрт чулуун зэвсгийн үеийн багаж зэвсэг үйлдэж байсны ул мөр байдаг. Монголчууд арцыг ариун ургамал гэж үздэг бөгөөд энэ уулын гүн хавцлаар энэ ургамал ургадаг тул ийнхүү нэр өгсөн ажээ.

ARTS BOGD MOUNTAIN

Information on the area:

The Mountain is situated at the edge of the Gobi Altai range, its highest peak reaching 2,477 m.

The mountain is named after the Juniper trees covering its slopes. The trees called 'arts' in Mongolian, are considered sacred.



**АРЦ БОГД УУЛНАА АРИУСГАЛ, ТАХИЛ ӨРГӨХҮЙ
ЁСОН ХҮССЭН ХЭРЭГ ӨӨРӨӨН БҮТЭХҮЙ
ХЭМЭЭГДЭХ ОРШВОЙ**

Өлзий хишиг тогтсон эрдэнийн дээд орноос
Өгөөмөр энэ орон хийгээд эрхтний орны их тэнгэр
Эх, хүү, гадаад, дотоод, түшмэл, үйлчин хийгээд
Эрхэт Найман аймаг, шивдагийн нөхөд энэ орноо залрагтун.
Өмнийн огторгуйд татсан солонгын дунд
Өөр өөрийн дүр ёсоор оршин саатаж соёрх.
Самади тарни, мутрын тэмдгээр адистидласан
Сайн цуврилгүй рашааны тахил, балин, жансиг
Санашгүй тансаг гадаад, дотоод нууцын зохилдох эд зай
Сац онцолбоос элдэв модны үүлэн утаан сан тахил үүнийг
Энэхүү орон газарт заларсан тэнгэрсийн чуулган
Эрхэт найман аймаг, омогт нөхөд сэлтэд өргөө.
Ялангуяа Арц Богд хэмээгдэх уул хайрханаа
Яг оршсон тэнгэр, лус, шивдаг, орны тэнгэрсүүдэд өргөө.

Бурханы шашин өргөжин дэлгэрэхийн сацуу
Түүнийг баригч дээд төрөлхтөний нас сүүдэр уртсаад
Түүнээ оршсон шар, хар нийт хүмүүн
Мал сүрэг тэргүүтний өвчин хижиг, ад тотгорын
Аюулт хөнөөл бүхнийг сайтар амирлуулах хийгээд
Аливаа зохилдох нөхцөл бүхнийг сэтгэлчлэн бүтээж хайрла.
Харин тэдгээрт оршсон хүмүүн хийгээд хүмүүн бус бүхэн
Харилцан сэтгэл зохилдсоны шүтэн барилдлагаар оршигтун.
Хур усан цугтаа бууж үр тариа арвижаад
Хурднаа санасан хэрэг нь сэтгэлчлэн бүтэхийн эрхин үйлсийг
зохио.

Асар ялангуяа умар зүгийн халхын орон энд
Арц Богд хэмээх алдар цолыг нөмөрсөн
Энэхүү ууланд оршсон тэнгэр, лус үлэмж их хүчтнүүдийн

Эгээрч санасан хэрэг сэтгэлчлэн бүтэхийн эрхин үйлсийг зохио.
Эндэх орон газарт хүн малын хижиг өвчин эцэслэж
Эсэргүү дайсны аюул, хулгай дээрэм, чонын хор хөнөөл хийгээд
Эрдэнэт мал сүргийн гарз, ган гачиг, хорхой шавьж, хэрүүл
уруул
Эгээрч үл хүсэхүй бэрх хөнөөлийг хоцроолгүй амуусгаж
хайрла.

Сүлд хийморь доройтон, буурахын гэм бүхнийг
Сүр хүчний өмгөөр түргэн зуур арилган үйлдээд
Арслан, бар, хангарди, луу, эрдэм төгс ажнай хөлөг
Амь, бие, хувь тавилан, хийморь сүлдийг дэгжээ
Сүлд хийморь ийн дэгжсэний шүтэн барилдлагаар
Шашин төр элдэвлэн аян замд одохуйг зохиож хайрла.
Үл зохилдох бүхнийг амирлуулан, бие сэтгэлийг баясгаснаар
Үнэнхүү жаргалан түгээд санасан хэргийг бүтээх болтугай.
Хур усан тэгширч, өвс ургамал, үр тариа дэлгэрч
Сүү цагаан идээний шим далай мэт уйлгалаад
Мал сүрэг амгалангаар үржин арвидахын ам дэлгэрч
Сав шмалим ертөнц дуртмал өнгөтэй, элбэг дэлбэг болж
амгаланг эдлэх болтугай.

Сац бас хотол чуулганы цогоор илтэд сүрийг хайрла. Зочдууд
өөр өөрийн хэмээх тэргүүтнээр залран соёрх. Өлзий бүхний... хэмээх
тэргүүтнээр өлзий өгүүлэн үйлдсүгэй.... хэмээсэн үүнийг Эрдэнэ
мэргэн ноён хутагт ламын тааллыг хангахын тул зальхай явдалт өтөл
тойн равжамба Лувсанчойнпил-бээр найруулсны бичээч нь гэлэн
Лувсанчимэд болой. Өлзий хутгийн сайн буян арвидаг.

БАГА ГАЗРЫН ЧУЛУУ

Бага газрын чулуу нь Дундговь аймгийн нутагт Монголын дорнод талд /з.у. 106°. х.ө 46°,10' орших багавтархан уул. Адаацаг сумын нутагт буй. Хамгийн өндөр цэг нь 1751 м. Энд гарч буй Дэлгэрцогт нь түүнээс холгүй орших нэг жижигхэн уулын нэр. Энэ судрыг Монголын их бандида Зава Дамдины /1867-1937/ төвд хэлээр буй сүмбумаас авч орчуулав.

Дайчин бэйсийн хошууны гол хийд болох 320 гаруй лам хуврагтай байсан Дэлгэрийн Чойрт амьдралынхаа сүүлийн хорин жилийг өнгөрүүлсэн Зава Дамдин нь судар номынхоо төгсгөлд өөрийн нэрээ Лувсандаян /Сайн оюут морин дуун/, Жамъянжейвийшэйнин /Манзширийг баясгах буяны садан/ гэхчлэнгээр бичсэн байдаг.

Монголын их гүн ухаантан түүхч, Судар бичгийн хүрээлэнгийн анхны гишүүн, Зава Дамдин гавж Утайд очиж, Маньбадарын агуйд мөргөөд тэр агуйн тухай зохиол бичжээ. Эргэж ирснийхээ дараа Зава Дамдин хол ойрын олон хийдэд урилгаар очиж лүн, ван, жинан тавих, нутгийн уул усыг аргадаж, лус савдгийг номхотгох зэрэгт бие сэтгэлийн алжаалыг умартан зүтгэж нутгийн тахилгат 16 уулын сан, тахилгын судрыг зохиосон нь сүмбумд нь бүгд бий.

Зава Дамдин нь нэрт түүхч байсан бөгөөд “Хорчойнжун”, “Алтан дэвтэр” зэрэг түүхийн зохиол бичжээ. Энэхүү сангийн судрын төгсгөлийн хэсэгт энэтхэг, монгол болоод ордосын шашин соёл, түүхэн үйл явдалтай холбоотой сонин мэдээ занги гарч байна. Бага газрын чулуу нь Өндөр гэгээний үйл амьдралтай холбоотойг тэмдэглэх хэрэгтэй. Учир нь Халх, Өөлдийн самууны үед Өндөр гэгээний ар гэр. ах дүүс, хүрээ хийд нь Бага газрын чулууны орчим нүүдэллэн суурьшиж байсан билээ.

Энэ судрыг хувилгаан цорж лам Данзандоржийн отгийн Гаалайням хиагийн хүсэлтээр Маань хадны хоргонд байхдаа айлдсан тухай төгсгөлийн үгэнд гарч байна. Маань хадны хорго /хонгил/ Дэлгэрийн Чойрт буй.

Энэ судрыг зохиохдоо Гирди /Дагва/ ринбүүчийн урьд өмнө зохиосон тахилгын судрыг бага зэрэг өөрчлөн туурвисан байх ба бичээч нь Лусын хувилгаан лам Пагважавын /1870-1938/ үед байсан сойвон Ишжамц ажээ.

Уг сан нь Зава ламын сүмбумын эргүүлгэн НА ботид байгаа бөгөөд энэ эх Гандантэгчинлин хийдийн Гунгаачойлин дацанд хадгалагдаж байгаа төдийгүй Энэтхэгт бас хэвлэгдсэн нь Улсын төв номын санд бий.

BAGA GAZRYN CHULUU OR THE ROCK OF THE TEENY LAND

Information on the sutra:

This copy is a revised and rewritten version of a manuscript originally written by Girdi Rinbuuchi. The original manuscript is kept at Gungaachoinlin Monastery of Gandan Temple. Another copy, printed in India, is kept in the National Library of Mongolia in Ulaanbaatar.

The Baga Gazryn Chuluu mountain is situated on the eastern steppes of Mongolia in Adaatsag soum, Dornod Province. The highest peak reaches 1,751 m. The Baga Gazryn Chuluu site is closely related to Zanabazar, the first Bogd of Mongolia. During the conflicts between the Khalkh from Central Mongolia and the Oold people from Western Mongolia, Zanabazar temporarily settled at the foot of the sacred mountain.

۱۰۰
 مکتوباتی که در این کتاب است
 در این کتاب است که در این کتاب
 در این کتاب است که در این کتاب
 در این کتاب است که در این کتاب
 در این کتاب است که در این کتاب

مکتوباتی که در این کتاب است
 در این کتاب است که در این کتاب
 در این کتاب است که در این کتاب
 در این کتاب است که در این کتاب
 در این کتاب است که در این کتاب

۱۰۰
 مکتوباتی که در این کتاب است
 در این کتاب است که در این کتاب
 در این کتاب است که در این کتاب
 در این کتاب است که در این کتاب
 در این کتاب است که در این کتاب



مکتوباتی که در این کتاب است
 در این کتاب است که در این کتاب
 در این کتاب است که در این کتاب
 در این کتاب است که در این کتاب
 در این کتاب است که در این کتاب

۱۰۰
 مکتوباتی که در این کتاب است
 در این کتاب است که در این کتاب
 در این کتاب است که در این کتاب
 در این کتاب است که در این کتاب
 در این کتاب است که در این کتاب

مکتوباتی که در این کتاب است
 در این کتاب است که در این کتاب
 در این کتاب است که در این کتاب
 در این کتاب است که در این کتاب
 در این کتاب است که در این کتاب

Намо гурь Хаянхярваа,
Хөрлошгүй лам чухал дээд гурван эрдэнэ
Хорвоогоос нөгчсөн тэнгэрийн сахиусыг тахимуй.
Хотол дээдийн нууц зарлигийг анхааран авч
Хосгүй энэ ширээг өдгөө залран соёрх.
Эрдэнэ дор тэргүүтэн эдийн ариун савд

ВАГА ГАРЫН ЧУЛУУ ХЭМЭЭН АЛДАРШАН УУЛ
ХАДНЫ ЭЗЭНД ЗАЛБИРАЛ, ТАХИЛ ҮЙЛДЭХ ЁСОН,
ОМОГТНЫЛ БАВСТАХ ЦЭНГЭЛИЙН НААДАМ ХЭМЭЭХ
ОПШВОЙ



Эрдэнэт гурван цагаан, гурван амтат үр, гурим
Эгэл бөөрөнхий балин, лянхувын найман навч
Эрхий хурууны эгүүнд суудаар бөөрөнхийлсэн үрэл
Элдэв махаар гурван өнцгийг чимсэн улаан балин
Эгс хийгээд бас бус жимс тэргүүтэн
Идээ сэржим архи пайныч дээж
Эрдэнийн хувт, дуулгыг өргөн барья.

Эм хуж, элдэв эмийн ариутгал утаа сэлт
Эн чухал хэрэг болох хөгжим тэргүүтэн

Эд агуурсыг энд бүрнээ бэлтгэсүү.

Эртний тангарагт номлол бясалгалын йогоор
Эрхн авралыг сэтгэн цаглашгүй дөрвийг болон

Мдамьн дагжид ламын налжирьт бясалгаж

Матг давтан үншиж балин өргөмүү.

Арвис тарни, тахилын зай сэлтээр ариусгаад

Ариун номын агар би-бээр шүтэн барилдахуйн илбийн бүжит

Адист тахилын орон чүүлэнхүүд баясал үүсгээд

Тагаад, догоод эл өгөл үндийн хантагыг хэмжээлшгүйгээр

Ласлангүй гурван мянга нао тогортуйн нэ бүххээ дүүргэмүй.

Ум сарва бид буураа тэргүүтэн огторгуйн сангийн тарнийг
Гурвантаа болон Ум архам аа хум-аас сарша аа, хум хүртэл зургаан
тарни мутрын тэмдэг зургаан үнэнийн хүчин сэлтээр адистилгалтун

Ум -

Аливаа чанадсын дайсныг эцэлгэн зохио.
Эсруа Хормуста, Нанди, Гарди, Бирураза, Махаадева
Бишнү, Бирингиради, Гардигара тэргүүтэн
Эрхэт гучин гуравны тэнгэрийн чуулган, Манахан
Тэнгэр нөхөр лүгээ сэлт-нугуд-дор
Эрхэм сүүний рашааны далайгаар долоон ес тахимуй.

Эрхин өндөр язгуур хийгээд
Эрх баялагийн цог жавхланг бадруулан зохио.
Тухайлан Тиштарата, бирудаги, Бирувагша, Бисармана
тэргүүтэн

Тус тусын нөхөр лүгээ сэлт-дор
Тунамал сүүний рашааны далайгаар долоон ес тахимуй
Тунгаан таалаад харшлахуйн нөхцөл бүхнийг амирлуулан
Чанартай дотоодын сайн чуулганыг гадагш замхаруулал үгүй
Чанартай гадаадын эсэргүүцэн тэрслэгч дайсан тотгор
тэргүүтэн

Чивэлт буруу муу санаатныг
Чинагш эцэлгэн няцааж, сахин тэтгэн зохио
Бус бас байлдаанаас хагацсан төгс баясгалант хувилгаан-дор
баясгагч

Бусдыг хувилгааны эрхээр болгоогч
Дүрст хийгээд дүрс үгүй ба
Дөрвөн даяаны тэнгэр тэргүүтэн
Булт тэнгэрсийн чуулган нөхөр лүгээ сэлт нугуд-дор
Цагаан сүүний рашааны далайгаар долоон ес тахимуй.
Цаг насаа таалаад,
Цагаан зүгийн үйлс-дор баясалцан нөхөрлөн тэтгэж
Цаглашгүй амар жаргалангийн сүр хүчнийг зохио.
Эгнэгт дөрвөн тив-дор

Эрхшээсэн Жагарвардийн хаан ер хийгээд
Эрхин ялангуяа сод богд Чингис хаан ба
Эзэн Манзушири хааны үе зэрэг дараалан
Эртний их сахиулсан Гэсэр хаан ба
Эрхэт сүлд тэнгэр тэргүүтэн дор
Эрхин сүүний рашааны далайгаар долоон ес тахимуй
Эрхлэн зооглоод, элдэв харшлахуйн нөхцөл бүхнийг
амирлуулан

Эрхшээсэн шашин төрийн
Эрхэм ёс журмыг бататгаад

Эгэл самуун дайсан хорыг устган
Эрх хүчин цог залиг оргиулан зохио.
Нагараза, Варуна тэргүүлэн Ананда, Васуга
Дагишиг, Гаргода, Бадма, Махабадма
Найруулсан сүүний рашааны далайгаар таван ес тахимуй.
Эрхлэн зооглоод хад, мод, шороо, ус зэргийг хөндөж огтолсон,
Эрж малтсан тэргүүтнээс шалтгаалсан
Эгнэгт тус тусын өвчин зовлонгоос гэтэлгээд
Асрах нигүүлсэхүй сэтгэлээр
Амьтны хорлол хөнөөлийг устгаж
Алтан дэлхийн үр шимийг
Алин сайнаар дэлгэрүүлэн зохио.
Насад зүгийг тэтгэгч арван эрхтэн хийгээд
Найман аймаг ба Сүрияа, Зандар, Раху тэргүүтэн есөн их гариг
Нармай дээд Хэртиг тэргүүтэн хорин найман од ба
Нагчадарын чуулган ерэн ес, есөн мэнгэ
Найман хүлил, таван махбод, жил сар, өдөр шөнө, цаг мөч
тэргүүтнээ
Насад эзлэгч нөхөр лүгээ сэлт бүхэн-дор
Найруулсан сүүний рашааны далайгаар таван ес тахимуй.
Нийтээр зооглоод харшлахуйн нөхцөл бүхнийг амирлуулан
Нийгэм даатгасан үйлс бүхнийг бүтээн соёрх.
Арьяа, Риманда, Шавари, Манбу, Цэтин Нибу Шамбу, Бупа,
Гигон, Цэрмо тэргүүтэн
Аливаа эд малын тэнгэр нөхөр лүгээ сэлт-дор
Амтат сүүний рашааны далайгаар таван ес тахимуй
Ажааран таалаад, агуужим огторгуйн сангийн үүднийг нээж
Алимад таван хүслийн эрдэм тэргүүтэн чухал олдвор ба
Адуу тэргүүтэн таван зүйлийн малын буян хишгийг заяаж
Асар олон төл үрсийг арвижуулан дэлгэрүүлэн соёрх.
Өвөрчлөн тэнгэр, хүмүүн, асур хийгээд там, бирид, адгуусан
Өвөрмөц хүмүүн, малын өвчний эзэд ад тотгор ба
Өр төлөөсөд хийгээд сансрын зуурд нугуд-дор

Өсөг рашааны далайгаар гурван ес тахимуй
Өөр өөрөө зооглоод харшлахуйн нөхцөл бүхнийг амирлуулан
Өөр бусдын элдэв хорлол хөнөөлийг устган
Өөр өөрийн хилинц зовлонгоос гэтэлгээд
Өндөр дээд амгалан мөрийг олох болтугай.
Орны тэнгэр Онгон Зотол хан, Бага Зотол,
Туулайн гол, Нарийнбулаг, Хулстай, Ламын зэрэг булгууд,
Хадан хөв, Хайлас, Хөх овоот, Арбулаг, Хөөвөр, Харгилтай, Зангиа,
Гүн өндөр, Ац, Жанчив, Цагаан хошуу, Араат, Цавчир, Шахаа ширээ,
Бургастай, Арбулаг, Хана, Хадат, Хонхор, Зүрхийн хавчил,
Түмэндэмбэрэл, Хайлас, Аман ус, Их бага дэлгэр, Эрээн шар худаг,
Бичигт уулзар, Их бага тохой, Жаргалант, Таван толгой, Баяндулаан,
Говь Бурхант, Чулуут хөөвөр, Шүүт, Цүнхрэг, Цагаан нигуур /нуур/
Цагаан тээг тэргүүтнээ сүүний рашааны далайгаар ес ес тахимуй.
Харшлахуйн шалтгаан бүхнийг амирлуулан, зохилдохуйн шалтгаан
бүхнээ нөхөрлөн бүтээн зохио. Жавхлант, Хөмөг, Жаргалант, Асгат,
Агуйт, Баянцогт, Билүүтийн гол, Гурван ус, Цагаан овоо, Булшина
гол, Цагаан овоо, Баруун зүүн цагаан тал, Үхэр чулууны гол, цагаан
чулуут, Бор хошуу хэсэг, Морин хушуу, Энгэр шанд, Хийн цагаан
овоо, Бор-Өндөр, Цагаан чулуут, Хуранбадрах, Жавхлант, Чулуут,
Баян өргөн, Гурван хар хошуу, Цагаан овоо Хадагийн /Адагийн/ бор
хөндий, Энгэр шанд, Ганц, Таван толгой тэргүүтнээ сүүний рашааны
далайгаар долоон ес тахимуй. Харшлахуйн шалтгаан бүхнийг
амирлуулан, зохилдохуйн шалтгаан бүхнээ нөхөрлөн бүтээн зохио.
Баян цагаан, баруун, зүүн Баян-цагаан, Баянбулаг, Тахилгат,
Мандал овоо, Далайбулаг, Хөөвөр толь, Орвонт хадат, Начин хэжүү,
Урд булаг, Билгэх Жавхлант, Хамар-булаг, Хавчил, Бадрах овооны
гол, Уулзар Цагаан овоо, Мандалт, Ар гол, Мойлт, Хадат, Зүрх хэрээ,
Тарган, Хэсэг ус, Хоёр шугам, Өлзий, Дурдахай, Далт, Дулаан хар,
Баян-Эрхт, Баруун Аргат, Хоёр Могнор, Хөв, Хашаат, Хэрстэй,
Гангат холбоо, Ар гурван бургас, Эмт бүлээн, Улиастай, Зар Цавчир,
Байтын цагаан хургалж, Суйхуйн цагаан өндөр, Барчин, Залаа, Хоёр
хавтгай, Хадан хөв, Хоёр бүдүүн, Оюут, Холбоо, Балар Бургастай.

Адуун чулуу, Хоёр улиастай, Шанд хөх, Баян номхон, Нөөлөгт тал,
Ар хөндий тэргүүтнээ сүүний рашааны далайгаар долоон ес тахимуй.

Харшлахуйн шалтгаан бүхнийг амирлуулан

Зохилдохуйн шалтгаан бүхнээ нөхөрлөн бүтээн зохио.

Лхачинвандад, Яргайт уул, Дөрвөн шар овоот, Усны эх, Хэцүү,
Улаан ганга, Бөөр, Хөв, Манхат, Хөндлөн,

Баян мод, Эмчийн толгод, Хоёр хавтгай дөрвөлжин

Хамар ус, Хар хошуу, Бичигт Хатавч, Хэвтэшийн говь,

Сундарах, Холбоо зүрх, Бүдүүн уушиг, Жимст, Үнэгэд,

Цагаан өндөр тэргүүтнээ сүүний рашааны далайгаар долоон
ес тахимуй.

Харшлахуйн шалтгаан бүхнийг амирлуулан

Зохилдохуйн шалтгаан бүхнээ нөхөрлөн бүтээн зохио.

Баатар жанжин уул, Буянбадрах, Хана хулстай, баруун, зүүн
Сэрвэн, Хэцүү, Залаа, Шилүүстэй, Буян-Өндөр, Балин-уул, Ар өвөр
журамт, Зүрх, Мэнэн ямаан, Улиастай, Ар нүхэн, Өвгөн уул, Дүнгэнэх,
Баян хушууны говь, Хоёр шугамт, Хайрт хашаат, Бага нуур, Дэвсэг
/Дэвсэн/, Өгөөмөр, Хөндлөн хайлас, Бяцхан хавчил, Нарам Тэргэт,
Хашаат, Оцол, Баянхайлас, Эрээн овоот чулуут, Зүрх харт, Хар овоо,
Цац тэргүүтнээ сүүний рашааны далайгаар долоон ес тахимуй.

Харшлахуйн шалтгаан бүхнийг амирлуулан

Зохилдохуйн шалтгаан бүхнээ нөхөрлөн бүтээн зохио

Баян уул, Цахиур, Хавирга, Талын овоо, Тарган, Тосон, Адуун чулуу,
Шийрийн булаг, Улаан далан, Билгэх, Сэвсүүл, Нарийнбулаг, Хөх
чулуу, Улаан чулуу, Ханхал, Нүүгэл, Адуун чулуун булаг, Хоёр
дарчин, Төөдхөн, Норов уул, Хайластын өндөр, Галтар бүрд, Халтар
хушуу, Баянцагаан, Хутаг овоо, Галтарын булан, Адуун чулуу, Лагийн
бүрд, Орой хашаат, Баянбулаг, Цагаан чулуут, Цагаан овоо, Бор
хошуу Ихбулаг, Хөл гурван ус, Ацын хоёр овоо, Зэгстэй, Хөх нүдэн,
Өлзийт өндөр, Гурван хурга, Хажуу хөв, Талын гол, Адаг талбай, Ар
гол, Зотол, Баян хавчил, Өлөг цагаан овоо, Буйм, Өлзийт өгөөмөр,
Мандал тэргүүтнээ сүүний рашааны далайгаар долоо ес тахимуй.

Харшлахуйн шалтгаан бүхнийг амирлуулан

Зохилдохуйн шалтгаан бүхнээ нөхөрлөн бүтээн зохио.

Цагаан овоо, Цагаан дэрс, Хоёр нүхт, Буян өндөр, Сайхан тохой,
Хайласт гуу, Лонготын /лонхотын/ цагаан овоо. Хоёр мушгиа,
Жавхлант, Арбулаг, Эрдэнэ овоо, Сэвжидноров, Уулзар, Мандал
овоо, Барчин, Өнгий, Шар хад, Тохой, Хоёр харангал, Замын овоот,
Билгүүний овоо, Модот хүйс толгой, Мааньт, Улаан хавчил, Хөх
нөрөө, Шар овоот, Хаданхудаг, Улаан хушуу. баруун, зүүн Жавхлант,
Улаан Ханга /Ганга/, Хоёр ховд, Арвад дэнж, Хоёр хөндлөн, Арбулаг,
Хоёр цагаан овоо, Цагаан тал ба Чандмань овоо, Бага бор, Ширээ
шанд, Цагаан овоо, Хоёр хар ангир /энгэр ?/, Цагаанчулуут, Жаран,
Үхэр чулуу, Оготор хавчил, Төмөрхүрээ, Өтөгт, Билигүүдэй, Улаан
дов, Шохойт, Алтан овоо, Цагаан овоо, Гурван цагаан тал, Хөндлөн,
Үхэр чулуу, Цагаан чулуут, Бөөр, Дөрвөлжин, Чонын гол, Номын
дов тэргүүтэн

Эрхлэн нэрлэсэн ба эс нэрлэсэн

Эгнэгт харъяат нутаг орон-дор

Эрхшээсэн эрхт тэнгэр, лус, дэлхийн эзэд бүхэн-дор
Эрхэм сүүний рашааны далайгаар долоо ес тахимуй.

Эдүгээ даруй баясан таалаад

Эгэл харшлахуйн нөхцөл бүхнийг амирлуулан

Эгүүрд ба бүрэн багш, шавь өглөгийн эзэд, нөхөд сэлтийн

Элдэв горилсон тус өөр өөрөө сэтгэлчлэн бүтэж

Эрхэлсэн шашин, төрийн үйлс-дор

Эгүүрд тэтгэмжлэн өмөглөж нөхөрлөн зохио.

Эдүгээ товчилбоос гурван мянган

Их мянган орон хийгээд

Ихэд алдаршсан Энэтхэг, Хятад, Түвд, Амдуу, Монгол нийт
ба

Эгнэгт халхын орон-нугуд-дор

Эрхшээсэн тэнгэр, лус, газар орны эзэд бүхэн-дор

Эрхэм сүүний рашааны далайгаар гурван ес тахимуй.

Эрхлэн таалаад харшлахуйн шалтгаан бүхнийг амирлуулан

Эгүүрд зохилдохуйн шалтгаан бүхнийг тус тус бүтээн зохио.

Адистидийн дээдийг өршөөгч лам гурван эрдэнэ
Аливаа шидсийн хурыг булгагч
Амирлингуй хилэнтний Ядам бурхан
Аюулт тотгор бүхнийг арилгагч
Аугаа хүчит дагинас номын сахиулсан тэргүүтэн
Алимад тэнгэр, лус, найман аймаг-нугуд ба
Алтан дэлхийн эзэд хийгээд
Арван зүгийн орны зочид нийт-дор
Амтат балын шим бүрдсэн өсөг сацал үүнийг
Ариун санааны үүднээс өргөн тахиад
Алин хүссэн тусыг өчин залбирч айлтгаснаас
Дээд төрөлхтөн лам нарын
Тэгш өлмий лянхуа маш батдан
Дээшид таалсан сайн зохиол үйлс
Дэгжих шинийн сар мэт
Дээрээс дээш арвижин дэлгэрээд
Бурхны шашин арван зүг-дор
Бум нарны гэрэл мэт сацран мандаж
Бурсан хуврагуудын насан уртдах болтугай
Гурван суртал-дор хир үгүй болоод
Буян чуулган эрдэм номын үйлсийг өрнүүлэн зохио.
Манзушири богд эзний хутаг өлзий
Маш өнид гийн бадарч
Муу самуун дайсан хулгай устаад
Мандах төр үүрд тогтож
Чингис хааны эрхэм язгууртаны чанар ариун үр үндэс дэлгэрээд
Цэх түвшин журам ёс эергүү найралтай
Чийрэг эрх баялгийн цогоор цэнгүүлэн зохио.
Хамаг даяар болон харлиг албат
Хамтаар нас буян дээшид арвидаж
Гайхамшигт яруу алдар, цог заль
Ган сан, сүрэг мал ба
Гавьт төгс эдлэл хотол төгсөж

Гадаад дотоод дэлхий дахины орон-дор
Хатуу догшин мөндөр хяруу ба
Гариг одод аянга цахилгааны хорлол үгүй болоод
Ган зуд, гал ус, шороо салхин тэргүүтэн
Гачиг гамшиг, гашуун хувьсгал хийгээд
Гаслан зовлонгийн аюул үгүй
Гайхамшигтай зөөлөн хур цаг цаг тор нийлүүлэн
Газар газар төр үр тариа, цэцэг жимс болон
Гайхамшигт шим ногоо сайтар боловсрон дэлгэрч
Хүмүүн ба хүмүүн бусад элдэв ил далд
Хөндөлдөн харшлагч дайсан тотгор бүхэн аяндаа сөнөж
Хүсэн зохилдохын сайн шалтгаан бүхэн зөндөөн бүтээд
Хүмүүн-дор цаг бусын өвчин зовлон үгүй
Хөнөөл хорлол, зарга тэмцэл устаж
Хөхилдөн хөгжилдөж, баясгалан жаргалангаар цэнгэлдэн
Хөрөнгө мал-дор архаг эмгэг гай гарз үгүй болоод
Хүй хүй зуун мянганаар үржүүлж
Хөдөө гадна дүүртэл өрнүүлэн зохио.
Аяа бас хамаг бүхнээр
Арван их баян буяныг
Алин зоргоор эдэлж
Амар амгалангаар цэнгээд
Аврал гурван эрдэнийг дээдлэн тахиж
Ашдын буян чуулганыг үлэмжид хурааж
Амьтан бүхэн бодь хутгийг түргэнээ олох болтугай.

ОЦОЛ УУЛ

“Оцол уулын сан” хэмээх эл бяцхан судрыг эрдэмт ламтан Ш.Сонинбаяр өгсөн болно. Оцол нь Дорноговь аймгийн Даланжаргалан, Сүмбэр сумын нутагт орших 1693 м өндөр уул. Зарим номд 1731 м өндөр ч гэсэн байдаг. Олонд алдаршсан нэр нь Чойрын Богд уул болно. Замын үүд, Улаанбаатарын гол замаас зүүн тийш арав орчим км зайд тодорхой үзэгдэх бөгөөд /з.у. 108 47, х.ө. 46 16/ газар зүйчид элэгдмэл боржин чулуунаас тогтсон уул гэдэг. 1923 оноос Хан Хэнтий аймаг байгууллагдахад нэг хошууг нь Оцолсансар уулын хошуу гэж энэ уулын нэрийг оролцуулан нэрлэх болсон билээ.



Оцол гэсэн нэр нь төвд хэлний *od gsal* /Од сал/ буюу “гэгээн гэрэлт” гэсэн утгатай үг гэж зарим судлаачид тэмдэглэсэн байх боловч энэ нэр хожуу үед сангийн судар зохиох үест бий болсон бололтой. Учир нь анхны нэр нь *Ац* уул гэсэн монгол нэр байсан гэдгийг нутгийнхан ярилцсаар ирсэн билээ. Чухам энэ үгийг төвд үг болгон хувиргасан бололтой.

OTSOL SACRED MOUNTAIN

Information on the area:

This granite mountain, otherwise known as Choiryn Bogd Mountain, stands on the territory of the Dalanjargalan and Sumber Soums of Dornogobi Province, at an altitude of 1693 meters.

The sacred mountain of Otsol is visible from a long distance and stands as a beacon in the landscape, it's Tibetan name meaning 'the enlightened one'.



ОЦОЛ УУЛЫН САН

Хэзээний тийн ариун баяслаас хагацсаны агуу төвөөс
Хий сэтгэл элдэв цэнгэлийн үйл бүтээсэн
Элдэв дүр хувилж, хувилгаснаас огоорохыг өгүүлж зохиогч
Эл гурван орны баатар, дагинас зохих өлзийг соёрх.
Дэндүү гоо үзэсгэлэнт бүхний цагийг булаасан
Дэндүү өндөр газрыг баригч Оцол нэртийг дээдлэе.
Дэндүү хэтийдсэн наадан цэнгэлийн Их Сүлдэн тэнгэр
Дэндүү олон нөхөд сэлт энд ажран тавцнаа залрагтун.
Сац бас газарт аху баатдын хиргүй самади бясалгалаас
Сайтар үүдсэн хотолд сайн тахилын үүлэн далай мэт
Сайтар бишрэлээр бодитой бэлдсэн сэтгэлээр хувилгасан
тахилын чуулганыг
Саруул огторгуйн их орноо дүүргэж Юлхаагийн мэлмийд
өргөмүү.
Эд баригч орон адил уужим их савын дотор
Энгүй ариутгагч Галын бурханыг бадраасны идээн дотор
Эрхэмсэг хиргүй эм, хүжис ариун зай, элдэв эдлэлийн
чуулганаар
Эндүү атгаггүй сэтгэлийг үүсгэх цэнгэлийн утаан үүлсээр
Энэхүү сансрын зочид, зохист бүгд нөхдийг ариусгая.
Эрхт тэнгэр та ариун, асар атгаг сацралаас хагацсан ч
Эс арилсан эндүүрлийг орхиж бузар балчгийг хоцроолгүй
Эл ариун тахил, рашааны чимгээр ариусгах болтугай.
Ариулсан болой
Эрхин тангараг эвдэрсэн ариун бус хамгийг ариулсан болой
Ялсан болой
Эрхт шашны сахиулсан цагаан зүгийг тэтгэгч ялсан болой.
Магтсан болой.
Энэ орны шивдагийн сүр сүлдийг магтсан болой
Дурдсан болой.
Эндүүгүй дөрвөн үйлийг бүтээхийг дурдсан болой.

Ялгуусан шашин, хамаг төрөлхтний тус амгалангийн шүтээн
Ялгуух шашныг баригч төрөлхтний номлол бүтээлийн үйл ба
Цаглашгүй шашны өглөгийн эзний нас цог, суу заль нь
Цаашид зуны саран мэт дэлгэрэхийн эрхин үйлийг зохио.
Дээд гурван адистид, үл барагдах буянт сайхан билэг ба
Дэвжээх орныг тэтгэгч Сүлдэн тэнгэрийн агуу хүчит цог
адисаар
Дээрээс сэтгэлийг арвитгагч эрхтийн хаантан мэтээр
Дэлгэр сайн буян, санасан бүхэн үүдэхийн өлзий орштугай
Оцол уулын сан тахил төгсвэй.

ӨНДӨР ХАН УУЛ

Өндөр хаан нь Их Хэнтий уулын дүү уул гэгддэг бөгөөд сүр жавхлантай, холын хараа бараатай, эртний тахилгат уул болно.

Энд толилуулан бүхий Өндөр хааны сангийн судрын монгол орчуулгыг миний бие “Ундур хан ги шивдаг сан”, “Ши вдаг чин по тао жал баши сан сол чод” гэсэн хоёр төвд эхийг харгуулан орчуулсан болно. Бийрээр бичсэн нэгэн зүйл монгол орчуулгыг энд бас хавсаргав. “Өндөр хан уулсын сан” нэртэй энэ монгол бичмэл судрыг төвдөөс орчуулсан нь илт байна. Үүний хуулгыг яруу найрагч, зураач Ж.Саруулбуян өгсөн бөгөөд тэрээр “эл судрыг өөрийн эцэг Д.Жүмпэрэл Өндөр хаан хотын төвд суудаг 75 настай өвгөн ах Д.Раднаабазарын хадгалж байснаас хувилан авсан” гэж хэлсэн билээ. Төвд судрын төгсгөлд “Халхын зүүн аймаг Цэцэн хааны хошууны захирагч Гомбожав ноёны дурдсанд...” гэсэн гэхдээ занги гарч байгааг үзэхүл зохиогдсон цаг үеийг тодотгох баримт болох ажээ.

Сэцэн хан аймгийн олон засаг нарын нутаглан суусан газар орны нэрийг ялган салгаж бичсэн цэс дэвтэр хэмээх нугалбарт /ГТА. Фм.31. х/н 128/, Сэцэн хан Чойжавын хүү “Сэцэн хан Махшир /1800-1808 онд хан байсан/ би Өндөр хан уулын тус Хэрлэн голын хойт этгээдэд нутаглан суумой. Миний хошууны... зүүн хойт этгээд Салхит уулаар чуулганы дарга гүн Гомбожавын хошуу лугаа зах нийлж овоо байгуулав” гэж буй. Үүнийг УТТА-д хадгалагдаж байгаа халхын Сэцэн хан аймгийн зарим хошууны газрын зургаар хөөн үзвэл Гомбожавын хошуу нь Сэргэлэн засгийн хошуу байжээ. Энэ хошууны тахилгат уулын нэг нь Өндөр хаан байсан ажээ. Сэцэн хан Махшир нь 1800-1808 оны хооронд хан байсан тул Өндөр хан уулын сангийн судрыг Гомбожав ноён энэ үед зохиолгосон бололтой.

Нутгийнхан Өндөр ханы шадар түшмэл нь Баян-уул, сөн түшигч нь Баян-Эрхт гэдэг. Иймд Баян-Эрхт уулын баруун урд хормойд айл нутаглаваас их өлзийтэй гэлцдэг. Баянхутаг сумын нутагт орших Хэрээ гөхөл уулыг хонх очроо урдаа тавьсан лам шинжтэй гэх тул Өндөр ханы лам уул гэдэг. Энд Богдын долоон цорж

тасралтгүй мэндэлсэн гэх тул эрхэмлэн шүтэж иржээ. Хэрээ гөхөл нь жоншоороо ихэд алдаршсанаас нутгийнхан:

Хэрээ гөхөлийн жонш

Хэрлэн голын бургас... гэхчлэнгээр холбон шүлэглэсэн байдаг. Мөн Баянхутагийн Алдар уулыг очроо өвөр дээрээ тавьсан бурхан шинжтэй гэдгээс Өндөр ханы бурхан нь гэнэ. Өндөр хан уулын тухай хэд хэдэн домог тааралддаг ба энэ уул хэрхэн модтой болсон тухай нэгэн домгийг энд толилуулсугай.

Эрт цагт энэ уул модгүй байжээ. Модтой болгох гээд уг уулын савдаг нь их явжээ. /Богд уулын/ Дүнжонгарвыг унтаа байхад нь модноос нь хулуугаад зугтааж гэнэ. Дүнжонгарав сэрмэгцээ мэдээд араас нь элджээ. Одоогийн Налайхын зүүн талд гүйцэж очоод газрын хөрсийг нь эргэтэл ноцолдож гэнэ. Тэгээд Өндөр хааны савдаг тэнд зуун мод орхисноос зуун мод гэгдэх болж, хэсэг модыг авч явснаас Өндөр хан уул модтой болсон тухай газар усны домгийн арвин цуглуулга хийсэн доктор Х.Сампилдэндэв нэгэнтээ ярьж билээ.

ONDOR KHAAN SACRED MOUNTAIN

Information on the sutra:

The Ondor Khaan's sutra-manuscript was translated into Mongolian, from original sutras written in Tibetan. Only two Mongolian copies exist.

Ondor Khaan Mountain is known as the sister mountain range to the Great Khentii Mountain.

The locals call the mountain 'Bayan-Uul', the adjacent mountain is part of the Ondor Khaan Mountain and is called Master of the Ceremony. The nearby Kheree Gokhol Mountain is considered the guardian for Ondor Khaan Mountain, on account of its looking like a Lama holding a bell and thunder-bolt. It is highly respected and worshipped by the locals, due to its being the birthplace for the seven highest ranking Master Lamas of the last emperor of Mongolians, Bogd Khan.

A legend exists on how Ondor Khaan Mountain became forested. Once upon a time, the Ondor Khaan mountain had no forest cover, only a bare surface. The deity of Ondor Khaan Mountain had

been obsessed with how to encourage forestation. Consequently the deity made a final decision and had trees stolen from Bogd Khan Mountain, under the cover of night, while its guardian-deity Dunjingarav was asleep.




When the Bogd Khan Mountain's deity woke up and realized that its trees had been stolen, he immediately set forth to where modern day Nalaikh town is situated, where he battled with the Ondor Khaan mountain deity.

During the fight, Ondor Khaan Mountain's deity lost one hundred trees, and thus the battleground was named after those one hundred trees, 'Zuun Mod' or 'One Hundred Trees'. The trees which the deity managed to escape with became the basis for the Ondor Khaan mountain's forest.

ӨНДӨР ХАН УУЛЫН САН

Намо баара бхайра, вааа. Энэ Өндөр хааны дэлхийн эзэн / шивдаг/-д сан тахил багинн өргөхийг хүсвээс сэтгэлдээ зохилцуулан оршуулаад тахил багинт дэлгэрүүлэн үйлдвээс зүрхэн тарнийн үйлс номлох мэт ба хураангуйлаас их цагаан багин нэг, улаан багин мах цус зэргээр чимээд бусад ариутгал хийгээд тостой гурил /чимар/, сержим, жансигт тэргүүтнийг зэхэглүн. Өөрийн тангараг алиныг үйлдэхүйн бүтээлийн аргаас номлох мэт адистилла !
Тэр мэтийг эс мэдвээс: Ум аа хум хэмээн гурвантаа урилта сэлтийг өглүүлж уншин үйлдэх бөлгөө.

Өндөр хан ууланд бодитой оршсон
Өндөр хан тэргүүтэн их дэлхийн эзэн
Өгөөмөр энэ орны уул нуруу хийгээд
Өвс ургамал, ус мөрнөө оршсон
Орныг тэтгэгч нөхөр сэлтэс, тэнгэр, лус
Огноороо энэ орноо ажиртугай.
Өөрийн өмнөх, сэтгэл зохистой
Өнгөт сайхан орд харшийн
Эрдэнийн их ширээндээрх
Эрхин их тэнгэр Өндөр хан
Байгаа биеийн өнгө цагаан
Хөвр мутар, нэгэн нигууртай
Баруун мутартаа сангийн бумба
Бас зүүнээ чандмань барьсан
Эрхтийн нум-солонго адил
Тэнгэрийн элийн хувцаар хувцаслан
Эрхийн паст уул мэт маш цагаан
Саа торгон титмийг агссан
Энгүй сүр жавхланта нөхдийн
Чуулганыг дагагчаар хүрээлүүлсний дунд
Баруун өлмийгөө батал жийгээд



Зүүнийг хумбин цэнгэхүй байдлаар оршмуй.
Үнэмлэхүй зөв билэг билгийн
Үзэгдлийн хувь маш бадарсан гэрлээр
Хотол чуулганы сангийн эд зайг
Хоролзуулан түлсний утаан үүлэн
Зун цагийн огторгуйн эн дүүрснээр
Их шивдаг Өндөр хан, нөхөр сэлтийг ариулмуй.
Азар бузар түйтгэр бүхнийг
Номын төвд ариутгах болоод
Аху энэ оронд өвчин хижиг
Ножид хямрал, зуд тэргүүтэн
Оршихуйн үест үл зохилдохын
Олон чуулган зэргийг амирлуулах агаад
Магад утга хоёр түйтгэрийг
Дайн тэмцлээр ялан дийлэхийг зохио.
Согтоон үйлдэхүйн шимийг хураасан
Сархдын үр эмийн зүйлээр найруулсан
Алтан ундааны рашааны их далай
Адьбиш гурван сансрын ундаа нь
Адилтгашгүй хэтэрхий болсон үүгээр
Дэлхийн эзэд нөхөд сэлтгэст
Дээдийн баяслыг үүсгэх болтугай /Ум аа хум-энэ номыг
гурвантаа өгүүл/
Гурван мянганы эн адил
Уужим их эрдэнийн савыг
Олон дээд сайн идээний
Охь шимээр сайтар дүүргэж
Онохуй ба судлахуйг бадруулан үйлдсэн
Оргил рашааны их далай үүнийг
Тэнгэр лус, шивдаг, нөхөд сэлтийг
Тэнцүүхэн баясгахуйн тулд өргөмүй /Гурвантаа унш/
Чухал эдлэхүй таван хүсэл, долоон эрдэнэ
Чухам гадаад дотоодын нууцын

Чухаг дээд эд зай, жансиг тэргүүтэн
Бодитой бэлдсэн ба сэтгэлээр хувилгаснаас
Болсон Саманбадраагийн тахилын үүлсийн
Бойлох их далайгаар тахин үйлдсүгэй.
Ид хүссэн хэрэг бүхнийг гаргагч
Элдэв эдээр машид дүүрсэн
Их хүү сангийн бумба
Сэтгэлчлэнгийн эрхээр ялан дийлснийг
Торгон титэм, тэнгэрийн эд нөмрөг тэргүүтэн
Тоолшгүй хэрэглэл, эд агуурс бүхнээр тахиваас
Энэ орны хаан түшмэл
Эгэл албат иргэн сэлтүүдийн
Хүчин олдвор язгуур үндэс нь
Хүсэлт зуны далай мэт арвидаад
Хуврагийн аймгууд сэтгэл элэлдэн
Шагшаабадын ариун тэргүүтэн сайн чуулганыг
Шадар тэгшид арвитгах үйлсийг зохио.
Долдой бид бүхний үл мэдэх хийгээд
Дорой сэрэмж үгүйн эрхээр болсноос
Догшин газрыг ухах төнхөх болон
Догшин модыг огтлох тайрах хийгээд
Одон гаригийн тохиол учралын
Онц муу үест үйл үйлдэх тэргүүтэн
Зохистой сэтгэл лугаа харшлагч
Аливаа гэм юу үйлдсэнийг
Зоригдошгүй их амгалангийн агаарт
Аяндаа хүлцэн таалж соёрхоод
Өдрийн гурван хувьд сахих болон
Шөнийн гурван хувьд манах тэргүүтэн
Дөрвөн зүйлийн эрхин үйлсээр
Дөжрөлгүй насад сахин аварч
Аврал итгэл, өмөг садныг
Ашид алмайралгүй зохион хайрла.

Хотол төрөлхтний тус амгалан
Хоцролгүй гарахын уг шүтээн
Шар малгайтын эгүүрдийн ёсон
Арван зүгтээ өргөжин дэлгэрээд
Амьтан бүхэн номын учралын цогийг эдэлж
Алив хүссэн бүхэн хоцролгүйяа
Аяндаа бүтэх болтугай хэмээмүү

гэсэн Дэлхийн эзэн Өндөр ханы тахилга энэ мэт нэгэн хэрэгтэй гэж
Халхын зүүн аймаг Цэцэн хан хошуу захирагч Гомбожав ноёны
чухалчлан дурдсанд Шагжийн аяга тахимлиг
Лувсанбалданамбийнямчоглойнамжилбалсанбо-бээр найруулвай.

СЭРЖИМ ӨРГӨХҮЙ

Багш лам, Ядам, Чухаг дээд гурав
Бас язгуур дөрвөн аймгийн
Барилдлагат тэнгэрийн чуулганд
Авад цуврилгүй сэржим өргөсөн болой.
Адистидийн дээд хувьт шидийг үзүүл.
Авралт ном, Намсрай, Лхам тэргүүтэн
Авуурьд шашны сахиус далайн чуулгануудад
Алтан ундаа тахил, өргөсөн болой.
Ашдын сайн дөрвөн үйлийг бүтээн зохио.
Эрх хүчит тэнгэрийн хаан Өндөр хан
Бэрх хатуу нөхдийн чуулган далай сэлтэст
Энэхүү сэржим тахилыг өргөсөн болой
Эгүүрд даатгасан үйлийг бүтээн зохио.
Жил, сар, хоног, цагийн тэнгэрсүүд ба
Жич энэ оны эзэн, дэлхийн эздэд
Жинхнээс сэржим тахил өргөсөн болой.
Жишээ орны эзэн сахиулсны бошгийг зохио.
Энгүүн шудрага эрхээр тэргүүн шүтээнд
Эрдэнийн эм, шимт үр элдвийг найруулсны

Энэхүү цувралгүй алтан ундаа нь
Эгнэгт билэг билгийн айлтгалын гэгээ мэт
Эрхин дөрвөн үйлсээр бидний нөхөд сэлтийн
Эчнээ харшлахуй элдэв шалтгааныг
Эрхшээн тасалж бүхнийг амирлуулаад
Эвлэлдэх нөхцлийг бүтээх хамсааг зохиогтун.

Өлзий хутаг орших болтугай.

СУВАРГА ХАЙРХАН УУЛ

“Их цагаан уулын сан тахил” гэдэг энэ судрыг түүхч, эрдэмтэн Дашбадрахад байгаа эхээс татуулж авав. Энэ нь Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт орших Суварга хайрхан уулын сангийн судар болно. Суварга хайрхан уул Хангайн нурууны зүүн хэсэгт зүүн хойш жар гаруй км үргэлжилсэн томхон уул юм. Орхон Тамир зэрэг олон гол эх авч урсдаг эртний тахилгат уул болно. 2600-3000 м өндөр энэ уул з.у. 101 25 х.ө. 47 03-д оршино. Суварга хайрхан нэрийг цээрлэн “Их цагаан уул” гэж нэрлэжээ.

Суварга хайрхан уулыг цасан цагаан додигтой, ус мөрөн, ой модон шамтавтай хадан гярга элдэв чимгээр чимэглэсэн байдлаар дүрсэлсэн нь бусад сангийн судраас ялгаатай байна.

Энд тэмдэглэхэд додиг нь *stod gyogs* “цээжний өмсгөл, цээживч” шамтав нь “лам нарын номын хувцас, банзал буюу хормогч” гярга нь *sge rags* -бүс гэсэн утгатай, төвд хэлнээс монгол бичгийн хэлэнд орсон үгс болно.

Суварга хайрханы талаар домог яриа цөөнгүй буй. Түүний нэгийг толилуулбал: Балар эрт цагт Сэлэнгэ мөрнийг хойш урсгахгүй гэж Хангайн нуруу тогтсон гэдэг. Гэвч Сэлэнгэ мөрөн хойш урсаад гүйцэхдэхгүй байсан тул Суварга хайрхан буруу харж Хангайн нурууны төгсгөл болж тогтсон гэдэг.

SUVARGA KHAIRKHAN MOUNTAIN

Information on the sutra:

Suvarga Khairkhan, the Great White Mountain, is located in Tsenkher Soum, Arkhangai Province.

The mountain forms the eastern part of the Khangai mountain range. Large rivers such as the Orkhon and the Tamir flow directly from this mountain.

The mountain has been worshipped for centuries, and in the manuscript its snow-capped mountain tops, forests and rocky surfaces are praised for their creation and extraordinary beauty.

The ancient legend, describing the origin of Suvarga Khairkhan Mountain, tells that the Khangai mountain range was created to stop the northward flow of the Selenge river.

However, the Khangai Mountain Range alone could not manage to halt the northward flow of the river. According to legend Suvarga Khairkhan Mountain came to help and took his place standing to face the North.

Handwritten text in a rectangular box, likely a manuscript fragment. The text is written in a cursive script and is partially obscured by a dark, irregular border.

Handwritten text in a rectangular box, similar to the first fragment. The text is written in a cursive script and is partially obscured by a dark, irregular border.

Handwritten text in a rectangular box, similar to the other fragments. The text is written in a cursive script and is partially obscured by a dark, irregular border.

Handwritten text in a rectangular box, similar to the other fragments. The text is written in a cursive script and is partially obscured by a dark, irregular border.

ИХ ЦАГААН УУЛЫН САН ОРШВОЙ

Суварга хайрхан уулын сан

Эрхин чанарын өвөрчлөнгийн асар ариун их амгалант
мэргэний агаарт

Эрхтийн нумын гэр барьсан ордон өргөөнөө
Элдэв лянхуваар чимсэн очирт суурин дээр
Ээлийн их тэнгэр их Далха батад залрагтун.
Уулын эрхт тахилын шүтээн үзэсгэлэнгийн дунд
Ус мөрөн, ой модон шамтав, цасан цагаан додигтой
Ургах нар, сар, хадан гярга элдэв чимгээр болгоосон
Урмас бадраах Далха тэнгэрийн нэгэн төрөл ид хүчит
Баруун мутартаа илд, зүүнээ цалам далайсан
Басхүү эгээрлийн их далайг хурцатган чимсэн
Амирлангуй дэлгэр эрхт догшин үйлсийг бүтээх
Асар олон нөхдийн чуулган, туст олон уулаар хүрээлүүлсэн
Атгаггүй та бүхнийг баясгахаар зохилдох зайг өргөх нь:

Ариун гурван цагаан хийгээд гурван амтат үр
Архи дарс, тахил, балин сэлтэс хийгээд
Асар салхин хүчит хөлөг тэмээ, ямаа, хонь, нохой
Бадрах сангийн тахилын үүлээр
Баясгаж, тэнгэр огторгуйг дүүргэн тахиж
Ба бүрний хийд орныг
Бас шүтээн үйлдэгч хамгууд
Авран хамгаалах зохилдохуй нөхцлийг бүтээж
Аливаа харшлахуй шалтгааныг арилга.
Хамаг ном, эрдэнэ, таалал, тонилохуйн аймгийн чуулган
Харилцан тэнсэлдэн дэлгэрэхүйн эрхин үйлсийг зохио.

Арван зүг зовхис, дээд доодод оршсон бурхад
Аврал итгэл дээд итгэлт чухаг гурав тэргүүтэн
Буян, нүглийг ялгагч тангарагтан номын хаан

Буй биднийг авран бусдын уул уснаа эс оршуулснаар
Мөргөл авралын хүчээр бид бүхэн хаа одовч
Мөхөөх дайсан, хуйхуй, хулгай дээрэм эс үйлдээд
Амьтан бүхэн сансрын зовлонгоос гэтэлж
Аюул бүхнээс аврагдан санасан хэрэг бүтэх болтугай.

СУТАЙ ХАН УУЛ

Сутай хан уулын энэ сангийн судар миний анд нөхөр Алтай нутгийн хүү доктор, профессор, зурхайч Л.Тэрбиш мөн МУИС-ийн Ховдын Багшийн их сургуулийн багш, эрдэмтэн Д.Ганболдод тус тус эхээрээ хадгалагдаж байснаас буулган авсан болно. Д.Ганболд уг судрыг Ховд аймгийн Дарив сумын нутгаас олж авчээ.

Сутай уул нь Алтайн нурууны нэг хэсэг, Баатархайрхан уулын зүүн хэсэг болдог. Мөнх цасан оргилтой баруунаас зүүн тийш жараад км сунаан тогтсон байдгийг газар зүйчид тодорхойлжээ. Ямар боловч Алтайн 13 мөнх цаст оргилын нэг энэ алдарт уул Говь-Алтай, Ховд аймгийн дөрвөн сумын заагт орших тахилгат уул болно. Хантайшир уулын аймгийн нэг хошууг Сутай уулын хошуу гэж газрын зурагт (1925 онд) тэмдэглэсэн байдаг. Хамгийн сонирхолтой нь энэ уулын үнэмлэхүй өндөр оргилыг газар зүйн ном, сурах бичиг, лавлах толь зэрэгт 4226 м, 4090м гэхчилэнгээр тэмдэглэжээ.

Сутай гэсэн нэр нь Су (ус)+ тай (уул) буюу “Уст уул” гэсэн утгатай түрэг гаралтай үг болно. Нутгийнхан Цаст богд ч гэж нэрлэдэг. Аман уламжлалаас үзвэл домогт Сутай хайрханы эзэн нь сэргэр хоёр эврээрээ дээд тэнгэрийг сүлбэж, урд хоёр туурайгаараа газрын хөрсийг онгичсон, нүдээ улаанаар эргэлдүүлсэн догшин сүрлэг цагаан бух хөлөглөсөн цайвар царайтай, дөлгөөн харцтай, зүүн мутартаа эрдэнийн тавагтай, баруун мутартаа шар торгон хадаг намируулсан, цагаан хувцас хөдөрсөн эмэгтэй хүн байдаг гэнэ. Тэрээр ядуусыг энэрэгч, догшдыг номхотгогч увдистай ажээ.

SUTAI KHAN MOUNTAIN

Information on the sutra:

The manuscript has been copied from the original kept by Professor L. Terbish and Professor D. Ganbold.

Sutai Sacred Mountain is part of the Altai Mountain Range. The mountain has numerous snow-capped peaks reaching over 4000 meters. The mountain name derives from the Tibetan language and translates as ‘The Water Mountain’ (‘su’ meaning water and ‘tai’ meaning mountain).

The deity for the holy mountain is depicted as a female dressed in white robes, holding in one hand a treasure-plate full of precious stones and in the other, a yellow silk ribbon called a ‘khadag’. She rides a fierce red-eyed white bull with two long horns reaching up to the sky.

People believe that the mountain deity is a protector of the poor.

༄༅། །ལྷ་དཔང་སྤྱི་མཉམས་ལྟུང་ལྟུང་། །
 ༄༅། །ཀྱུང་གི་མཚན་དཔལ་གྱིས་མཛེས་པར་མཛོལ་ཏེ་ལྷོངས། །དུམ་
 ལྷ་ས་ས་འཛེབ་མཚན་དུང་དང་པོ་དབུས། །བརྟེན་པའི་དུམ་ལྷ་མཚན་གཤམ་
 རྒྱུ་ལྷ་ས་པའི། །ལྷ་སྤྱོད་སྤྱི་མཉམས་ལྟུང་ལྟུང་། །འགྲུ་ལྷ་སྤྱོད་
 མཚན་དུང་དང་། །གཞུ་ལང་རྒྱ་གཞུ་མཚན་ལྷོངས་ལ། །གནས་

འབུལ། །མི་གཙང་ལྷོངས་པོ་ཚོ་གསལ་ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ས་གཞུ་སྤྱོད་
 གཞུ་སྤྱོད་པ་དང་། །འོང་གཞུ་གཞུ་ཚོང་ཚོང་ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །
 མི་སྤྱོད་དང་གསལ་ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལོ་གཞུ་གཞུ་ལྷོངས་ལྷོངས་
 ལྷོངས། །མཚན་གཞུ་ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་
 དང་འགྲུ་ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །འགྲུ་ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས།

པོ་ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ཐོག་མཚན་ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །
 གཞུ་སྤྱོད། །མཚན་དུང་ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་
 ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་
 ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །
 །མཚན་ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས།

༄༅། །སྤྱོད་ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །
 མཚན། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །
 ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །
 ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །
 ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །
 ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །

མཚན་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་
 ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །
 ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །
 ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །
 ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །
 ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །

པོ་ཚོ་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །
 ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་
 ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །
 ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །
 ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །
 ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །ལྷོངས་ལྷོངས་ལྷོངས། །

СУТАЙ ХАНЫ САН

Аяа,
Сайн билэгт цогоор илтэд өндөр орон хотноо
Сайн хэвтэй газрыг баригч гайхамшигт жигдэрсний төвд
Буурашгүй бөх бат, сүр жавхлант цаст уулнаа оршсон
Бурханы эмт, ид, хүчин чадалт Сутай хатан
Зарлиг сонсогч лусын охин, долоон хань түшээ
Завсаргүй бас бус уул хад, тал аль зохистой газарт
Заларч баттай оршсон орны тэнгэр шивдагууд
Завдан яарч ирд хувилгаан лугаа сэлт энэ орноо залрагтун.
Өмнөдөд хурын үүлэн үймэлзэн хөвхөлзөн тогтсоны төвд
Үнэнхүү сэтгэлд зохистой солонгын гэрэл нумран тогтсон
өргөөний дотор
Тус тус ямар мэтчлэн баясан цэнгэлийн тавцант ширээндээ
Тууштайгаар насад бат, өнид тогтвортой залрагтун.
Тарни Самади хийгээд мутраар адистидласан
Тахилын чуулган лугаа зохилдох зай, нүдний үзмэрийг
Тансаг газар хийгээд завсарын гэгээн огторгуйн энгээр дүүргээд
Тавьж өргөсөн болой, алиана ч баясан таалж соёрхсуу.
Эрдэнийн уул адил цогцолсон, энгүй далай адил мэлтэлзсэн
Эрхэмсэг элдэв зүйл өвөрмөц идээ ундаа хийгээд
Эрдсийн цуврилгүй рашааныг адистидлан өргөө.
Эгээрч баясан ханахуй сэтгэлийн ханалыг даруй соёрх.
Зүйтэй сайн эм хийгээд сайхан үнэрт элдэв мод
Зүйл зүйлийн зохилдох эд зайг шатаасны үүлэн
Зүдэргүй хүслийн таван эрдэм төгс сан тахилыг өргөө.
Зүй бус гэм алдасын чуулган бүхэн ариусах болтугай.
Онц догшин газрыг ухах, малтах, уул хайрханыг товроглох
Онгон модыг огтлож, догшин усыг хутган булингартуулахыг
Ойшоож эс мэдсэний эрхээр үйлдсэнээ тэнгэр, лус, шивдагуудад
хандаж
Онцгой хор хүргэх, хорлол, харшлалыг арилгахыг өгүүлэгтүн.

Балин тахил, сан тэргүүтэн зохилдох зайг сайтар өргөөд
Бас нигүүлсэхүй лугаа харшлахуй гэмийг наминчлан үйлдээд
Өш хонзонг хариулж санасан явдлыг бүхнээ дүүргэхээр
Өргөсөн болой, аливааг баясган таалаад соёрх.
Янаглан дотносох, асрахуй сэтгэлийг төгөлдөр болго.
Ямагт газар тэтгэгч хаан хүний эрхт хөвгүүн, түшмэлийн аймаг
Буянт хүмүүний нас сүүдэр, мал сүргийн гарз
Бусцар шарнууд, чононцор тэргүүтэн араатны хорлол
Буруу хэрүүл тэмцэл, эвдрэл самуурал, цаг бусын хур бороо
Бусад үл хүсэхүй муу шалтгаан нөхцөл бүхнийг амирлуулж
хайрла.

Энэ хүн зоны насан уртсаж, эд таваарын язгуур үндэс арвижиг.
Эсрэг тэсрэг сэтгэл зохилдон богдосын номд орж
Эрдэнэт мал сүрэг үржин арвидаад үл хорогдон
Эрхин сайн буяны үрийг сав шимийн ерөнцөд арвитгаж хайрла.
Эрхэт сансар нирвааны бүхний сайн чуулган хишиг буян
Эс бүрдэгсэн гэх нь үгүй тул энэ оронд огоот хураад
Элэгт хамаг төрөлхтөн жаргалангийн цогоор насад цэнгэн
Ээлт өлзий хутгийн далай зүг бүхнээ дэлгэрэн түгэх болтугай.

СЭНСЭР БҮЮУ САНСАР УУЛ

Сэнсэр хэмээх уул нь Дорноговь аймгийн Даланжаргалан, Сүмбэр сумын нутагт орших Чойрын Богд уулаас хойш гуч гаруй км-зайтай газарт буй одоогийн Сансар уул болно. Сансар, Чойрын богд, Сүмбэр уул гурав нь бие биеэ харж чандмалан оршино. 1683 м өндөр энэ уулыг Халхын гурван оргилын нэг байж магадгүй гэж газарзүйч эрдэмтэн Ш.Шагдар таамаг дэвшүүлсэн буй.

Сэнсэр: - гэдэг нэр нь хожуу үед Сансар болон хувирав уу, эсвэл Сансар гэдэг нэрийг цээрлэн Сэнсэр болгон хувиргав уу гэдэг нь сонирхууштай юм. Ямар боловч Сансар гэдэг нэр нь самгарди хэлний samsara гэдгээс гаралтай бол Сэнсэр нь төвд хэлний seng ser буюу “Шар арслан” гэсэн утгатай нэр болно. Сэнсэр гэдэг нэрийг санамсаргүй тохиолдлоор өгсөн хэрэг биш, монголчуудын газар шинжих ёстой холбоотой юм. Нутгийнхан уг уулыг хэвтэж байгаа шар арслангийн хэлбэртэй уул гэж хэлэлцдэгийн дээр энэ уулын эзэн, хийморийг эзлэгч нь цээж дээгүүрхэн, дэлээ сагсайлган, шүдээ ярзайлган, буруу талын урд хөлийг урагш жийж хэвтэж байгаа арслан байдаг гэж домоглон ярилцах буй. Ер нь монгол газар усны нэрийн бүрэлдэхүүнд газрын цогцлон тогтсон байдлыг шинжин ан амьтантай адилтган нэрлэсэн зүйл цөөнгүй тааралддаг билээ. Бас зарим онгон догшин газар буюу тахилгатай газрын нэрийг эерүүлж цээрлэн нэрлэх явдал элбэг байсан. Ялангуяа тухайн газар усны сангийн судрыг зохион найруулсан хүн. жинхэнэ нэрийг нь төвдөөр орчуулах буюу өөрчлөн нэрлэсэн тохиолдол бидний цуглуулсан хэрэглэгдэхүүнд цөөнгүй дайралдаж байна. Чухам энэ шалтгаанаар Сансар нэрийг Сэнсэр болгосон бололтой гэж үзэж байна.

Энэ судрыг хэдийд зохиов гэдэг нь тодорхойгүй боловч зохион найруулсан хүн нь бид бүхний сайн мэдэх Сэртог хутагт Лувсанцүлтэм /жамш/ юм. Сэртог хутагт нь Жанжин Чойрын хийдэд байсан Боржигины алдарт ламын нэг бөгөөд хэд хэдэн боть сүмбумтай хүн болно.

SANSAR SACRED MOUNTAIN

Information on the sutra:

The manuscript on this sacred mountain was written by Lama Sertog Khutagt from Janjin Choir Monastery of Borjigin.

Sansar Mountain is located 30 km north of Otsol Mountain, as described above.

The word ‘Sansar’ originates from the word ‘Samsara’ in Samgardi. The word ‘Sanser’ has roots in the Tibetan language, ‘seng ser’ meaning ‘yellow lion’. This translation relates directly to the formation of the landscape, which resembles a dormant lion reclining on the skyline. Mongolian sacred places are often named after animals. There is a tradition to avoid using the actual names for sacred places, as this is believed to bring bad fortune. The authors of manuscripts on sacred sites therefore often translated the Mongolian place-names into Tibetan or Samgardi, or simply renamed the place. Sansar mountain is in this manuscript named Senser Mountain.

Ногад ялгуусан бүхний хурсан нигурын ачийг батшихийгээд
ордноос





Номын агaarын хувилашгүй бигтийн, үлгэрээс хэтрэсэн
жээ,

өвөрчлөн болгоож зургаан тарнийг зургаан мутраар адистидла.
багсган пэнгүүлэх дээд эдийг ариулаад зохист Огторгийн сант
нэрийн эхний үсгийг бинт дуслаар чимэн отоот болгосноор зочдыг
... Хоосон чанарын агаараас тахилын эд, ариусгалын эд тус тусын
болно. О.С.)

сэтгэл явуулахыг энэ завсарт дурдан байгаас сонирхох хүн үзэж
тос тэргүүнтээр чимэн, бас бус сүү тарар, идээ ундаа тавин авралын
онлогоос дэлхийн эздэд өргөх багинт лянхувын навч, дөрвөн үрэл,
тахил өргөхийг хүсвээс нийт зочлод цагаан багинтэй өргөн,
(Ингээд эндэхийн Сэнсэр хэмээх уугаад оршсон шивдэгт ариусгал

Аршаначь дээжээр өглөгийг орныг ханган бичүү;
Ашиг сайн мөрийг үл энгдүүрүүлэх найрызг зохиолч
Асар пөвийн амьтныг бодь сэтгэлээр гэтэлгэхийн
Аяа, Намо гурү Бадама Самбохава хум

СЭНСЭР ХЭМЭЭХ ҮҮГНАА ОРШСОН ШИВДЭГТ САН
ТАХИЛ ӨРГӨХ ЁС ЭРДНИЙН ЭРХИ ХЭМЭЭТ ДЭХ ОРШВОЙ



Энэрэл ихт нийгүүлслийн эрхээр эдүгээ залран соёрх.
 Ялгуусны хөвгүүн, бодьсадва, шарвагууд хийгээд
 Ялагч баатар, дагинас, тангарагтан, сахиулсаны чуулган
 Орны тэнгэр, шивдаг, цагаан зүгийг тэтгэн зохиогч нар
 Одоохон тахил өглөгийн зочноор энд залран соёрх
 Онцолбоос Сэнсэр хэмээн алдаршсан газрыг баригчийн
 Оргилд оршсон шивдаг, эцэг, эх, тойн хөвгүүн
 Олон түшмэл, боол зардас тэр бүхэн
 Онц баяслын бүжиглэлээр энэ орноо залран соёрх
 Жээ,
 Алимд дорнын туурвилаас хагацсан билгийн ид хаваас
 Аяндаа ирсэн тахилын зай, хүслийн эрдэмт
 Үнэн буяны орон хийгээд өглөгийн орон хамгийг
 Үл баримтлан эс тачаасан сэтгэлээр тахин үйлдсүгэй.
 Булингараас хагацсан усаар найруулсан тахил эрдэм
 Буй сангийн зай, цэцэг навч, найлзуурыг жигдлэн өрж
 Сайн хүжийн үнэр анхилагт утаа нь тэнгэрийн мөрт түгэж
 Сан ариусгал бадарсан зулын гэгээн гэрэл гийгүүлж
 Шимт үнэрийн анхилгаар эд баригчид хоцролгүй тархан
 Шидэт сангийн гурил тэргүүтэн идээ зоогийн зүйл
 Яруу аялгуу зохист дуун, хөгжмөөр гэгээн завсрыг дүүргэн
 Яндашгүй эл сангаар тахилын орны бясалгалыг хангасугай.
 Тэнгэр хүмүүний идээ сэлт ундааны шим хурсан
 Тэрхүү амтлаг цагаан сэржим, цай, дарс, мах тэргүүтэн
 Тэнсэлгүй тахилын чуулган балинг уул мэт цогцлуулж, далай
 мэт мэлтэлзүүлснээр
 Тэнгэрлэг дээд орон бүхнийг сүсгээр сайтар тахья.
 Жээ,
 Баримтлалгүй өршөөлт огторгуйн уйл уужмаас
 Багцашгүй дээд хувийн адистид бүтээхийн хурыг буулгасан
 Багш лам, дээд гурав, очирт сахиулсныг
 Бас бие, хэл, сэтгэл гурваар бишрэн мөргөж маггъяа.
 Энэ мэт тахил өглөгийн залбирал тавьсны хүчээр

Элбэрэлт сургаал зарлигийн шашны сайн ёсны тэмдэг оршоод
 Их богдын бие, нас өнид батдахын үйлсийг дэлгэрүүл
 Илтээр хуврагийн номлол бүтээлийг номлохыг сонсон

дэлгэрүүл

Энэ бүхий ертөнцөд чивэлт мууг эс ухаарсны
 Элдэв билэг тэмдэг агшин төдийд ч эс гараад
 Өлзийт жаргал баясгалангийн хурим арвидаж
 Өдгөө бодгалис бүхэн номын явдалд орох болтугай
 Ялангуяа энэ орон зүг болон энэ газар нутагт
 Ям хижиг, хэрүүл тэмцэл, хэл амын зүйл
 Яхир ган, хяруу мөндөр, араатны хөнөөл
 Яавч үл зохилдох онц аюулыг амирлуул.
 Зорилын орны өглөгийн эзэн, хамаатан, аль буй бүхний
 Зол буяны язгуур үндэс, нас буян, цог учрал, эд эдлэл
 Зогсоо дөрвөн хөлт мал, дөрвөн аймгийн эд эдлэлийн
 Зохилдохуй хамаг нөхцлийг арвитган дэлгэрүүлтүгэй.
 Товчилбоос онгон догшин шивдаг та бүхэн
 Тон хар зүгийн шимнусын аймгийн самуурсныг ариусган
 Тод цагаан зүгийн сайтар ялгуусан элдэв хүслийг бүтээх хурыг
 буулга

Тонж өлзийт цогийн хишиг буяныг арвитган хайрла

хэмээсэн умар зүгийн Халх сэцэн ханы Жанжин бэйлийн газар Сэнсэр
 хэмээх ууланд оршсон шивдагт сан тахил өргөх ёсон эрдэнийн эрхи
 үүнийг язгуур овгийн хотол гурван чуулганы сүсгийн хүчээр илтэд
 өндөр тайж Дашцэрэн-бээр Лхазай лугаа сэлтээр дурдсаны урмаст
 сэртог Номун хан Лувсанцүлтэмжамц Жанжин Чойрын Лочинлинд
 найруулбай.

БАЯНТӨХӨМИЙН НУУР

Баянтөхөмийн давст нуур нь Улаанбаатараас баруун өмнө зүгт 210-аад км-т, Төв аймгийн Бүрэн сумын төвөөс өрнө зүгт 2-3 км зайтай газарт оршино. Энэ нуурын сангийн судрыг олонд туслахын сэтгэлтэн гэлэн Лувсанцэрэнгийн хүссэний дагуу Мишиг гүний хүрээн дэх Норовчойнпиллинд Зава Дамдин заларч ахуйдаа зохиосон ажээ. Судрын төгсгөлд шашин амьтны тусад эмийн эрдэм чадал нь төгс болтугай гэсэн адис ерөөл тавьжээ.

Судрын эхэнд уг рашааны нуурыг хэрхэн тахих зан үйлийг дэлгэрэнгүй өгүүлжээ. Юуны өмнө Жанжаа хутагт Ролбийдоржийн лусын балингийн зан үйл, эмт усны чанарын талаар сануулаад энэ нуурын хөвөөнд аль сэтгэлд зохистой газарт хор бузрын зүйлгүй гурван цагаан идээ, гурван зүйл амттан зэргийг галд өргөөд гүн сүсэглэл үүсгээд улаан үнээ цагаан ямааны сүүг ваар саванд дүүргээд мах цус, хүдрийн заар зэргийн үнэр эс шингэсэн ариун балинг цогцлуулж тавих ба авралын сэтгэлийг цаглашгүй дөрөвт үйлдэх тэргүүтнийг дурдсан байна. Энэ нуурын эзний байдал төрхийг өгүүлэхдээ саран лянхуат тавцан дээр заларсан хөх өнгийн биетэй, нэгэн нигуур, хоёр мутартай, дээд өглөгийн баруун мутартаа арурын голыг барьж, тэгш агуулахын зүүн мутартаа рашаанаар дүүргэсэн бадар аяга барьсан, номт хувцас эгэлдэрэглэсэн, очир завилалаар суусан баатар ажээ. Мөн ямар тарнийг хэдэнтээ уншихыг дурдсан байх ба өөрийн юу санасан хэрэг бүтэхийг сэтгэлдээ бясалган өгүүлэхийг чухалчлан дурд гэжээ.

Эндээс сангийн судар нь эхэлж, эцэст нь номын өглөг үйлдэхийг сануулаад, чингэснээр энэ уснаа оршсон лусууд хорхой шавьж тэргүүтний хилинц нүгэл арилаад эмт усны чадал нь улам улмаар арвидан шүтэн биширсэн хүмүүсийн архаг өвчнийг илааршуулахын тулд Огоч Манла, Лүваанжалбо, Хутагт дээд Арслан дуут /буюу Сэнгээдаа/ тэргүүтнийг болон Ялж төгс нөгчигсөн тэргүүтнийг дурдаад оточ Маналын биндэрьяагийн гэрлийн хаанд мөргөж тахиад авралыг хүсэмжилжээ. Бас залгуулаад ямар тарнийг

хэдэнтээ уншихыг дурдсанаас нэгийг буулгавал ийн буюу:

Ом татхаа гата бхагаваан наага рааза ишвара адхиштхан тэ суухаа /Ом ялж төгс нөгчигсөн бурхан, лусын хаан, Ишвар соёрхож адис хүртээ/.

Мөн энэ үед Бурханы бодь сэтгэл, тэдгээрийн гэрлийн хувиас рашаан ба гэрлийн чуулган цаглашгүй гарах болоод тэр эмт нууранд шүтсэн бодинарын биед шингэснээр эмт усны хүчин чадал улам нэмэгдэн амьтан хүний өвчин зовлон, энэлгэ шаналга хийгээд түүний уг шалтгаанаас нисванисын бузрыг арилган бие болон сэтгэлийг цуврилгүй, амгалан төгс болгохыг соёрхжээ. Дээр дурдсан зан үйлсийн зүйлийг цөмийг орчуулсангүй, гол агуулгыг дурдаад сангийн уншлагыг орчуулав.

Сүүлийн үеийн эрдэмтдийн судалгаанаас үзвэл энэ нуурын ус шавар нь арьс өнгөний өвчтэй хүнд тустай ажээ. Судрыг зохиогчийн тэмдэглэснээр бол арьсны өвчин, өмхий хатиг, боом, уяман, мухар мунгас, тулай хэрэх зэрэг өвчинд тустай гэсэн байна. Зава Дамдингийн эл судар түүний зохисон бусад судраас ялгаатай нь Баянтөхөм нуурыг тахихад үйлдвэл зохих зан үйлийн зүйлийг дэлгэрэнгүй оруулж, ямар ямар өвчинд тустайг өгүүлсэнд оршино. Үүнээс үзвэл зохиогч энэ рашаант нуурыг ихэд сонирхон судалж, өндөр үнэлж байсны баталгаа гэлтэй.

Эцэст нь энэ нуурын нэрийн тухайд авч үзэхэд Зава ламын үед Баянтөхөм нэртэй байсан нь тодорхой байна. Харин сүүлийн үед Их төхөмийн нуур гэж ном бичигт үзэгдэх болсон нь Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутагт /у.ө. 46⁰45', д.у. 104⁰31' /д.т.д, 1452 м өндөрт орших Бага Төхөмийн нуураас ялгахын тулд ийн нэрлэсэн бололтой. Үүнээс гадна зөвхөн Төхөмийн нуур гэж нэрлэж байсныг өөр нэгэн сангийн судраас мэдэж болно. Төхөм гэдэг нэр нь хонхор хотгор гэсэн утгатай билээ.

BAYANTUKHUM SALT LAKE

Information on the sutra:

The text was written by the great scholar and philosopher, Zava Damdin, at the request of Bikkhu Lama Luvsantseren.

In the introduction to the sutra-manuscript, detailed instructions are given on how to perform the worshipping rituals for the lake.

The sutra describes the deity of the lake having a blue colored body and her two arms are extended. The deity holds in one hand the Arura tree and in the other, a bowl with water from the lake.

Bayantukhum Salt Lake is located 210 kilometers to the southwest of Ulaanbaatar in Buren Soum, Tuv Province.

The lake was recently renamed Ikh Tukhum Lake in order to distinguish it from Baga Tukhum Lake, also situated in Tuv Province, 'tukhum' meaning a gully or ravine.

༄། ལྷ་ཡན་རྩེ་དུ་མཚེས་པའི་ལན་རྩེ་རྒྱུ་རྒྱུ་གནས་པའི་ལྷ་རྣམས་ལ་
བསའ་མཚོ་དབྱེ་ལྷ་ལ་བདེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་
བཞུགས་པེ།

༄། ལྷ་ཡན་རྩེ་དུ་མཚེས་པའི་ལན་རྩེ་རྒྱུ་རྒྱུ་གནས་པའི་ལྷ་རྣམས་ལ་
བསའ་མཚོ་དབྱེ་ལྷ་ལ་བདེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་
བཞུགས་པེ། ལྷ་ཡན་རྩེ་དུ་མཚེས་པའི་ལན་རྩེ་རྒྱུ་རྒྱུ་གནས་པའི་
ལྷ་རྣམས་ལ་བསའ་མཚོ་དབྱེ་ལྷ་ལ་བདེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་
བཞུགས་པེ། ལྷ་ཡན་རྩེ་དུ་མཚེས་པའི་ལན་རྩེ་རྒྱུ་རྒྱུ་གནས་པའི་
ལྷ་རྣམས་ལ་བསའ་མཚོ་དབྱེ་ལྷ་ལ་བདེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་
བཞུགས་པེ།

༄། ལྷ་ཡན་རྩེ་དུ་མཚེས་པའི་ལན་རྩེ་རྒྱུ་རྒྱུ་གནས་པའི་ལྷ་རྣམས་ལ་
བསའ་མཚོ་དབྱེ་ལྷ་ལ་བདེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་
བཞུགས་པེ། ལྷ་ཡན་རྩེ་དུ་མཚེས་པའི་ལན་རྩེ་རྒྱུ་རྒྱུ་གནས་པའི་
ལྷ་རྣམས་ལ་བསའ་མཚོ་དབྱེ་ལྷ་ལ་བདེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་
བཞུགས་པེ། ལྷ་ཡན་རྩེ་དུ་མཚེས་པའི་ལན་རྩེ་རྒྱུ་རྒྱུ་གནས་པའི་
ལྷ་རྣམས་ལ་བསའ་མཚོ་དབྱེ་ལྷ་ལ་བདེ་རྩེ་རྩེ་རྩེ་རྩེ་
བཞུགས་པེ།

**БАЯНТӨХӨМ ХЭМЭЭХ ДАВСАН ЭМТ УСНАА
ОРШИГЧ ЛУСЫН ЯЗГУУРУУДАД АРИУСГАЛ ТАХИЛГА
ҮЙЛДЭХ ЁС РАШААНЫ ҮРЭЛ ХЭМЭЭГДЭХ ОРШВОЙ**

Намо гүрү бхайша зьез раа зааяа.

Тэмдэг билгийн төдий дурдан санахуйн сэрүүн гэрлээр

Тэсрэг ужиг халуун өвчний энэлгэ бүхнийг амуусгах

Тэнгэрлэг эмийн бурхныг дээш дээшид хүндлээд

Тэнхрүүлэх эмт усны лусыг тахих зан үйлийг бичсүү...

Намо,

Өнид авралын орны хуурмаггүй багш дээд гурав

Өөсөөн ялж төгссөн эмийн багшийн нууц гурвыг

Өөрөө шүтсэний хүчээр эндэхийн тэнгэр, лус, хүмүүн бүхний

Өгөөмөр сэтгэлд зохилдох ном мэт явдлын их адистадыг

буулга.

Сүр жавхлант цэнгэлийн долоон далай лугаа сэлтэст

Сүлдэн орныг зассан хур усны эзэн Варуна

Сүслэн баясахуйн шадар баясгалант их найман лус тэргүүтэн

Сүмбэр ертөнцийг тэтгэгч лусын язгуур хамгийг

Хотол замбуулингийн цогноймолтын эзэн Мапам далай

Хосгүй ялгаварт түвд, монголын орноо оршсон лусын чуулган

Хамгаас онцгой ба бүрний суусан энэ зүгийн орны

Хатан давст рашаан Баянтөхөм тэргүүтэн

Нуур далай, гол мөрөн, нүдэн булаг, цөөрөм бүрд

Уул хад, энхжингийн модноо оршсон

Дөрвөн язгуурын хамаат догшин лус хоцролгүй

Тэргүүлэшгүй ирд хувилгааны хүчээр энд залрагтун.

Сэрүүн тунгалаг тахил эрдэм, цагаан цэцэг

Сэнгэнэм улаан, цагаан зандан, хүж, зул

Сэндэн гавар, үнэрт ус, зуун амтат идээн хийгээд

Сэтгэлд яруу аялгуу цэнгэлээр ариулж тахин үйлдье.

Бас гурван цагаан, гурван амтат идээ ундаан

Балингийн чуулган, элдэв олон эрдэнэ тэргүүтэн баялаг эд

агуурсыг бодитой бэлтгэн сэтгэлээр хувилгаснаар

Байгаа лусын хааны нөхөд сэлт баясан цэнгэх болтугай.

Олноос онцгой сайн эмийн найрлагыг зуунтаа

Охь үнэрээр анхилуулснаар элдэв утаан үүл нь

Осолгүй үхэлгүйн мөр бүхнээ огоот түгсэн үүгээр

Омог догшин савдаг хийгээд лусыг үлдээлгүй сагнай.

Ухах сэндлэх, хиншүү хярвас тавих, мод огтлох,

Ус буртаглах хот орон бас тарианы газар эвдэж гэмтээх

Бусдыг дарах, жатга хийх, арга бачлах, ам хаах

Бусцар ямар хорлол оршсныг сагнаснаар ариусах болтугай.

Бузар түйтгэр, өс хонзон, эдийн бузар

Бус бас улаан бузар, идээний бузраас үүдэн гарах

Цул сав, үс гишүүн, арьсны элдэв өвчин

Сахуу, боом, уяман, мухар мунгас, тулай хэрэх

Лусын өвчин бүхнийг сагнаснаар ариусах болтугай.

Урьдын болзорын эндүүрлийн гэм алдаа юу оршсон

Уугих сан тахилын дээд үүгээр ариун болготугай.

Эдүүгээгээс атаа хилэн, атгаг найдангуйг эс зохион

Эгнэгт егзөрийн эрдэм тахил бүхнийг нөхцөлдүүлэн зохио.

Хүмүүн малын халдварт өвчин, гарз гарлагыг тасал.

Хяруу мөндөр, ган зуд, хөлчин хан адын хорлолыг сахь.

Хар тарнийн хороор муу муухайг гэсгээн дарж соёрх.

Товчилбоос гадаад дотоод хүчир гамшигийн үйл бүхнээс салга.

Үүрдийн таван чухаг эдлэлийн цэнгэл, ашдын цааз засаг

батдаад

Үндэс язгуурын багшийн мэлмийн дэргэд ам аваад

Үзтэл Ядмын хот мандалд бошгыг тангарагласан мэт

Үнэн ном төгс үйлсийг бүтээхийг эс алгасруулагтун.

Ялангуяа батадсан зуйгар зальт хорт өвчнөөр будангуйрч

Давст усанд дэвтэх амьтныг нигүүлсэн өршөөснөөр

Рашааны эмийн чадлыг ихэд үүсгээд

Өвчнөөс хагацаан баясгалант амгалангийн өршөөлийн үйлсийг

бүтээ

Хүн малын идээ, эд буяны далай мэт бялхаад
Хур жаргалангийн баяслын лянхувын цэцэрлэг мөшөөхүйн
төвд

Номын барилдлага, балаар согтоогч зургаан хөлт
Яруу алдрын дуун эгшгийг авахын өлзийг хайрла.

...Эмүүдийн хүчин лүгээ төгс ба

Нууц тарниас эхлэн өгүүлэн бүтээх болтугай.

Догшин лус, мангас тэргүүтэн

Нигүүлсэхүй сэтгэл төгөлдөр болтугай.

Бодгалийн өвчин ямар байлаа

Түргэн зуур түүнээсээ салах болтугай.

Амьтны өвчнийг огт үл үлдээж

Ашид гаргахгүй байх болтугай.

Муу явдал зовлонг эс амсаад

Бэрх хатуу явдалгүй боловч

Үзлээр сонин бие нь

Тэдгээрүүд нь түргэнээ бурхан болтугай.

... Дээдийн сургаал рашааны хувийг

Хамтатгасан лусын тахил, эмийн үрэл үүгээр

Хамаг төрөлхтнөөс зовлонгийн өвчнийг нь арилгаад

Үхэл үгүй баясгалангийн хуримыг түгээх болтугай

хэмээх Баянтөхөм хэмээгдэх давст рашаанаа оршсон лусын
язгууруудад ариусгал тахил үйлдэх ёс рашааны эмт үрэл хэмээгдэх
үүнийг бусдад туслахын санаатан тэтгэгч гэлэн Лувсанцэрэн-бээр энэ
мэт чухаг хэмээн маш цагаан хадаг ба мөнгө танга цэцэг... дурдсаны
урмаст Шагжийн тойн дүрст Жамъянжэйвийшэйнин /Зөөлөн
эгшигтийг баясгах билгийн садан. О.С/ -бээр номын хүрээ
Норовчойпэллингийн ойролцоо эмт усны мөн чанарыг шүтсэн үестээ
найруулвай.

ОНГИЙН ГОЛ




Модон бараар хэвлэсэн энэхүү судар нь есөн хуудастай бөгөөд гаргац сайтай юм.

Эл судрын төгсгөлийг үзвэл Түшээ гүний хошууны хар, шар олны хүсэлтээр Бари лам Дамцагдорж зохиосон ажээ. Энэ хүн Дэлгэрхангай уулын сангийн судрыг зохиосон ба уг судрын орчуулгын тайлбарт дурдсаныг үзмүү.

Хээр талын болон говийн бүсийн олон сумын хүн малын ундны усны хэрэгцээ хангадаг голын нэг нь Онгийн гол юм. Энэ гол нийтдээ 45 салаагаас эх авдаг гэсэн тооцоо бий.

Онгийн гол нь Хангайн гол нурууны өмнөд хажуугаас эх авч 435 км урсдаг юм. Арвайхээр хот хүртэл уулсын дундуур урсч, Арвайхээрээс урагш тэгш талаар урсана. Бороо хургүй жилд Сайхан-Овоо хүрэлгүй ширгэдэг гэнэ.

Өвөрхангай аймгийн Уянга сумын нутаг нь Онгийн голын нэг сав газар бөгөөд Мааньтын бүрдэнд 50 гаруй мөр бичигтэй Түрэгийн хөшөө бий. Энд 730-аад оны үйл явдал бичигдснийг судлаачид тогтоожээ. Онгийн голын эхэнд дээр үед онгитой чулуу байсан гэх ба тэр онгин дундуур уг гол урсан гардаг байснаас ийн нэрлэх болсон гэнэ.



Handwritten Mongolian script on a rectangular fragment.

Handwritten Mongolian script on a rectangular fragment.

Handwritten Mongolian script on a rectangular fragment.

Handwritten Mongolian script on a rectangular fragment.

ИХ ГОЛ ОНГИЙН ТЭРГҮҮТ ОРШСОН ЛУС САВДАГИЙН
ЗАЛБИРАЛ, ТАХИЛ, САЙН АМГАЛАН БҮХЭН ГАРАХУЙ
ХЭМЭЭГДЭХ ОРШВОЙ

Намо гүрү ратна траяая.
Эндэхийн Их Монголын ялгуугсан орон умар зүгийн Халх
нутгийн төв хүйс энх жаргалант их мөрөн Онгид оршсон Лус
болон савдагуудад залбирч тахихуйг хүсвээс ... гэж эхэлсэн энэ
сударт ямар ямар идээ будаа бэлтгэж, яаж хэрхэн тахих зан
үйлийг дэлгэрэнгүй өгүүлсэн байна. Үүнийг сонирхоод лавдан
уншмуу.

Handwritten Mongolian script on a rectangular fragment.

Сайн амгалан гарахуй орны язгуур, үндэсний багш хийгээд
Сац бас хуурмаггүй чухаг дээд гурав болон Ядам тэнгэр
Саад тотгодын омгийг даран зохиогч номын сахиулсан
чуулганууд

Сааталгүй эдүгээ энд өлзийт сайн буяны их адистидыг буулга.
Энэ замбуулингийн умар зүгийн Монгол орны их нутгийн
Эх газрын хотол чуулганы өлзий хутгийн
Эрхт арван буяны цог төгөлдөр Хангай хэмээн алдаршсан
Эрхэмсэг жавхлант ялгуугсан өмнийн уулын цэнгэлээс
Алгуурхнаар буугч сэрүүн тунгалаг мөрний урсгал
Агуу ихийг барилгүйгээр өнөд шалтгаалж
Асар дэлгэр мөрний олом бүхнийг ч тэвчсэн орон, намаг зүлэг
Амт шимийн эм, ой цэцэрлэг, цэцэг навчис олноор хурснаар
Үзтэл халуун хүйтэн өвчин хийгээд эвэршээл зовлонгийн
язгуурыг арилгаад

Үхэлгүй амины шим авахуулах рашааны шидээр
Чинхүү их төрөлхтөн дээд олноороо адистидлаад
Чингис хааны ургийн тэнгэрээр тэтгэн зохиосноор
Хотол чуулганы барилдлагаар хэзээ ч эс мухардаад
Хосгүй төр, шашны сайн буян арвидахын өлзий оршиг.
Орон хийдийн бурсан хуврагийн олон аймаг орны
Онц барилдлагат хаан, түшмэл, харцас нарыг чухал шүтсэнээр
Орон нутгийн замд орж хээр явахад айл гэр бүхэнд
Огт үл зохилдох хөнөөлөөс хагацаж, үл аюулгах өглөгийн цогт
Үнэхээр олон хамаг төрөлхтөний амар амгалангаар гол шүтээн
баягоод

Үзэмж уужим газар дэлхийг үзэсгэлэнтэй үйлдэн чимэгч
Онги их, шар мөрөн гол
Орны зүг бүхнээ яруугаар алдаршсан түүний
Эх адаг гурван завсар бүхнээ эрхшээгээд
Энэ шүтээний орон сэлт тахин шүтээд бэлдэхийн
Рид хувилгааны хүчин төгс цагаан зүгийг тэтгэгч эрхт
Их усны эзэн, лусын хаан эцэг, эхийн нэрт охин дүү

Эрхэм хөвгүүн, түшмэл нөхөд, зарц элч, лусын чуулган
Энэ газар орныг эрхшээн үйлдэгч савдаг, бошиг сэлтийг
Эрдэмт тахил өглөгийн энэ орноо энэлэгсэд урин залбаас эл
Эрхт үгүй дүрвэлгүй зочлон, баясгалангийн ёсоор оршигтун.

Өөрийн дурын мутрын тэмдэг лүгээ сэлт: Ом батали батали махаа
батали хум хум за за сухаа хэмээн гурвантаа өгүүлээд: Ом аагазца
махаануга адхи батаеэ сарва бхүрбхү ува бхрүм бхрүм сухаа хэмээн
өгүүлээд тэдгээрийг ирүүлэхэд: Бадма гамалаеа стам гэх.

Ая,
Ялгуусны шашинд машид баясаад
Ялгуум их хүчит рид хувилгааны хүчин төгссөн
Ягчис лусын хааны нөхөд лүгээ сэлтэд
Яруу зохилдох тахилын зай өргөх нь:
Өгөөмөр эмт ус, ариун тавигийн усан хийгээд
Өнгө зүс үзэсгэлэнт сайн хэвтэй цэцэг, цэцэрлэг
Үнэр сайтай хүж, эмийг шатаасны анхилаг
Үлэмж сайн саран, наран, эрдэнийн зулын гэрэл
Хүслэнт гавар гүргэм, сүрчсэн зай
Хүмүүн болон тэнгэрийн идээ сэлт, уух ундааны зүйл
Яруу сонсголонт аялгуу, сэтгэлд зохист хөг дуун
Яндашгүй хүслийн таван эрдмээр тахъя
Увайгүй өвчин болон муу заяаны зовлон арилгах эмийг
Улаан үнээ, цагаан ямааны сүүгээр найруул.
Ой шугуй, зүлэг төхөм, цэцэг навчсын дуртмал өнгө
Олон нуур усан, цөөрөм бүрд, булаг шанд, их мөрөн
Онгон уул хад, тал газар, даваа гүвээ, хонхор төхөм
Ой цэцэрлэг, сайхан орд, угаалын бүрд
Онцгой сэтгэлчлэнгийн эрдэнэ биндэрьяа
Одон бадмаараг, маргад, бор ногоон оюу
Очин болор шил, алмааз, алт мөнгө
Оюу, сувд, шүр, сий эрдэнэ, чон эрдэнэ, лавай дун
Тансаг эрдэнийн чимгийн зүйл, цэцгэн эрхи
Тавцан ширээ, дэвсгэр, шүхэр лаври, туг дуаз, манжлага зэлэм

Өөр бусад хэрэг хоёртоо бүтэх болтугай хэмээх ба:

Чухаг дээд гурвын үнэн лугаа

Бурхан хийгээд бодь сэтгэл адистид ба

Хоёр чуулганыг огоот төгссөний их буян хишиг лугаа номын агаар сайтар ариусаад санаж сэтгэшгүйн хүчээр догшин лус, савдаг бүгдийг огторгуйн тэгтрээ ба ялгамжаат халуун хийгээд гал, мэс, эд зайг барилдуулан Муусын аюул, өвчин бүгдээс хагацуулж, бие, хэл, сэтгэл гурвыг энх эсэн амгуулж, хотол гурван чуулган лугаа төгөлдөр болтугай.

Түүний хүчээр энэ орон зүгийн газарт өвчин, хорлол, хөнөөл өнөд эцэслэн амирлаад, сав, шим ертөнцийн ерөөл талбиад үнэн хүчээр өгүүлсүгэй.

Түүнээ дэлгэрүүлбээс:

Огторгуйн уудамд өлзийт сайн гариг одон гараад

Газрын уужимд түмэн шүхэрт нарны гэрэл гийж

Завсарт нь хүмүүний эд баялаг, орд харш, хөрөнгө зоорийг

агуулаад

Гайхамшигт өлзийт буяны энэхүү дээд оронд

Эсрүн, Хормуст, Лусын эрхтэн, Ягчис болон

Эрхин хүрдэн эргүүлэгч тэргүүтэн энэ сансарын илэрхий өндөр

язгуурын

Эргэх нас цог, буян заяа, есөн хүслийн эд эдлэл

Энгүй цог учрал, яруу алдар, хишиг буяныг нь соёрх.

Ялгусан шашин дэлгэрээд шашныг баригчийн насан сүүдэр

батдаж

Хуврагуудын тоо олшроод сэтгэлд зохист номлол бүтээл

дэлгэрэн

Хаан, түшмэл, харлиг иргэдүүд энхжин жаргаж хишиг буян нь

өндөрсөж

Бүх л сэтгэл ном-дор зүгийн сайн буяныг соёрхон хайрла.

хэмээн өгүүлээд хишгийг дуудан үйлдсү.

Түүгээр игчааг өгүүлж олз эс олох огоот эс мэдэл хэмээх тэргүүтнээр

гэм алдалыг хүлцэн соёрхохуйд тахил өглөгийн оронд дуудсан зочид бүхэн баясан ханаад тус тусын орноо залрагтун.

Жич бас цагтаа морилж орны эзэн тэргүүтэний юу хүссэн хүсэл эгээрэл, өмөг садан, хань хамсааг зохио.

Ом-Махаа нааг адхи пати бхүми пати сабари вара газца. Лус хийгээд савдагийн нөхөр сэлт өөрийн орондоо залрах болтугай. Завсарт нь санахуй:

Хуурмаггүй авралын орны багш чухаг дээд гурав

Хүчин төгөлдөр сахиулсан, тэнгэр лус, шивдагийн

Хотол чуулган тийн цагаан буяны билэг тэмдгээр

Зүг, цаг бүхэнд түгэхийн ёлзий орших болтугай.

хэмээх тэргүүтэн өлзий хутгийн аль болох зохистойг нь өгүүлснээр хязгаарыг чимэн үйлдтүгэй. Ариусгал залбирал үүнээс хураахын төдий үйлдвээс: тарни болон шүлэглэсэн ба үргэлжилсэн бүгдийг чимээд бас дан шүлгээр ч эвлүүлэн үйлдэж ч болох болой хэмээсэн үүнийг Чингис хааны алтан ургаас заяат агуужим их газрыг сахигч хүмүүний эрх, буяны хүчээр илэрхийеэ өндөр Түшээ гүн далай дайчин хошууны лам, ноён, шар, хар нийт олноос дурдан сануулсанд шүтэж язгуурыг баригчийн тойн дүрст Дамцагдорж-бээр их мөрөн гол түүний хөвөөнөө буухуйд найруулсаны сайн буян аригдаг. Луваанжалбын (Лусын эрхт хааны)тарни, тогтоол нь: Тадьяатхаа. Дхаарани дхаарани. Уддхаарани. Сампра тиштха тиби заяа барна. Сагъяа прати.

Зьнаана пати. Үтпата ниби наамани. Абхишиньзани. Абхи бьяахаар. Шүбхаа бити. Азимару. Ээ хи күмбаана. Бааха хэра клээшаана. Дхүна баапама. Шодхаа. Мангана. Бираахэка дхармата шуддха. Лока бити мати рааза садху хашамана сарва Буддха аблохана адхишти празьяня зьянаана бхээ суухаа хэмээх болой.

ДЭЛГЭР МӨРӨН

Дэлгэр мөрний сан нь хоёр хуудас бөгөөд их төлөв өөр бусад олон уул усыг дурдсан сантай хамт явдаг. Энэ нь Засагт хан аймгийн Хотгойд таван хошууны нутагт багтах Дэлгэр мөрний сан болно.

Монголын энэ алдарт мөрний савд эх оронч шадар ван Чингүнжавын дурсгал мод, овоо, Баянзүрх, Хулгана уул, Наран уул, Зүлэгтийн голд бичигт хөшөө, Бэлтэс, Хядагын гол, Уушгийн өвөрт буган хөшөө зэрэг түүх дурсгалын зүйл цөөнгүй бий. Мөн энэ мөрний сав Арбулаг сумын нутгаас 1953 онд Мөнххааны гэрэлт хөшөө олдсон билээ. Дэлгэр мөрний тухай олон сайхан дуу шүлэг бий.

Тухайлбал:

Дэлгэр мөрний хөвөөнд нь
Дээдийн жаргалыг эдэллээ би.
Мөдхөн эргээд ирнээ гэж
Мөрөнгийнхөө чулуунаас авлаа...

гэж яруу найрагч Ч.Дагвадоржийн зохиосон сайхан дууны шүлэг бий. Уг сангийн судрыг зохиогч Балганшадвийдорж нь Зуугийн лам Дагвадаржаа болно. Энэ судрыг доктор, профессор Л.Хүрэлбаатар Хөвсгөл аймгийн Мөрөнгийн хурлын лам 85 настай Жигжидсүрэн гуайгаас буулган авчирсан болно.

DELGER MORON SACRED RIVER

Information on the sutra:

The sutra was written by Lama Dagvadarjaa in tribute to one of Mongolia's longest sacred rivers. The original manuscript is kept by Lama Jigjidsuren in Khovsgol Province.

The Delger River is a tributary of the Selenge River and has an estimated length of over 440 kilometers. Smaller rivers such as Beltes and Bugsei contribute to Delger River.

The Delger River basin is rich in historic finds. The discoveries include a memorial sacred tree dedicated to an honorary nobleman, Chingunjav, who fought for Mongolia's independence, several memorial plates inscribed with traditional scripts, and stones depicting images of deer and other animals.

ᠲᠡᠭᠡᠷ ᠮᠥᠷᠨᠢЙ ᠰᠠᠨ ᠣᠷᠰᠬᠣЙ
 ᠲᠡᠭᠡᠷ ᠮᠥᠷᠨᠢЙ ᠰᠠᠨ ᠣᠷᠰᠬᠣЙ
 ᠲᠡᠭᠡᠷ ᠮᠥᠷᠨᠢЙ ᠰᠠᠨ ᠣᠷᠰᠬᠣЙ
 ᠲᠡᠭᠡᠷ ᠮᠥᠷᠨᠢЙ ᠰᠠᠨ ᠣᠷᠰᠬᠣЙ

ᠲᠡᠭᠡᠷ ᠮᠥᠷᠨᠢЙ ᠰᠠᠨ ᠣᠷᠰᠬᠣЙ
 ᠲᠡᠭᠡᠷ ᠮᠥᠷᠨᠢЙ ᠰᠠᠨ ᠣᠷᠰᠬᠣЙ
 ᠲᠡᠭᠡᠷ ᠮᠥᠷᠨᠢЙ ᠰᠠᠨ ᠣᠷᠰᠬᠣЙ
 ᠲᠡᠭᠡᠷ ᠮᠥᠷᠨᠢЙ ᠰᠠᠨ ᠣᠷᠰᠬᠣЙ

ᠲᠡᠭᠡᠷ ᠮᠥᠷᠨᠢЙ ᠰᠠᠨ ᠣᠷᠰᠬᠣЙ
 ᠲᠡᠭᠡᠷ ᠮᠥᠷᠨᠢЙ ᠰᠠᠨ ᠣᠷᠰᠬᠣЙ
 ᠲᠡᠭᠡᠷ ᠮᠥᠷᠨᠢЙ ᠰᠠᠨ ᠣᠷᠰᠬᠣЙ
 ᠲᠡᠭᠡᠷ ᠮᠥᠷᠨᠢЙ ᠰᠠᠨ ᠣᠷᠰᠬᠣЙ

ДЭЛГЭР МӨРНИЙ САН ОРШВОЙ

Жээ,
 Дэлгэр мөрний их эх, хөвгүүн, түшмэл болон
 Дэргэд хамт төрсөн тэнгэр мангас, дэвжид, шивдаг
 Аяндаа барилдаж, сэтгэлээр хувилсан чуулганыг таалаад
 Азарган бороо, аянга мөндрийн хорлолыг амуусган зохио.
 Алтан хайлмал эргэлдсэн билгийн галын дотор
 Агар зандан, арц хүж, элдэв үр жимс хийгээд
 Арвай замар тэргүүтнийг шатаасан утаан үүл үүгээр
 Агуу их мөрний нөхөд сэлтийг утан ариусгая
 Энэ зүгийн орны лусын хаан, савдгийг ариусгая.
 Эл гурван цагаан идээ, цай сүүн тахил өргөхүй хэмээвээс
 Бид бүхний багш шавь, эрдэмт тахил, нөхөд сэлтийн
 Ад өвчин, гай барцад амирлаад, нас буян дэлгэрэг
 Малын өвчин, чонын хөнөөл, хулгай дээрэм, гарзын амыг
 Машид авран сахиж, дээдийн өмөг садан болж хайрла
 Магадтайяа эл орноо ган зуд, хяруу мөндрийг номхотго.
 Мал сүргийн өвчин, араатны хорлолыг амирлуулж хайрла.
 Их цас, зудын аюулаас зайлуулж амуутга.
 Илтэд тэр мэт асарваас зуурдын тэнгэр, чөтгөрийн хөнөөл
 Ивээлгүй өвчин хижиг, хамуу нясуу, боом нөрөө
 Ирэх ган, зудын хорлолыг амирлуулан соёрх.

Язгуур ухааныг баригч Балганшадвийдорж нэрт-бээр найруулав.
 Өлзий хутаг орших болтугай.

ОНОНГИЙН ХАЛУУН РАШААН

Энэ судрыг Шашны дээд сургуулийн багш, төвдөч Ш.Сонинбаяраас буулган авав. Судрын төгсгөлийн үгээс үзвэл дотны шавь Пражня киртийн дурдснаар бигшү Сумадирасми Ононгийн халуун рашаанд байх үестээ бичвэй гэжээ. Нэрээ самгардиар орчуулдаг уламжлалыг харгалзан Пражня кирти хэмээх самгарди нэрийг төвдөөр буулгавал Шаравдагва, Сумадирасми нь Лувсан-Од болно. Ононгийн халуун рашаан нь ямар ямар өвчин эмгэгийг илааршуулдагийг энэ сангийн сударт дурдсан нь нэн сонирхолтой байна.

Ононгийн рашаан нь Хэнтий аймгийн нутагт Онон голын эхэнд (з.у. 108° 49, х.ө. 48° 56) д.т.д 1950 м өндөр оршино. Хорь гаруй булаг бүхий энэ рашаан ой, хөвч, сүрлэг уулсын дунд орших тул хүрч очиход багагүй саадтай.

Ононгийн рашааныг тахирын тулд Мапам далайд оршсон лус савдгийг эхлээд урин залж байна. Монголын алдарт гол, нуурын сан болон цацал мялаалгын үгэнд Мапам далай, Анавад буюу Анамад далай гэсэн нэр элбэг тааралддаг. Үүний баримт болгож аман ба бичгийн зохиолоос хэдэн жишээ авъя.

Мапам их далайн дундах

Матар загасны ходоодоор хийсэн
цавуу (1-60) гэх буюу:

Элдэв эрдэнэсээр цогцолсон Сүмбэр уул минь

Энд тэндээс олон мөрөн цугтгасан

Анабад далай минь (1-63)

Эс билидүгсэн (гатлах) давлага ихт Мапам далай минь

Элдэв жаран жигүүр лүгээ төгссөн их хүчит гарди минь(1-94) гэх мэтэд байгаа нэрс нь цөм нэг л далайн (нуурын) нэр болно. Анамад далай нэрийг зарим эрдэмтэн “Каспийн далайг төвдөөр Мапам (тө. ma pham) гэх ба Энэтхэг хэлэнд Анабад гэж хэлдэг. Монгол ардын аман зохиолын зүйлд Анамад болж орсон байна” (2-138) гэж тайлбарлажээ.

Анабад далайг төвдөөр Мапам гэдэг нь үнэн. Анамад нь

самгарди хэлний Анабад бус Anavatapta гэдэг нэрийн хураагдсан хэлбэр. Энэ нь Каспийн далай биш. Сарат Чандра Дас: “ma-phang, ma-pham, ma-dras pa” гэж бичээд Маансароовар нуур, Кайлас уулын өлмийд орших хоёр жижиг нуурын нэг mtsho ma pham (Мапам далай) ч гэж нэрлэнэ. (3- 947) гэсэн байна.

Мөн “Энэтхэгийн түүхэн газар усны толь”-д шүүрдвэл: “Эртний нэр нь Брахмасар (Брахма нуур), энэ нуураас Энэтхэг болон Дундад Азийн олон гол эх авдаг. Ганга мөрний эх ч энэ буй. Үүний төвд нэр нь Comorana болно гэжээ. Энд нэгэн зүйл тэмдэглэхэд Энэтхэгчүүд төвдийн mtsho (нуур далай), Ma pham (Мапам) гэсэн хоёр үгийг нийлүүлж өөрсдийн дуудлагаар болгожээ. Ийнхүү самгарди нэрийн төвд хуулбар орчуулга нь эргээд Энэтхэг хэлнээ орсон нь сонин үзэгдэл болно.

“Хөх түлхүүр” хэмээх толь бичигт “Нэгэн нуурын нэр болох ба утга нь Хүйтэн нуур хэмээх буюу (4- 448) гэжээ. Мөн тэнд: “Анабад гэдэг тунамал буюу дөлгөөн гэсэн утгатай Энэтхэг үг. Монголоор Эс булингартагч гэсэн үг” (4- 53) гэж тайлбарлажээ. Чухамдаа самгардийн Anavatapta гэсэн нэрийг төвдөөр madros mtsho гэж үгчилж орчуулсныг даган монголоор “Үл бүлээдэх далай” “ Эс бүлээдсэн газар” (-1235) гэж орчуулсан нь зөв бөгөөд “Эс булингартагч” гэсэн нь эндүүрэл бололтой. Лу “Алтан товч” “Эс билидүгсэн” гэсэн үгийг хаалтад “гатлах” гэж тайлсан нь мөн л ташаарал, “эс бүлээдүгсэн” гэвэл зохих байжээ. Угтаа самгарди нэрийн утгыг “нарны туяагаар бүлээсдэггүй далай гэсэн утгаар ухаарч болмой.

Энэ бүхнээс ургуулан товчоор дүгнэвэл монгол хэлний Анамад далай нь самгарди хэлнээ эрт цагт Anavatapta гэж нэрлэдэг байсан, төвдөөр Ма пам цо болсон Маансароовар нуурын нэр болно. Энэхүү сангийн сударт гарч байгаа Ма дрос цо гэдэг нэрийг уламжлалыг даган Мапам гэж орчуулсны учир энэ буюу.

Онон голын нэрийн гарлыг Буриадын эрдэмтэн Мельхеев “салаа” (развилка) гэсэн утгатай буриадын ОНО (н) гэсэн үгээс үүссэн гэж төсөөлж байна. Өөрөөр хэлбэл Онон, Ингэдэй хоёр гол нь

Шилка голыг үүсгэдэг. Развилка нь рассоха гэсэн нэр томъёотой дүйнэ. Рассоха нь салаа, салаалах, голын хоёр эх болно (6- 87) гэсэн бол Хятад улсын эрдэмтэн Ш.Цэцэнцогт “Арван нутаг” гэсэн утгатай түрэг гаралтай үг гэж тайлбарлажээ. Солонгосын эрдэмтэн Ким Ки Сонь Солонгосын томхон голыг Кън, хан (гон, хон) гэсэн нэрээр нэрлэдэг гээд монголын Онон нэрийг бүтээвэр болговол Он-он болох ёстой. Эртний утга нь Дуут гол гэсэн утгатай. Эртний монгол хэлэнд голыг хан хон < он < хон < hon гэдэг байсан нь илэрхий гэдгийг мэдэхэд хялбархан юм гэж зэрэг горилсон зохиолдоо бичжээ.

Солонгос, монгол хэлэнд байгаа энэ хэлбэр нь бүр урал-алтайн хэлний үеийн ул мөрийг хадгалж үлдсэн байхыг үгүйсгэхгүй. Гэвч эвенк хэлнээ зуны цагт ширгэдэг голыг Онгньоо гэж нэрлэдгийг анхаарахгүй өнгөрч болохгүй. Монголын умарт нутгийн газар усны нэрд эвенк гаралтай нэр цөөн бус тохиолдоно. Ингэж үзвэл ОНГНЬОО > онньо> онон болон хувирсан байж магадгүй.

Энд нэгэн зүйлийг тэмдэглэхэд хятад судлаач, эрдэмтэн Я.Ганбаатар Онон гол гэсэн нэр Нон гол болж үүнээс Монгол гэсэн нэр үүссэн гэдэг саналыг эрдмийн зэрэг хамгаалсан бүтээлдээ дэвшүүлсэн буй.

1. Лу. Алтан товч., УБ- 1990
2. Монгол ардын аман зохиолын дээж бичиг. Ш.Гаадамба. Д.Цэрэнсодном. УБ. 1978
3. Tibetan English Dictionary, by Sarat Candra Dass, New Delhi - 1979
4. Koke Tulkiguri, B. Vangyal, Koke qota 1987
5. Монгольско-Русско-Французский словарь. Том I-III, 1844-1849
6. Мельхеев. Бурятская топонимика, Улан/Үдэ

ONON SACRED RIVER


Information on the sutra:

The sutra was written by Bikkshu Sumadirasmi, while he was visiting the hot springs at the source of the river Onon.

The printed copy has been obtained from Sh. Soninbayar, Professor at Zanabazar University of Buddhism Studies, Ulaanbaatar.

The source of the Onon River is situated at the northern slope of the Khentii Khan mountain range and flows over 800 kilometers to join the Shilka river in Russia.

The Balj River is its largest tributary. The source is located at 1950 m. altitude and surrounded by twenty other hot water springs which are said to have medicinal qualities.



ОНОНГИЙН ХАЛУУН РАШААНЫ САН ТАХИЛ, ТУС АМГАЛАНГИЙН ҮҮЛНИЙ ЦОГЦ ХЭМЭЭХ ОРШВОЙ

Намо гүрү бхаяа:

Энэ гайхамшигт лусын эм рашааны халуун уснаа сан тахил үйлдэхийг хүсвээс түүний эд зайд лусын эм, эээр нууц эм тан, элдэв хүжис, элдэв мод, гурван цагаан, гурван амтат тэргүүтэн төрөл бүрийн үр болон мах, дарс, сармис, сонгиноос хараат бус элдэв идээ, орцыг хольсноор авралын сэтгэлийг урьдаар үүсгэн тэнгэрийн омог лугаа төгөлдөр адистидлаад нийтийн ёсоор үйлдэх энэчлэн буюу:

Зээ,

Энэ замбуутивийн цогноймолт
Эрхин мапам далайд оршсон
Эрхт лусын хаан, нөхөд сэлт
Энэ орноо ажран залрагтун.

Ай хө,

Сайн хэвтэй, үзвээс гоо газрыг
Садаалал үгүй баригч эрхт
Сайхан зүлэг, галбарбаасан ой цэцэрлэг
Саруул нуга хөндий, цэцгэс
Эеэрийн нууц эм, тэнгэрийн ус
Энэ бүхнээр хамгийг чимээд
Гайхамшигт рашааны халуун усны
Гаталгагч чуулганы эзэн тэргүүтэн батдаж
Тансаг жавхлантайяа найруу зохист
Талтай лусын эм хэмээн алдаршсан
Халуун рашааны газраа оршсон
Хан хүчит орны эзэн
Тэнгэр лус, нөхдийн чуулган
Тэнгис далайн эм, албин тэргүүтэн
Савдаг, шивдаг, орны тэнгэр

Сац бас хэвцэг догшин лус сэлт
Ариулалаар зочлон энд залраад
Алжаалгүй өөр өөрийн баясгалангийн тавцнаа оршоо!
Элдэв зүйл хүж, сайн эм
Элдэв төрлийн мод хийгээд
Элдэв амтат цагаан идээ сэлт
Элдэв олон үр тэргүүтэн
Өрвөлзөн бадарсан галд шатснаар
Үнэрт угааны чуулган цогц
Үхэлгүйн зам мөр бүхнээ
Үлэмж огоот түгсэн үүгээр:

Аяа,

Найман гишүүн төгс төгөлдөр
Найртай Мапам далайд оршсон
Нармай лусын эрхт хаан
Найман лус, нөхөд сэлтийг ариусгая.
Онц гайхамшигт халуун рашааны
Охь чуулганы эзнийг ариусгая.
Орны эзэн, лусын эм
Орчлон сансрын хатныг ариусгая.
Тэнгэр лус, далайн эм, албин
Тэргүүтэн нөхдийн чуулганыг ариусгая.
Ба бүрний сэрэмжгүй үйл хэрэг
Басхүү мунхаглалын харгайгаар
Газар сэндлэх, чулуу ховхлох
Мод огтлох, онгон ус буртаглах
Өс хонзон, бузар буртаг бөсийн бузар
Өнгө амтны бузар, улаан бузар зэрэг
Өсөрхөн хорлуулах, харгууцалдах
Өөдгүй бүхнийг хүлцэн болгоо.
Рашаан усны мөн чанарт
Халуун рашаанаа шүтсэнээр
Ариун дагшин маргад эрдэнийн

Охийн оюу эрдэнэ мэтээр
Архаг өвчнийг хоцролүй
Арилгах эмт усыг соёрх.
Арур тийн ялгуусан мэтийн
Ариун эмт усыг соёрх
Таагүй хий, цөс, бадгана тэргүүтний
Таван цул, зургаан сав
Халуун хүйтэн, үе гишүүн
Хамаг судас шөрмөсний өвчин
Алаг махта, тулай хэрэх
Аливаа тахир, доголлон, хүдгэнэ
Тал талын өвчин гарахыг
Таслан илааршуулан эдгээх болтугай.
Хүн зоны насны цөв
Эд баялгийн гай гарз болон
Хямрал самуурал, хэрүүл тэмцэл
Хяруу мөндөр, сохор доголлон, ган зуд
Амьтан хүмүүний чухаг хүсэл тэргүүтэн
Амин насны хязгаар хүртэл амирлаад
Нас буян, цог учралын
Найртай сайн чуулганыг арвитган зохио.
Ёс болгон шүтсэн бүхний
Ёстой хүчнээр амьтан болгоны
Ахуй орноо нас нь уртдаж
Амгалан жаргалан, өвчингүй болоод
Юу санасан есөн хүсэл нь
Юунаас ч шамдалгүйгээр өөсөөн бүтээд
Юүтэлгүй хойт төрөлд диваажинд төрөх

болтугай хэмээсэн Ононгийн халуун рашааны сан тахил, тус амгалангийн үүлэн цогц үүнийг дотны шавь Пражня кирти-бээр дурдсанд тойн дүрст бигшү Сумадирасми Ононгийн халуун рашаанд байх үестээ бичвэй.

ТУХАЙЛАН ТАГНА, УВС НУУР

Эл судар Хэл зохиолын хүрээлэнгийн төвд номын хөмрөгт 806 дугаарын бүртгэлтэй хадгалагдаж байгаа болно. Цаасны хэмжээ 17 см х 6 см, 4 хуудаснаа хар бэхээр бичсэн буй. Зохиогчийн нэр тодорхойгүй. Уг сударт гарч байгаа Тагна нь манай улсын баруун хойт хилийн цаана оршдог үргэлжилсэн урт нуруу. Түүний салбар хэсэг нь Увс, Хөвсгөл, Завхан аймгийн нутагт орж ирсэн буй. Тагна гэдэг нэрийн бүтцэнд орсон Таг нь уул, нуруу гэсэн утгатай түрэг гарлын үг.

Увс нуур нь Их нууруудын хотгорт Увс аймгийн нутагт з.у. 92° 50', х.ө. 50° 30' –д, 745 м өндөрт оршдог давстай, томхон хэмжээний тогтмол нуур.

Увс гэдэг нэр нь түрэг хэлний *ub* /гашуун/ + *su* /ус/ = Гашуун уст гэсэн утгатай болно.

Тэсийн гол нь Булнайн араас эх авч Увс нуурт цутгадаг, урт нь 568 км. Тэргүүлэгч цэцгийн язгуурын нэг зүйл модыг тэс гэх бөгөөд Булнайд ургадаг. Тэс гол нь энэ модны нэрээр нэрлэгдсэн бололтой. Энэ нэр монголд ч төдийгүй баруун европод ч тохиолддогийн нэг баримт нь Дунай мөрний зүүн гарын цутгал болох Тиса гол юм. Зарим эрдэмтэд Тиса гэдэг энэ нэрийг славян гаралтай тис /модны нэр/ гэж үзсэн байдаг. Үүнийг үнэний хувьтай гэвэл монгол хэлний тэс, славян тис нэг гаралтай байж магадгүй.

TAGNA SACRED MOUNTAIN AND UVS LAKE

Information on the sutra:

This manuscript on Tagna and Uvs is particularly special as it focuses on both mountains and lakes. The Tibetan copy of the sutra is kept in the archive of the Language and Literature Institute, Academy of Science, Ulaanbaatar.

Though most of the Tagna Mountain Range now lies outside the national border of Mongolia, part of the mountain range borders the territory of Uvs, Khovsgol and Zavkhan Province.

The name 'Uvs' originates from the Turkish 'ub', meaning bitter and 'su' meaning water. Uvs Lake is the largest land-locked lake in Mongolia and is situated at 743 meters above sea level. Its width and length are measured at eighty kilometers. The Nariin, Sagil, Borshoo and Khundlen sacred rivers also reach the lake.

ТУХАЙЛАН ТАГНА, УВСЫН САН ОРШВОЙ

Зээ,

Язгуур үндэсний лам, ядам, бурхадын чуулган
Ялгуусан баатар, дагинас, номыг тэтгээчин сахиуснууд
Тэнгэр ракшас, найман аймаг орны эзэн, шивдаг
Тэр бүхнээс онцгойлон Тагна, Идүг уул хийгээд
Тэнгис далай Увсын Тэс, Эрсүн гол тэргүүтэн
Тэр зүгийн уул ус, нуур далай, хад чулуу, ой шугуй
Тэндэх цөөрөм бүрд, булаг шанданд оршсон
Тэнгэр лус, бодинар, дэлхий газрын эзэд
Эс нөгчсөн хийгээд нөгчсөн сансар нирвааны зочин бүгд
Эдүгээ энд заларч тус тусдаа баясан батад орш.

Зээ,

Бодьтой бэлтгэж, сэтгэлээр хувилгаснаас үүдсэн нууц утлага
Болон гадаад дотоод тахил балин сэржмийн далай үүгээр
Багш лам, ядам, бурхан бодьсатваа хийгээд
Баатар дагинас номыг тэтгээчин сахиусны чуулган
Тэнгэр, ракшас, найман аймаг орны эзэн шивдаг
Тэнсэлгүй сансар нирвааны зочин бүхэн ивээгдэх болтугай.
Ариун эд зай, аливаа арц хүжис, элдэв эрдэнэс
Амгат үр жимс, хив торго, замар, идээ тэргүүтнийг
Агнийн галд шатаасны утаан үүлийг үхэлгүйн мөрд дүүргэн
Адбиш язгуур үндэсний лам, ядам. тэнгэрийн чуулганыг сагна
Бас бус бурхан бодьсатваа, шарвага хамгийг сагна
Баатар, дагинас номыг тэтгэгч сахиулсаныг сагна.
Онц ялангуяа сүмбэр их Тагна уулыг сагна.
Оюу их далай Увс, үлэмж уст Тэсийн голыг сагна.
Эрсүн тэргүүтэн уул ус, мөрөн голыг сагна.
Энэ хавийн цөөрөм бүрд болгоноо оршсон
Эрхин тэнгэр, лус. тэнгэр бус, бодинарыг үлдээлгүй сагна.
Эн тэргүүнд энэ зүгийн газар нутагт оршсон

Орны эзэн, дэлхийн эзэн

Орны тэнгэр хамгийг сагна.

Нөхөн товчилбоос бидний цог лугаа дуурсхан зохиосон

Нөгчигсөн ба эс нөгчигсөн тэнгэр хамгийг сагна.

Сан тахил, балингийн дээд эдгээрийг таалаад

Сацлалгүй ба бүрний багш шавь, өглөгийн эзэд, нөхдийг

Өдөрт гурвантаа харж, шөнөд гурвантаа манан

Өөд уруугаа явагсдыг гэрлээр угтан зохио.

Ертөнцийн энэ орноо хяруу мөндөр ган зуд

Ер хүн, малын хүчир өвчнийг тэгш сацуу амирлуулж

Нас буяны цог учрал, яруугаар алдаршсан бүхнийг

Найртай шинэдийн саран мэт дэлгэрүүлж хайрла.

Асар гурван ертөнцийн амьтан бүхнийг эрхэндээ хураагтун

Атаат хорлогч дайсны тотгорыг догшноор мөхөөгтүн.

Арван зүгийн хотол гурван чуулганы хишиг буян

Алзалгүй эдүгээ бидний буян хишиг лүгээ өөдлөн залрагтун

Буян болтугай.

ХЭРЛЭН ГОЛ

“Хэрлэнгийн сан оршвой” хэмээх энэ бяцхан судар нь академич Ц.Дамдинсүрэнгийн нэрэмжит гэр музейн хөмрөгт МН-996 гэсэн дугаартай хадгалагдаж байгаа болно. Хэрлэнгийн сангийн өөр хувилбарыг энэ хир олж үзсэнгүй. гагцхүү энэ нэгэн эхийн хуулга мэр сэр тааралдана.

Энэ судрын төгсгөлийн үгэнд: “Умар зүгийн Баргын орны ноён Жанчивдорж энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн зарлигласанчлан Шагжийн тойн Агваанчойдогжамцбалсанбо найруулсны бичээч нь тойн Агваандорж болой” гэсэн буй. Тэгэхлээр эл судрыг Хэрлэн хавиар нутаглаж байсан Баргын ноён зохиолгосон бололтой.

Их Хэнтийн нурууны өвөр бэлээс /1750 м өндрөөс/ эх авч урсах Богдын гол, Цагаан гол хоёрын уулзварыг Хэрлэнгийн эх гэж үздэг. Монголын дорнод хэсгийн дундуур хэдэн аймгийн нутгаар дамжин улсын хил хүртэл 1090 км урсаж хилийн чанад Далай нуурт цутгах, Номхон далайн ай савд багтах энэхүү голын нийт урт нь 1264 км ажээ.

Хэрлэн гэсэн нэр нь “Монголын нууц товчоонд” Хэлүрэн гэж тэмдэглэгдсэн, жинхэнэ эртнийх нь хэлбэр болно. Хэлүрүн гэсэн нэр нь авиа тонгорсны улмаас эдүгээ Хэрлэн болжээ.

Эртний монголчуудын уугуул ус, шүтлэгт мөрөн Хэрлэн нь олон арван уран зураг, ерөөл магтаал, дуу шүлэгт мөнхрөн үлдсэн юм.

KHERLEN SACRED RIVER

Information on the sutra:

The single surviving manuscript on the Kherlen river is kept in the private collection of the academician Ts.Damdinsuren.

It is assumed that the sutra was written upon the request of a nobleman from the Barga minority region, residing in the Kherlen area.

The Kherlen river, which flows through the territories of several aimags to the northern border of the country, has a length of around 1100 km. It is a tributary to Dalai Lake and is considered to be one of the main rivers of the Pacific drainage basin.

The original name for Lake Kherlen was spelled as ‘Khelurun’ in the ‘The Secret History of Mongols’ which recounts the history of Chingis Khaan’s empire.

ШАРГАЛЖУУТЫН РАШААН

Энэхүү судрыг Шаргалжуутын рашаанд зориулан зохиожээ. Зохиогч нь Халхын Зая бандид Лувсанпринлэй ажээ. Лувсанпринлэй нь Халхын Хангай ханы нутаг Хужирт гэдэг газар төрсөн. Багаасаа ном эрдэмд авъяастай байснаас Төвдийн Гүнбум, Үйзэн зэрэг газарт очиж шавилан суужээ. 18 жил төвд, самгарди хэлийг судлаж, тэр хэлээр бурхны шашны гүн ухаан, уран зохиолын номыг судалжээ. Энэ хүний Бээжин хотноо барлагдсан сүмбум УТНС-ын төвд хөмрөгт хадгалагдаж байгаа ба миний бие түүнээс газар усны сангийн судрыг нь буулган авсаны нэг нь энэ юм. Ихэнх судар нь Хангай нутгийнх нь нэр алдартай гэгдсэн газар усанд зориулагдсан буй. Мөн Хэнтий ханд зориулж бичсэн сангийн судар ч байна. Отгонтэнгэрийн сангийн сударт нь Шар ус, Хар ус, Халтар ишиг, Балгатай, Бөөнцагаан, Завхан гол, Шураг, Улиастай, Арц, Хөх сэрх, Таг, Тайшир, Хасагт, Хоёр харгана, Цагаан тогоо, Дааган тал зэрэг олон газар усны нэрийг дурдсан бол Хэнтий ханы сангийн сударт Хэрлэн гол, Сэнхэр гол, Таргилж, Хээр саарь, Баян-Улаан, Баян-Эрхэт, Хоёр тойног, Долоод, Бутын Хар сүүл, Мугнар, Идэрмэг, Дархан уул, Хэхээр язгуур, Эрэгнэг, Гурван тарган уул, Хоёр үнэгэд, Үхэр бөгс, Улаан гуна зэрэг олон газар усны нэр буйн нэлээд нь түүхэн газар усны нэр байна. Зая бандидын зохиосон “Дээдийн сангийн эрдэнийн эрх хийгээд ариусал, залбирал, тахил тэргүүтэн оршвой” хэмээх нэг бүлэг бүтээл дэх бүх судрыг энэ удаагийн номд хараахан багтааж завдсангүй. Дараа тусгай ном болгон гаргах санаатай.

Ингээд Шаргалжуутын халуун рашааны тухай товчхон өгүүлсүгэй. Энэ халуун рашаан Баянхонгор аймгийн төвөөс зүүн тийш Шаргалжуут голын хөндийд д.т.д 1492 м өндөрт оршдог манай орны хамгийн халуун рашаан юм. Халуун нь 90 хэмтэй байдаг аж. Сангийн сударт нь 400 орчим өвчнийг илааршуулдаг гэсэн бол одоо цагийн шинжлэх ухаан тахир дутуу, үе мөч, бөөр нуруу, мэдрэл зэрэг олон өвчнийг анагаадаг гэсэн буй. Нутгийнхан Шаргалжуутыг 108 рашаантай гэдэг.

Урьд дээр цагт Манжийн эзэнт гүрний үед энэ гол айхавтар үерлэсэн гэдэг. Тэр үед Манжийн хааны буухиа элчийг саатуулсанаас уг голыг Шар галзуу гол гэсэн нэр өгсөн нь яваандаа Шаргалжуут болж хувирсан тухай домог уламжлагдан иржээ.

SHARGALJUUT SACRED SPRINGS

Information on the sutra:

The Shargaljuut hot springs are situated in the valley of the Shargaljuut river at 1492 m. altitude in Bayankhongor province. The temperature of the hot spring can reach up to 90 degrees Celsius.

The sutra-manuscript for the Shargaljuut hot spring details the healing power for nearly four hundred different conditions, viruses and diseases humans may suffer from. According to the locals, there are 108 hot springs to be found over an area of two hectares in Erdenetsogt Soum's territory.

According to legends, the name for the springs derive from a historic event which occurred during the Manchu occupation. It is believed that whilst running an errand, the head-messenger to the Manchu Emperor was delayed for several days by a great flood. The flood water adopted a yellow tinge, and flowed vigorously. Subsequently, the river was named 'Shar Galzuut', meaning ferocious yellow water.

ШАРГАЛЖУУТЫН САН ОРШВОЙ

Свасти. Сан тахилууд Ом аа хум хэмээн гурвантаа адистидлагтун.

Аяа,

Умар зүгийг тэтгэн сахигч Хангай ханы

Угсаа аймгийн харьяат буянт Чинту болон Шаргалжуут

Угаас алдаршсан уул ус, рашаан булгийн орон

Учиртай агаад онцгой эндэх халуун рашаанаа оршсон

Тэнгэр, лус, асуурь, навдаг, шивдаг, бүднэр тэргүүтэн

Тэр бүхэнд бодьтой бэлтгэж, сэтгэлээрээ хувилгасан

Тэнцээрт тахилгыг цогцлоон, сангийн зайг уугуулснаар

Тэнцэшгүй сайхан үнэрт утаан үүл нь бүхнийг сэлбэрүүлж

Хэмжээлэшгүй дүүргэн өргөснөөр баясан цэнгэж ханаад

Хэргээр эндэхийн рашаанаа орсон бүхнийг

Хишиггүй урьдын үйлээс нь түргэн салгаж, гурван харын үрийг
арилган

Хий, цөс, бадгана, сүсгийн тохиолоор хурсан өвчин зэрэг

Дөрвөн зуун үндсэн өвчний уг язгуурыг

Дөлж хоцроолгүй арилган, бие тавируулан эрхтнийг гийгүүлж

Ухаан мэдрэлийг зохистой болгон, өтөлсөнийг чийрэгжүүлэн

Угаас халуун рашааны хамаг эрдмийг олоод


Ивээлт хамаг үйлс шамдалгүй өөсөөн бүтэж

Итгэл, авралт, өмөг садан, зуучилж тусалсан хийгээд

Илтэд хураангуйлбаас бид бүхний, юу хүссэн хэрэг

Ихэд хуу цөм бүтэхийн хань хамсааг зохио

хэмээсэн энэ мэт нэн хэрэгтэй гэж хос ёсны айлдлыг мэлмий төгс
бонмо Данзанцэвээнравдан Бунддхара зарлиг дурдсанд Заябандида
Лувсанпринлэй бээр найруулбай.



Dr. Hatgin Osornamjimyn SUKHBAATAR

Born in 1945, in the southern area of Erdenetsagaan Soum, Sukhbaatar aimag (province), adjacent to the sacred mountain of Zotolkhan, Dr. Sukhbaatar attended secondary school in the aimag-center of Baruun-Urt. Following this, he studied Mongolian language and literature until 1970 at the State University in Ulaanbaatar, the capital of Mongolia.

Between 1973 and 1976, he specialized in translation and interpretation of Hindi at the Central Hindi Institute in Delhi, India and received his second degree in linguistics.

Sukhbaatar started his career as a researcher at the Institute of Language and Literature, Mongolian Academy of Sciences from 1976 to 1980, then as a visiting Professor for the University of Neru, India from 1980-1984. In 1984 to the present day, he has been working as the Department Head and Scientific Secretary for the Institute of Language and Literature at the Mongolian Academy of Sciences. He wrote his doctoral (Ph.D.) thesis on "Samgard elements in Mongolian language" in 1992.

The list of his published works include the following:

- Dictionary of Dandin's Kavyadarsa (1980)
- Dictionary of Borrowings in Mongolian language from foreign languages (1997-1999)
- Great Academic Dictionary of Contemporary Mongolian-Russian Languages (4 volumes, 2001)
- 'Lu Altan tovch' or 'A Golden History of Mongolia' (revised version, Khokh khot, Inner Mongolia, PRC, 1998)
- Mongolian Legends of the Land (2001) in association with ARC, Gandan Monastery, WWF Mongolia and supported by The World Bank

Dr. Sukhbaatar has published over fifty articles on various topics he has researched, both domestically and internationally. He has translated several books from Hindi, Samgard and Tibetan, and was awarded with the Prize of the Mongolian Translators Association in 1997 for his translations and publications. For his contribution to language studies, he has been awarded with the honorary title of the "Best Researcher of Science".

The English part of this publication is translated by Ms. Elbegzaya Batjargal and edited by Ms. Tara Lewis.



**Доктор (Ph.D), дэд-профессор
Хатгин Осорнамжимын СҮХБААТАР**

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг эртний Сүлдэн тахилгат Зотолхан уулын өмнөдөд 1945 онд төрсөн. 1965 онд Баруун Уртын 10 жилийн дунд сургууль, 1970 онд МУИС-ийг монгол хэл, утга зохиолын багш мэрэгжлээр төгссөн.

1973-1976 онд Энэтхэг улсын нийслэл Дели хотын хинду хэлний төв институт-д орчуулагч мэрэгжлээр суралцан төгссөн. 1976 – 1980 он хүртэл ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн-сүрэн шинжилгээний ажилтан, 1980-1984 он хүртэл Дели хотын Жавахарлал

Неругийн нэрэмжит их сургуульд багшаар, 1984 оноос өнөө хүртэл Хэл зохиолын хүрээлэн-сүрэн шинжилгээний дарга, эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

1992 онд "Монгол хэлэн дэхь Самгарди махбод" гэдвээр докторын (Ph.D) зэрэг хамгаалсан.

Өнгөрсөн хугацаанд "Дандины зохист аялгууны толь" (1980. хамтын), "Монгол хэлний харь үгийн толь" (1997, 1999), "Лу. Алтан товч" (шинэчилсэн сийрүүлэг, Хөх хот, 1998) "Монгол Орос дэлгэрэнгүй их толь" (хамтын, 4 боть, 2001 он, Москва), "Монголын газар усны нэрийн домог" (2001) зэрэг бүтээл болон 50 гаруй эрдэм шинжилгээний өгүүллийг гадаад улсуудад тус тус хэвлэгдсэн байна.

Түүний "Монголын газар усны нэрийн домог" (2001 он) ном ДБХС-ийн Монгол дахь Товчоо, ШБХХ, Гандан Тэгчилэн хийд, Дэлхийн Банкны дэмжлэгтэйгээр хэвлэгдсэн байна.

Мөн төвд, самгарди, хинди хэлнээс хэд хэдэн ном орчуулж, 1997 онд Монголын орчуулагчдын эвлэлийн шагнал хүртсэн юм. Хэл судлалын шинжлэх ухаанд оруулсан түүний хувь нэмрийг үнэлж ШУА-ийн "Төргүүний ажилтан" цол тэмдгээр шагнасан юм.

- Энэхүү номын ариун шүтлэгтэй газар орны товч тайлбарыг англи хэлнээ Батжаргалын Элбэгзаяа хөрвүүлж, Тара Луис хяналаа.



WORLD BANK